



БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
АРДЫН ИХ ХУРЛЫН ХУРАЛДААНЫ  
**ПРОТОКОЛ**

199 I оны II  
сарын II өдөр

I  
Дугаар

Улаанбаатар  
 хот

БНМАУ-ын Ардын Их Хурлын II хуралдаан 1991 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн өглөөний 9<sup>00</sup> цагт Ардын Их Хурлын хуралдааны танхимд нээгдэв.

Хуралдааныг Ардын Их Хурлын дарга Ж.Гомбожав даргалав. Хуралдаанд 427 депутат хуралцэн ирэхээс 420 депутат ирсэн, ирц 98,2% байв. Ардын Их Хурлын 339-р тойргийн депутат Г.Чингэл, 376-р тойргийн депутат Г.Батмөнх, 254-р тойргийн депутат Ц.Охинтогтох, 199-р тойргийн депутат Н.Сампилиноров нар өвчтэй, 145-р тойргийн депутат Л.Лантуу, 299-р тойргийн депутат Г.Сүрэнжаргал, 84-р тойргийн депутат Н.Самат нар гадаадад ажлаар явсан байв.

Өглөөний хуралдаанд БНМАУ-ын Ерөнхийлөгч П.Очирбат, Ерөнхий сайд Д.Бямбасүрэн, Засгийн газрын шадар сайдууд болон гишүүд, тусгай газрын дарга нар, гадаадын дипломат төлөөлөгчдийн газрын тэргүүн нар байлцав.

Ардын Их Хурлын II хуралдааныг нээж Ардын Их Хурлын дарга Ж.Гомбожав уг хэлэв./Халсан угийг хавсаргав/

9<sup>05</sup> цагт аиждугаар хуралдаан нас хойшхи хугацаанд өртөнцийн мөнх бусыг үзүүлсэн Ардын Их Хурлын депутатуудын дурсгалыг депутатууд нэг минут босч хүндэтгэв.

9<sup>06</sup> цагт Ардын Их Хурлын зарим депутатын бурэн эрхийн тухай илтгалийг Депутатын бурэн эрхийн асуудал эрхалсэн байнгын комиссын дарга 46-р тойргийн депутат Ю.Жаргал тавыж хэлэлцүүлэв. Дараа нь Ардын Их Хурлын депутатуудын бурэн эрхийг дуусгавар болсонд тооцох тухай Ардын Их Хурлын тогтоолын төслийг н.Жаргал уншиж танилцуулж батлуулав. Татгалзсан, тутгалзсэн байхгүй санал нэгтэй батлав.

Н.Зоригтбаатарыг Ардын Их Хурлын депутатын үүргээс чөлөөлөх тухай тогтоолыг мөн санал нэгтэй батлав.

Л.Пүрэвдорж-Дашдундогийн бурэн эрхийг зөвшөөрсөн тогтоолыг

хүчингүй болгох нь зөв үү? Чөлөөлж болохгүй юу?

Депутатууд хэлэлцээд Дацлондогийг огцорсон гэдгээр бүрэн эрхийг нь дуусгавар болсонд тооцох болов.

Шинээр нөхөн сонгогдсон депутатуудын бүрэн эрхийг хэлэлцэж санал нэгтэй батлав.

119-р тойрт сонгогдсон Д.Цээн-Ойдовын бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай тогтоолын төслийг халалцуулэв. Сонгууль будлиантай болж, сонгуулийн хууль зөрчигдсөн гэж тус комисс үзсэн.

120-р тойргийн депутат Н.Отгон-Шалгалт хийсэн хүмүүсийн шалгалтын дүнг сонсох хэрэгтэй байна.

Энэ талаар комиссын дарга Ю.Жаргал тайлбар хийв.

Л.Дашням-Цээн-Ойдов өөрөө энд юу бодож байгааг сонсьё.

Депутатууд яриулах шаардлагагүй гаж үзэв.

123-р тойргийн депутат Д.Гинаажав, 429-р тойргийн депутат Д.Рэнцэннацаг нар үг хэлэв. Дараа нь 119-р тойргийн депутат Д.Цээн-Ойдов өөрөө үг хэлэв.

Ардын Их Хурлын дарга санал хураах хусалт гаргав.

I.н.Цээн-Ойдовын бүрэн эрхийг түдгэлзүүлэх саналыг зөвшөөрсөн 215, 51, 19/;

II.Татгалзсан 176, 41,90%,

III.Түдгэлзсэн 29, 6,9%

294-р тойргийн депутат И.Бадарч, 20-р тогтоолын нууц задруулсан Улсын Бага Хурлын гишүүн депутатуудын асуудлын талаар н.Жаргалаас асуув. 164-р тойргийн депутат Ц.Дэмжид зөрчил гаргасан депутатуудын асуудлыг одоо л ярих нь зөв. Их хурлын үйл ажиллагаа дундуур алдэв өөр зүйл ярьж хэрэггүй.

301-р тойргийн депутат Д.Жамсран, 289-р тойргийн депутат Г.Нороврагчаа, 56-р тойргийн депутат Р.Гончигдорж 354-р тойргийн депутат Х.Баянмөнх, 121-р тойргийн депутат Б.Норжин, 25-р тойргийн депутат Л.Энэбиш, 39-р тойргийн депутат Д.Ламжав, 178-р тойргийн депутат Д.Энхбаатар нар үг хэлэв.

II9-р тойргийн депутат Цээн-Ойдовын бүрэн эрхийг 51,2%-ийн саналаар түдгэлзүүлэв.

10<sup>22</sup> цагт Ардын Их Хурлын дарга, орлогч нарыг сонгох ажил эхлэв.

МАХН-ын Төв Хорооны дарга, 42-р тойргийн депутат Даш-ёндон, 318-р тойргийн депутат Ж.Уртнасанг Ардын Их Хурлын даргаар сонгох санал гаргаж танилцуулав. Санал хураалтанц татгалзсан 3, түдгэлзсэн 8, депутат байв. Олонхийн саналаар н.Уртнасанг Ардын Их Хурлын даргаар сонгож батлав.

Ардын Их Хурлын орлогч 4 хүн байна гэдгээр санал хураахад татгалзсан 65, түдгэлзсэн 7 депутат байв. Олонхийн саналаар 4 орлогч даргатай байхаар тогтов. Орлогч даргад 24-р тойргийн депутат Р.Хатанбаатар МСДН-ын булгийн өмнөөс 278-р тойргийн депутат Д.Моондойг, 383-р тойргийн депутат Б.Гүнджалам МУДН-ын өмнөөс 43-р тойргийн депутат Н.Батбаярыг, 198-р тойргийн депутат Батмэнх 194-р тойргийн депутат Г.Жагайг, 424-р тойргийн депутат Х.Бадамсүрэн 33-р тойргийн депутат Д.Мөнхбат, 124-р тойргийн депутат З.Дашцэдэн 144-р тойргийн депутат Ц.Лоохуузыг, 52-р тойргийн депутат Э.Бат-Үүл 207-р тойргийн депутат М.Моёорыг, 245-р тойргийн депутат Чинбат 246-р тойргийн депутат Н.Дашдоңдогыг, тус тус нэр дэвшүүлэв. Дараа нь нэр дэвшигчидтэй депутат <sup>Үүд</sup> Танилцаав. Асуулт гарсангүй.

Д.Мөнхэе-Жагайг Ардын Их Хурлын орлогч даргаар үлдсэн нэхцэлд нэрээ авах болно.

Намын дэс дараалалаар санал хураалт явагдав.

|             |            |     |       |
|-------------|------------|-----|-------|
| 1.Д.Моондой | зөвшөөрсөн | 309 |       |
|             | татгалзсан | 5   |       |
|             | түдгэлзсэн | 16  |       |
| 2.Н.Батбаяр | зөвшөөрсөн | 317 | 75,4% |
|             | татгалзсан | 64  |       |
|             | түдгэлзсэн | 39  |       |
| 3.Г.Жагай   | зөвшөөрсөн | 324 | 77,1  |
|             | татгалзсан | 59  | 16%   |
|             | түдгэлзсэн | 37  | 8,8%  |
| 4.Д.Мөнхе   | зөвшөөрсөн | 261 | 62,1% |
|             | татгалзсан | 116 | 27,6% |
|             | түдгэлзсэн | 43  | 10,2% |

|                |            |     |
|----------------|------------|-----|
| 5. Н.Лоохууз   | зөвшөөрсөн | 250 |
|                | татгалзсан | 125 |
|                | түдгэлзсэн | 45  |
| 6. М.Моёор     | зөвшөөрсөн | 121 |
|                | татгалзсан | 224 |
|                | түдгэлзсэн | 75  |
| 7. Н.Дашлондог | зөвшөөрсөн | 135 |
|                | татгалзсан | 109 |
|                | түдгэлзсэн | 86  |

132-р тойргийн депутат С.Чулунбаатар-Нэрийн дараалалаар санал хураана. Орлогч боллоо гэж зарламааргүй байна. Дараа нь хүнд байдалд орно.

288-р тойргийн депутат С.Баярцогт, 31-р тойргийн депутат Д.Дожодорж, 52-р тойргийн депутат Э.Бат-Үүл, 132-р тойргийн депутат С.Чулунбаатар нар үг хэлэв.

Санал хураалтын дүнг үндэслэн Д.Моондой, Н.Батбаяр, Г.Жагай, Н.Лоохууз нар сонгогдов. Д.Мөнхөө нэрээ авав.

Шинээр сонгогдсон дарга, орлогч нар II<sup>15</sup> цагт суудлаа эзлэв.

Улсын Бага Хурлаас өргөн барьсан Их цаазын болон хавсралт хуулийн төслийг н.Р.Гончигдорж Ардын Их Хурлын дарга Ж.Уртнасандаа өргөн барив.

Хуралдаан II<sup>17</sup> цагт завсарлаад II<sup>40</sup> цагт эхлэв. Хуралдааныг Ардын Их Хурлын дарга Ж.Уртнасан даргалав.

Ардын Их Хурлын хуралдааны дэгийг хэлэлцэж батлах ажилд оров.

389-р тойргийн депутат Н.Бат-Очир, 427-р тойргийн депутат Ц.Элбэгдорж, 282-р тойргийн депутат Д.Лхагвасүрэн, 391-р тойргийн депутат Ш.Лхагва, 353-р тойргийн депутат Ш.Бороодой, 290-р тойргийн депутат С.Цэвээндээрж, 369-р тойргийн депутат Д.Пүрэвдорж, 25-р тойргийн депутат Л.Энэбиш, 55-р тойргийн депутат Ц.Адъяасүрэн, 283-р тойргийн депутат Ш.Шагдарсүрэн, 309-р тойргийн депутат Д.Батбаяр, 272-р тойргийн депутат С.Лунаа, 336-р тойргийн депутат Т.Ганхуяг, 340-р тойргийн депутат Б.Сумьяа, 210-р тойргийн депутат П.Хаадгар, 24-р тойргийн депутат Р.Хатанбаатар, 257-р тойргийн депутат Ч.Цэрэндэгва, 59-р тойргийн депутат Ч.Пүрэвдорж, 15-р

тойргийн депутат Д.Лундаажанцан, 258-р тойргийн депутат Ш.Гунгаадорж, 309-р тойргийн депутат Д.Батбаяр, 290-р тойргийн депутат С.Цэвээндорж, 208-р тойргийн депутат З.Жанжаадорж нар үг хэлэв.

12<sup>14</sup> цагт Ардын Их Хурлын хуралдааны баримт бичгийг эцэслэн боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн/ ахлагч нь С.Баяр I тойрог/-ийг хэлэлцэж олонхийн саналаар уг тогтоолыг батлав.

Дэгийг олонхийн саналаар зүйячлэн хэлэлцэхээр тогтов.

132-р тойргийн депутат С.Чулуунбаатар, 22-р тойргийн депутат Л.Дашням, 283-р тойргийн депутат Ш.Шагдарсүрэн, 178-р тойргийн депутат Д.Энхбаатар, 407-р тойргийн депутат Б.Нүүрэй, 350-р тойргийн депутат У.Давааням, 27-р тойргийн депутат Л.Пүрэвдорж нар дэгийн төслийн талаар санал хэлэв. Ардын Их Хурлын депутат биш Улсын Бага Хурлын гишүүдийг Ардын Их Хурлын хуралдаанд зөвлөх эрхтэй оролцуулахыг зөвшөөрсөн 234, татгалзсан --, түдгэлзсэн -- 192-р тойргийн депутат Г.Бөхчүлүүн зөвлөх эрхтэй биш, тайлбар өгнө гэж санал хураах, 351-р тойргийн депутат Б.Мөнгөн, 353-р тойргийн депутат Ш.Бороодой нар мөн санал хэлэв.

Дэгээс ердийн олонхийн гэсний "өрдийн" гэснийг хасахыг зөвшөөрсөн 144, олонхийн санал авч чадсангүй 1.326-р тойргийн депутат Ж.Гомбожав, I-р тойргийн депутат С.Баяр, 143-р тойргийн депутат Г.Зуунай, 15-р тойргийн депутат Д.Лундаажанцан, 311-р тойргийн депутат Д.Баяр, 427-р тойргийн депутат Ц.Элбэгдорж, 261-р тойргийн депутат Д.Пүрэв, 191-р тойргийн депутат Б.Лханаасүрэн нар үг хэлэв.

|                                    |     |
|------------------------------------|-----|
| 3 хүртэл санал хураахыг зөвшөөрсөн | 226 |
| татгалзсан                         | 32  |
| түдгэлзсэн                         | 28  |
| 5 хүртэл санал хураахыг зөвшөөрсөн |     |
| татгалзсан                         |     |
| түдгэлзсэн                         |     |

Депутатуудаас санал авч 5 хүртэл гэдгээр санал хураахыг болив.

56-р тойргийн депутат Р.Гончигдорж, 427-р тойргийн депутат Ц.Элбэгдорж, 140-р тойргийн депутат Т.Гантэмэр нар үг хэлэв.

Шаардлагатай уед Ардын Их Хурлын дарга 4-5 дахь удаа санал хураалгаж болно гэсэн нэмэлтийг дэгд оруулахыг зөвшөөрсөн 229, татгалз сан -"- , түдгэлэсэн -"- депутатуудын олонхийн саналаар оруулах болов.

178-р тойргийн депутат Д.Энхбаатар, 132-р тойргийн депутат С.Чулунбаатар, 1-р тойргийн депутат С.Баяр нар уг хэлж санал гаргав.

Хуралдаан 13<sup>03</sup> цагт завсарлах 15<sup>00</sup> цагаас ажлаа үргэлжлүүлэв.

Үдээс хойши хуралдааныг Ж.Уртнасан даргалав.

Дэгийн 1-р зүйлийн 2-р заалтаас эхлж халалцэв.

141-р тойргийн депутат Ж.Авхиа, 98-р тойргийн депутат Д.Марав, 264-р тойргийн депутат Б.Банди нар уг хэлэв. Санал системийг шалгах Ирц 390 депутат ирсэн, 91% байв.

1-ийн 2-оор санал хураав. Хэвээр үлдээх 389, татгалзсан 7, түдгэлэсэн 2 байв. Хэвээр үлдээв. 277-р тойргийн депутат Л.Болд, 23-р тойргийн депутат Ц.Энхбат, 85-р тойргийн депутат К.Сайраан, 109-р тойргийн депутат С.Лхагвасүрэн, 1-р зүйлийн 3-р заалтаар санал хураахад хэвээр үлдээхийг зөвшөөрсөн 356/88%, татгалзсан 36/9% / түдгэлэсэн 13 /5% / байв. Олонхийн саналаар хэвээр үлдээв. 72-р тойргийн депутат А.Болат, 381-р тойргийн депутат Н.Цэрэнхүү, 9-р тойргийн депутат С.Зориг нар уг хэлэв.

Дэгийн 2,3,4-р зүйлээр санал хураав. Зөвшөөрсөн 395 / 97%, татгалзсан 7 / 2%, түдгэлэсэн 5 / 1% / байв. Хэвээр батлав. 282-р тойргийн депутат Д.Лхагвасүрэн, 288-р тойргийн депутат С.Баярцогт, 41-р тойргийн депутат Н.Пүрэвдорж, 405-р тойргийн депутат Б.Лигдэн, 50-р тойргийн депутат А.Далхжав, 18-р тойргийн депутат Г.Ганболд, 328-р тойргийн депутат Б.Дашзөвэг нар 5-р зүйлтэй холбогдуулан уг хэлэв. Санал хураав. 1.5-р зүйлийг Дэгд байгаа хэвээр үлдээх. Зөвшөөрсөн 196 /49 % /, татгалзсан 165 / 42% / түдгэлэсэн 36 / 9% /, болж олонхийн санал авч чадсангүй. 315-р тойргийн депутат Ч.Бат-эрдэнэ уг хэлэв. Иймд 5-р зүйлийг 2 зүйл болгохоор санал хураав. Зөвшөөрсөн 250 / 62% /, татгалзсан 132 / 33% /, түдгэлэсэн 23 /6% / болов. 69-р тойргийн депутат Ж.Ядамсүрэн, 10-р тойргийн депутат Θ.Дашбалбар, 24-р тойргийн депутат Р.Хатанбаатар, 86-р тойргийн депутат С.Харжаубай, 10-р тойргийн депутат О.Дашбалбар, 197-р тойргийн депутат Н.Шура, 27-р тойргийн депутат Л.Пүрэвдорж, 15-р тойргийн

депутат Д.Лундаажанцан, 280-р тойргийн депутат Ш.Цэндбаяр, 226-р тойргийн депутат Д.Гарамжав, 47-р тойргийн депутат С.Лхагвасүрэн, 14-р тойргийн депутат С.Лхагвасүрэн, 314-р тойргийн депутат М.Гантэмэр, 105-р тойргийн депутат Б.Чойжилсүрэн, 177-р тойргийн депутат Б.Буянмөнх, 9-р тойргийн депутат С.Зориг, 165-р тойргийн депутат Ч.Гомбосүрэн нар намуудын депутатуудын бүлэгтэй холбогдуулан үг халэв. Депутатын бүлэг байна гэдгийг зөвшөөрч 357 /88% / татгалзаж 42 /10%, түдгэлзэж 6 /1% / депутат санал өгөв.

Бүлгийн депутатын тооны хувьд хязгаар тогтоохгүй гэдгээр санал хураах болов. 95-р тойргийн депутат Т.Төмөрбаатар, 80-р тойргийн депутат Д.Зарыккан, 317-р тойргийн депутат Д.Мандах, 11-р тойргийн депутат Ж.Бямба, 231-р тойргийн депутат Г.Амарбаян, 15-р тойргийн депутат Д.Лундаажанцан, нар үүнтэй холбогдуулж үг халэв. Тооны хязгаар байхгүйг зөвшөөрч 346 /84% /, татгалзаж 60 /15% /, түдгэлзэж 6 / 1% / депутат санал өгөв.

Р.Хатанбаатар, Д.Ламжав, Ж.Бямбаа нар өөрсдийн саналаа халэв. 132-р тойргийн депутат С.Чулуунбаатар, 52-р тойргийн депутат Э.Бат-Үүл нар үг халэв.

5-р зүйлийн 1-р заалтыг хасахыг зөвшөөрч 350 / 90% /, татгалзаж 31 / 8% /, түдгэлзэж 10 /3% /, депутат санал өгөв.

<sup>16</sup><sup>18</sup> цагт 6-р зүйл хэлэлцэж эхлэв. 46-р тойргийн депутат Ю.Шаргал үг халэв. 6-р зүйлээр санал хураалтанц зөвшөөрч 399 /97% /, татгалзаж 7 /2% /, түдгэлзэж 4 /1% / депутат санал өгөв. 7-р зүйл дээр 427-р тойргийн депутат Ц.Элбэгдорж, 41-р тойргийн депутат Н.Нүрэвдорж, 47-р тойргийн депутат С.Лхагвасүрэн, 293-р тойргийн депутат Ч.Бадарч, 150-р тойргийн депутат Д.Балдан-Очир, 340-р тойргийн депутат Б.Сумьяа, 429-р тойргийн депутат Д.Рэнцэннацааг, 55-р тойргийн депутат Ц.Адъяасүрэн, 286-р тойргийн депутат С.Батсух, нар үг халэв. Санал хураав. 1.Их хурлыг Ардын Их Хурлын дарга удирдана гэснийг зөвшөөрч 378 /92% /, татгалзаж 24 /6% /, түдгэлзэж 7 /2% /, депутат санал өгөв.

427-р тойргийн депутат Ц.Элбэгдорж, 315-р тойргийн депутат Ч.Бат-эрдэнэ, 47-р тойргийн депутат С.Лхагвасүрэн, 104-р тойргийн депутат Д.Жагварал нар үг халэв.

<sup>16</sup><sup>38</sup> цагт Ардын Их Хурлын дарга, орлогч нарыг сонгосон Ардын

Их Хурлын тогтоолыг хэлэлцэж батлав.

АИХ-ын даргыг сонгосон 6-р тогтоолыг зөвшөөрч 399 /98%, татгалзаж 7 /2%, тудгалзаж 2 /0% санал өгөв. Орлогч дарга нарыг сонгосон 7-р тогтоолыг зөвшөөрч 380 /94%, татгалзаж 19 /5%, тудгалзаж 7 /2% депутат санал өгөв.

Дэгийн 7-р зүйлийг дэмжих 395 / 96%, татгалзаж 7 /2% тудгалзаж 8/2% депутат санал өгөв.

427-р тойргийн депутат Ц.Элбэгдорж, 45-р тойргийн депутат М.Энхсайхан нар хажуугийн саналыг эхэлж авч байхыг санал болгов.

16<sup>45</sup> цагт 8-р зүйлийг хэлэлцэж эхлэв. 309-р тойргийн депутат Д.Батбаяр, 184-р тойргийн депутат С.Биелгсайхан, 287-р тойргийн депутат Ч.Хурц, 326-р тойргийн депутат Ж.Гомбожав, 383-р тойргийн депутат Б.Гунцжалам нар уг хэлэв. 8-р зүйлийг зөвшөөрч 399/97% татгалзаж 8/2%, тудгалзаж 3/1% депутат санал өгөв.

16<sup>53</sup> цагт 9-р зүйлийг хэлэлцсэнд тодорхой санал гарсангүй. Уг зүйлийг дэмжих 393 /96%, татгалзаж 12/3%, тудгалзаж 3/1% депутат санал өгөв.

Үдээс хойшхи хуралдаан 16<sup>56</sup> цагт завсарлаад 17<sup>20</sup> цагт ургэлжлэв. Хуралдаанд 358 депутат ирсэн, ирц 84% байв.

17<sup>21</sup> цагт 10-р зүйлийг хэлэлцэж эхлэв. 368-р тойргийн депутат Н.Баасанжав, 169-р тойргийн депутат Б.Шагдар, 55-р тойргийн депутат Ц.Адъяасурэн, 231-р тойргийн депутат Г.Амарбаян, 427-р тойргийн депутат Ц.Элбэгдорж, 405-р тойргийн депутат Б.Лигдэн, II-р тойргийн депутат Ж.Бямба, 214-р тойргийн депутат Б.Доржсамбуу, 355-р тойргийн депутат Х.Баянмөнх, 215-р тойргийн депутат Ж.Чунаг сурэн, 8-р тойргийн депутат С.Ёндөнцоо, 163-р тойргийн депутат Б.Мижид, 188-р тойргийн депутат Б.Буяндалгэр, 164-р тойргийн депутат Ч.Гомбосурэн, 296-р тойргийн депутат Л.Батжаргал, III-р тойргийн депутат Г.Бадарч, 430-р тойргийн депутат Д.Тогооч, 191-р тойргийн депутат Б.Лханаасурэн, 224-р тойргийн депутат М.Гомбо сурэн, 288-р тойргийн депутат С.Баярцогт, 413-р тойргийн депутат Н.Насан-Очир, 266-р тойргийн депутат Д.Цэвэгдорж, 98-р тойргийн депутат Д.Марав, 389-р тойргийн депутат Н.Бат-Очир 399-р тойргийн депутат Д.Чилхаажав нар уг хэлэв. 346/97% депутат санал таслахыг дэмжив.

Шаардлагатай үед хураддааны хугацааг сунгахыг зөвшөөрч 303 /74%, татгалзаж 94/23%, түдгэлзэж 12 /3% депутат санал өгөв.

Намын гэдгийг хасахыг зөвшөөрч 279 /70%, татгалзаж 114/28% түдгэлзэж 8/2% депутат санал өгөв. 45-р тойргийн депутат М.Энхсайхан намын гэдгийг байлгах саналаа хэлэв. Дахин санал хураав. Намын бүлэг байна гэдгийг дэмжиж 236 /58%, татгалзаж 167 /41%, түдгэлзэж 6/1% депутат санал өгөв.

27-р тойргийн депутат Л.Пүрэвдорж, 288-р тойргийн депутат С.Баярцогт, 147-р тойргийн депутат Д.Баттулга, 71-р тойргийн депутат Т.Ядамсүрэн, 147-р тойргийн депутат Д.Баттулга нар уг хэлэв. Депутат Д.Баттулгын саналыг дэмжиж 329/83%, татгалзаж 52/13%, түдгэлзэж 15/4%, депутат санал өгөв. Ням гаригт амарна гэдгийг дэмжиж 341/82% татгалзаж 59/14%, түдгэлзэж 14/3% депутат санал өгөв. 414-р тойргийн депутат Н.Ганбямба саналаа хэлэв. Тодорхой асуудлаар завсарлага авахад цаг тогтооно гэж 318/77%, татгалзаж 87/21%, түдгэлзэж 6/1%, депутат санал өгөв. 163-р тойргийн депутат Б.Мижид уг хэлэв. Тухайн үед нь цагийг нь тогтооно гэж 338/82%, татгалзаж 69/17%, түдгэлзэж 5/1% депутат санал өгөв. 14-р тойргийн депутат С.Лхагвасүрэн, 327-р тойргийн депутат Ж.Гомбожав, 215-р тойргийн депутат Ж.Чунагсүрэн, 168-р тойргийн депутат Г.Вандаандагва нар уг хэлэв.

10-ийн 3-ийн 2-р өгүүлбэрийг хасъя гэж 374/91%, татгалзаж 32/8%, түдгэлзэж 3/1% депутат санал өгөв. 22-р тойргийн депутат Л.Дашням саналаа хэлэв. 2-р заалтын "а" хэсгийг байлгая гэж 397 /98%, татгалзаж 5/1%, түдгэлзэж 5/1% депутат санал өгөв. "Б" хэсгийг хасъя гэж 382 /95%, татгалзаж 14/3%, түдгэлзэж 6/1%, депутат санал өгөв.

"В" хэсгийг үлдээе гэж 399/97%, татгалзаж 9/2%, түдгэлзэж 4/1%, депутат санал өгөв. "Г" заалт 387/94%, депутатын саналаар хэвээр хоцров.

426-р тойргийн депутат Ж.Барамсай саналаа хэлэв. "е" заалт 363/89%, депутатын саналаар хэвээр хоцров. "ж" заалт 312/78%, депутатын саналаар хоцров. 288-р тойргийн депутат С.Баярцогт, Г.Зуунай нар саналаа хэлэв.

Ердийн олонхийн саналаар гэдгийг үлдээе гэж 331/83%, тат-

галзаж 56/14%, түдгэлзэж 13/3% санал өгөв.

2<sup>т</sup> заалт хэвээр үлдэв. 427-р тойргийн депутат Ц.Элбэгдорж цөөнх болж үг ханэв. 30-аас доошгүй хүний саналаар гэж оруулахыг санал болгов.

Энэ саналыг нээлттэй үлдээж хойшигуулав.

"ж" хэсгийг хасъя гэж 174/44%, татгалзаж 202/51%, түдгэлзэж 23/6% санал гарч хэвээр хоцров.

"з" заалтыг халэлцэв. Ц.Элбэгдорж саналаа хэлэв. Энэ редакцийг дэмжих 376 депутат санал өгөв.

9-р тойргийн депутат С.Зориг саналаа хэлэв. 132-р тойргийн депутат Ц.Нанзаддорж, 369-р тойргийн депутат Д.Пүрэвдорж, 18-р тойргийн депутат Г.Ганболд, 328-р тойргийн депутат Б.Дашэвэг, 1-р тойргийн депутат С.Баяр нар үг хэлж дахин санал хураах болов.

"з" заалтыг хэвээр үлдээе гэж 387 /97%, татгалзаж 13 /3% депутат санал өгөв. 317-р тойргийн депутат Д.Мандах санал хэлэв. 235-р тойргийн депутат Ц.Өлд, 326-р тойргийн депутат Ж.Гомбожав нар үг хэлэв.

"и" заалтыг хэвээр үлдээе гэж 326/80%, татгалзаж 75/18%, түдгэлзэж 8/2% депутат санал өгөв.

"к" заалтыг хасъя гэж 140/35%, татгалзаж 248/62% /, түдгэлзэж 10/3% депутат санал авч хэвээр үлдэв.

"л" заалтыг хэвээр үлдээе гэж 389/96%, татгалзаж 14/3%, түдгэлзэж 3/1%, депутат санал өгөв.

С.Баяр асуулт асуув.

"м" заалтыг үлдээе гэж 403/99%, татгалзаж 3/1%, түдгэлзэж 1/0% депутат санал өгөв.

Депутат Нанзаддорж саналаа хэлэв.

"н" заалтад Ерөнхийлөгч хэдийд ч үг хэлж болно гэж 367/90%, татгалзаж 37/9%, түдгэлзэж 6/1%, Дэд ерөнхийлөгч; зөвшөөрч 113 /28%, татгалзаж 280/69%, түдгэлзэж 11/3% санал өгөв.

II.

27-р тойргийн депутат Л.Пүрэвдорж, 9-р тойргийн депутат С.Зориг нар үг хэлж дахин санал хураав. Дэмжиж 106/26%, татгалзаж 283 /70%, түдгэлзэж 14/3% депутат санал өгөв. Ерөнхий сайдыг хэдийд ч үг хэлж болно гэж зөвшөөрч 129/32%, татгалзаж 266 /66%, түдгэлзэж 8/2% депутат санал өгөв.

52-р тойргийн депутат Э.Бат-Үүл, Ш.Цэндбаяр, 178-р тойргийн депутат Д.Энхбаатар, 41-р тойргийн депутат Н.Пүрэвдорж, 45-р тойргийн депутат М.Энхсайхан, 3-р тойргийн депутат Р.Барсболд, 428-р тойргийн депутат Д.Ганболд, 22-р тойргийн депутат Л.Дашнам, 10-р тойргийн депутат О.Дашбалбар, 429-р тойргийн депутат Д.Рэнцэннацааг, 85-р тойргийн депутат Х.Сайраан, 47-р тойргийн депутат С.Лхагвасүрэн, 52-р тойргийн депутат Э.Бат-Үүл, 288-р тойргийн депутат С.Баярцогт, 191-р тойргийн депутат Б.Лханаасүрэн, 45-р тойргийн депутат М.Энхсайхан, 25-р тойргийн депутат Л.Энэбиш, 132-р тойргийн депутат С.Чулувунбаатар, 283-р тойргийн депутат Ш.Шагдарсүрэн нар үг хэлэв.

Энэ заалтыг бүрмесен хасъя гэж 240/60%, 146/36% татгалзаж 16 /4% депутат түдгэлзэж санал өгөв. 306-р тойргийн депутат Н.Дэлгэрмөрөн, 15-р тойргийн депутат Д.Лүндаажанцан нар үг хэлэв. З-р заалтыг хэвээр үлдээе гэж 379/97%, татгалзаж 7/2%, түдгэлгэж 6/2% депутат санал өгөв.

Ардын Их Хурлын дарга, орлогч дарга нарыг чөлөөлсөн тогтоолыг хэлэлцүүлж батлуулав.

Оройн хуралдаанд депутат С.Баярцогт 10 мин, Ш.Сүрэнжав 20 мин, О.Дашбалбар 35 мин, Б.Баасанхүү 2 цаг тус тус хоцорч ирсэн болно.

Өнөөдрийн хуралдаан 19<sup>48</sup> цагт дуусав/Хуралдааны соронзон бичлэгийг хавсаргав/

ТАНИЛЦСАН:

ТЭМДЭГЛЭСЭН:

#  
Х.УРТНАСАН  
Г.ХҮРЭЛБААТАР

1991.XI.II

Кассет № 07

9.02-9.25

БНМАУ-ЫН АРДЫН ИХ ХУРЛЫН 12 ДАХЬ УДААГИЙН  
СОНГУУЛИЙН II ХУРАЛДААНЫГ НЭЭЖ АИХ-ЫН ДАРГА  
Ж.ГОМБОЖАВЫН ХЭЛСЭН ҮГ

БНМАУ-ЫН Ардын Их Хурлын анхдугаар хуралдаанаас хойш жил гаруй хугацаа өнгөрч байна. Өнгөрсөн хугацаанд Монголын ард түмний улс төр, нийгмийн амьдралд ихээхэн өөрчлөлтүүд гарлаа. Улс төрийн талаар харьцангуй тогтвортой ажиллалаа. Бидний улс орны болоод олон улсын байгууллагуудтай ажиллах ажиллагаанд ихээхэн ахиц өөрчлөлтүүд гарлаа. Манай орны эдийн засгийн амьдрал бидний урьд өмнө төсөөлж байснаас илүү хямралтай байдалд ороод байна. Өнгөрсөн хугацаанд шинэ Үндсэн хуулийн төсөл боловсруулж, ард түмнээрээ хэлэлцүүлж дунг нэгтгэн Ардын Их Хурлын депутат та бүхнээр хэлэлцүүлэх мөчид бид тулж ирээд байна. Шинэ үндсэн хуулийн төслийг хэлэлцэж батлана гэдэг бол манай ард түмнээс депутат та бидэнд олгосон хариуцлагатай бөгөөд нэр хүндтэй үүрэг мөн. Бид энэ нэр хүндтэй үүргийг амжилттай биелүүлэх ёстой. Хэрвээ бид энэ үүргээ амжилттай биелүүлж чадвал энэ хувь заяндаа бид баярлаж, бахархаж явах бүрэн эрхтэй юм. Бид асуудлыг эв зээ хичээж, ард түмнийхээ эрх ашгийн худнээс шийдвэрлэх учиртай. Нэг депутатын хэлж байгаа үг санааны цаанаа өдий төдий сонгогчдын санал, бодол байгаа гэдгийг бид бодолзох ёстой. Асуудлыг бид олонхийн саналаар л шийдвэрлэнэ. Гэхдээ цөөнхийн үгийг гүн хүндэтгэлтэй, хүлээцтэй сонсож, тал буреэс нь нягтлан хэлэлцэх нь зүйтэй юм. Эцсийн эцэст ард түмнийхээ эрх ашигт нийцсэн, дэлхийн улс орнуудын үндсэн хуулийн дэвшилттэй, ололтой бүхнийг тусгасан монгол хууль гаргахад оюун ухаанаа дайчлан ажиллах мөчид бид тулж ирээд байна.

Үндсэн хууль бол манай ард түмний депутат та бидний хамтын оюун ухааны бутээл мөн. Бид энэ цагаас эхлэн шинэ Үндсэн хууль бутээх түүхийг бутээлцэх их ажилд бие сэтгэлээрээ орж байна. Монгол улс ямар үндсэн хуультай болох нь вэ гэдгийг дэлхийн олон орны хумуус ч сонирхож харж байна.

Депутат нөхөд өө, энэ хуралдаанаараа Улсын бага хурал, Засгийн газар өнгөрсөн хугацаанд хэрхэн ажилласанд үнэлэлт дүгнэлт өгч, цаашид ажиллах чиг зүгийг тодорхойлох болно.

Ардын Их Хурлын хуралдаан явал амжилттай болох талаар мөн Ардын Их Хурлаас гарах шийдвэрийг аль болохоор оновчтой, мэргэн болгох талаар манай орны олон арван хөдөлмөрчид захидал, цахилгаан ируулэх, утсаар ярих, биеэр уулзах зэргээр үзэл бодлоо хуваалцаж байна.

Сургийн бэлчээрт малчид, суурь машины ард ажилчид, бичгийн ширээнийхээ дэргэд сэхээтнууд хэвлэл, радио, телевиз ашиглан бидний үйл ажиллагааг сонирхож, та бидний хэлэх уг, гаргах санал бурийг шүүн тунгааж байна. Нэг угээр хэлбэл төрийн ордны зүг Ардын Их Хурлын хуралдааны энэ танхим руу манай орны иргэд анхаарлаа хандуулаад байна. Бид АИХ-ын хуралдааны энэ өдругүйдэд ард түмэнтэйгээ хамт асуудлыг шийдвэрлэх болно. Манай ард түмэн энэ өдругүйдэд АИХ-ын хуралдаанд бие сэтгэлээрээ идэвхтэй оролцохос гадна өвлийн энэ хүнд хэцүү өдруүдэд хөдөлмөрийн өндөр идэвх гаргаж, сахилга, зохион байгуулалт сайтай ажиллана гэдэгт найдаж байна. Ингэж ажиллах нь АИХ-ын депутатуудад тав тухтай асуудлаа ярилцаж шийдвэрлэх өргөн бололцоо олгоно гэдгийг тэмдэглэж хэлье.

Депутат нөхөд өө, БНМАУ-ын Ардын Их Хурлын 12 дахь удаагийн сонгуулийн АИХ-ын II хуралдаанд АИХ-ын депутат 427 ирэхээс 420 депутат хүрэлцэн ирсэн байна. Депутат нөхөр Г.Чингэл, Охинтогтох, Самилзоров, Батмэнх нар өвчтэй, депутат нөхөр Лантав, Сурэнжаргал, Самат нар гадаадад ажлаар явж байна. Ингээд хуралдааны ирц 98,4 хувьтай байгаа учраас БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан журмыг үндэслэн АИХ-ын II хуралдааны ажиллагаа нээснийг мэдэгдье.

Депутат нөхөд өө, АИХ-ын анхдугаар хуралдаанаас хойш АИХ-ын 102 дугаар тойргийн депутат Чойсурэнгийн Батболд, 278 дугаар тойргийн депутат Мажигсурэнгийн Бат-Өлзий, 362 дугаар тойргийн депутат Авирамэдийн Чойжил, 375 дугаар тойргийн депутат Дамдинсурэнгийн Буянцэлгэр нар ертөнцийн мөнх бусыг үзүүлж таалал төгслөө. АИХ-ын депутат байсан дээр нэр дурдсан нөхдийн гэгээн дурсгалыг нэг минут босч хүндэтгэе.

Одоо БНМАУ-ын Ардын Их Хурлын зарим депутатын бүрэн эрхийн тухай илтгэлийг БНМАУ-ын Ардын Их Хурлын депутатын бүрэн эрхийн асуудал эрхлэх байнгын комиссын дарга, 46 дугаар тойргийн депутат нөхөр Юлтийн Жаргал тавина.

Хундэт депутатууд аа!

БНМАУ-ын Ардын Их Хурлын 12 дахь удаагийн сонгуулийн анхдугаар хуралдаанаас хойш жил гаруй хугацаа өнгөрлөө. Монголын ард түмэн улс төр, эдийн засгийн хуучин тогтолцоог эрс шинэчилж, эрх чөлөө, ардчиллыг хөгжүүлэх, зах зээлийн эдийн засгийн хариулсаанд шилжих зорилтыг шийдвэрлэхээр чармайн ажиллаж байна. Нийтмийн амьдралыг букий л чиглэлээр нь ардчилах үйлсэд ахиц дэвшил хийж байгаа боловч эдийн засгийн амьдралд багагүй бэрхшээл гарч, ээдрээ бэрхшээлтэй замыг туулж байна. Ард олныхоо итгэл хундэтгэлийг хулээсэн депутат та нехэд сонгогч олон түмнийхээ эрх алгийг хамгаалж, захиасыг нь төр, засгийнхаа бодлого шийдвэрт тусган хэрэгжүүлэхэд бух үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж ирлээ. Давхардсан тоогоор депутатууд хуулиудыг боловсруулах, явцад мянга гаруй санал ёгч, сонгогчидтойгоо тогтмол уулзалт хийж, есөн зуу гаруй санал хүсэлтийг төр, засгийн удирдлага, яам, тусгай газар, байгууллагуудад хандаж тавьсны 620 гаруй нь шийдвэрлэгдэж, зохих хариу ёгөгдсөн байна.

Ардын Их Хурлын анхдугаар хуралдаанаас хойш АИХ-ын 6 тойрогт дахин сонгууль, 9 тойрогт нехэн сонгууль явагдсаныг тус байнгын комисс бүрэн эрхийнхээ дагуу сонгуулийн бүх материалыг хянан узэхэд сонгууль хуулийн дагуу зохион байгуулагдан явагдаж, АИХ-д сонгогч олон түмний итгэл хундэтгэл хулээсэн тэргүүнийхээ хумуусийг депутатараар сонгожээ.

БНМАУ-ын Ардын Их Хурлын 15 тойрогт явагдсан дахин ба нехэн сонгуулиар сонгогдсон нэр бүхий 15 депутатын бүрэн эрхийг зөвшөөрүүлэхээр тус хуралдаанд санал оруулж байна.

БНМАУ-ын Ардын Их Хурлын 5 дугаар тойргийн депутат Даваадоржийн Ганболд БНМАУ-ын Засгийн газрын тэргүүн шадар сайл, 41 дүгээр тойргийн депутат Д.Дорлигжав БНМАУ-ын Засгийн газрын шадар сайдаар, 169 дүгээр тойргийн депутат Ш.Хадамбаа БНМАУ-ын Батлан хамгаалахын сайдаар тус тус тохoon томилогдсон байна.

БНМАУ-ын дэпутатын тухай хуулийн 9 дүгээр зүйл БНМАУ-ын АИХ-ын дэпутатуудын сонгуулийн тухай хуулийн 3 дугаар зүйлийг хундэслэн Д.Ганболд, Д.Дорлигжав, Ш.Хадамбаа нарын депутатын бүрэн

эрхийг дуусгавар болгох саналыг тус хуралдаанд оруулж байна. АИХ-ын 330 дугаар тойргийн депутат Зоригтбаатар биеийн эруул мэндийн байдлын улмаас ажил өөрчлөгдэн өөр газар шилжин суух болсон тул тойргийн сонгогчиддоо тайлагнаж, депутатынхаа ургийг цаашид биелгүүлэх боломжгүй учир депутатын ургээс чөлөөлж өгөхийг хүсч өргөдлөө өгснийг тус комисс хянан хэлэлцээд депутатын ургээс чөлөөлех саналыг тус хуралдаанд оруулж байна. АИХ-ын 19 дүгээр тойргийн депутат Д.Дамдин сонгогчдынхоо итгэлийг алдаж депутатын нэр төрд харш үйл ажиллагаа явуулсныг сонгогч олон түмэн авч хэлэлцээд БНМАУ-ын АИХ-ын депутатын огцруулах журмын тухай хуулийн дагуу санал хураалт явуулж, уүнийг БНМАУ-ын АИХ-ын депутататаас огцруулсан байна. Ингэснээр БНМАУ-ын депутатын тухай хуулийн 10 дугаар зүйлийн дагуу Д.Дамдингийн АИХ-ын депутатын бүрэн өрх дуусгавар болсон тул АИХ-аас Д.Дамдингийн бүрэн өрхийг хүлээн зөвшөөрч гаргасан түрүүчийн шийдвэрээ цуцлах саналыг оруулж байна. Булган аймгийн Тэшиг сумын АИХ-ын 119 дүгээр тойрот сонгууль будлиантай явагдсан тухай шалгаж өгөхийг хүссэн зарим сонгогчдын санал хүсэлтийн дагуу тус байнтын комисс аймгийн прокурортой хамтарч шалгаж үзэхэд Энтий хэмээх газарт отроор явсан 12 сонгогчийн саналыг 1990 оны 7 дугаар сарын 28-нд буюу сонгуулийн урьд өдөр илээр цаасан уутанд авч сонгуулийн хуулийн 32,35 дугаар зүйлийг зөрчсөн нь шалгалтаар тогтоогдсон байна. Иймд тус тойрот явагдсан сонгууль будлиантай болж, сонгуулийн хууль зөрчсөн учир АИХ-ын депутататаар сонгогдсон Дамдинсүрэнгийн Цээн-Ойдовын бүрэн өрхийг тудгэлэүүлэх саналыг тус хуралдаанд оруулж байна. Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын АИХ-ын 79 дүгээр тойрот дахин сонгууль явагдсан боловч депутататаар нэр дэвшигчдийн хэн нь ч олонхийн санал аваагүйгээс одоо болтол депутататаа сонгож чадаагүй байна.

БНМАУ-ын Ардын Их Хурлын депутатын 84,3 хувь буюу 360 нь МАХН-ын, 3,9 хувь буюу 17 нь МоАН-ын, 1,2 хувь буюу 5 нь МУДН-ын, 1,2 хувь буюу 5 нь МСДН-ын гишүүд байна. ЧХН-ын гишүүн 1 байна. Намын гишүүн бус 39 депутат байна. Сонгогдсон бух депутатуудын 89,7 хувь нь буюу 383 нь дээд, 19 буюу 4,5 хувь нь тусгай дунд мэргэжлийн, 25 буюу 5,8 хувь нь ерөнхий боловсролын бүрэн ба бүрэн бус дунд боловсролтой хумуусууд байна.

## 5.

АИХ-ын депутатын 80,5 хувь буюу 344 нь анх удаа БНМАУ-ын АИХ-ын депутатараар сонгогдож байгаа хүмүүсүүд байна.

Депутатуудын мөрийн хөтөлбөрийн биелэлтэнд хийсэн судалгаанаас үзэхэд эдийн засаг, нийгмийн талаар тусгагдсан асуудлууд энэ чиглэлээр сонгогчдоос тавьсан эрэлт хүсэлтийг хэрэгжүүлэхэд багагүй бэрхшээл тохиолдож байна. Депутатуудаас хөдөлмөрөө хэрэгжүүлэх, сонгогч олон түмнийхээ эрэлт хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэхэд тухайн орон нутгийн хурал, түүний гүйцэтгэх захиргаад, яам, тусгай газруудын бодит туслалцаа, дэмжлэг ихээхэн угуй-лэгдэж байгааг зориуд тэмдэглэж байна.

Терийн байгуулалтын одоогийн тогтолцооны нөхцөлд АИХ-ын депутат, байнгын комисс, депутатуудын хэсэг, булгүүдээс хуралдааны чөлөөт цагт бүрэн эрхээ хэрэгжүүлэх ажиллагааг эрх зүйн актаар зохицуулах шаардлагатай байгааг харгалзан АИХ-ын ажлын зохион байгуулалтын дурмийн төслийг тус байнгын комисс хөдөлмөр хүн ам, эрх зүйн байнгын комисстой хамтран боловсруулж, та нөхдүүдэд тараасныг хянан үзэж шийдвэрлэж өгөхийг энэ далимд хүсч байна.

Ингээд АИХ-ын тогтоолын төслийг уншиж хэлэлцүүлье.

Гомбожав- Жаргал даргаа, илтгэл чинь дуусав уу.

Жаргал- Илтгэл дууслаа.

Гомбожав- Илтгэлээс асуух зүйл байна уу? Байхгүй юу.  
Байхгүй.

Гомбожав- Тэгвэл өхлээд чөлөөлөх юнаасаа өхэл.

Жаргал- БНМАУ-ын Ардын Их Хурлын тогтоол.

Ардын Их Хурлын депутатын бүрэн эрхийг дуусгавар болсонд тооцох тухай.

БНМАУ-ын депутатуудын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, БНМАУ-ын АИХ-ын депутатуудын сонгуулийн хуулийн З дугаар зүйлийн I дэх хэсгийн заалтыг үндэслэн БНМАУ-ын Ардын Их Хурлаас ТОГТООХ НЬ:

БНМАУ-ын Ардын Их Хурлын 5 дугаар тойргийн депутат Д.Ганболд БНМАУ-ын Засгийн газрын тэргүүн шадар сайдаар,

41 дүгээр тойргийн депутат Д.Дорлигжав БНМАУ-ын Засгийн газрын шадар сайдаар, 169 дүгээр тойргийн депутат Ш.Жадамбаа БНМАУ-ын Батлан хамгаалахын сайдаар тохоон томилогдож уурэгт ажилдаа орсон тул Даваадоржийн Ганболд, Дамбийн Дорлигжав, Шагалын Жадамбаа нарын БНМАУ-ын Ардын Их Хурлын депутатын бүрэн эрхийг дуусгавар болсонд тооцсугай.

Гомбожав- Энэ тогтоолын төсөл дээр өөр саналтай депутатууд байна уу?

Гомбожав- Байхгүй бол тогтоолыг баталъя гэсэн саналтай депутатууд гараа өргөнө уу.

Гомбожав- За болно.

Гомбожав- Татгалзсан депутат байна уу? Байхгүй байна.

Гомбожав- Түдгэлзсэн депутат байна уу? Байхгүй байна.

Гомбожав- Уг тогтоолыг санал нэгтэй баталлаа.

Харгал- БНМАУ-ын Ардын Их Хурлын тогтоол.

Ардын Их Хурлын депутатын уургээс чөлөөлөх тухай.

БНМАУ-ын Ардын Их Хурлын депутатуудын бүрэн эрхийн асуудал эрхлэх байнгын комиссын илтгэлийг хэлэлцээд БНМАУ-ын депутатуудын тухай хуулийн 9 дүгээр зүйлийг үндэслэн БНМАУ-ын Ардын Их Хурлаас ТОГТООХ НЬ:

Нацагдоржийн Зоригтбаатарыг БНМАУ-ын Ардын Их Хурлын депутатын уургээс чөлөөлсүгэй.

Гомбожав- Энэ тогтоолын төсөл дээр өөр саналтай депутат байна уу?

Гомбожав- Байхгүй бол батлая гэсэн саналтай депутат гараа өргөнө уу!

Гомбожав- За болно.

Татгалзсан депутат байна уу? Байхгүй байна.

Түдгэлзсэн депутат байна уу? Байхгүй байна.

Гомбожав- Тогтоолыг санал нэгтэй баталлаа.

Харгал- БНМАУ-ын Ардын Их Хурлын тогтоол.

Ардын Их Хурлын депутатын бүрэн эрхийг зөвшөөрснийг хүчингүй болсонд тооцох тухай.

БНМАУ-ын Ардын Их Хурлын депутатуудын бүрэн эрхийн асуудал эрхлэх байнгын комиссын илтгэлийг хэлэлцээд БНМАУ-ын Ардын Их

## Хурлаас ТОГТООХ НЬ:

БНМАУ-ын Ардын Их Хурлын 1990 оны 9 дүгээр сарын 3-ны өдрийн Депутатуудын бүрэн эрхийг зөвшөөрөх тухай З дугаар тогтоолоор БНМАУ-ын Ардын Их Хурлын 12 дахь удаагийн сонгуулийн 5 дугаар тойрот АИХ-ын депутататаар сонгогдсон Даваадоржийн Ганболд, 41 дүгээр тойрот сонгогдсон Дамбийн Дорлигжав, 169 дүгээр тойрот сонгогдсон Шагалын Жадамбаа, 19 дүгээр тойрот АИХ-ын депутататаар сонгогдсон Дэнсмаагийн Дамдин нарын АИХ-ын депутатын бүрэн эрхийг хулээн зөвшөөрснийг хүчингүй болсонд тооцсугай.

Гомбожав- Энэ тогтоолын төсөл дээр өөр саналтай депутат байна уу?

Б.Чимил- Дамдингийн бүрэн эрхийг чөлөөлсөн тогтоолыг хүчингүй болгож байгаа чинь түрүүн бүрэн эрхийг

/бичлэг сонсогдоогүй/

Гомбожав- Түрүүн зөвшөөрсөн тогтоолоо л хүчингүй болгож байна л даа.

/бичлэг сонсогдоогүй/

Гомбожав- Тэрнээс цааш дутагдал гаргасан байхгүй юу.

/бичлэг сонсогдоогүй/

Гомбожав- Огцруулсан тогтоол уншсан шүү дээ.

Жаргал- Депутатуудын тухай хууль, АИХ-ын депутатуудын сонгуулийн тухай хуулинд депутатыг сонгогч олон түмнээр хэлэлцүүлж огцруулна гэсэн журмын дагуу хэлэлцээд сонгогч олны 81,8 хувийн саналаар Дамдинг огцруулсан. Ийм учраас Дамдингийн бүрэн эрхийг зөвшөөрсөн анхдугаар хуралдааны тогтоолын тэр хэсгийг бид хүчингүй болгох нь зүйтэй юмаа гэж санал оруулж сая тогтоолын төсөл уншиж байгаа юм.

Гомбожав- Өөр саналтай депутат байна уу?

Гомбожав- Байхгүй бол энэ тогтоолыг батлав гэсэн саналтай дөпүтатууд

/бичлэг сонсогдоогүй/

Б.Чимил- Өөрөө гараад огцроод дуусгавар болчихсон зүйл шүү дээ.

Нас барсан тухайд хүчингүй болгосугай гэж хэлдэггүй шүү дээ.

Тийм учраас Пүрэвдоржийн хэлж байгаа бол үндэстэй. Сонгогчид огцруулчихсан байна. Тэгээд нэхэн сонгууль явуулчихсан байгаа.

шүү дээ оронд нь. Шаардлагатай бол дуусгавар болсныг хүлээн зөвшиөрөх л юм хэрэгтэй байна. Тэрийэс биш Их Хурлын тогтоол буруу гарчээ гэсэн утгатай юм болчихоод байна шүү дээ.

Гомбожав- Их Хурлын тогтоол буруу гарчээ гэж хэлээгүй байна шүү дээ.  
Түрүүчийн. /бичлэг сонсогдоогүй/

Б. Чимил- тогтоолыг хүчингүй болгочих дээр зэрэг 10 жилийн дараа харах дээр зэрэг тэр тогтоол хүчингүй болчихсон байна гэж. Тэр тогтоол гараад үүрэг гүйцэтгэж байсан улсууд чинь хууль бус байсан байна аа гэсэн утгатай юм болчихно шүү дээ.

Гомбожав- Тэгэхээр Дамдинг энэ тогтоолын заалтаас хасъя гэж байгаа юм уу

Б. Чимил- Дуусгавар болсонд л тооцохоос тогтоолоо хүчингүй болгож хэрэггүй юм л даа. Тиймийн учир депутатад байхад харшлах нийцэхгүй ажилд гэдэг юмуу тийм ажилд томилогдсон тул сонгогчид нь огцруулсан тул /бичлэг сонсогдоогүй/

Гомбожав- Тэгвэл энэ тогтоолыг өрөөсөө хэрэггүй гэж үзэж байгаа юмуу?  
Түрүүн бид дуусгавар болгосон тогтоолоо баталчихсан шүү дээ.

Б. Чимил- Дахиад нэгийг гаргачихгүй ку?

Гомбожав- Түрүүнийхээрээ болох юм байна. Нэгэнт түрүүн бид анх баталсан тогтоол дээрээ саяын 3 хунийг Дамдингаас бусад нь дуусгавар болсон тогтоол гарчихсан л даа. Тэгэхээр бас тэгэж ойлгох болох л юм байна. Заавал давхар тогтоол гарахгүйгээр. Тэгэж тохирох уу.

СОРОНЗОН ХАЛЬСТАЙ ТУЛГАЖ  
НИЙЛСЭН эб ажилж — /д. БАЯНДҮҮРЭН/  
БИЧЭЭЧ /д. ЭНЭБИШ/

1991.XI.XI

Кассет № 08

9.25-9-45

Жаргал: БНМАУ-ЫН АРДЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

Ардын Их Хурлын депутатуудын  
бүрэн эрхийг хулээн зөвшөөрөх  
тухай

БНМАУ-ЫН Ардын Их Хурлын депутатуудын бүрэн эрхийн асуудал эрхлэх байнгын комиссын илтгэлийг хэлэлцээд БНМАУ-ЫН Ардын Их Хурлаас ТӨГТООХ нь:

БНМАУ-ЫН Ардын Их Хурлын 12 дахь удаагийн сонгуулийн 5, 8, 19, 36, 41, 147, 151, 169, 278, 289, 330, 351, 353, 358, 378 дутаар тойрот АРДЫН ИХ ХУРЛЫН ДЕПУТААР СОНГОГДСОН НАЦАГИЙН ГАРАВСҮРЭН, СОДОВДАЛАЙН ЕНДОНЦОО, БАТ-ОЧИРЫН БАТ-САЙХАН, РЭНЦЭНХОРЛООГИЙН ЕНДОНДЭМБЭРЭЛ, НЭМЭХИЙН ЦУРЭВДОРЖ, ДУВСАНДАГВЫН АМАРСАНАА, БАТ-ӨЛЗИЙН АЛГАА, БАДАМЫН ШАГДАР, ДОРЖИЙН МЮОНДОЙ, ГУРРАГЧААГИЙН НОРОВРАГЧАА, САНДАГИЙН ГОНЧИГ, БУЯНТЫН МӨНГӨН, БАЛЖИНГИЙН ШИНЭН, БАДАМЫН ЖАНЦАНСАМБУУ, ДОРЖГОТОВЫН БАЯНДАЛАЙ НАРЫН БНМАУ-ЫН Ардын Их Хурлын депутатын бүрэн эрхийг хулээн зөвшөөрсүгэй.

Гомбожав:

Сая Жаргал дарга сүүлийн тойргийг буруу хэлчих шиг боллоо. 378 гээд хэлчих шиг боллоо. 375.

Энэ тогтоолын төсөл дээр өөр саналтай депутат байна уу. Байхгүй бол энэ тогтоолыг батлава гэсэн саналтай депутатууд гараа өрге.

За болно. Татгалзсан депутат байна уу?  
Байхгүй байна.

Түдгэлзсэн депутат байна уу? Байхгүй байна.

Санал нэгтэй энэ тогтоолыг баталлаа.

Жаргал:

БНМАУ-ЫН Ардын Их Хурлын тогтоол

Ардын Их Хурлын депутатын бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай

БНМАУ-ЫН Ардын Их Хурлын депутатуудын бүрэн эрхийн

## 2.

асуудал эрхлэх байнгын комиссын илтгэлийг хэлэлцээд БНМАУ-ын Ардын Их Хурлаас ТОГТООХ нь:

БНМАУ-ын Ардын Их Хурлын I2 дахь удаагийн сонгуулийн II9 дүгээр тойрот явагдсан сонгуульд БНМАУ-ын Ардын Хурлын депутатуудын сонгуулийн хуулийг зөрчсөн тул тус тойрот депутат татаар сонгогдсон Дамдинсүрэнгийн Цээн-ойдовын БНМАУ-ын Ардын Их Хурлын депутатын бүрэн эрхийг түдгэлзүүлсүгэй.

Энэ тогтоол дээр өөр саналтай депутат байна уу?

Байхгүй юу.

Тойргийнхoo нэр, тойргийнхoo дугаар нэрийг хэлээд микрофон дээрээс та ярь.

I20 лугаар тойргийн депутат Отгон: II9 дүгээр тойргийн сонгуулийн дүрэм зөрчигдсөн, тэр талаар нь акт, шалгасан улсуудын мэдээллийг сонсмоор байна.

Харгал: Ардын Их Хурлын II9 дүгээр тойрог дээр хийсэн шалгалтыг өр нь II9 дүгээр тойрот сонгууль будлиантай боллоо гэдгийг сонгогчдоос гурван удаа асуудал гаргаж ирж тавьсан. Ардын Их Хурлын даргын нэр дээр сонгууль явагдаж байх үед хоёр удаа мэдээлэл ирсэн. Энийг орон нутгийн сонгуулийн комисс, аймгийн орон нутгийн сонгуулийн комиссыг газар дээр нь танай дээр сонгууль будлиантай байна гэдгийг анхаарч зориуд сонгуулийг будлиангүйгээр зохион байгуулах зохион байгуулалтын арга хэмжээ ав гэж хоёр удаа үүрэг өгчээ. За энэний дараагаар сонгууль явагдсан. Сонгууль явагдаад сонгуулийн дун гарсны дараагаар Ардын Их Хурлын бүрэн эрхийн байнгын комисст сонгууль будлиантай болсон энэ дээр тодорхой арга хэмжээ авагдсангүй. Энийг дахин шалгаж үзэж, зөв шийдвэрийг гаргаж өгөөчээ гэж хүсэлт иргүүлсний дагуу манай байнгын комисс, Булган аймгийн Ардын Хурлын тэргүүлэгчид, аймгийн прокурор газар нутгийн чиглэлээр шалга гэсний дагуу аймгийн прокурор шалгаж үзсэн. Ингэж шалгаж үзэхэд тургун хэлсэн оторчид Энтэй гэдэг газарт I6 өрхийн I2 сонгогчийн саналыг авахдаа алслагдсан га-

зар байгаа гэдгийг нь далимдуулж 7 дугаар сарын 28-ны өдөр, сонгуулийн урд өдөр хүмүүсийн саналыг авахдаа шууд хуудас тарааж өгөөд илээр аваад хэн нь хэний төлөө өгч байна вэ гэдгийг сонгуулийн сонгогчийн эрхийг нууцлах эрхийг нэгдүгээрт зөрчсөн, хоёрдугаарт сонгуулийн сонгогчийн саналыг битүүмжлэгдсэн, нууцлагдсан хайрцганц авах байтал энийг ил задгайгаар шууд конвертанд саналыг авсан, гуравдугаарт сонгуулийн хуульд 7 дугаар сарын 29-ний өглөөний 7.00-оос шенийн 22 цагийн хооронд сонгуулийн ажиллагаа явуулах байтал 7 дугаар сарын 28-нд урд өдөр нь очиж сонгууль авсан байгаа юм. Энэ учраас үнэхээр хууль зөрчигдэж, сонгуулийн хууль зөрчигдсөн үү гэвэл зөрчигджээ. Ийм учраас бид энийг будлиантай болсон байна гэдгийг тогтоож саяны асуудлыг фуулж байгаа юм. Үнээс бусад жижиг, сажиг, аахар шаахар юмнууд бий. Бид тэрийг төдийлэн зөрчил гэж авч үзээгүй байгаа юм. Сонгогдсон депутатын үйл ажиллагаатай холбогдсон ямар нэгэн санал гомдол гараагүй. Бид зөвхөн сонгуулийн хууль зөрчигдсөнд нь тойргоос сонгогдсон депутатын бүрэн эрхийг тудгэлзүүлж байгаа юм.

Лхагвасүрэн. I09 дүгээр тойрог. Хоёр асуулт байна. Нэгдүгээрт тэр I2 сонгогчийн саналыг нийт дунгээс нь хасч үзэхэд ямар дунтэй байгаа юм болоо. Хоёрдугаарт тэр дутгуйн санал авах ажил бол нэлээд дээхэн эхэлж байсан. Нутаг дэвсгэрийн комиссоор тодорхой ажил байдлын нь онцлогоос, шилжих хөдөлгөөний улмаас ч юмуу саналыг дутгуйнд битүүмжилж авч тооцож байсан ийм явдал бий байх. Энийг хэрхэн үзэв ээ.

Харгал:

Тэгэхлээр II9 дүгээр тойрог дээр I496 сонгогч саналаа өгсөн. I496 сонгогчоос I0 саналын хуудас хүчингүй болсон. I486 сонгогчийн 754 нь Цээн-ойдовын төлөө, 727 нь Болдбаатарын төлөө санал өгсөн. Цээн-ойдов 50,4 хувиар санал өгсөн сонгогчдын 50,4 хувийг, Болдбаатар 48,9 хувийн санал авчээ. Энтий дээр болсон I2 хүн бол нэгэнт саналыг нь илээр авсан учраас I2-уулаа Цээн-ойдовын төлөө санал өгсөн байгаа юм. Энэ I2 хүнийг сонгуулийн хуудсыг хүчингүйд тооцож юм бол Цээн-ойдов 49,6 хувийн санал авч мөн олонхийн саналдаа хүрэхгүй болж байгаа юм. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, сонгуулийн саналыг битүүмжилнэ гэдэг бол I2 сонгогч I2-уулаа саналынхаа хуудсыг аваад нууц байдалд өөрснийхөө саналыг өөрөө битүүмжлээд ингээд өгсөн болбол энэ сонгуулийн дүрэм журамд тохирох ёстой. Гэтэл тэгээгүй саналыги лээр аваад бүгдээрэнг нь нийлүүлээд нэг конвертонд хийгээд явсан учраас сонгуулийн саналын нууц байдал энэ дээр хуулийн эсрэг үйл ажиллагаа явагдсан нь нотлогдсон.

406 дугаар тойргийн депутат Тэрбиш: Түдгэлзүүлсэн  
 тогтоол дээр зарим депутатын нэр нэмэгдмээр юм шиг санагдаад байх юм. Урд энэ сонин хэвлэлээр Бат-үүлийг хүн зодсон гэж гарсан, Зоригийг төрийн ордны цонхоор шээсэн гэж гарсан. Хэрвээ энэ нь батлагдаагүй худлаа мэдээлэл юм бол депутатын эрхэнд халдсан тэр хэвлэл мэдээллийн ажилтнуудад эсэргүүцлийг их хурлаас өгсөн ч болохгүй юм байхгүй. Хэрвээ шалгагдаж байгаа үнэн болох нь үндэстэй юм бол энэ депутатын бүрэн эрхэнд түдгэлзээд шалгалтын дун гартал ххлээх ёстой гэж бодогдож байна.

Жаргал:

Депутат Бат-үүлтэй холбогдсон асуудлыг Цагдаагийн ерөнхий газрын мөрдөн байцаах газраас Бат-үүлийг яллагдагчаар татах тухай асуудлыг манай байнгын комисст оруулж ирсэн. Бид энэ асуудлыг нэлээд нухацтай авч ярилцсан. Энэ дээр дахин нэгэнт бид төрийн төлөөлөгчийн эрх зүйн асуудлыг хөндөж байгаа учраас депутат Бат-үүлийг удаа дараа хулгай хийсэн, айл ухсан гэдэг энэ асуудлаар Н.Зоригтбаатар байнгын тийм шантаж хийж байсан явдал бол байгаа. Ийм учраас бид депутатын эрх зүйн дагуу, хуулийн дагуу тэдгээр зүйлүүдийг дахин тодруулж оруулж ирээчээ гэсэн асуудал яригдаад Цагдаагийн газрын нөхцүүд энийг хянаж оруулж ирэхээр тохироод түр хойшлогдоод байж байгаа.

Депутат Зоригийн тухай сонин хэвлэл дээр ийм мэдээлэл гарсан. Депутат Зоригийн тойргийн сонгогчдоос Зоригийн үйл ажиллагаатай холбогдуулж депутатын эрх зүйг хөндөх тухай асуудлыг тойргийн сонгогчдоос тавиагүй, хөдөлмөрчдөөс бидэнд энэ чиглэлээр албан ёсоор ийм асуудал тавиагүй. Депутат Зоригч өөрийн нэр

## 5.

тертэй холбогдсон асуудлыг манай комисст хянаж өгөөчээ гэдэг ийм асуудал тавиагүй учраас бид үүнийг авч үзээгүй.

Депутат Лашням:

Надад ийм санал байна. Депутат нөхөр Цээн-ойдов одоо бидний дунд сууж байгаа. Цээн-ойдов бол түргүний хуралдаанаар бид нар эрхийг нь баталсан манай нэг ажлын үр дүн энд байгаа гэж ойлгож байна. Тэгэхээр Цээн-ойдовыг түдгэлзүүлнэ гэдэг бол их хурал өөрийнхөө ажилд эргэж хандаж байгаа нэг хандлага. Нөгөө талаар депутат хүн ийм байдалд орчихоод өөртөө ёс суртахууны ямар дүгнэлт хийж байгааг Цээн-ойдовоос өөрөөс нь асуумаар байна. Яагаад гэвэл энэ зарчмын асуудал.

Жаргал:

Уучлаарай депутатуудаа. Зоригийг Зоригтбаатар гээд хэлчих-сэн юм байна.

С.Чуллуунбаатар:

Тэр хүн чинь өөрөө ямар ч буруугүй шүү дээ. Тэрийг энд шүүгээд яах юм бэ.

Гомбожав:

За тэгвэл ярих шаардлагагүй гэж үзэх үү. Ихэнх нь ярих шаардлагагүй гэж үзэж байна.

123 дугаар тойргийн депутат

Линаажав: Цээн-ойдовтой

өөртэй нь холбогдолгуй тэр сонгуулийг зохион байгуулж байсан хүмүүсийн ажлын хариуцлагатай холбогдолтой асуудал юм. Нэгдүгээрт.

Негөө талаар улс орны ирээдүйг шийдэх энэ чухал асуудал, Үндсэн хууль хэлэлцэх гэж байгаа энэ үед депутататаас нь түдгэлзүүлнэ гэдэг бол тэр тойргийн сонгогчдын энэ асуудалд оролзоход нь зохих хэмжээгээр саад болж байна гэж би ойлгож байна. Өчигдөр бид орон нутгийн нутаг дэвсгэрийн бүлэг энэ тухай ярилцаад ер нь энэ асуудлыг цаашид тодотгох шаардлагагай. Тэгж байж хэлэлцуулжээр хойшлуулбал ясан юм бэ гэсэн синалтай байгаа. Ер нь байдлыг ажих юм бол энэ шалгалт зарим талаар хуудан болсон хувийн чанартай ч асуудал байгаа болов уу гэх шиг ийм байдалтай байгаа. Ийм учраас энийг депутатууд бас тунгааж ойлгох болов уу гэж бодож байна.

Хуудан болсон болов уу гэдэг юу гэвэл Энтий бол хол газар тойрч явдаг газар нутгийг нь бид мэднэ. Тэр үеэр бороо, шороо ихтэй байдал. Урьдчилан авах нь авсан байна. Гэхдээ тэрэнд хажууд нь хяналт шалгалтын улсууд цуг явсан байгаа. Монголын ардчилсан холбооноос одоо тавигдсан хяналт шалгалтынхан хуртэл цуг явсан. Гэтэл яагаад ийм байдал гарсан бэ гэдэг ойлгомжгүй санагдаж байгаа.

За өөр энэ асуудлаар асуух хүн байна уу, ярих хүн байна уу.

429 дүгээр тойргийн депутат Рэнцэннапаг. Саяны энэ депутат Динаажавын саналыг дэмжиж байгаа юм. Ерөөсөө сонгууль явуулахад депутат Цээн-ойдовын өөрийн буруу алга байна шуу дээ. Тэр хэдэн хуудсыг нэг дугтуйнд хийж явсан тэр хариуцлагагүй хүмүүсийг хариуцлагад татмаар санагдаж байна. Хоёрдугаарт энэ депутатын эрхийн асуудлыг хөндөж байхад яагаад манай их хурлаас газар дээр нь хүн оролцож шалгалгүй аймгийн прокурор явуулаад ингэж байгаа юм бэ. Тийм учраас энэ Цээн-ойдовыг энэ депутатын эрхийг өдлүүлж энэ ажиллагаанд оролцуулах нь зүйтэй гэсэн ийм санал оруулж байна.

#### Даргал:

Манай байнгын комиссоос зориуд энэ асуудлыг газар дээр нь шалгасан. Түүнээс ганцхан аймгийн прокурорын шалгасан дунгээр ярьж байгаа юм биш. Би түрүүн хэлсэн. Манай байнгын комиссоос бид зориуд манай байнгын комиссын орлогч дарга депутат Энэбиш өөрөө газар дээр нь очиж шалгаж тогтоогоод ирсэн юм. Тэгээд бид энэ асуудлыг хэлэлцсэний үндсэн дээр өнеөдөр их хуралд оруулж байгаа юм.

Динаажав: Депутатын хуулийн асуудлыг баримталж байна гэж байна. Ер нь амьдрал практик дээр зөрж байгаа юм хаана хаанаа их л байна шуу дээ. Үүнийг харж үзэх хэрэгтэй байх аа.

119 дүгээр тойргийн депутат Цээн-ойлов. Энэ асуудал бол бол хувийн шинж чанартай, хувийн тооцоо хийсэн ийм шинж чанартай гарч ирсэн асуудал байгаа юм. Шалгалтыг болбол аймгийн туслах прокурор Хадбаатар гэдэг хүн голчлон хийсэн. Гол үүрэг гүйцэтгэхэд оролцсон. Ингээд Хадбаатар гэдэг прокурор ямар хүн байв

гэдгийг сонирхоход хувийн тооцоо хийж мэдээлэл ирүүлсэн хүмүүсийн ах дүү, садан төрлийн хүн юмуу, дотнын найз нөхөр юмуу, ямар ч байсан тэнд байхдаа тэднийхээр байрлаж, орж гарсан ингэж байсан хүн юм. Ийм учраас жинхэнэ газар дээр нь хийсэн шалгалтыг депутатын хувьд дахин шалгаж өгөөч гэсэн хүсэлттэй байгаа юм.

Хоёрдугаарт байнгын комиссоос очиж үзсэн. Гэхдээ Энэбиш дарга очсон. Тэшиг суманд очоод хагас өдөр ч болоогүй. Ийм учраас жинхэнэ тэр санал өгсөн хүмүүсууд, тэр ажил хариуцаж байсан бүх хүмүүстэй уулзаж нягталж үзээгүй байх гэж бодож байна. Тийм бололцоо гараагүй. Ийм учраас тэр саналыг урьдчилж авсан нь үнэн юм билээ. Харин тэр ил задгай, конвертонд авсан гэдэг бол худлаа байхаа. Ямар ч байсан үргийн хайрцгаар битүүлмжилж авсан байх ёстой гэж бодож байгаа. Ийм учраас дахин шалгаж өгөөч гэсэн саналыг депутатын хувьд оруулж байгаа юм. Дахин нягталж өгөөч гэж.

Гомбожав:

За тэгэхээр хоёр санал гарч байгаа.

1. Цээн-ойдовын депутатын бүрэн эрхийг түдгэлзүүлье
2. Хэвээр үргэлжлүүлье гэсэн.

Үүн дээр саналаа хураах уу.

За тэгэхээр Ардын Их Хурлын байнгын комиссоос оруулж байгаа санал дээр санал хураалт явуулж. Өөрөөр хэлбэл нөхөр Дамдинсүрэнгийн Цээн-ойдовын их хурлын депутатын бүрэн эрхийг түдгэлзүүлье гэсэн саналтай депутатууд гараа өргөнө үү.

Тоологчоор тавигдсан хүмүүс Отгонбаяр, Элбэгсайхан, Энэбиш, Гэрэлт, Туяа, Шарбанли, Аюурзана, Дамбасурэн, Даваацэрэн, Пунцагням, Янжмаа тоолоод дунгээ өгөөрэй.

Соронзон хальстай  
тулгаж нийлсэн

*М.Мула*

ЭНХТУЯА

Бичээч

*B.OJUUN*

1991-XI-II  
Кассет № 09  
9.45-10.05

27

Ж.Гомбожав -Сонгууль нь хүчингүй явагджээ гэдэг тухай л яриа байна шуу дээ.

-ҮГҮЙ ЭЭ, ЭНЭН ДЭЭР САНАЛ ХЭЛМЭЭР БАЙНА.  
Тэр 12 ХУНИЙГ ДҮНГЭЭС НЬ ХАСНА ШУУ ДЭЭ БАС. ЦЭЕН-ОЙДОВТ ӨГСӨН САНАЛААС ХАСНА. БАС ДҮНГЭЭС ХАСААД ТООЦОХООР ЗЭРЭГ НИЙТ САНАЛ ХҮЧИНТЭЙ ХУУДСЫН 50,5 ХУВЬ НЬ ЦЭЕН-ОЙДОВЫН ТӨЛӨӨ САНАЛ ӨГСНӨӨР ГАРЧ БАЙНА ШУУ ДЭЭ.

Ж.Гомбожав -ТЭГЭХЭЭР ОДОО БОЛ ТЭР САНАЛЫН ТОО, ХУВЬ ПРОЦЕНТЫН ТУХАЙ ЯРЫЖ БАЙГАА ЮМ БИШ, ЕРЕӨСӨӨ ЭНЭ ТОЙРОГТ ЯВАГДСАН СОНГУУЛЬ ХУУЛЬ ЗЭРЧЖЭЭ ГЭДЭГ ТУХАЙ Л ЯРИА БОЛЖ БАЙНА. ХУУЛИЙНХАА ДАГУУ ЭНД СОНГУУЛЬ ЯВАГДСАНГҮЙ ГЭЖ. ЗА ТООГОО АВЧИХАВ УУ? ЗА ТАТГАЛЗСАН ДЕПУТАТУУД ГАРАА ӨРГӨӨ. ЦЭЕН-ОЙДОВЫГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХЭЭС ТАТГАЛЗАХ БАЙГАА ДЕПУТАТУУД ГАРАА ӨРГӨӨ. ЗА БУУЛГАЯ. ТООЛСОН УУ?

ЗА ТҮДГЭЛЭЭЖ БАЙГАА. ЗА ДАРААГИЙН САНАЛ ХУРААЛТ ЯВУУЛЬЯ. ТООГОО ТУРГЭН НААШАА ЯВУУЛЧИХЬЯ. ЦЭЕН-ОЙДОВЫН БҮРЭН ЭРХИЙГ ЦААШ НЬ ХЭВЭЭР ҮРГЭЛЖЛҮҮЛЬЕ ГЭСЭН САНАЛТАЙ ДЕПУТАТУУД ГАРАА ӨРГӨНӨ УУ. ТАТГАЛЗСАНААРАА БОЛОХ УУ? ТАТГАЛЗСАНЫГ ЦЭЕН-ОЙДОВЫН ТӨЛӨӨ БАЙЖЭЭ ГЭЖ ҮЗЭХ УУ? ТҮДГЭЛЗСЭНИЙГ САНАЛ ХУРААСАН. ОДОО ДҮНГЭЭ НААШАА АВААД ИР.

ДЕПУТАТ ЧИМИД ТАЙЛБАР ӨГҮЕ ГЭЖ БАЙНА. СОНСОХ УУ? ЗА ХЭРЭГГҮЙ ГЭЖ БАЙНА.

Бадарч /293 дугаар тойргийн депутат/ -ӨНӨӨДЕР ДЕПУТАТУУДЫН БҮРЭН ЭРХИЙН АСУУДАЛ ХЭЛЭЛЦЭЖ БАЙНА. ЭНЭ БОЛ ДЕПУТАТУУДЫН ХАЛДАШГҮЙ БҮРЭН ЭРХИЙН ТУХАЙ АСУУДАЛ. МАНАЙ УЛСЫН СОНИН ХЭВЛЭЛ ДЭЭР МАНАЙ БАГА ХУРЛЫН ГИШҮҮД, НЭЛЭЭН ОЛОН ГИШҮҮДИЙН ТУХАЙ АСУУДАЛ ГАРСАН. ХАМГИЙН СҮҮЛД АРВАН ДЭРЕВ ДЭЭР НЭМЭХ НЬ ЧИМИД ГЭСЭН АСУУЛТ ГАРСАН. ХЭД ХЭДЭН ХЭВЛЭЛ ДЭЭР БИЧИГДСЭН. ЭНЭ АЛДАРТ 20 дугаар тогтоолын нууцыг задруулсан, албан тушаа-

## 2.

лаа урвуулж ашигласан эдгээр хүмүүсийн тухай асуудал. Хоёрдугаарт энэ улсууд чинь ийм Бага Хурлынхаа гишүүнийхээ хувьд үнэнч шударга бус байдал гаргасан, Бага Хурлынхаа гишүүний тангаргийг няцсан энэ асуудлууд аль ч талаараа депутатын бүрэн эрхтэй авч ярихаар хууль зүйн бөгөөд ёс суртахууны ийм асуудал байна. Энэ асуудлыг депутатын бүрэн эрхийн хүмүүс шалгаж узсэн юм уу? Энэ асуудал энэн дээр яригдах юм уу үгүй юу? Олон түмэн энэ талаар ихээхэн сонирхож, зэвүүцэж байгаа шүү.

Ю.Жаргал /байнгын комиссын дарга/ -Улсын Бага Хуралд ажиллаж байгаа Ардын Их Хурлын II депутатын 20 дугаар тогтоолын нууц задалсантай холбогдсон, нууц ч гэж ярих юм уу, 20 дугаар тогтоолыг Засгийн газраас Улсын Бага Хуралд танилцуулсны дараа Ардын Их Хурлын II депутат, Бага Хуралд ажиллаж байгаа, хувийнхаа хадгаламжид хөдөлгөөн хийсэн нь бидэнд мэдэгдсэн. Энэ асуудлыг Улсын прокурор шалгаад, Улсын Бага Хуралд албан ёсоор мэдээлэл хийсэн. Улсын прокурор депутатын бүрэн эрхийн асуудалтай холбогдуулж хөндөх зүйл байна уу үгүй юу гэдгийг бид Улсын прокуророос хоёр удаа бид шаардсан, энэний дагуу Улсын прокурор бидэнд мэдээлэл гаргаж өгөөгүй, зүгээр бид хамгийн суулд нь депутатын бүрэн эрхийн байнгын комисс хуралдааны өмнө албан ёсоор Улсын Бага Хуралд оруулж ирсэн материалыг Ерөнхий прокурорын нэгдүгээр орлогчийг байлгаж байгаад мэдээлэл сонссон. Үнэхээр Улсын Бага Хуралд ажиллаж байгаа зарим депутатуудын хийсэн энэ үйлдлийг бид үзэхдээ Улсын Бага Хурлын гишүүний андгай, төрийн хууль тогтоох дээд байгууллагад ажиллаж байгаа байнгын төлөөлөгчийн хувьд эрх зүйтэй холбогдсон зөрчил байгаа нь тодорхой байгаа учраас Улсын Бага Хурлын тайлан дээр энэ асуудал тодорхой яригдах байх. Манай комиссоор энэ асуудал болгож яригдсан юм байхгүй.

Ж.Гомбожав -Сонин тоо гарч байна. Бид нар 420-уулаа хуралдаж байгаа. Өглөө би ирц зарласан. Одоо 429 болоод 9 депутат нэмэгдээд байна. Ийм учраас давхар давхар битгий өргөөч. За дахин санал хураая.

3.

Е.Моголцог /154 дүгээр тойргийн депутат/

-Саяын саналтай холбоотой нэг асуудал ярья. Юуны урьд бид сонгууль буруу болсноос өөрөө эрх зүйн ямар ч зерчилгүй депутатын тухай асуудлыг бид өнөөдөр эрхэнд нь халдаж ярж байна. Гэтэл зөрчил гаргаад монголын ард түмнээр яригдсан саяын 12 депутатын тухай асуудлыг энд Бага Хурлын асуудлыг ярих үедээ ярья гэж байна. Миний бодлоор бол нэгэнт депутатын эрхийн тухай ярж байгаа учраас одоо л ярж авмаар байна. Ард түмэн бидэнд дургүйцэж байна шуу дээ. Тэдний юугаар Ардын Их Хурлын депутат, бидний итгэл хүлээсэн хумуус ийм зөрчил гаргачхаад байхад эвлэрээд суугаад байдаг тухайд нь жирийн явсан депутатууд хэлмэгдэхэд хүрч байна. Тийм учраас нэгэнт л сахилга, дэг журам гэж юм байдаг л юм бол одоо энэ депутатынхаа дэг журмын тухай асуудлыг яриад, эрхийн тухай асуудлыг ярчихаад дараачийн асуудалдаа шилжвэл Их Хурлын чуулган маань ч нэр хүндтэй болох болов уу. Эхнээсээ л бид ингэж ярих юм бол Их Хурлын чуулган маань ямар болох вэ гэдгийг өнөөдөр ард түмэн хараад сууж байгаа шуу дээ. Тийм учраас тэрэнд юунд нь тудгэлзээд байгаа юм, яагаад энэ улсуудын тухай ярж болохгүй байгаа юм, яриад эрхийг нь эдлүүлэх юм уу, аль эсвэл болих юм уу гэдгээ одоо шийдвэр байна. Зүгээр Их Хурлынхаа ажиллагаанд орчихсон хойноо энэ асуудлыг ярих юм бол бид бас нэг л бөөн будлиан, шуугиан болсон, маргаантай юм болно шуу дээ. Эхлээд л бид замаа цэвэрлэж, асуудлаа шуудруулахын тулд уг асуудлыг ярих нь зүйтэй байх гэсэн ийм саналыг депутатын хувьд тавьж байна.

Ж.Томбожав - Тэгэхээр одоо энэ хэлэлцэж байгаа асуудлаа эхлээд шийдвье. 119 дүгээр тойрогт сонгууль буруу явагджээ. Сонгуулийн хууль зөрчжээ гэсэн, энэтэй холбогдсон асуудал бид ярж байна шуу дээ. Энийгээ эхлээд шийдчихье. Тэгээд дараачийн асуудлаа ярья.

Ц.Дэмжил /164 дүгээр тойргийн депутат/ би бас санал байна. Яагаад гэхээр одоо бас депутатын бүрэн эрхийн хугацаанд хариуцлага алдсан, гэмт хэрэгт ч холбогдож болох

-Энэн дээр

тийм олон улсууд бас байж байна. Тэгэхээр энийг сая хэлэлцээд, ийм улсуудынхаа асуудлыг хөндөөгүй байж байж, тэр нэг сонгуулийн будлианаас болсон хүнийг түдгэлзүүлээд, тэр зах хязгаарт байгаа ард түмнийг санал бодлыг нь сонсохгүй, тэднийг хохироож байхын хэрэг байгаа юм уу? Энэ чинь үнэн хэрэг дээрээ тэр ард түмэн чинь сонгочихсон байна. Ил ч гэсэн тэр улсууд сонгуулийн комиссын өмнө тэр улсууд санал өгсөн байна, тэр 12 хүн чинь. Тэгэхээр Цээн-Ойдовын талаар ямар нэгэн буруу, ёс суртахууны янз бурийн догоолдол гарч мэдээлсэн юм байхгүй байна. Тэгэхээр энэ чинь сонгуулийн комиссын үйл ажиллагаатай холбоотой гарсан нэгэн дутагдал юм. Тэгэхээр энэ хугацаанд тэр ард түмний сэтгэлийг нь бодоод, ер нь энэ депутат ямар ч хэрэг хийгээгүй, тийм учраас ер нь бусдыг ашил, тэр неге юл суудыг түдгэлзүүлэхгүй л оруулж байгаа юм бол Цээн-Ойдовоо мөн л энэ асуудалдаа оруулах нь зөв болов уу гэдэг ийм санал байна.

Г.Нороврагчаа /289 дүгээр тойргийн депутат/ -Тэгэхээр депутатуудаа хандаж нэг юм хэлмээр байна. Яг ингээд тооллого яваад эхэлсэн ийм үедээ ингээд дахиад санал дураараа оруулж яриад байхаар чинь наадах ажил чинь ерөөсөө явахгүй байна шуу дээ. Тэгэхээр зэрэг тооллого ингээд аваад санал хурааж байгаа тохиолдолд дундуур нь ярихаа больё л доо. Санал ярих тохиолдолдоо л ярья.

Р.Гончигдорж /56 дугаар тойргийн депутат/ -Учлаарай эрхэм депутатууд аа. Бид нар нэг зүйл дээр анхаарах ёстой юм болов уу гэж бодож байх юм. Бид нар бол Ардын Их Хурлын депутатыг, бүгдээрээ ардын Их Хурлын депутатууд. Ардын Их Хурлын депутатууд өөрсдийнхөө өөрөө өөрийгөө зохион байгуулах үйл ажиллагаагаа хийгээд Их Хурал маань хуралдаж байгаа шуу дээ. Их Хурлын депутат болгоно гэдгийг маань эцсийн эцэст тэр сонгуулийн тойргийн сонгогчид л өгч байгаа шуу дээ. Тэгэхээр зэрэг бид нар сонгуулийн тойргийн сонгогчид л депутатынхаа асуудлыг ярьж, тэрэн дээрээ огцуулсан тохиолдолд бид энд түүнтэй холбогдуулж асуудал авч үзэхээс биш, нэг байгууллагад гишүүн элсүүлж байгаа биш. Харин Бага Хурлын гишүүнийх нь хувьд асуудал яривал үнэхээр Их Хур-

## 5.

лаасаа сонгон баталсан хүмүүс, эрх олгогдсон хүмүүс учраас Бага Хурлынх нь гишүүнээс эгүүлэн татах уу угүй юу гэдэг асуудлыг бид эндээ шийдэх асуудал. Гэтэл түргүний ярьсан эрхэм депутатуутай холбоотой асуудлыг өнөөдөр сонгогчид сонгуулийн тойрог дээр аливаа асуудал юу ч яриагүй байна шуу дээ. Тэгэхээр зэрэг бид нар сонгогчдынх нь өмнөөс энд ингэж авч шийдэх бол бидэнд эрх зүйн хэмжээ байхгүй юм шуу эрхэм депутатууд аа. Түрүүний асуудал дээр бид тийм ч учраас ер нь депутатыг нь түдгэлзүүлэх гэдэг ойлголт энэ хуралдаан дээр байж болохгүй. Тэргүүнийг зөвхөн тэр тойргийн сонгогчид хийх асуудал. Бидний энд хийх асуудал бол сонгууль хууль зүйн дагуу явагдаж уу, угүй юу? Тэр сонгууль хүчинтэй юу угүй юу гэдэг асуудлыг харин бидэнд шийдэх эрх мэдлийн хэмжээ байгаа. Тийм учраас аргачлалын хувьд ингэж авч узээд түрүүнийхээ асуудлыг дуусгaaад тэгээд үнэхээр одоо Бага Хурлын гишүүдтэй холбоотой асуудлыг бид Бага Хурлынхаа тайлан дотор байгаа, түүнтэй холбогдуулсан хууль хяналтын байгууллагын дүгнэлт байгаа, энийгээ эрхэм депутатууд та бүхэндээ Улсын Бага Хурлын гишүүнийх нь хувьд та бүхэнд толилуулна. Ийм л байна. Баярлалаа.

Ж.Гомбожав -За тоогоо нарийн болгохын тулд дахиад санал хураалт явуулъя. Тэгэхээр энд бол ийм угээр байгаа шуу дээ. Ардын Их Хурлын 12 дахь удаагийн сонгуулийн 119 дүгээр тойрогт явагдсан сонгууль Ардын Их Хурлын депутатуудын сонгуулийн хуулийг зөрчсөн тул тус тойрогт депутатараар сонгогдсон Дамдинсүрэнгийн Цээн-Ойдовын бүрэн эрхийг түдгэлзүүлсүгэй гэсэн ийм л тогтоол байгаа шуу дээ. Сонгуультай нь холбож ярьж байгаа болохоос биш, депутат Цээн-Ойдовын тухай яриа биш юм байгаа юм. За ингээд санал хураалт явуулъя. Эхлээд оруулсан дэс дарааллаараа Цээн-Ойдовын бүрэн эрхийг түдгэлзүүлье. Өөрөөр хэлбэл тэр сонгууль хүчингүй болжээ гэж узэж байгаа депутатууд гарaa өргөнө үү.

Соронзон хальстай тулгаж  
нийлсэн

*М.Ишсаид*

Д.АЛТАНЦЭЦЭГ

Бичээч Уранчимэг

32  
К-10  
1991.II.II.10.05-10.20

Ж.Гомбожав:

Одоо татгалзаж байгаа нь, өөрөөр хэлбэл Цээн-Ойдовын бүрэн эрхийг цааш нь хэвээр үргэлжлүүлье, гэсэн санаатай сонгууль нь хүчинтэй гэж үзэх. Нэг хүн хоёр санал өгч болохгүй шүү, түүнийг анхаарай. Тoo вэричихнэ.

Түдгэлзэж байгаа нь энэ хоёрын алинаар нь ч биш.

Татгалзсан

Түдгэлзсэн

355 дугаар тойргийн депутат Ж.Баянмөнх: Тэгэхээр энд ийм санагдаж байх юм. Бидэнд энэ асуудлыг яг танилцуулангуут санал авахаар бид үнэн учрыг нь ялгаж чадахгүй байна. Нэг хоногийн өмнө энэ асуудлыг өгсөн бол бид олон талаас нь ярих байсан. Тэгэхээр энэ санал бол буруу хураагдаж байна. Хүмүүс сонсохдоо ч энэ депутатын тухай асуудал, депутат л их дутагдалтай хүн, үүнд эрх өгөх уу, угүй юу гэдгийг бид хураагаад байна.

Уг асуудал бол тэр сонгууль хүчинтэй юу, угүй гэдэг дээр санал хураах ёстой байсан. Сонгуулийг хүчинтэй гэж нэгэн-тээ дурмийнхээ дагуу яваад өнөөдөр Их Хурлаар, анхдугаар хуралдаанаар баталсан юмыг өнөөдөр депутат ямар нэгэн хэрэг зөрчил гаргасан асуудлыг хэлэлцэж байгаа юм шиг санал хураагаад байгаа юм шиг санагдаж байна.

Ийм учраас бид саналыг тэр тойргийн сонгууль хүчинтэй угүй юу гэдэг дээр л хураах ёстой.

Ж.Гомбожав: Сая тэгсэн шүү дээ. Одоо дун танилцуулъя. 215 хүн буюу 51,19 хувь нь түдгэлзүүлье гэсэн санал өгсөн байна. 176 хүн татгалзсан байна. 29 хүн түдгэлзсэн байна. Ингээд тогтоолоо батлах уу?

2.

Сонгуулийн хууль зөрчсөн гэдгээр л тарах нь байна шүү дээ.

121 дугаар тойргийн депутат Норжин: Энэ олон депутатууд ярилаа. Бид депутатын тухай асуудал яриагүй. Энэ сонгууль зөв үү? буруу юу гэж ярьж байгаа. Тэгэхээр энэ сонгууль явагдсан нь зөв явагдсан. 12 хүнээ хасчихаад, хувилсан ч өнөөдөр Цэн-Ойдовын эзэлж байгаа хувь 50,3 хувьтай байна. Тэгэхээр одоо бид ямар ч холбогдолгуй депутатыг энд авч узээд бид эрхийг нь эдлүүлэх үү, угүй юу гэж ярьдаг түрүүний Баянмөнх депутатын ярьдаг үнэн уг. Хэрэггүй юм. Энэ бол утгагүй асуудал болно. Ер нь сонгууль хүчинтэйюу, хүчингүй юу гэдэг асуудлыг одоо ч ярих асуудал биш. Энэ хүчинтэй гээд батална, түүгээр явна. Энэ 12 хүнийг хасахад 50,3 хувь авсан хэвээрээ л байна. Сонгууль хүчинтэй явуулаад, депутат үүргээ эдлээд өдий хурлээ, тэгэхээр одоо энэ асуудлыг одоо ярих асуудал биш гэж бодож байна.

Харин 12 хүнээ хасчихаад тэр учир явдал, сонгууль бүрэн явуулсан тухай, тэр сонгуулийн комисст асуудал ярих нь зүйтэй гэж бодож байна.

<sup>эрхийн</sup>  
Хоёрдугаар асуудал, чухам хэлбэл депутатын бүрэн+комисс Тэшиг суманд явсан шалгалт хаашаа болсон юм бол, дам сонссон угээр хэлэхэд хагас сайн өдөр оччилоод, бутэн сайн өдрийн өглөө буцаад ирсэн гэж байгаа юм, Энэбиш дарга. Депутат Энэбиш. Тэгэхээр үүнийг ч нь гэсэн өргөж узэх шаардлагатай байхаа гэж бодож байна.

25 дугаар тойргийн депутат Л.Энэбиш: Энд шалгалт хий гэж байнгын комисс үүрэг өгсөн. Ерөнхийлөгчийн нэр дээр 2 удаа, байнгын комиссын нэр дээр нэг удаа, дараа нь Булганц Ардчиллыг хэн саатуулж байна вэ гэдэг гарчгийн дор Тэшигт тээглээ их байна гэсэн нийтийн Дэвшил сонинд ноднин гарсан. Үүний хэл яриа маш их байгаа юм билээ.

Ер нь энд яриад байвал их олон юм байна. Үүнийг би сонгуулийн комиссын ажилтай нь холбогдуулж ярих нь зүйтэй байх.

## 3.

Үнэн хэрэг дээрээ бол энд суман дээр нь очиход сум нь бараг хоёр хуваагдчихсан ийм юм байгаа. Цээн-Ойдов гуай бол 24 жил Тэшиг, Бугатын сум-нэгдлийн даргаар ажилласан хүн байна билээ. Ингээд энд ярьдаг л юм бол ах дуу, төрөл садан янз бурийн юм ярьж байгаа.

Би энд олон юм яривал их юм ярина. Үүнийг хэрэгтүй. Сонгуулийнхаа ажилтай холбогдолтой, өнөөдөр бол гол нь бид депутатууд юуг нь анхаарах ёстой вэ гэвэл, бид нарын өнөөдрийн энэ Их цаазыг хэлэлцээд батлахад хүчингүй сонгуулийн тойргоос депутат ороод батлагдсан гэвэл энэ Их Хурлын чинь бух баримт бичиг хүчингүй болж магадгүй шүү дээ. Энүүгээрээ л бодох хэрэгтэй байх. Цаана нь энтийн бригадаас илүү сонгуулийн комисстай холбогдолтой олон асуудал бий. Хужирт бригадын тойргийн комиссын дарга Дэмбэрэл гэдэг хүн сонгогдож ажиллаж байсан. Ганцхан шөнө ирээд Дорж гэдэг хүн таны нэр депутатад дэвшигдсэн учраас дурмэнд сонгуулийн хуульд таарахгүй, энэ өөрчлөх ёстой гээд хэрэг, материалыг нь аваад явсан. Үүнийг л бид ийм юмнуудыг нь л сонгуулийн комисс дээр узсан. Үнэхээр Дэмбэрэл бол нэр дэвшсэн хурлын проткол, нутаг дэвсгэрийн комисст бүртгүүлсэн, өөрөө зөвшөөрөл өгсөн, юмнууд байхгүй, зарим тойргийн комисс дээр батлагдсан хурлын тэргүүлэгч, сумын хурлын тэргүүлэгчдийн тогтоолоор батлагдсанх тойргийн комиссоо ямар ч шийдвэргүй, нэг хүн явуулаад л сонгууль авсан. Хэсгийн комисст өр нь өөрөө нэр нь ч ороогүй хүн кабин дээр ажиллаад л ингээд сонгууль өгсөн хүнд нөлөөлөөд, энд маргаан бол маш их бий. Би бол энэ турүүн санал хураахад нөлөөлөх байх гэж бодоод босоогүй юм. Сонгуулийн дүрэмтэй зөрчсөн, тэр сонгуулийн комисстай нь холбож узэх ажил бол маш их байгаа. Үүнийг бид очиж узсан. Бид сумын төв дээр сонгуулийн комиссын материалыг узэхээс гадна, бид Хужирт бригад, Харлан, Төмөрлөн түүгээр маш олон айл, тэр Дэмбэрэл гэдэг хүнтэй нь уулзах гэсэн, үнэхээр тэр хүн нь бол 3-4 хоног өвөлжөө нь шатсан, түүнийхээ дагуу ууланд гараад явсан байна билээ. Гэр орноор нь орсон, 10 гаруй хүнтэй уулзсан.

4.

Сонгууль бол будлиантай явсан. Өнөөдөр энэ хурлын ажиллагаа нэвтрүүлж байгаа байх, бүх орон даяар. Тэр улсууд мөн л сонсч байгаа. Тэнд өчнөөн, төчнөөн хүн гомдол гарсан, бичиг баримт, 2-3 санал нь энд байгаа. Тэнд бичсэн олон юмыг, бүгдийг энд ярина гэвэл тэр бол манай Хурлын зорилго биш байх. Хамгийн гол нь бид сонгууль хууль дурмийнхээ дагуу явсан уу? Угүй юу гэдгийг ярих нь зүйтэй байх гэж бодож байна.

39 дүгээр тойргийн депутат Л.Ламжав: Бид +/анх удаа Ардчилсан сонгууль хийж, туршлагагүйтэж, алдаа дутаагдал гаргасан тойргуудыг ярих юм бол бараг 100 хувь болох байх гэж би бодож байна. Ер нь саяны танилцуулсан тооноос үзэхэд нэгэнт тоон үзүүлэлтийнхээ хувьд энэ бол хүчин төгөлдөр байгаа юм уу гэж би ойлгоод байгаа юм.

Ийм учраас энэ асуудлыг авч хэлэлцэхээ болъё гэдэг дээр санал хурааж өгнө уу?

178 дугаар тойргийн депутат Л.Энхбаатар: Тэгэхээр бид энд хүний тухай асуудал өрдөө яриагүй. Тухайн сонгууль хүчинтэй явагдсан уу? Угүй юу гэдгийг. Үүнийг бүгд хүлээн зөвшөөрч байна, нэгдүгээрт.

Хоёрдугаарт, тэр комиссын дүгнэлт ч гарлаа. Энэ хумус ч өөрсдөө ч хэлж байна, Цээн-Ойдов гуай ч хэлж байна, ганцхан зүйлийг. Юу вэ гэхээр сонгууль товлосон өдрөөс нэг өдрийн өмнө санал хураалтыг авчээ гэж. Ингэхээр чинь зөвхөн үүгээр, хэрвээ тэр 12 хүнийг нэмбэл яах вэ? хасвал яах вэ? үржүүлбэл яах вэ? хуваавал яах вэ гэж ярихаа болъё.

Зөвхөн сонгуулийн хуульд заасан өдрөөс өмнө өдөр нь явууллаа гэхэд сонгуулийн хуулийг зөрчлөө, зөрчилтэй явагджээ гэдгийг гэрчилж байгаа юм. Сонгуулийн товлосон хугацааг.

Тэгэхээр хууль тогтоох дээд байгууллагын гишүүд ирж цуглачихаад үнэхээр хууль зөрчигдөөд, товлосон өдрөөс өмнө явагджихаад байж байхад үүнийг нуд аниад байж болмооргүй гэж санагдаж байна.

Соронзон хальстай  
тулгаж нийлсэн

А.З.Борж

д.Чулуунцэцэг

1991.XI.II.  
Кассет № II  
10.20-10.35

Ж.Гомбожав -Би түрүүнд нэг тоо хэлсэн, дахин хэлье.  
420 депутат оројдох байна. 215 нь түдгэлзүүлье. Энэ нь 51,19  
хувийг эзлэж байгаа юм байна. Татгалзсан 176 буюу 41,90 хувь  
байна. Түдгэлзсэн 29, буюу 6,92 байна. Олонх нь түдгэлзүүлье  
гэсэн тогтоолыг батлая гэсэн саналтай байна.

Энэ тогтоолоо батлах уу, батлая гэсэн депутатууд  
гараа өргөе. Тоологчид тоольё.

Энэ тогтоолыг 51,19 хувиар баталлаа.

Дараагийн асуудалдаа орьё. БНМАУ-ын Ардын Их Хурлын дарга, орлогч дарга нарыг сонгох тухай асуудал байна. Эхлээд Ардын Их Хурлын даргыг сонгох асуудалдаа орьё. Энэ талаар ямар санал хэнд байна. Саналаа хэлнэ уу.

Ардын Их Хурлын даргыг хэнийг сонгох вэ гэсэн санал энд байна. Даш-Эндон - МАХН-ын Төв Хорооны дарга:

-Эрхэм Хүндэт депутат нехөд өө! БНМАУ-ын Ардын Их Хурлын тургуучийн даргын хугацаа дууссантай холбогдуулж манай нам бусад намын удирдагчидтай харилцан зөвлөсний үндсэн дээр манай одоогийн хуралдааны даргаар ЗІ8 дугаар тойргийн депутат Жамбалдоржийн Уртнасанг сонгох саналыг оруулж байна.

ЗІ8 дугаар тойргийн депутат Уртнасан 1942 онд Ховд аймгийн төвд төрсөн. Халх, МАХН-ын гишүүнд 1970 онд элссэн. 1950-1960 онд Ховдод 10 жилийн дунд сургууль, 1960-1965 онд Улаанбаатарт Хөдөө аж ахуйн дээд сургууль төгссөн. Мал өмнэлгийн ангид суралцсан, малын их эмчийн мэргэжилтэй, мал өмнэлгийн ухааны дэд эрдэмтэн.

Сургууль төгсөөд ШУА-д мөн МАА-н эрдэм шинжилгээний хүрээлэнд ажиллах байсан. Дараа нь ХААЯ, ХААХҮЯ-ны орлогч сайд, Засгийн газрын ахлах референт зэрэг ажлуудыг хийж байсан.

## 2.

Одоо Монголын Нэгдлийн холбооны дээд зөвлөлийн дарга юм.  
Ардын Их Хурлын анхдугаар хуралдаанаар нь

Улсын Бага Хурлын гишүүнээр сонгогдсон. Энэ оны 6-р сараас өөр ажилд шилжсэн учраас Улсын Бага Хурлын гишүүнээс түдгэлзээд байгаа юм.

Депутат н.Уртнасанг Ардын Их Хурлын II хуралдааны даргаар сонгох саналыг бид тавихдаа түүний ажил, амьдралын эдгээр туршлагыг харилцан харгалзан үзсэний зэрэгцээ бас дор дурдсан зүйлүүдийг харгалзаж бодолцлоо гэдгийг би уламжлая.

Нэгдүгээрт Уртнасан улсын хэмжээний цар хүрээний ажил, асуудал нэлээд хугацаагаар эрхлэж ирсэн. Ялангуяа түүний хөдөө аж ахуйн талаарх мэдлэг Ардын Их Хурлын цаашдын ажилд ач холбогдолтой, хэрэгтэй юм.

Хоёрдугаарт Уртнасан Улсын Бага Хуралд ажиллаж, хууль хэлэлцэх дадлага нилээд суусан гэж үзэх үндэстэй юм. Түүнчлэн хурал удирдах арга барилыг Улсын Бага Хурлын ажиллагаанаас нэлээд ажиглаж мэдэрсэн болов уу гэж үзэж байна.

Туравдугаарт Ардын Их Хуралд шууд тайлганддаггүй байгууллагад ажилдагаараа мөн авч үзэх болоцтоой байгаа юм. Энэ бүх зүйлүүд нь н.Уртнасанг Ардын Их Хурлын даргын албан тушаалд нэрийг нь дэвшүүлэх боломжийг бидэнд олгосон юм.

н.Уртнасанг Ардын Их Хурлын даргаар сонгуулъя гэсэн манай намын саналыг дэмжих өгөхийг та нөхдөөс хүсэж байна. Өмнөх Ардын Их Хурлын дарга үүрэгт ажлаа амжилттай гүйцэтгэсэнд бид талархаж байгааг ияэрхийлэх нь зүйтэй гэж бодож байна.

Ж.Гомбожав -Өөр нам, депутатуудаас санал байна уу?  
Өөр хүний нэрийг дэвшүүлэх үү? Хэрэв байхгүй бол санал хураах үү?

## 3.

Одоо саналаа хураая. Уртнасангаас асуух, ярих зүйл байна уу?

Байхгүй байна. Тэгвэл Уртнасанг БНМАУ-ын Ардын Их Хурлын даргаар сонгоё гэсэн саналтай Ардын Их Хурлын депутатууд гараа өргөнө уу.

Татгалзсан -3  
Түдгэлзсэн -8

Олонхийн саналаар н.Уртнасан Ардын Их Хурлын даргаар сонгогдлоо.

Дараагийн асуудал нь Ардын Их Хурлын орлогч даргаар ил сонгох асуудал байна. Эхлээд тоогоо тогтоё. Та бухэнд та-раасан дэг дээр Ардын Их Хурлын даргад 2 хүн гэж байна. Улс төрийн намууд урьдчилан яриад 4 байх нь зүйтэй гэсэн санал ирж байна. Тийм учраас энэ хоёр тоон дээрээ санал хураах уу?

Ардын Их Хурлын даргаар хоёр хүн сонгох уу, аль эсвэл 4 хүнийг сонгох уу? Тэгвэл 4 дээр санал хураая.

орлогч

Ардын Их Хурлын даргаар дэrvөн хүнийг сонгоё гэсэн саналтай депутатууд гараа өргөнө уу!

Татгалзсан -65  
Түдгэлзсэн -7

Олонхийн саналаар Ардын Их Хурлын орлогч даргад 4 хүнийг сонгоё гэж тооны хувьд тохирлоо.

Ардын Их Хурлын орлогч даргад хэн, хэний нэрийг дэвшүүлэх вэ, энэ талаар саналаа хэлнэ уу.

4.

Р.Хатанбаатар -Ардын Их Хурлын орлогч даргад БНМАУ-ын Ардын Их Хурал дахь МСДН-ын булгээс 278 дугаар тойргийн депутат Доржийн Моондоог дэвшиүүлж байна. Д.Моондой нь 1957 онд Сүхбаатар аймгийн Наран сумын нутагт төрсөн. 1975 онд Сүхбаатар аймгийн 10 жилийн дунд сургуулийг төгсөж, Болгар улсын Техникийн дээд сургуульд элсэн суралцсан.

1981 онд тус сургуулийн радио, техникийн салбарыг электроник техникийн инженер мэргэжлээр төгссөн. 1981 оноос ШУА-ийн Физик-техникийн хүрээлэнд орчин үеийн электрон техникийн эд ангийг зохион бүтээх чиглэл бүхий лабораториид эрдэм шинжилгээний ажилтнаар ажиллаж байсан.

Моондой манай оронд суулийн үеийн цахим техник , микро-компьютер, өнгөт зурагт, холбооны техник хэрэгслэл зэрэг бутээгдэхүүнийг зохион бүтээж, үйлдвэрлэх шинэ салбарт идэвх зүтгэлтэй ажиллаж, бид бүхний танил болсон "МОНЭЛ" фирмийн үндэс суурийг тавилцсан юм. Одоо "МОНЭЛ" фирмийн техникийн бодлого хариуцсан захирлаар ажилладаг. Ингээд Ардын Их Хурлын орлогч даргад 278 тойрог /Энэ нь Сүхбаатар аймгийн Наран сумын тойргийн депутат/ депутат Д.Моондойг сонгож өгөхийг та бүхнээс хүсэж байна.

Гунджалам /Ардын Их Хурлын 383 дугаар тойргийн депутат: -МУДН-ийн Зөвлөлийн хурлын шийдвэрийн дагуу Ардын Их Хурлын орлогч даргад Ардын Их Хурлын депутат Нямжавын Батбаярын нэрийг дэвшиүүлж байна.

Н.Батбаяр Комплекс импорт нэгдлийн орлогч даргаар ажиллаж байгаа юм. Москва хотын Статистикийн дээд сургууль төгссөн.

Н.Батбаярын талаар бусад асуудлыг нь өөрөөс нь асуух лавлана уу?

5.

Бас өөр хоёр хунийг нэрийг дэвшүүлье.

I98

С.Батмөнх /Ардын Их Хурлын +дугаар тойргийн депутат:/

-Ардын Их Хурлын орлогч даргад I94 дүгээр тойргийн депутат Т.Жагайгийн нэрийг дэвшүүлэх саналтай байна.

Т.Жагай I95I онд төрсөн. I969 онд Мандалговь хотын I0 жилийн сургууль төгсөж, Анагаах ухааны дээд сургуульд орж суралцаад, төгссөн цагаасаа Дундговь аймгийн Говь-Угтаал сумадд хуний их эмчийн ажил хийж байгаа.

Ардын Их Хурлын депутатаар сонгогдоод мөн хөдөлмөрчдийн дунд хууль зүйг сурталчлан таниулах, улс төрийн байр суурь нь төлөвшиж байгаа сэхээтэн, эмэгтэй хүн байна. МАНХ-ын гимнүүн. Энэ хунийг Ардын Их Хурлын орлогч даргаар сонгуулж өгөхийг хүсэж байна.

Ж.Гомбожав -Өөр хүн байна уу?Одоо нэг хүн үлдэж байна. Өөр санал байхгүй юу?Дөрвөн орлогчтой байна гэсэн турван хуний нэрийг дэвшүүллээ шүү дээ.

Х.Бадамсүрэн -Ардын Их Хурлын 424-р тойргийн депутат:

-Ардын Их Хурлын орлогч даргад Ардын Их Хурлын 33 дугаар тойргийн депутат Монголын эмэгтэйчүүдийн Төв Холбооны Төв Зөвлөлийн дарга Доржийн Мөнхөөг дэвшүүлэх саналтай байна.

Энэ хүн нь энэ даргад сонгогдож ажиллахад бүрэн боломжтой. Бусад шаардлагыг манай депутатууд ойлгож байгаа байх.

Соронзон хальстай  
тулгаж нийлсэн

Бицээч

*У.Баяржав*

Д.БАЯРМАА/  
/С.ТУУЛ/

91

Кассет I2  
1991.XI-II  
10.35-10.50

Ардын Их Хурлын 52 дугаар тойргийн депутат Э.Бат-уул:-  
Монголын ардчилсан намын бүлгийн зүгээс Дундговь аймгийн  
Мандалговь хотын гүйцэтгэх захиргааны дарга, Ардын  
ИхХ Хурлын депутат Моёор гуайг Ардын Их Хурлын орлогч дар-  
гын нэрд дэвшүүлж байна. Моёор гуайгаас асуух юм байвал  
өөрөөс нь асууна биз.

Ардын Их Хурлын 426 дугаар тойргийн депутат Ж.Барамсай:-  
-Тэгэхээр би тойргийг нь сайн мэдэхгүй байна. Ардын Их Хурлын  
орлогч даргад Ж.Лоохууз гуайг дэвшүүлье гэж бодож байна.

Ардын Их Хурлын 245 дугаар тойргийн депутат Ч.Чинбат:-  
-Ардын Их Хурлын орлогч даргад 246 дугаар тойргийн депутат  
Норовын Дашлондогийг дэвшүүлэх саналтай байна. Дашлондог 1946  
онд төрсөн. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, түүний дотор мал аж  
ахуйн үйлдвэрлэлд 20 гаруй жил тогтвортой ажиллаж байгаа, хөдөө-  
гийн ард түмний итгэл найдварыг хулээсэн ийм бололцоотой депу-  
тат гэж узэж байна.

Ж.Гомбожав:- Саналаа таслах уу? Дөрвөн хүн дээр долоон  
хүний нэр дэвшээд байна. Одоо саналаа таслах уу? За тасалжя  
гэсэн саналтай депутатууд гараа өргөнө уу. За болно. Татгал-  
заж байгаа хүн байна уу? Түдгэлзэж байгаа хүн байна уу? Байх-  
гүй байна. За эхлээд хумуустэйгээ танилцах уу? Нэгдүгээрт,  
Социал демократ намаас нэр дэвшүүлсэн 278 дугаар тойргийн  
депутат Доржийн Мондой. Нямжавын Батбаяр, Төмөрийн Жагаа ,  
Доржийн Мөнхөө, Мандалговь хотын царга Моёор, Лоохууз,  
Норовын Дашлондог.

За Мондойгоос асууж танилцах зүйл байна уу? Байхгүй ю.  
За Нямжавын Батбаяраас асуух зүйл байна уу? За Төмөрийн Жагаа -  
гаас асуух зүйл байхгүй ю? Доржийн Мөнхөөгөөс асуух зүйл  
байна уу? Моёороос асуух зүйл байна уу? Лоохуузаас асуух  
зүйл байна уу? За Норовын Дашлондогоос асуух зүйл байна уу?

## 2.

Долоон хүн танилцаглаа. Яаж асуудлаа шийдэх вэ гэдгээ тохирх  
хэрэгтэй байна. Тэгэхээр ингэх уу. Эхлээд нам намаар нь үзье  
гэж уу?

Ардын Их Хурлын 33 дугаар тойргийн депутат Д.Мөнхөө:- Би  
Дундговь аймгийн депутат Жагааг орлогч даргаар үлдсэн нөхцөлд  
өөрөө татгалзаж байна. Жагааг дэмжвэл би өөрийнхөө юнээс  
татгалзъя.

Ардын Их Хурлын 2II дүгээр тойргийн депутат Д.Дагваадорж:- Энэ  
долоон хүн чинь өөрсдөө бүтгээрээ энэ нэр дэвшигдэж байгаагаа  
зөвшөөрч байгаа юм уу? Тэрийг асуусангуй шүү дээ.

Ж.Гомбожав:- Одоо хэлж байна л даа. Жагааг үлдсэн нөхцөлд  
Мөнхөө татгалзъя гэж байна. Намын нэр дэвшүүлсэн дарааллаар  
явах уу? За Социал демократ намаас 278 дугаар тойргийн депу-  
тат Доржийн Моондойгийн нэрийг дэвшүүлсэн. Мондойг Ардын Их  
Хурлын орлогч даргаар сонгоё гэсэн саналтай депутатууд гараа  
өргөнө уу. За ер нь олонхи нь байна. Татгалзсан, түдгэлзсэнг нь  
тоолъё.

Татгалзсан 5

Түдгэлзсэн 16.

За ингээд олонхийн саналаар нөхөр Мондой Ардын Их Хурлын  
орлогч даргаар сонгогдлоо.

Дараа нь Монголын үндэсний дэвшлийн намаас Нямжавын Бат-  
баярын нэрийг дэвшүүлсэн. Батбаяарт ярих хэлэх зүйл бий юу?  
Байхгүй байна. Батбаярыг Ардын Их Хурлын орлогч даргаар сонгох  
саналтай депутатууд гараа өргөнө уу.

Олонхи нь байна.

Татгалзсан 14

Түдгэлзсэн 39

Ингээд олонхийн саналаар нөхөр Нямжавын Батбаяр Ардын

3.

Их Хурлын орлогч даргаар сонгогдлоо. За тэгвэл нэrsийн жагсаалтад үлдээлээ.

Дараа нь Төмөрийн Жагаан талаар явах уу, эсвэл Монголын арцчилсан намынхыг санал хураах уу? Нэр дэвшсэн дарааллаар явах уу?

Ардын Их Хурлын I32 дугаар тойргийн дэпутат С.Чулдуунбаатар: «Дарга аа, нэгдүгээрт та нэр дэвшсэн дарааллаар хэлэлцүүлэх ёстой. Хоёрдугаарт тэр сонгогдлоо гэж урьдчилж зарлаад баймааргуй байна. Яагаад вэ гэхлээр зэрэг долоон хүн дээрээ тус бүр дээр санал хураасны эцэст өөр тоо гаралц ирэх юм бол та өөрөө хүнд байдалд орно. Тэгэхлээр одоо нэр дэвшсэн дарааллаар хэлэлцүүлэх хэрэгтэй байна.

СОРОНЗОН ХАЛЬСТАЙ ТУЛГАЖ  
НИЙЛСЭН

P. ТӨМӨРБААТАР

БИЧЭЭЧ Л.ХОРЛОО

1991-XI-II  
Кассет № 13  
10.50-II.05

Ж.Гомбожав:

-Санал хураалт явуулъя.

-Би хүнд байдалд орохоос гадна бид нар бүгдээрээ хүнд байдалд орох нь байна шүү дээ.

Нэг намаас нэг хүн дэвшсэн тэр олонхийн санал авбал сонгогдох нь ээ гэж тэгвэл тэгэхгүй <sup>юм</sup> байна. Энэ 7-гоос хамгийн олон санал авсан нь сонгогдсон юм байна гэж ойлгох уу, тэгж тохирох юм уу, за тэгвэл тэгж тохирлоо шүү. Сүүлд нь одоо ийм юм гарна шүү, манай намаас хүн гарсангүй ээ манайхаар бол тийм л дээ, тэгэхдээ олон санал авсан энэ долоогоос хамгийн олон санал авсан 4 хүн л сонгогдох нь байна. Тэрнээс биш ямар нэгэн намын асуудал хамаагүй боллоо гэж ойлгох нь. За тэгвэл тэр хэний тоогоор

-Ганц уг хэлье.

-Дараа нь

-Дарга аа,

-Хаанаас дуудаж байна

-За Жагаан талаар санал хураалт явуулъя. 194 дүгээр тойргийн депутат Төмөрийн Жагааг АИХ-ын орлогч даргад үлдээс гэсэн, сонгое гэсэн саналтай депутатууд гараа өргөе. Нам МАХН-уу Жагаа, аль намых вэ гэж асуугаад байна. За яахав дээ хамаатай ч бас сонирхж байгаа юм байна л даа. Аль намын хүн бэ гэдгийг. Жагаа аль нам бэ? МАХН-ын гишүүн гэж байна. За Жагаагийн талаар саналаа өгье. За олонхи нь байна, за буулгачих. Татгалзаж байгаа хүн, за үүнийг тоолоорой, за болсон уу. За түдгэлзэж байгаа, За дараачийн санал хураалт явуулж байя тоо гартал, бүгдээрэнгий нь төлөө өгөөд хамгийн их олон саналтай нь үлдэх нь 4 хүнийх. За Мөнхөөг нэрээ авсан гэж үзэж болох уу. Санал хураах уу. За тэгвэл Мөнхөөг. Түрүүн өөрөө татгалзлаа гэсэн шүү дээ. Санал хураалт явуулах уу. За Мөнхөөг АИХ-ын орлогч даргад сонгое гэсэн

2.

саналтай депутатууд гараа өргөө За буулга

288-р тойргийн депутат С.Баяцогт:

-Их Хурлын дарга аа, процетуртай холбогдуулж нэг санал хэлэхгүй бол, энд та татгалзсан, түдгэлзсэний нь авахгүйгээр шууд 7 хүнээ 7 хүний төлөө хэн дандаа за гэсний нь төлөө гэсний нь аваад абсолют олонхоор нь узэхгүй бол нэг хүн 4 хүний төлөө саналаа өгөх зарчмаар явна шүү дээ.

Ж.Гомбожав: -420-иосоо татгалзсан, түдгэлзсэн гэдгий нь хасчихаар тэр за гэдэг нь гараад ирнэ шүү дээ.

-Нэг хүн 4 хүний төлөө саналаа өгнө гэдэг зарчмаар явахгүй болбол

Ж.Гомбожав: -Үгүй 4-ийн төлөө өгөх биш, 7-гийн төлөө ч өгч болно.

-Би нэг ганц уг хэлчих уу.

Ж.Гомбожав:

-За Мэнхеөг татгалзаж байгаа депутатууд гараа өргөө За тоолоорой Тэрэлтээ тоолж байгаа юу энэ дунд, за тоолчих сон уу түдгэлзэж байгаа нь Мэнхеөг түдгэлзэж байгаа нь Мэнхеөг ярьж байна. Түдгэлзэж байгаань Тэгэхээр та нар тэгж байна, нэлээд нь болбол санал хураая гэж байна. Олонхи нь санал хураалгая гээд байна шүү дээ. Үгүй та нар, харин тэгнэ л дээ тэгнэ, жаахан хүлээж бай. Би турүүн ярьсан шүү дээ. 7 хүн дээрээ санал авчихъя. Хамгийн олон санал авсан 4 хүн сонгогдоно ингээд бугдээрээ тохирсон шүү дээ. За Мэнхеөгийн талаар санал хураалт дууслаа. Одоо Моёор

Д.Дожоо-дорж: -Би нэг ганц уг хэлчихъе. Болох уу, цор ганцхан секунт Энэ чинь одоо багийн хурал бишээ, улсын хурлыг удирдах гэж байгаа хүн чинь бас нэг хурал удирдах нэг ухаантай, ур авьяастай хүн байх хэрэгтэй юм. Энэ дотор чинь чухам ямар хүн байна вэ энийг бас бодолцооч ээ.

Сайн

Ж.Гомбожав: -Тийм учраас та бүгд л болгоол доо, тунгааж байгаад их зөв хүнээ олоод л сонгох хэрэгтэй байна. За Моёор, Моёорыг АИХ-ын орлогч даргад сонгоё гэсэн депутатууд гараа өргөө. Моёор МоАН-аас нэр дэвшиж байгаа тийм ээ, Бат-Үүл ээ. За тоолчихсон уу, за Моёорыг татгалзаж байгаа нь, за болсон уу, За түд-

гэлзэж байгаа нь, Мөёорыг түдгэлзэж байгаа нь. За Мөёорын талаар санал, хураалт дууслаа. За Лоохууз, Лоохуузыг АИХ-ын орлогч даргад сонгоё гэсэн саналтай депутатууд гараа өргөе. Тоологчид ясан бэ? За жаахан хулээж байгаарай, Лоохууз гуайн юут хулээж бай, тоологчид бэлэн биш байна. Нэг тоогос нэг авья гэсэн,

тоогоо нэгтгэчихсэн уу, За Лоохуузын талаар санал авья. Лоохуузыг орлогч даргад сонгоё гэсэн саналтай депутатууд гараа өргене уу. За Лоохуузыг татгалзаж байгаа, за буулгая, за түдгэлзэж байгаа нь. Лоохуузыг түдгэлзэж байгаа нь, за буулгая. За хамгийн суулчийн хүний санал хураалт явуулъя.

52-р тойргийн депутат

Э.Бат-Үүл: -Гомбожав дарга аа, би энэ дашрамд нэг ганц юм танд анхааруулах гэсэн юм. Зүгээр яг санал асуулга эхэлхэд уг нь 4 намаас орсон намынхаа намаас оруулсан саналынхаа дагуу хураая гээд Ардын эрх сонинь эрхлэгч Балдорж гуай тэнд санал болгосны дагуу депутатууд, за тэгье гэсэн. Тэгээд намынхаа нэрийн намынхаа дарааллаар явж байснаа МоАН-ын булгээс оруулсан саналын өмнөхөн ирэхдээ зэрэг эндээс депутат I, депутат босоод угуй угуй, нэрийн дарааллаар явья гэчихсэн. Тэгэхээр зүгээр ингэж замбараагүй удирдах, удирдахдаа жаахан бодолтой удирдахгүй бол энэ чинь нэг тийм буруу ойлголт төрүүлэх янзтай болох гээд байна гэдгийг хурлын дарга анхаараарай гэж, өөрөөр хэлбэл яаж анх тохирсон яг л тэруүгээрээ хиймээр байна л даа.

Ж.Гомбожав: -Түрүүн тохирсон доо. Одоо суулчийн хүн. Одоо эргэж задлаад яадаг юм. За бэлэн уу тоологчид. Дашдондогийн талаар санал хураалт явуулъя. Норовын Дашдондог, Их хурлын орлогч даргад сонгоё гэсэн саналтай депутатууд гараа өргене уу. Дашдондогийг За буулгая, за татгалзаж байгаа, Дашдондогийг татгалзаж байгаа депутатууд гараа өргөе, за буулгая, түдгэлзэж байгаа, Дашдондогийг түдгэлзэж байгаа, за буулгая.

Утсаар хумуус ярыж байна, энийг мэдээлээд яах вэ дээ тийм ээ, тийн, энийг дарлаа би, та бүгдийн зөвшөөрснөөр би энэ бичгийг дарлаа шуг. За тоогоо нааш нь өгчих.

За би энд ирсэн тоонуудыг хэлж байя. Та нар бичээд тэгээд шалгаруулж байна биз дээ. Түргүчийн ирснийг.

Соронзон хальстай  
тулгаж нийлсэн

Бичээч

М.Бурмаа БУРМАА

Л.БАТЦЭЦЭГ

1991.XI.21

Кассет № 14

11.05-11.20

Арлын Их Хурлын дарга Ж.Томбожав: ... Моондой

|            |     |       |
|------------|-----|-------|
| Зөвшөөрсөн | 399 | 95%   |
| Татгалзсан | 5   | 1,19% |
| Түдгэлзсэн | 16  | 3,80% |

Батбаяр

|            |     |        |
|------------|-----|--------|
| Зөвшөөрсөн | 317 | 75,47% |
| Татгалзсан | 64  | 15,38% |
| Түдгэлзсэн | 39  | 9,28%  |

Жагай

|            |     |       |
|------------|-----|-------|
| Зөвшөөрсөн | 324 | 77,1% |
| Татгалзсан | 59  | 15,0% |
| Түдгэлзсэн | 37  | 8,8%  |

Д. Менхеэ

|            |     |       |
|------------|-----|-------|
| Зөвшөөрсөн | 261 | 62,1% |
| Татгалзсан | 116 | 27,6% |
| Түдгэлзсэн | 43  | 10,2% |

М. Мөөор:

|            |     |
|------------|-----|
| Зөвшөөрсөн | 121 |
| Татгалзсан | 224 |
| Түдгэлзсэн | 75  |

Ц.Доохууз

|            |     |
|------------|-----|
| Зөвшөөрсөн | 250 |
| Татгалзсан | 125 |
| Түдгэлзсэн | 45  |

### Дашлонлог

Зөвшөөрсөн 135

Татгалзсан 199

Тудгэлзсэн 86

Ж.Гомбожав: -Энэ дээр ямар нэгэн яриа байна уу?

132 дугаар тойргийн депутат С.Чулдуунбаатар: -Би үнэндээ эсэхийг мэдэхгүй байна. Бид турүүн орлогч даргаар нэр дэвшигдсэн депутатуудын намтрыг дэлгэрэнгүй танилцаагүй болох учраас тодруулах нэг шаардлагатай зүйл сонссон. Энэ юу гэхээр Их Хурлын орлогч даргад нэр дэвшигдэж харьцангуй олонхийн санал авч байгаа депутат өйтбаяр, депутат Мөнхээ нарыг өх, хүү хоёр гэдэг юмуу, иймэрхүү яриа байна. Хэрэв энэ үнэн үү? Хэрвээ үнэн бол бид олонхийн санал авснаар нь сонгочихвол хожмоо ямар нэгэн яриа хөөрөө гарах болов уу, угүй болов уу гэдгийг Их Хуралд хэлэх нь зүйтэй байх аа.

33 дугаар тойргийн депутат Д.Мөнхэе: -Тэр бол үнэн. Тийм учраас би турүүн Жагай орсон нөхцөлд татгалзана гэж санал хэлсэн. Ийм учраас одоо нэрээ авч байна. Миний төлөө санал өгсөн улсад их баярлалаа. Жагай найдвартай орсон учраас би нэрээ авч байна.

Ж.Гомбожав: -Өөр яриа байна уу? Байхгүй бол Д.Моондой, Т.Жагай, Н.Батбаяр, Ц.Лоохууз ийм дөрвөн хүн үлдэж байна гэж би ойлгож байна.

Энэ дөрвийг Ардын Их Хурлын орлогч даргаар сонгое гэсэн саналтай депутатууд гараа өргөе.

Зөвшөөрсөн

Татгалзсан

Тудгэлзсэн 7. Олонхийн саналаар Ардын Их Хурлын орлогч даргаар Д.Моондой, Т.Жагай, Н.Батбаяр, Ц.Лоохууз нар сонгогдлоо.

3.

Ардын Их Хурлын дарга, орлогч дарга нараар сонгогдсон хүмүүсүүдийг энэ хурал удирдах байранд урьж байна.  
Ардын Их Хурлын дарга, орлогч дарга нараар сонгогдсон хүмүүст баяр хүргэе./Алга ташив/

Ж.Томбоожав: -БНМАУ-ын Ардын Их Хурлын даргаар сонгогдсон нөхөр Ж.Уртнасан, орлогч даргаар сонгогдсон Ц.Лоохууз, Т.Жагай, Д.Моондой, Н.Батбаяр наарт депутат та оухний нэрийн өмнөөс баяр хүргэж цаашдын үйл ажиллагаанд нь амжилт хүсье./Алга ташив/

Ардын Их Хурлын дарга, орлогч дарга наарт одоо хэлэлцүүлэх гэж байгаа шинэ Үндсэн хууль, хавсралт хуулиудыг дэд ерөнхийлөгч, Улсын Бага Хурлын дарга нөхөр Р.Гончигдорж гардуулна.

Р.Гончигдорж: -Их Хурлын эрхэм дарга, орлогчид, Их Хурлын депутат аа. Юуны өмнө Их Хурлын дарга, орлогчид та оухэнд Бага Хурлын нэрийн өмнөөс баяр хүргээд Улсын Бага Хурлаас Улсын Их Хуралд өргөн барьсан Монгол улсын Их цаазын төсөл, мөн Улсын Бага Хурлаас Их Хуралд өргөн барьсан Монгол улсын Их цаазын хавсралт хуулийн төслийг өргөн барья./Алга ташив/

Ардын Их Хурлын дарга Ж.Уртнасан: -Их Хурлын депутат хүндэт нөхөд өө. Та бид эх орныхоо түүхэн хөгжлийн нэн эгзэгтэй зурvas мөчид эх орныхоо тусгаар тогтнол, сайн сайхны бэлэг тэмдэг болсон Үндсэн хуулийг хэлэлцэж батлах нэн хариуцлагатай, хүндтэй, дурсгалтай уйл явдлын босгон дээр тулж ирээд байна.

Үндсэн хуулийн тухай манай Хурлын дарга түруун хэллээ. Энэ бол хамтын оюун ухааны бүтээл юм гэж. Хамтын оюун ухааны бүтээлийг бид хэлэлцэхдээ хамт олноороо, сэтгэл зорилго нэгтэй хэлэлцэж шийдвэрлэнэ гэж бодож байна.

Энэ хуулийг хэлэлцэхэд бид эх орныхоо сайн сайхан, ашиг тусын төлөө гэсэн чин зориг, нэгэн сэтгэлээр оролцно

4.

гэдэгт та бүхэнд итгэж энэ хурлын чил ажиллагаа, өмнөө тавьсан зорилтыг амжилттай хэрэгжүүлэхийн өлзийтэй өрөөлийг шинээр сонгогдсон тэргүүлэгчдийн нэрийн өмнөөс хүсч байна.  
/Алга ташив/ Баярлалаа та бүхэнд.

Ж.Уртнасан: -Та бүгдийг бидэнд их итгэл найдвар хүлээлгэж, энэ эгзэгтэй мөчид, энэ хурлыг даргалах ийм хүндтэй уүрэг хүлээлгэсэн явдалд баярлаж байна. Баярлалаа. Та бүгдийн идэвхтэй оролцоо, та бүгдийн хүчин туслалцаатайгаар бид энэ ажлыг явуулахыг чин сэтгэлээсээ хэрэгжүүлнэ гэж бодож байна. Баярлалаа.

Манай Их Хурлыг удирдах, өнөөдрийг хуртэл хурлыг даргалаж байсан манай туршлагатай Их Хурлын дарга нехер Ж.Гомоожав, түүний орлогч наарт та бүгдийн нэрийн өмнөөс баяр талархал хүргэе./Алга ташив/

Завсарлага

Соронзон хальстай  
тулгаж нийлсэн

Бичээч

Ж.НАРАНТУЯА

Ө.ОЮУНЧИМЭГ

1991.XI.11  
Кассет № 15  
II.45-II.00

одоо Их хурлын урьдчилан төлөвлөсөн программын дагуу Их хурлын дэгийг хэлэлцэх ажилд орьё гэж бодож байна. Дэг хэлэлцэхтэй холбогдуулж Их хурлын депутатуудаас гаргах санал байвал одоо сонсоё.

389 дүгээр тойрог-Бат-Очир -Энэ их хурлын уйл ажиллагааны явцад төрийн тамга хурал удирдаж байгаа дарга нарын гарч байх уу? Үүнийг зүгээр тодруулж асууя.

Уртнасан -Их хуралдааны явцад төрийн тамга өренхийлэгчид байгаа. Энэ хэвээрээ байх болно.

Их хурлын депутатуудаа! Тэгэхээр хэлэлцэх журмын дагуу билд дэгийнхээ асуудалд орж байна. Дэгээ хэлэлцэж байна.

427 дугаар тойргийн депутат Ц.Элбэгдорж -Түрүүн хурлын ёмнөх удирдлагад нэг бичиг гардуулсан. Сая танд шилжүүлсэн гэж надад хэлсэн. Энэ МоАХ-ноос депутатууддаа хандсан ийм хундэтгэлийн бичиг гаргасан юм. Энэ ямар нэгэн өргөн барих бичиг юмуу шаардах хуудас бишээ. Хундэтгэлийн бичиг байгаа юм. Үүнийг уншиж депутатуудад танилцуулаач ээ гэсэн хүсэлт байна.

Уртнасан-Дэгийг урьдчилан тараасан учраас манай депутатуудад танилцаж байгаа байх. 427 дугаар тойргийн Их хурлын депутат Ц.Элбэгдоржийн хүсэлтийг хэрэгжүүлье.

Манай Их Хурлын дарга Гомбожав гуай сая надад энэ хундэтгэлийн бичгийг гардуулсан юм. Энэ хундэтгэлийн бичгийг та бүхэнд уншиж сонордуулья.

-Хурлын даргаа санал байна.

-За.

282 дугаар тойргийн депутат Лхагвасурэн -Тэгэхээр хурлын дундуур, хэлэлцэх хэргийн төлөвлөгөөнд ороогүй юмуу, дэгд ороогүй асуудлуудаар хүн санал тавибал хэлэлцүүлээд шийдвэрлэж баймаар байна. Одоо шууд дэгээ л хэлэлцээ гэсэн саналтай байна.

Уртнасан-Тэгвэл анхааралдаа авлаа. Үнээс хойш энэ баярын бичиг,

мэдүүлэх бичиг, өргөх бичгийг та бүхний санал авч байж хэлэлцэж сонордуулж байя. Одоо нэгэнт бид дэгээ хэлэлцэе гэж ингэж тогтвол учлаарай нөхдүүд минь, санал хураагаад шийдчихье.

Уртнасан-Дэгээ хэлэлцэе гэсэн депутатууд гараа өргөнө уу.

Уртнааан-Ер нь олонхи нь байна. Дэг хэлэлцэхээс татгалзаж байгаа хүн байна уу,

Уртнасан-Байхгүй байна.

Уртнасан-Түдгэлзэж байгаа депутат байна уу?

Уртнасан-Байхгүй байна.

Уртнасан-Ийм учраас хурлын хэлэлцэх асуудлын дагуу дэгээ хэлэлцэх ажилд орьё.

Дэгийг та бүхэнд урьдчилан тараасан учраас нэгдсэн нэг санал хүсэлт авья гэсэн санаа байсан юм. Энүүгээр санал гарахгүй байна. Ийм учраас шууд дэгийнхээ зүйл тус бүрээр хэлэлцээд явья гэсэн саналтай байна.

Уртнасан-Дэгээ шууд хэлэлцэж эхэлэе. Ямар санал байна вэ, депутатууд, зүйл тус бүрээр. Нэгдүгээр бүлэг. Хуралдааны ерөнхий журмын талаар. Нэгдүгээр зүйл. Хуралдааны зарчим.

-Ардын Их Хурлын хуралдааны үйл ажиллагаанд депутатууд ард түмний нийтлэг эрх ашиг, үндэсний эв нэгдэл, териийнхэе хуулийг дээдлэн, дотоод журмыг чанд сахин, асуудлыг чөлөөтэй, ажил хэрэгчээр хэлэлцэн, цөөнхийг хүндэтгэж үндсэн дээр Ардын Их Хурлын/ үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол хуралдаанд оролцсон нийт депутатуудын ердийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. гэсэн нэгдүгээр зүйл байгаа юм.

-Булгээр нь хэлэлцвэл ясан юм бэ?

Уртнасан-Арай хурдавчилъя гэвэл булгээр нь хэлэлцэж болох юм. Татгалзахгүй бол.

391 дүгээр тойргийн депутат Лхагва -Энэ нэгдүгээр зүйл дээр нэгдүгээр булгийн, нэгдүгээр зүйлийн эхний энэ өгүүлбэрийн дараах АИХ-ын хуралдаанд депутат бус, Улсын бага хурлын гишүүн зөвлөх эрхтэй оролцно гэсэн энэ өгүүлбэрийг АИХ-ын хуралдаанд Улсын бага хурлын гишүүдийг урилгаар оролцуулж болно гэсэн ийм утгаар оруулбал ясан юм бэ гэсэн санал байна.

Уртиасан -Зөвлөх эрхтэй гэдгийг урилгаар гэж сольё гэж үү?  
Лхагва -Тийм.

354 дугаар тойргийн депутат Бороодой -Сая дээр гаргасан хүний санал байна. АИХ-ын хуралдаанд депутат бус Улсын бага хурлын гишүүд зөвлөх эрхтэй оролцоно гэснийг бүрэн хасах саналтай байна. Энэ эхний нэгдүгээр зүйлд оруулахгүйгээр Дараагийн хоёрдугаар зүйлд нь оруулж, зөвхөн тэр нам, олон нийтийн байгууллага, хөдөлмерчдийн төлөөлөгчид радио, хөвлөл мэдээллийн ажилтиуудын нэгэн адил оролцуулах саналтай байна. Тэр өгүүлбэрийг хасаад.

290 дугаар тойргийн депутат Цэвээндорж -Би тэр саяны саналыг дэмжих байна. Доор оруулна. Улсын бага хурлын гишүүн зөвлөх эрхтэй оролцоно гэдгийг бүрэн хасна. Харин цөөнхийг хундэтгэн үзнэ гэдэг дээр тодруулга хийхгүй бол болохгүй нь ээ. Бид цөөнхийгээ хундэтгэж байгаад л олонхийн саналаар баталчихна. Тийм учраас цөөнх тодорхой хэмжээний 50-иас дээш хүн цөөнх нь болсон тохиолдолд дахин санал хураалгах эрхтэй, тайлбарлаж байгаад дахин санал хураалгах эрхтэй гэсэн тодруулга нэмбэл ясан юм бэ.

369 дугаар тойргийн депутат Пүрэвдорж -Би турүүчийн санал гаргасан хоёр депутаттай санал нэг байна. Нэгдүгээр зүйлийн төгсгөлийн хэсэгт орсон бага хурлын гишүүд Их хурлын хуралдаанд зөвлөх эрхтэй оролцоно гэснийг тэр чигээр нь хасаад, хоёрдугаар зүйлд АИХ-ын хуралдаан нээлттэй хийж байх үед бусад нэхдүүд ямар хэмжээнд оролцож байна энэ хэмжээнд оролцуулах бодолтой байна.

25 дугаар тойргийн депутат Л.Энэбиш -Зарчмын ийм нэг юм байна. Туруун Их хурлын хуралдааны эхэлж байгаа юм шиг хоёр едер болоход энэ горимын, дэгийн талаар зөндөө санал гарсан шүү дээ. Бид асуусан шүү дээ. Энэ саналыг бид дахиад л ярина. Ийм саналдуудыг яах юм бэ гэх дээр зэрэг үүнийг аваад, нэгтгээд засвар оруулах юмаа гэж хэлчихээд одоо шинээр эхэлж байгаа юм болбол их ойлгогдохгүй байна. Тэгвэл бид дахин саналаа хэлэх хэрэгтэй. Энэ авсан санал, тэр нэг цутглуулсан хуралдааны чинь ажиллагааны үр дүн гэж байна уу үгүй юу. Хэрвээ тэрийг саналыг тусгахгүй одоо эхэлнэ гэвэл бид туруун ярьсан юмаа давтаад саналаа хэлмээр байна. Байхгүй бол саналаа хэлье. Энэ дотор хэд хэдэн юмнууд урьдчилан

шийдэгдсэн учраас хасах нь зүйтэй юмнууд байгаа.

Нэгдүгээр зүйл дотор булэг дотор би тэр саналыг дэмжих байна.  
Хоёр, гурав дээр санал хэлж болохгүй ю.

Депутатууд -Болохгүй болохгүй. Зөвхөн нэгээ ярьж байна.

55 дугаар тойргийн депутат Ал्यасурэн -Энэ бид хоёр өдөр ярилцаад тэрний хэмжээнд тохиролцсон зарим асуудлаар энэ дэгд жижиг хэмжээний засвар хийсэн байгаа шуу дээ. Тэр хийсэн засварыг сролшуулаад энэ дэгийг хэлэлцвэл ясан юм бэ гэсэн нэгдүгээрт ийм горимын санал байна. Хоёрдугаарт, энэ дэгийн булгуудийг, эхлээд дэгийнхээ бүтцийг узье. Дэгийн энэ булгуудийг хулээн зөвшөөрч байгаа юмуу угүй ю. Ийм нэгдүгээр булэг нь хуралдааны үндсэн журам, хоёрдугаар булэг нь Их цаазыг хэлэлцэх асуудалд зоридулагдсан булэг байгаа шуу дээ. Гуравдугаар булэг бол АИХ-ын шийдвэр гаргах, нийтлэх журам гэх мэтчилэнгээр булгууд байж байгаа. Энэ булгуудийг хулээн зөвшөөрч байгаа юмуу угүй ю. Үүний өмнө Их цааз дээрээ тусдаа дэгтэй байя, Засгийн газар, Бага хурлын тайланг хэлэлцэхэд дэгтэй байя гэсэн хуртэл санал гарч байсан юм. Ингээд үүнийг бид энэ дээр нэг мөр тогтох авмаар байна. Нэгдүгээрт. Хоёрдугаарт, уржигдар, очигдэр та бүгдийн саналыг дагуу хийсэн засвар л Гомбожав даргад байгаа, надад ч гэсэн байгаа. Үүнийг уул нь танилцуулж, хэлэлцвэл бидний хуралдаан шуурхай явах байх гэсэн бодолтой байна. Тэгээд дараа нь булэг дотроо зүйлтэй, зүйлийг авч хэлэлцэе.

Өөр нэг санал бол та бүхэн энэ дээр нэг юмыг ойлгох хэрэгтэй байх аа. Нэгдүгээр зүйл дээр бид тэр депутат бус Улсын бага хурлын гишүүнийг зөвлөх өрхтэй оролцохыг больё гэж байна. Энэ зөвлөх өрхтэй оролцож байгаа болохоос биш таслах өрхтэй оролцогүй. Тийм учраас бид Их цаазыг тодорхой хэмжээгээр хэлэлцэж, ойлгоц авсан тул эд нарыг зөвлөх өрхтэй оролцуулах нь зүйтэй байх гэсэн саналтай байна.

283 дугаар тойргийн депутат Шагдарсурэн -Бидний өмнө уг хэлсэн, санал гаргаж байгаа депутатуудад нэг зүйлийг хэлье гэж бодсон юм. Ер нь өнөөдөр терийн тогтолцоо бол бид байгаа байдлаар нь хэлэхэд шилжилтийн үеийн ийм тогтолцоо. Их, бага хурал нийлж

мэдүүлэх бичиг, өргөх бичгийг та бүхний санал авч байж хэлэлцэж сонордуулж байя. Одоо нэгэнт бид дэгээ хэлэлцээ гэж ингэж тогтвол учлаарай нөхдүүд минь, санал хураагаад шийдчихье.

Уртнасан-Дэгээ хэлэлцэе гэсэн депутатууд гараа өргөнө уу.

Уртнасан-Ер нь олонхи нь байна. Дэг хэлэлцэхээс татгалзаж байгаа хүн байна уу,

Уртнасан-Байхгүй байна.

Уртнасан-Түдгэлзэж байгаа депутат байна уу?

Уртнасан-Байхгүй байна.

Уртнасан-Ийм учраас хурлын хэлэлцэх асуудлын дагуу дэгээ хэлэлцэх ажилд орьё.

Дэгийг та бүхэнд урьдчилан тараасан учраас нэгдсэн нэг санал хүсэлт авья гэсэн санаа байсан юм. Энүүгээр санал гарахгүй байна. Ийм учраас шууд дэгийнхээ зүйл тус бүрээр хэлэлцээд явья гэсэн саналтай байна.

Уртнасан-Дэгээ шууд хэлэлцэж эхэлэе. Ямар санал байна вэ, депутатууд, зүйл тус бүрээр. Нэгдүгээр бүлэг. Хуралдааны өрөнхий журмын талаар. Нэгдүгээр зүйл. Хуралдааны зарчим.

-Ардын Их Хурлын хуралдааны түйл ажиллагаанд депутатууд ард түмний нийтлэг эрх алтиг, үндэсний эв нэгдэл, терийнхөө хуулийг дээдлэн, дотоод журмыг чанд сахин, асуудлыг чөлөөтэй, ажил хэрэгчээр хэлэлцэн, цөөнхийг хүндэтгэж үндсэн дээр Ардын Их Хурлын үндсэн хуульд өөреөр заагаагүй бол хуралдаанд оролцсон нийт депутатуудын ердийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Гэсэн нэгдүгээр зүйл байгаа юм.

-Бүлгээр нь хэлэлцвэл ясан юм бэ?

Уртнасан-Арай хурдавчилъя гэвэл бүлгээр нь хэлэлцэж болох юм. Татгалзахгүй бол.

ЗГІ дүгээр тойргийн депутат Лхагва-Энэ нэгдүгээр зүйл дээр нэгдүгээр бүлгийн, нэгдүгээр зүйлийн эхний энэ өгүүлбэрийн дараах АИХ-ын хуралдаанд депутат бус, Улсын бага хурлын гишүүн зөвлөх эрхтэй оролцно гэсэн энэ өгүүлбэрийг АИХ-ын хуралдаанд Улсын бага хурлын гишүүдийг урилгаар оролцуулж болно гэсэн ийм утгаар оруулбал ясан юм бэ гэсэн санал байна.

мэдүүлэх бичиг, өргөх бичгийг та бухний санал авч байж хэлэлцэж сонордуулж байя. Одоо нэгэнт бид дэгээ хэлэлцэе гэж ингэж тогтвол учлаарай нөхдүүд минь, санал хураагаад шийдчихье.

Уртнасан-Дэгээ хэлэлцэе гэсэн депутатууд гараа өргөнө уу.

Уртнасан-Ер нь олонхи нь байна. Дэг хэлэлцэхээс татгалзаж байгаа хүн байна уу,

Уртнасан-Байхгүй байна.

Уртнасан-Түдгэлзэж байгаа депутат байна уу?

Уртнасан-Байхгүй байна.

Уртнасан-Ийм учраас хурлын хэлэлцэх асуудлын дагуу дэгээ хэлэлцэх ажилд орьё.

Дэгийг та бүхэнд урьдчилан тараасан учраас нэгдсэн нэг санал хүсэлт авья гэсэн санаа байсан юм. Энүүгээр санал гарахгүй байна. Ийм учраас шууд дэгийнхээ зүйл тус бүрээр хэлэлцээд явья гэсэн саналтай байна.

Уртнасан-Дэгээ шууд хэлэлцэж өхөлзее. Ямар санал байна вэ, депутатууд, зүйл тус бүрээр. Нэгдүгээр булгээ. Хуралдааны ерөнхий журмын талаар. Нэгдүгээр зүйл. Хуралдааны зарчим.

-Ардын Их Хурлын хуралдааны чийл ажиллагаанд депутатууд ард түмний нийтлэг эрх ашиг, үндэсний эв нэгдэл, төрийнхөө хуулийг дээдлэн, дотоод журмыг чанд сахин, асуудлыг чөлөөтэй, ажил хэрэгчээр хэлэлцэн, цөөнхийг хундэтгэж үндсэн дээр Ардын Их Хурлын/ үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол хуралдаанд оролцсон нийт депутатуудын ердийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. гэсэн нэгдүгээр зүйл байгаа юм.

-Булгээр нь хэлэлцвэл ясан юм бэ?

Уртнасан-Арай хурдавчилгээ гэвэл булгээр нь хэлэлцэж болох юм. Татгалзахгүй бол.

391 дүгээр тойргийн депутат Лхагва -Энэ нэгдүгээр зүйл дээр нэгдүгээр булгийн, нэгдүгээр зүйлийн эхний энэ өгүүлбэрийн дараах АИХ-ын хуралдаанд депутат бус, Улсын бага хурлын гишүүн зөвлөх эрхтэй оролцно гэсэн энэ өгүүлбэрийг АИХ-ын хуралдаанд Улсын бага хурлын гишүүдийг урилгаар оролцуулж болно гэсэн ийм утгаар оруулбал ясан юм бэ гэсэн санал байна.

байж парламентат ёсыг бий болгож байгаа юм шиг ингэж ойлгогддог. Тэгэхэд нэг танхим гэдэг юмуу Бага хурлынх нь гишүүд оролцох үнэхээр шаардлагатай гэж би хувьдаа үзэж байна. Яагаад гэвэл монголын парламент гэдэг бол хоёр их хурал, бага хурал гэсэн ийм хоёр зүйлээс бүрдэж байна гэж ойлгож болж байгаа болбол. Энэ дээр жаахан анхаарч үзэхгүй юу нэгдүгээрт. Хоёрдугаарт, Үндсэн хууль буюу Их цаазыг хэлэлцэн, боловсруулсан, тэрэнд үнэхээр оролцож ирсэн хүмүүс байгаа бага хурлын депутат бус гишүүд бол. Энд харин ч шийдвэрлэх эрхтэйгээр оролцуулахгүй байна. Энд зөвлөх эрхтэйгээр оролцоход үнэхээр болохгүй зүйл бол байхгүй, үүнийгээ би үндсийг нь гаргах гэж оролцлоо. Энэ дээр бас анхаарч үзэхгүй юу гэж хэлэх байна.

### 320 дугаар тойргийн депутат Ч.Хилигдалай

- Энэ дэгийн нэгдүгээр зүйлийн нэгд, АИХ-ын хуралдаанд оролцсон нийт депутатын өрдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ гэж орсон байгаа. Тэгэхээр өнийг доорх байдлаар найруулсан нь зүйтэй болов уу гэж бодож байна. Цөөнхийг хундэтгэх үндсэн дээр хэлэлцэж буй асуудлын шинж байдлыг харгалзан Ардын Их Хурлын хуралдаанд оролцсон нийт депутатын олонхийн болон өрдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ гэсэн ийм санаа оруулах хэрэгтэй байх. Нэгөөтэйгүүр энэ цөөнхөө хундэтгэх гэдгээ баталгаажуулж өгөхгүй бол болохгүй нь ээ. Бид цөөнхийг хундэтгэх гэдэг зүйл оруулаад, цөөнхийнхөө саналыг харгалздаггүй ийм тохиолдол байдаг. Тийм учраас мөн зүйл дээр ингэж нэмэлт хийж өгвөл яласан юм бэ? Цөөнх өөрийн саналыг үндэслэгээтэй болохыг Их Хуралд тайлбар тавьж уг асуудлаар дахин санал хураалгах хэрэгтэй гэсэн ийм нэмэлт оруулбал зүгээр юм уу гэж бодож байна.

Ж.Уртнасан - Эрхэм депутатууд аа, нэг ийм санал байна. Бид зарим хэсэг нь шууд дэгээ хэлэлцээд өхлэх сонирхолтой байх шиг байна. Манай Адъяасүрэн орлогч даргын хэлж байгаагаар бидний хоёр өдрийн хуралдааны дун, бас манай хуучин бүрэлдэхүүн, Их Хурлыг удирдаж байсан бүрэлдэхүүн энэ дэг дээр нэлээн ажиллаж зарим засварыг хийсэн юм шиг байна. Үүнийг сонсвол бид арай цаг хожихгүй байгаа гэсэн ийм бодол байна. Хэрэв та бүгдийг хүсвэл Их Хурлын дарга, Гомбожав даргын засвар хийсэн хувилбарыг сонсвол болох уу? Эсвэл бид өөрийн гартаа барьж байгаа энэ дэгээ бариад явах уу гэдэг ийм нэг асуудал байна.

272 дугаар тойргийн депутат С.Лунаа -Нэг саналтай байна.

Бид ингээд цөмөөрөө хурал удирддаг, хуралдц оролцдог ийм л улсууд. Тэгээд дэг бол зүйл зүйлээр, өгүүлбэр өгүүлбэрээр явж цаг бармааргүй байна. Гол ажил руугаа ормоор байна шүү дээ. Энэ чинь хэн ч бодвоос. Тийм учраас засвар хийсэн тийм эх байгаа бол түүн дээр ажиллаад, ерөөсөө энэ чинь олон хоногийн өмнө авсан, энэ олон дөпүтатууд. Тэгээд өөрсдөө тус тусдаа харьцаад саналаа хэлсэн. Тун ноцтой, санал зөреөтэй юм байвал түүн дээрээ яриад, тэгээд ажил хэргийнхээ юманд шилжих талаас нь бо дохгүй бол, ерөөсөө уг хөөцөлдөөд ингэсээр байгаад өчнөөн хоног, цагийг бардаг ийм уламжлалыг энэ хуралдаанаас тасалбал яласан юм бэ гэдэг санал байна.

336 дугаар тойргийн депутат Ө.Ганхуяг -Энэн дээр нэг гуравхан санал байна. Нэгдүгээрт, энэ санал хураалтын асуудлыг ер нь нэг тийшээ болгож шийдмээр байна. Илээр юм уу, нууцаар хураах нь сайн мэдэгдэхгүй байна. Жишээлбэл, энэ цахим тоолуураар санал хураах болох юм бол энэ чинь одоо илээр хурааж байгаа юм уу, нууцаар хурааж байгаа юм уу, хамгийн суулд тэр 9 дүгээр зүйл дээр нууцаар санал хураах үед тооллогын комисс ажиллана гэсэн нэг тийм зүйл байгаа. Тэгэхээр эндээс үзэхэд энэ цахим тоолуур чинь ил санал хураалт юм уу гэж ойлгогдоод байна. Энийг нэг тийш нь болгоод, энэ техникийг ажиллуулах юм бол ажилд нь оруулахгүй юм бол бид их хугацаа алдах нь, олон удаа санал хураана. Нэгдүгээрт ийм санал байна.

Хоёрдугаарт, энэ нэгдүгээр бүлэг дээр бас нэг санал юу вэ гэхээр энэ хуралдааныг зарим үед хаяж гарах ийм тохиолдол бас гарч болзошгүй юм. Зарим хүмүүс. Энэ бол өмнөх хуралдааны зарим ажиллагаанаас харахад. Тийм учраас энэн дээр тэр хуралдааныг хаяж гарахыг хориглоно гэж заамаар байна. Хэрэв хаяж гарсан тохиолдолд дараагийн хуралдаанд тэр депутатыг оролцуулах уу, угүй юу гэдэг дээр санал хурааж шийдэх энэ журмыг нэлээн чангальж өгмөөр байна, дотоод журмыг.

Соронзон хальстай тулгаж  
нийлсэн

Д.БАЯНДУУРЭН

Бичээч Энэбиш

1991.XI.XI  
Кассет № I6  
I2.00-I2.I5

336-р тойргийн депутат Ө.Ганхуяг

Эцэст нь хурлынхаа дэгийг шууд хэлэлцмээр байна. Булэг, булгээр нь.

Мөн энэ булэг дээр нэг зүйл байна. Энэ хуралдааныг үдээс өмнө I3 цаг хүртэл үргэлжлүүлэхээр дэг дотор заасан байна. Харин тэр бидэнд тараасан хөтөлбөр дээр I3 цаг 30 минут хүртэл үргэлжлүүлэхээр заасан ийм хоёр зүйл байгаа шуу. Ийм учраас энэ дэгэд зааснаар байвал ясан юм бэ гэсэн ийм саналтай байна.

340 лугээр тойргийн депутат Б.Сумьяа. Нэгдүгээр зүйлийн I-д нэмж хэлмээр зүйл байна. Энэ зүйл бол агуулгын хувьд дотооддоо зөрчилтэй байна.

Асуудлыг шийдвэрлэх үндэс нь цөөнхийг хүндэтгэх үндсэн дээр. Үндэс нь юу юм бэ гэхээр цөөнхийг хүндэтгэх үндсэн дээр. Тэгээд санал хураах зарчим болохоор хуралдаанд оролцсон нийт депутатын ердийн олонхийн саналаар гэж байна. Тэгэхлээр үндэс гэдэг нь арай биш байхaa. Цөөнхийн санал ч биш, цөөнхийг хүндэтгэх үндсэн дээр. Тэгэхээр найрлага зүйн хувьд ч буруу юм. Ийм учраас юу гэж найруулах вэ гэвэл асуудлыг чөлөөтэй ажил хэрэгчээр хэлэлчэж хуралдаанд оролцсон нийт депутатын ердийн олонхийн саналаар шийдвэрлэн, цааш нь үргэлжлүүлээд цөөнхийн саналыг тэгж тэгж хүндэтгэж үзнэ гэж. Цөөнхийг хүндэтгэнэ гэдэг бол асуудлыг шийдвэрлэх үндэс болсон мэтээр энд орсон нь тохирогчийн юмаа.

Эцэст нь Ардын Их Хурлын хуралдаанд депутат биш улсын бага хурлын гишүүдийг энд зааснаар оруулах нь зүйтэй гэж бодож байна. Тэр бол олон хууль тогтоомжуудыг баталсан, энэ их цаазыг ч боловсруулахад холбогдолтой улсуудыг чинь оролцуулахгүй бол болохгүй гэж бодож байна.

210 лугаар тойргийн депутат П.Хаалгар: Тэгэхээр Гомбожав даргын өчигдэрийн хэлсэн саналын дагуу боловсруулсан зүйлүүд дээр өр нь өчигдөр саармаг болчихжээ гэж би хэлж байсан. Ийм ч асуудал зүй ёсоор гарах гээд байсан. Тэгэхээр одоо өр нь ингээд

## 2.

хэлээд дуусгачихъя. Ийм учраас бүлэг булгээр нь цаг хэмнэхийн тулд ярчихгүй юмуу гэсэн ийм санал байна.

Бүлэг булгээр нь шуурхай саналаа хэлчихээд тэгээд өчигдөрийн засвар хийсэн дээр яривал яласан юм бэ? За тэр цөөнх гэж яриад байгааг тодруулъя гэж улсууд хэлчихлээ. Би улсын бага хурлын депутат биш гишүүдийг хуралд оролцуулах ийм саналтай байна. Энд хөдөлмөрчдийн төлөөлөгчдийг оролцуулъя гэж байна. Би зүгээр тодруулах гэж байна. Энэ төлөөлөгчид гээд сонгогдчихсон байж байна уу, одоо ингээд хүн орж ирэх байна уу, ямар зохион байгуулалттай юм бол. Энийг ойлгохгүй байна. Нэгэнт хөдөлмөрчдийн төлөөлөгчид оролцож байгаа юм чинь бусад олон урилгаар сууж байна. Өнөөдөр гол үйл ажиллагаанд оролчихсон, олон хууль баталсан ингээд бага хурлынхаа хичнээн депутат биш ч гэсэн гишүүдээ энүүнд оруулах нь зйтэй гэж бодож байна. Зөвлөх өрхтэй гэж хуучин төслөөр нь байвал яласан юм бэ гэсэн ийм санал байна.

За нэгдүгээр зүйлийн 3-т тогтоосон журмын дагуу гэсэн уг байна. Тогтоосон журам гэдэг нь тогтчихсон юм байна уу, ямар байна. Энэ дээр бас тодруулж тайлбар сонсмоор байна. За депутатуудын, мөн нэгдүгээр бүлэг дотор ярьж байна. Нэгдүгээр булгийн 5 дугаар зүйлийн I-д депутатуудын саналыг нэгтгэсэн байвал зохино гэж. Энэ чинь ямар утга байна, энд бас л эргэлзээ байна. Нэгдчихсэн, нэгтгэнэ гээд бас нэлээд байх юм уу. Энэ дээр тайлбар сонсмоор байна.

За ингээд булгээр нь хэлж байгаа учраас шууд юнуудаа хэллээд явчихъя.

Мөн 5 дугаар зүйлийн 4 дүгээр дээр Ардын Их Хурлын ажлын зохион байгуулалтын дүрэм гэж. За яахав энэ дүрэм тарсан энэ дээр санал хэлэх юм байх гэж ойлгож байгаа.

24 дүгээр тойргийн депутат Р.Хатанбаатар: I дүгээр зүйлийн

## 3.

I дээр депутатуудын санал өгөөд байгаа зүйл дээр яръя гэж бодсон юм.

Депутат бус улсын бага хурлын гишүүд зөвлөх эрхтэйгээр оролцно гэдэг дээр. Энэ дээр би депутат Сумьяа, Хаадгар гуай настай санал нэгтэй байна. Улсын Бага Хурал гэдэг бол Ардын Их Хурлаас өөрөө сонгон байгуулсан төрийн эрх барих байгууллага. Өөрөөр хэлбэл Ардын Их Хурлын хоёр чуулганы хооронд Ардын Их Хурлын төрийн эрх барих дээд үүргийг гүйцэтгэж байсан ийм байгууллага. Энэ Улсын Бага Хурлын гишүүд маань бол бүхэл гарсан хууль дүрэм, үүний дотор энэ орж ирээд байгаа Их цаазын төслийг хэлэлцэж оруулж ирж өргөн барьж байгаа хүмүүс. Ийм учраас энэ хүмүүсээрээ хүмүүсээ хуралдаа зөвлөх эрхтэйгээр оролцуулах нь зүйтэй гэж хэлэх гэсэн юм.

257 дугаар тойргийн депутат Ч.Цэрэндагва: Дэгийг хэлэлцүүлэх журмын талаар саналаа хэлье гэж бодож байна. Зарим нөхдүүд одоогийн хурлын удирдлагын гар дээр байгаа, депутатын гар дээр байхгүй ийм засварласан хувилбарыг хэлэлцүүлэхээр санал гаргажээ. Үүнтэй би санал нийцэхгүй байна. Хэлэлцүүлэгийг одоо депутатуудын гар дээр байгаа энэ үндсэн хувилбар дээрээ түшиглэж хэлэлцүүлэх нь зүйтэй. Хэрвээ урьд өмнө гаргасан саналуудыг нэгтгээд дүгнээд аль зүйл, бүлэг дээр нь ямар ямар санал гарсныг нэгтгээд тооцоолчихсон ийм хувилбар байвал тухайн зүйлийг хэлэлцэхдээ харин тэр гаргасан саналыг шууд хэлэлцүүлээд, дахин гаргуулахгүйгээр хэлэлцүүлээд явбал арай хурдан болох болов уу гэж ингэж бодож байна. Түүнээс одоогийн депутатуудын гар дээр ерөөсөө байхгүй өөр нэг хувилбараар дэгийг хэлэлцүүлнэ гэдэг бол болохгүй байх гэсэн ийм саналтай байна.

Нэгдүгээр зүйл дээр сая гишүүдийн санал гаргасан. Улсын Бага Хурлын гишүүдийг зөвлөх эрхтэй, өөреөр хэлбэл уг хэлэх эрхтэйгээр оролцуулъя гэсэн саналыг дэмжиж байна.

Уртнасан:

Эрхэм депутатуудаа. Засварласан дэг гэж ийм хувилбар байх-

гүй юм байна. Энд нийтдээ 6 хүний 10-аад саналыг нэгтгээд түүвэрлэсэн байна. Энийг бид хүчин төгөлдөр гэж хэлэлцэх аргагүй юм. Тийм учраас та нөхцийн гар дээр байгаа дэгийг шууд энэ барыш байгаагаараа хэлэлцээд явах нь зүйтэй гэсэн ийм саналтай байна.

59 дүгээр тойргийн дэпутат Ч.Нүрэвзорж: Товчлон яаналаа хэлье. Тэр бага хурлын дэпутат бус гишүүний тухай яригдаж байна. Би үүнийг хоёр язгаар тайлбарлаж байгаа юм. Миний хувьд бол энэ хууль дүрэм батлахад оролцсон үүргийнх нь талаас биш энэ улсууд юу гэж ярыж байгаа юм гэхээр ер нь дэпутат хүн өөрөө цаанаа фракц болж байдаг, олон түмнийг төлөөлж байдаг тэр утгаар нь энд авч үзэж байгаа болов уу гэж бодож байна. Өөрөөр хэлбэл аливаа дэпутатууд цаанаа 3000-аас 10000 хүнийг төлөөлж байдаг. Тийм утгаар нь энэ дээр яригдаж байгаа бол зөвлөх эрхтэй орох уу, ажиглагчаар орох уу гэдэг дээр. Миний хувьд ажиглагчаар орох нь зүйтэй болов уу гэж бодогдож байна.

Яагаад гэвэл хууль тогтоомж батлагдсан талаас авч үзэхэд бусад олонхи нь энд оролцож байгаа учраас, гэхдээ тухайн үед өөрөө санал бодлоо илэрхийлэх бололцоотой гэж би үзэж байна.

Хоёрдугаар зарчмын хувьд энд дэпутатуудын булгийн тухай асуудал байна. Дэпутатуудын булгийн тухай асуудлыг ерөөсөө намын булэг давамгайлсан ийм байдлаар л энд ерөнхийдөө санаа нь орсон байна. Тэрнээс өнөөдөр манай нийгэмд үзэл сурталжуулсан нийгмийг үзэл сурталжуулж байсан нэг үе. Өнөөдөр бол улс төржүүлэх ийм хандлага нэлээд байж байгаа. Энэ ч гэсэн энэ дэг юман дээр нэлээд тусаж байна. Энэ дээр намын гишүүн бус дэпутатууд нэгдэн нэг булэг ахлагчтай сонгон ажиллаж болно. Энэ дээр заавал намын гишүүн бус, ер нь дэпутат булэг байгуулах асуудлыг чөлөөтэйгээр оруулах ийм саналтай байна. Өөрийнхөө санаачилгаар намын гишүүн ч бай, намын гишүүнээрээ ч биш ер нь бусад байдлаараа, жишээлбэл иргэнлэг байдлаараа, ялангуяа энэ дээр бол бид нар өнөөдөр ард түмнийг төлөөлэх ёстой. Иргэний үүднээс хандах ёстой. Аливаа нэгэн намын байдлаар туйлшрах хандлага нэлээд байгаа. Бид нарыг өнөөдөр ард түмэн хүлээж байгаа. Тийм учраас бид иргэнлэг

## 5.

байдлаар энэ асуудалд хандах ёстой. Сонгогчид маань ямар байдлаар энэргүү юуг хулээж байгаа сонгогчдынхоо эрх амгийн түднээс хандах ёстой гэж бодож байна.

Их хурлын даргаа нэг асуулт байна.

15 дугаар тойргийн депутат Лунцээжанцан. Тэгэхээр дэг билэнд нэлээд эрт тараасан, хэд хэдэн удаа санал авсан байгаа. Тэгэхээр манай их хурлын удирдлага сая шинээр сонгогдлоо. Та бүхэнд туслах хүч байна уу? Энэ хумуусийн гаргаад байгаа санал дээр ажиллах ажлын хэсэг байгуулагдсан уу? Ажлынхаа <sup>хэс</sup> гийг аппаратаасаа байгуулах юм уу? Эсвэл одоо их хурлын бүрэлдэхүүн дотроосоо байгуулж оруулах юм уу гэсэн нэг ийм горимын шинжтэй асуулт байна.

258 дугаар тойргийн депутат Ш.Гунгаадорж: Тэгэхлээр их хурлын даргад хүсэх хүсэлт байна. Эхлээд энэ дэгээ хэлэлцэх асуудлаа дэгтэй эхэлмээр байна. Хоёр санал гарч байна. Дэгийг яж хэлэлцэх вэ гэж. Булгээр яръя гэсэн санал, байна. Зүйлээр яръя гэсэн санал байна. Ингэхлээр булгээр яриад хөнгөрөхгүй байх гэж миний хувьд бодож байна. Жишээлбэл сая нэг хүн нэгдүгээр зүйлийг яръж байгаад хойшоо хараад 5 дугаар зүйлийн талаар ярьлаа. Тийм учраас системтэй, түргэн түргэн зүйл зүйлээр яриад явчихвал түргэн болох байхаа.

Нэгдүгээр зүйлийн талаар санал байна уу? За байна, байхгүй.

За хоёрдугаар зүйл гээд ингээд явбал түргэн болох юм биш бийзээ. Ингээд тийм нэг системгүй, хойшоо, ургашаа орсон ийм байдлаар энэ хурал сунжрах байхаа гэж бодож байна. Тийм учраас зүйлээр нь яръя гэдэг дээр одоо саналтай байна. Энийг яж хэлэлцэх вэ гэдгээ тогтмоор байна. Тэгэхгүй бол нэг боссон хүн булгээр яриад, нэг боссон хүн зүйлээр яриад ингээд учир нь одохгүй байна. Нэгдүгээр зүйлийн талаар би тэр улсын бага хурлын гишүүдийг депутат биш гишүүнийг зөвлөх эрхтэй оруулах нь зүйтэй гэж бодож байна. Нэгэнт энэ их хурлаас энэ бага хурлаа

байгуулсан учраас энэ хүмүүстэй зөвлөх, өөрөөр хэлбэл энэ талаар уг хэлэхэд эрх олгоно гэсэн уг. Таслах шийдвэр гаргах эрхгүй шүү дээ. Тийм учраас энэнд айх, болгоомжлох юм байхгүй байхаа.

Сумъяагийн саналтай нэг байна. Тэр цөөнх гэдгийг тасалж бага хурлын депутат биш гишүүн зөвлөх эрхтэй гэдгийг хооронд тасалж оруулах нь зүйтэй байх. Ер нь цөөнхийн саналыг хулээж авах талаар бид нар энэ тал дээр ишлээд тодорхой юм оруулахгүй бол урьд урьдын хурлаас харж байхад цөөнхийн саналаар шийднэ гээд тэгээд олонхийн саналаар шийдчихдэг. Ийм учраас энэ цөөнх бол тэр санал дээрээ зогсдог, дахиж хэлэлцүүлдэг эрх байх ёстой байхаа. Энийг нь энд баталгаажуулж оруулж өгөх нь зүйтэй байх гэсэн ийм санал байна. Нэгдүгээр зүйл дээр.

309 дүгээр тойрог, депутат Д.Батбаяр: Тийм учраас саяны Гунгаадорж гуайн хэлж байгаа санал дээр булгээр уу, зүйлээр уу гэдгийг шууд санал хураагаад тогтчихъё. Зүйлээр гэдэг дээр нь саналтай байна. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, нэгдүгээр зүйл дээр Ардын Их Хурлын хуралдаанд депутат бус улсын бага хурлын гишүүний асуудал дээр бол хоёр асуудлаар оролцуулахыг дэмжих байна. Үндсэн хуулийн төсөл хэлэлцэх, улсын бага хурлын тайлан хэлэлцэх асуудал дээр зөвлөх эрхтэй оролцуулаад, бусад дээр нь урилгаар оролцуулах нь зүйтэй гэж үзэж байна.

Уртнасан:

Эрхэм депутатууд аа. Та бүгдийн саналыг хулээж авлаа. Тэхээр манай аппаратад зөвлөхийн хурлын, зөвлөхийн аппарат ажиллаж байгаа. Гэхдээ бидний бодож байгаагаар депутатуудаас сонгосон редакцийн групп томилон ажиллуулах нь зүйтэй болов уу гэсэн ийм санал байна. Хэлэлцэхдээ бид эмх журамтай, дэгтэй дахиж эргэж буцахгүйн тулд зүйлээрээ юу булгээрээ юу гэдгийг санал хураагаад шийдчихье.

Ийм хоёр асуудлыг шийдвэрлээ гэж бодож байна.

Редакцийн дэгийг засаж ариутган шүх, редакцийн групныг томилоход хичнээн хүний бурэлдэхүүнтэй, хэн хэнийг оруулах вэ гэдгийг депутатууд санал гаргана уу.

Редакцийн груп томилчихьё. Депутатууд дотроос. Дэгийн асуудлаар.

290 дүгээр тойргийн депутат С.Цэвээндорж: Редакцийн групийг Ардын Их Хурлын дарга, орлогчид тэндээсээ томилсон нь дээр байх л даа.

Дэгийн талаар редакцийн груп байгуулах уу, угүй юу гэдэг дээр санал хураах нь зүйтэй. Миний хувьд байгуулах хэрэггүй болов уу гэж бодож байна. Яагаад гэвэл тэнд аппарат ажиллах байна. Зүйл зүйлээр нь хэлэлцээд явахад тэрэн дээр дахиад бас нэг редакцийн групийн хэрэггүй байх гэж бодож байна.

Уртнасан:

Бага Хурлын сонорт ийм тогтоолын төсөл танилцуулъя. Хуралдааны дэгийн төслийг эцэслэн боловсруулах ажлын хэсгийг байгуулах тухай.

БНМАУ-ын Ардын Их Хурлаас тогтоох нь. БНМАУ-ын Ардын Их Хурлын II хуралдааны дэгийн төслийг эцэслэн боловсруулах ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Хэстийн ахлагчид Санжаагийн Баар - Нэгдүгээр тойргийн депутат, <sup>Гишүүдэд.</sup> Ходойн Шүрэвдорж 125 дугаар тойргийн депутат, Доржийн Гантэмэр 62 дугаар тойргийн депутат, Дондовын Ламзав 39 дүгээр тойргийн депутат, Лувсанцамбын Дашням 22 дугаар тойргийн депутат, Цэрэндоогийн Энхбат 23 дугаар тойргийн депутат, Егнэнгийн Моголцог 154 дүгээр тойргийн депутат. Ийм долоон хүний бүрэлдэхүүнтэй ажлын групныг томилъё гэсэн ийм санал байна. Энэ дээр санал хураах уу.

НИЙЛСЭН

Машиндсан:

*Б.Мурда*  
Б.Энхтуяа

Оюун

1991-XI-II  
Кассет № 17  
12.15-12.30

Ж.Уртнасан /Ардын Их Хурлын дарга/-За энэ ажлын хэсгийг баталъя гэсэн депутатууд гарцаа өргөнө уу. За олонхи нь байна. Татгалзаж байгаа хүн байна уу? Татгалзаж байгаа депутат байна уу? I9 хүн татгалзаж байна. Түдгэлзэж байгаа хүн байна уу? II хүн түдгэлзэж байна. Олонхийн саналаар энэ дэгийг эцэслэн боловсруулах ажлын хэсгийг байгуулъя. За энэ тогтоолыг баталъя. За баярлалаа. Олонхи нь байна. За саяын нэр дурдсан депутатууд ажлын хэсгийн байранд ирэхийг урьж байна.

Баяр, Пүрэвдорж, Гантэмэр, Ламжав, Дашиям, Энхбат, Монголцог ийм хүмүүс, та бидний саналыг эцэслэн боловсруулж дэгд редакци хийх юм.

За одоо та бүгдийн саналын дагуу бас энэ дэгийг зүйлээр хэлэлцэх уу, булгээр хэлэлцэх уу гэсэн санал байгаа юм. Бид эргэж мартахгүй, эргэж буцаад байхгүйн тулд бидний санал зүйлээр хэлэлцээд, саналаа хэлээд, нэгтгээд явчихвал арай хурдан болох болов уу гэсэн бодолтой байгаа юм. Одоо санал хураая. Энэ дэгийг зүйлээр хэлэлцье гэсэн депутатууд гарцаа өргөнө уу. За баярлалаа олонхи нь байна. Булгээр хэлэлцье гэсэн депутатууд саналаа өгнө уу. Депутатуудын өрдийн олонхийн саналаар дэгийг зүйл тус бурчлэн хэлэлцье. За ингээд дэгээ ургэлжлүүлэн хэлэлцуулэх ажилд орьё. Нэгдүгээр зүйл, хуралдааны зарчим дээр нэмж санал гаргах депутатууд байна уу?

С.Чулуунбаатар /132 дугаар тойргийн депутат/-Тэгэхлээр тэр цөөнхийг хүндэтгэх гэдэг тухай асуудлаар депутат нөхөр Сумьяагийн гаргасан саналыг бүрэн дэмжиж байна. Ингээд түүнд тэр саналыг тодруулах зорилгоор дараах санал хэлэх гэсэн юм.

Цөөнхийг хүндэтгэх үндсэн дээр гурав хуртал, өөрөөр хэлбэл цөөнх болсон талаас, депутатын тайлбар сонсож, дахин санал хурааж болно гэж байгаа юм. Ийм тохиолдолд бас нэг ийм юм гардаг. Энэ удаа цөөнх болчихоод дараагийн ээлжинд олонхи болдог ийм тохиолдол бий. Тэгэхлээр тийм нөхцөлд эхлээд олонхи

байсан нь дахин цөөнх болоод дахиад саналаа хамгаалах гэдэг. Энэний болоод хязгааргүй удаан хугацаагаар маргалдлаг учраас энд хязгаар тогтоох ёстой. Үүний тулд цөөнх нь, дахин санал хураалтаар олонхи болсон тохиолдолд цөөнх дахин нэг удаа санал хураалгаж болно гэж. Тэгэхлээр эцэстээ юу гэсэн уг вэ гэхээр зэрэг аливаа нэг асуудлаар гурваас илүү санал хураахгүй гэдгээ хатуу тогтвол цаг хугацаагаа хэмнэхэд ч зарчмын хувьд хэрэгтэй болох байх. Энэ дэгийг бид дахин задалж хэлэлцэхгүй байх тэр зорилгын үүднээс би Их Хурлын дарга танд нэг санал хэлэхэд, зүйл зүйл дээр ингэж санал сонссоны үндсэн дээр хэрэв зарчмын маргаантай санал гарвал тэргүүгээр нь шууд санал хураагаад зүйл бүр дээр, тэгээд орхиод орхиод, өөрөөр хэлбэл үлдээхээ үлдээгээд явчихгүй болбол хэлэлцүүлгийн явцад буцаад л нэгдүгээр зүйл руугээ 9,10 дугаар зүйлээс ороод ирж болзошгүй гэдгийг бодвол зүгээр болов уу гэж бодож байна.

Л.Дашням /22 дугаар тойргийн депутат/ -Би энэ дэгийг ерөнхийд нь ухарч байгаа юм биш, нэг санал хэлмээр байна. Тэр зассан, өчигдрийн, уржигдрийн ажлыг тусгасан юм байхгүй биш байгаа юм шиг санагдаж байх юм. Тэгэхээр тэрийг бас жаахан бодолцмоор байна.

Негеө талаар энэ Бага Хурлын депутат бус, зөвлөх эрхтэй, бусад юмнууд байгаа Их Хурлын, би тэрийг ингэж санаж байх юм. Бүгд үлдээх хэрэгтэй. Тэгэхдээ нэг ийм горимын юм байх юм. Олон ч депутатууд ярьж байгаа. Тэрийг бол Их Хурлын удирдлагын хойно бүлэг байгаа, дарга, орлогч гэдэг дээр хэнээс яж зөвлөлгөө авах, хэнийг яж уг хэлүүлэхээ тэнд мэдэх эрхэд нь хойно бүгдийг нь оруулчихмаар, тэгэхгүй бол нээрэн ч асуудлыг ярьж байгаа үед депутат хүн цагт горимдоо хавчигдаад, зүгээр зөвлөгч хүн ярьж байгаад депутат угээ хэлэхгүй тийм тохиолдол ч гарч болох юм. Дандаа зөвлөлгөө авах хэрэггүй байж болох юм. Тийм учраас тэрийг зүгээр дарга нарын юунд, Их Хурлын дарга бол, удирдлага бол тэр зэргийн соёлтой, хэнийгээ уриад яриулах, хэнийг нь урьд нь оруулахыгаа биш эрх биш болох байх

## 3.

гэж бодож байна. Энэ юугаар Тэгээд гол хэлэх гэж байгаа санаа бол Гомбожав даргад байгаа цагаа хэмнэхийн тулд, тэр засчихсан, ер нь бас нэг оруулж байгаа энэ хуралдаанд дэгийнхээ юг харгалзаж узвэл ясан юм бэ? Энэ зүйл зүйлээр ярихдаа. Тийм санал байна.

Ш.Шагдарсүрэн /283 дугаар тойргийн депутат/ -Тэгэхээр эхний нэгдүгээр зүйлийн нэг дэх хэсэг дээр бол би ойлгоходоо энд бол болж байгаа юм шиг надад ойлгогдож байгаа юм. Яагаад вэ гэхээр, яаж энийгээ цаашид бичсэнийгээ яаж ойлгож авах вэ гэдэг л асуудал байна гэж би бодож байна. Энэн дотроо жишээлбэл депутат Чулуунбаатарын хэлсэн шиг турав гэдэг дотроо тогтох цаашаа явах уу угүй юу гэдэг асуудал дээр тогтоод явчихвал энд бичсэн зүйл бол бүрэн ойлгогдож байгаа юм шиг ингэж бодогдож байна.

Цөөнхийн саналыг хүндэтгэнэ гэдэг бол нэг санал хураагаад цөөнх болоод уг хэллээ, уг халээд тэднийг сонсоно, тэгээд санал хураана л гэсэн уг. Харин чухам хэд вэ гэдгийгээ энд бичихгүйгээр тогтоод явчихаж ингэж болох юм гэж узэж байгаа юм.

Л.Энхбаатар /178 дугаар тойргийн депутат/ -Тэгэхээр энэ нэгдүгээр зүйлийн дерөв болгож нэг зүйлийг оруулмаар санагдлаа. Түрүүн сая бид нар ардчилалд нийцэхгүй, ам шийдвэрт, ам тохиролцоонд хурчихлээ л дээ. Тэр юу вэ гэхээр ингэлээ. Ер нь хөдөлмөрчдөөс ч юм уу, байгууллагаас ч юм уу ирсэн, гаргаж байгаа санал, захидал, цахилгаан, энэ мэтийн зүйлийг бол нийтээр хэлэлцэж байж, тохиролцож гарaa өргөж, саналаа хурааж байж, ер нь тэрийг Ардын Их Хуралд сонордуулах уу угүй юу гэж, нэг ийм тохиролцоонд хурчих шиг боллоо. Тэгэхлээр энийг байж болохгүй юм. Үнэхээр хөдөлмөрчид бол өөрийнхөө төлөөлөгчдийнхөө байгууллагадаа хандаж, төлөөлөгчдийн Ардын Их Хуралд сонордуулаач гэсэн захидал, цахилгаан, хусэлт, санал, янз бурийн юм ируулж болно. Тийм эрхтэй. Энийг нь Их Хурал сонсох уурэгтэй.

## 4.

Тэгэхлээр энэ нэгийн дөрөв дээр нь Ардын Их Хурлын депутатын зүгээс, Ардын Их Хурлын депутат, байгууллага, хөдөлмөрчдийн зүгээс Ардын Их Хурлын сонорт хургуулэхээр ирүүлсэн захидал, цахилгаан, санал, хүсэлтийг тухайн үед нь танилцуулж байна гэсэн ийм зүйлийг оруулах нь зүйтэй байх. Тэгэхгүй бол бид нар хэлэлцэх асуудлыг олонхийнхоо саналаар шийдэж болно. Сонордуулах, танилцуулах юмыг цаг тухайд нь танилцуулж байх ёстой.

Ж.Уртнасан - Эрхэм депутат Энхбаатараа, таны хэлж байгаа санал чинь энэ хойно орсон байгаа шүү дээ. Хуралдааны үед иргэдээс Ардын Их Хуралд ирүүлсэн өргөдөл, лавласан зүйл, асуултыг хуралдаан даргалагч зохицуулан нийтэд зарлан сонсгоно гэсэн ийм зүйл "л" хэсэг дээр байгаа.

Д.Энхбаатар - Тэгээд түрүүн нэг ам тохиролцоонд хурчихээр чинь би энийг чинь дахиад сэргээя гэж байхгүй ю.

Б.Нүүрэй /407 дугаар тойргийн депутат/ - Нэгдүгээр зүйл дээр депутат бус Улсын Бага Хурлын гишүүдийг Их цаазын төсөл хэлэлцэх, Улсын Бага Хурал, Засгийн газрын тайлан хэлэлцэх үед зөвлөх эрхтэй оролцуулья гэсэн ийм саналыг оруулаад, бүх депутатуудаас санал хураалгах саналтай байна.

Ж.Уртнасан - 4 дүгээр зүйл болгон оруулья гэж байна уу?

Б.Нүүрэй - Нэгдүгээр зүйл дээрээ.

Ц.Лавааням /350 дугаар тойргийн депутат/ - Нэгдүгээр зүйл дээр депутат бус Бага Хурлын гишүүдийг ажиглагчаар оролцуулах саналтай байна. Яагаад гэвэл тэд эцэслэн шийдсэн материалыг бидэнд ирүүлсэн учраас тэдэнд дахин нэмж тайлбар хийх тийм цаг өгөхгүй нь зүйтэй юм гэж узэж байна. Бид өөрсдөө шийдэх ёстой.

Ж.Уртнасан - Санал давхардаж байна, за одоо гуравдугаар микрофон депутат Пүрэвдорж.

Л.Пүрэвдорж /27 дугаар тойргийн депутат/ -Тэгэхээр энд нэг ийм жаахан зөрчилтэй юм байна уу? Депутатууд бодоод үзээч. Би ч бас өөрөө жаахан эргэлзээд байна. Ерөнхий зарчим дотроо бид нар асуудлыг чөлөөтэй хэлэлцэж, ердийн олонхийн саналаар шийдвэрлэнэ гээд еренхий зарчим дотроо шийдчихээр зэрэг дотор нь очоод ердийн олонхийн саналаар шийдэхгүй юм байгаа шуу дээ. Энэ дэг дотор. Энэ хоорондоо зөрчилдэж байх шиг байна. Тийм учраас ердөө ердийн гэдгийг авчихъя, энэ эхний юун дээрээс. Тэгээд олонхийн саналаар шийдчихнэ гээд хойноо зарим асуудал нь гуравны хоёроор энэ тэр гээд явж байгаа шуу дээ. Тэгэхээр энэ нэг тийм зөрчигдэж байгаа л янзтай байна. Энийг нэг бодож үзэж ярилцвал ясан юм гэсэн. Ердийн олонхиор гэчихээд хойноо нэлээн олон юмыг ердийн олонхиор бишээр шийдэж байгаа шуу дээ. Гуравны хоёроор энэ тэр гэж байгаа юм. Энийг хэлэх гэсэн юм.

Ж.Уртнасан -За одоо нэгдүгээр зүйл дээр саналаа хураая. Тэгэхээр редакцийн групп энэ цөөнхийн гэдгийн талаар редакциийг зөвлөх эрхтэй оролцуулна гэдгээр санал хураая. Зөвлөх эрхтэй оролцуулна гэсэн депутатууд гарцаа өргөнө уу. Бага Хурлын гишүүдийг Ардын Их Хурлын хуралдаанд зөвлөх эрхтэйгээр оролцуулна гэж. За манай тоологч нар тоолообой.

За Бага Хурлын гишүүдийг Ардын Их Хурлын хуралдаанд зөвлөх эрхтэй оролцуулна гэдгээр санал хураая. Зөвлөх эрхтэй оролцуулна гэсэн депутатууд гарцаа өргөнө уу. Бага Хурлын гишүүдийг Ардын Их Хурлын хуралдаанд зөвлөх эрхтэйгээр оролцуулна гэж. За манай тоологч нар тоолообой.

Энэ дашрамд хэлэхэд үдээс хойш манай цахим техник ажиллаж эхлэх байх. Тэгвэл та бидний цагийг нэлээн хэмнэнэ гэж найдаж байна. Одоохондоо бид хуучин журмаараа гарцаа өргөж байна. Ардын Их Хурлын хуралдаанд депутат биш Бага Хурлын гишүүд зөвлөх эрхтэй оролцно.

## 6.

гэж тодотгоё гэж байна. Тэр нь зөв байх.

Ж.Уртнасан -Ардын Их Хурлын хуралдаанд депутат бус Улсын Бага Хурлын гишүүд урилгаар оролцоно, эсвэл зөвлөх эрхтэй оролцоно гэдэг дээр л бид ярьж байгаа шүү дээ. Тэгэхээр одоо бид зөвлөх эрхтэй оролцоно гэдэг дээр нь санал хурааж байна. Улсын Бага Хурлын депутат бус гишүүд зөвлөх эрхтэй оролцоно гэдэг дээр.

Энэ депутатуудыг, бас нэг санал гарсан. Ерөөсөө Улсын Бага Хурлын гишүүн, депутат биш Улсын Бага Хурлын гишүүдийг энэ хуралдаанд оролцуулахгүй, бүрэн хасъя гэсэн. Энэ саналтай депутатууд гараа өргөнө үү.

Г.Бөхчүлүүн /192 дугаар тойргийн депутат -Хурлын даргаа надад нэг санал байна. Нэг ийм юман дээр л зөрчилдөөд байх шиг байх юм. Тэгэхээр зэрэг чинь Улсын Бага Хурал гэдэг маань, ... Тэгэхлээр Улсын Бага Хурал маань Их Хурлаас батлагдчихсан байгаа. Тэгэхээр Бага Хурлын зарим гишүүдийг Их Хуралд зөвлөнө гэдэгт энэ улсууд жаахан эмзэглээд байх шиг байгаа юм. Тийм учраас депутат биш Бага Хурлын гишүүнийг Их Хуралдаа тайлбар өгөх гэдэг утгаар оруулчихвал ямар байна вэ гэсэн миний санал байна.

Ж.Уртнасан -Эрхэм депутатуудаа түүүн нэг Бага Хурлын гишүүдийн талаар, депутат биш Бага Хурлын гишүүдийн талаар эрхэм депутат Хатанбаатар тодорхой хэлсэн гэж би бодож байна. Тэгэхээр зөвлөх эрхтэй, бидэнд ирсэн энэ санал хураах юм бол энэ хуучнаар нь урилгаар оролшуулья гэдэг, зөвлөх эрхтэй оролшуулья гэдэг, хасъя гэсэн ийм гурван санал байгаа юм. Тэгэхээр бид зөвлөх эрхтэй оролшуулна гэдэг дээр сая санал хураалаа. За одоо тоо гарч байгаа байх гэж бодож байна.

Одоо Бага Хурлын депутат биш гишүүдийг энд урилгаар оролшуулна гэдэг дээр санал хураах уу?

Б.Мөнгөн /351 дүгээр тойргийн депутат/ -Ерөөсөө 427 депутат саналаа гаргахад хангалттай гэж бодож байна. Ийм учраас Их Хурлын депутат бус Бага Хурлын гишүүдийг урилгаар оролцох нь зүйтэй, заавал энд бидэнд саналаа хэлж байх шаардлагагүй гэж үзэж байна. Ийм учраас энэн дээр манай депутатууд санал нэгтэй байгаа болов уу гэж бодож байна.

Ж.Уртнасан -Бид зөвлөх өрхтэй гэдэг дээр санал хураачихлаа шүү дээ.

Ш.Бороодой /354 дүгээр тойргийн депутат/ -Ер нь Их Хурлын депутатууд бид нар зөвлөх авах ямар шаардлага байна вэ? Толгой толгойгоороо бодож, ард түмний эрх ашгийг хамгаалж энд сууж байгаа биш бил уу? Ерөөсөө энэ урьд нь зөвлөдөг маань зөвлөсөн л байх Бага Хурал. Оруулдаг юмаа авчирч оруулж л байна. Бид энийгээ өөрсдөө шийдэх ёстой. Тэгэхлээр депутат бус тэр улсуудыг заавал зөвлөгчөөр авах шаардлага юу байна? Заавал депутат бүхэн зөвлөгчтэй байдаг юм бол бас 420 хүн шаардлагатай болж байна шүү дээ. Одоо олон ургальч нөхцөлд хүнийг зөвлөнө гэдэг чинь өөрийнхөө санааг хүнд тулган хүлээлгэнэ гэсэн санаа шүү. Ер нь яг зөвлөхийн тулд зөвлөхгүй гэдгийг одоо бодмоор байна.

С.Гончиг /330 дугаар тойргийн депутат/ -Тэгэхээр энэ...

Ж.Уртнасан -Эрхэм депутат Гончиг оо, бид нэг ийм асуудлыг зарчмын хувьд шийдэж авья. Энд бид жаахан замбараатай баймаар байна. Магадгүй бид өнөөдрийн хувьд шинэдэж байх шиг байна. Нэг асуудлыг зөвшөөрсөн, татгалзсан, тудгэлзсэн гэдэг саналаа хурааж дуусгаж байж дараагийн асуудалд орж байя, нэгдүгээрт.

Хоёрдугаарт, уг хэлэх хүмүүс зөвшөөрөл авч байна уу? Тэгэхгүй бол эндээс ч, тэндээс ч яриад ингээд үймээд бид ер нь замбараагүй болох нь шиг байна.

Депутат бус Улсын Бага Хурлын гишүүдийг Ардын Их Хурлын

## 8.

хуралдаанд зөвлөх эрхтэй оролцоно гэж зөвшөөрсөн 234 хүн байна, одоо татгалзсан депутатууд гарцаа өргөнө үү. Энэ олонхи нь болчихлоо шүү дээ. Тэгэхээр уучлаарай нөхөд өө, энэ зөвлөх гэдэг дээр манай зарим депутатууд өмзэглэж байх шиг байна. Миний бодоход энэ хуулийг боловсруулсан, манай Бага Хурал гэдэг бол бидний ажлын бус цагт төрийн эрхийг барьж, энэ хуулийг боловсруулсан гишүүд, ийм учраас өөрсдийнхөө хийсэн бүтээл, өөрсдийнхөө хийсэн ажлын талаар та бидэнд ярьж таниулах, зөвлөх ийм боломж олгохын тулд энэ асуудлыг бид ингэж оруулж байна гэж ойлгож байгаа. 234 хүн зөвшөөрчээ.

Соронзон хальстай тулгаж

НИЙЛСЭН

*Антанч*

Д.АЛТАНЦЭНГЭР

Бичээч Уранчимэг

Кассет 18.1991.11.11

12.30-12.45

Ж.Уртнасан: I дүгээр зүйлийн нэгдүгээр заалтыг редакци хийгээд энэ хэвээр нь үлдээс гэсэн депутатууд саналаа өгнө үү.

Ердийн олонхийн гэдгийг редакци хийг л дээ. Ердийн олонхийн гэдэг дээр таны саналаар бол ердийн гэдгийг авья гэж байгаа шүү дээ. Энэ бол авчихаж болох л юм. Энэ дээр санал хураая. Энэ нийт депутатуудын ердийн олонхийн саналаар шийдвэрлэнэ гэдгийн ердийн гэдгийг хасъя гэсэн депутат Пүрэвдоржийн санал байгаа юм. Үүнийг зөвшөөрч байгаа депутатууд тараа өргөнө үү.

Ердийн гэдгийг хасчихаж болох л уг л дээ. Сүүлдээ гуравны нэг, гуравны хоёр гэсэн юм тараад ирвэл, энэ маань эргээд зерчилд оруулах юм байгаа.

Депутат Пүрэвдоржийн энэ редакцид оруулсан санал олонхийн саналыг авч чадсангүй.

Зөвшөөрсөн I44 байна.

Эрхэм депутатуудаа нэг ийм санал ажлын группээс ирж байна. Та биднийг нэгдүгээр зүйлийн I дүгээр заалтыг бид ингээд ерөнхийд нь хэлэлцээд редакци хийх саналуудаа гаргачихлаа шүү дээ.

I дүгээр зүйлийн I дүгээр заалтыг бид ингээд ерөнхийд нь хэлэлцээд ингээд редакци хийх саналуудаа гаргачихлаа шүү дээ. Үүнийг бид/2 дугаар зүйлийг /I дүгээр зүйлийн 2 дугаар заалтыг хэлэлцэж байх хугацаанд манай ажлын групп, та бидний саналыг редакци хийгээд, шинэчилсэн хувилбарыг бидний гар дээр тавиг, бид эргэж сонсоод батлаад явбал болох уу гэсэн санал депутатуудаас ирж байна. Энэ бол мартаагүй дээрээ шинэ сэргэг дээр нь зүйл зүйлээр нь батлаад явахад ашигтай санал юм болов уу гэсэн ийм санал байна.

Үүнийг депутатууд зөвшөөрөх үү, энэ дээр санал хураая.

Баярлалаа, бид олонхийн саналаар зөвшөөрлөө.

2.

Энэ нэгдүгээр зүйлийн I дүгээр заалт дээр манай редакцийн комисс ажиллаж байна. Бид нэгдүгээр зүйлийн 2 дугаар заалт.

З дугаар микрофон депутат Гомбожав гуай уг хэлнэ.

326 дугаар тойргийн депутат Ж.Гомбожав: Бид ердийн олонхийн санаалаар шийдэхээр асуудлууд энэ хуралдааны явцад их гарна. Түүнээс гадна гуравны хоёр, дөрөвний турвын санаалаар шийдэх асуудлууд голдуу Үндсэн хуулийн асуудлууд байгаа л даа.

Ийм учраас би энэ тараасан дэг дээр ганцхан уг нэмж оруулбал болохгүй юу гэж бодож байна. Өгүүлбэрийн төгсгөл дээр хуралдааныг дэгд өөрөөр заагаагүй бол оролцсон нийт депутатын ердийн олонхийн санаалаар шийдвэрлэнэ гэж. Дэгд бол хувь дөрөвний гурав, гуравны хоёр гэдэг нь цаанаа их бодогдсон байгаа шүү. Түүнийг бас бодохгүй юу гэж. Дэгд өөрөөр заагаагүй бол гэсэн уг <sup>нэмж</sup> оруулах саналтай байна.

I дүгээр тойргийн депутат С.Баяр: Их Хурлын даргаа, нэг зүйл асууя. Сая энэ ажлын хэсэгт орлоо л доо. Саяны таны хэлсэн зүйлийг олонхийн санал авсан энэ саналыг би ойлгосонгүй. Ердийн олонхийг ердийн гэдгийг хасна гэдгийг <sup>болж</sup> олонхийн санал авсангүй. Энэ дээр ямар ч редакци орох арга байхгүй.

Ардын Их Хуралдаанд депутат бус Улсын Бага Хурлын гишүүн зөвлөх эрхтэй оролцоно гэдгийг олонхиороо баталчихлаа. Тэгэхээр ажлын хэсэг маань ямар редакци хийх үүрэгтэй болоод байгаа бол? Нэгэнт шийдээд явж байгаа юман дээр бол редакци оруулах арга байхгүй. Ийм ийм санаануудыг редакцилиад хуулийн хэллэгэнд оруул гэвэл өөр хэрэг л дээ.

Их Хурлын гишүүд нийтээр ингээд хэлэлцээд шийдэж байгаа юман дээр редакци оруулах арга байхгүй байна шүү дээ.

Ж.Уртнасан: Депутат Баяраа, Тэгэхээр Гомбожав даргын санал бол ийм л байна шүү дээ. Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол гэдгийн ард Үндсэн хууль болон энэ дэгд гэсэн ийм уг

нэмээд болох юмаа гэж. Депутат Пүрэвдоржийн гаргасан санал бол ердийн олонхийн гэдэг хэвээрээ үлдчихлээ. Ингээд энэ хэвээрээ явъя. Миний ойлгож байгаагаар тийм байгаа шуу дээ.

Өөрөөр хэлбэл ердийн олонхийн гэдгийг депутатууд маань хэвээрээ үлдэг гэсэн ийм саналтай байна гэж бодож байгаа. Тийм учраас энэ бол хэвээрээ үлдэх юмаа. Өөрөөр хэлбэл бид дээд талд нь редакци хийчихлээ шуу дээ. Энэ дэгд болон Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол гэж. Тэгэхээр энэ дэгд маань Үндсэн хуулийг хэлэлцэхэд Гуравны хоёр гэсэн ийм юм явж байгаа учраас энэ бол зргээд харшахгүй болчихож байгаа юм. Энэ хэмжээнд редакци хийвэл болох болов уу гэж бодож байна.

С.Баяр: Тэгэхээр таныг санал хураалгаад л олонхийн санал авсан зүйлийг л тусгаад явах үүрэг ажлын хэсэгт байна гэж ойлгож байгаа шуу дээ.

Өөр редакци хийх эрх байхгүй.

Ж.Уртнасан: Ажлын хэстгийн гол зорилго бол олонхийн саналыг авсан тэр өгүүлбэр, тэр үг, үсгээр энэ дэгийг өөрчлөөд явна гэсэн үг юм.

Энд цөөнхийн саналыг сонсоод дахин санал хураана гэсэн ийм өгүүлбэр ороод байгаа юм. Сумьяа гуайн санал юм. Үүнийг манай редакцийн групп болгоох болов уу гэж бодож байна.

Цөөнхийн саналыг сонсоод санал хурааж явна гэсэн.

Нэгдүгээр зүйлийн нэгдүгээр заалтыг бид ингээд редакцийн комисст шилжүүлээд, хоёрдугаар заалт руугаа орох уу?

143 дугаар тойргийн депутат Г.Зуунай: Энэ дээр нэг тодруулга хийх үү? Тэгэхээр энэ олон депутатууд чухал санал хэлсэн л дээ. Цөөнхи гэдгийг яах вэ гэж. Тэгэхээр Үндсэн хууль хэлэлцэхэд бол цөөнх гэдэг хүнд үе их тохиолдано..

Өнөөдрийн байдлаас ч харлаа гэсэн, бид олонхиор асуудлыг гүяджүүлдэг ийм гашуун туршлага Монгол оронд их дэлгэрсэн. Үндсэн хууль дээр бол цөөнх автагдах үе их олон ирнэ. Тийм учраас би энэ цөөнхийг редакцид хэлэхийн өмнө санал хураалгах шаардлагатай гэж бодож байна.

Яагаад гэвэл цөөнх саналаа гурав хүртэл хураалгах эрхтэй байх хэрэгтэй. Түүнээс ганцхан удаа нэг хоёр хүн юм хэлээд олонхи гээд ингээд хаагдчихдаг. Түүнээсээ болоод хурал бухимдлаг, бүлэг, бүлгээрээ ярьдаг, тасардаг ийм туршлага Улсын Бага Хуралд хүртэл бий.

Тийм учраас бид цөөнхи бол саналаа З хүртэл удаа хураалгах эрхтэй гэж тодорхой оруулах ёстой.  
— Энэ<sup>дээр</sup>+Их Хурлын даргыг санал хураалгаж өгнө үү гэж хүсэлт тавьж байна.

Нэг хураагаад болчихож болно, хоёр болж болно, дээд захын хугацаа гурав.

Ж.Уртнасан: Депутат Зуунайгийн саналыг бид хүлээж авч байна. Нэгдүгээр зүйл дээр бас анхаарууштай байх. Үнэхээр Үндсэн хуулийг хэлэлцэхэд бодитой санал гаргаад цөөнх тэр санал дээрээ тууштай зогсвол бид бас I, 2, 3 хүртэл удаа санал хурааж шийдэх хэрэгтэй болох нь ээ.

15 дугаар тойргийн депутат Л.Лундээжанцан: Гурав хүртэл хураана гэхээр нэг дээр нь олонхи, нөгөө дээр нь цөөнх гэсээр байгаад ингээд шовхыг нь хэзээ авах юм бэ гэдэг юм гарах уу? эсвэл нэг тухайн нэг асуудлаар З хүртэл байх уу? эсвэл цөөнхийн саналаар З хуваах уу? тухайн нэг асуудлаар З удаа санал хураах уу гэдгийг л бас нэг ялгамжтай тогтоохгүй бол болохгүй юм шиг байна.

Ж.Уртнасан: Тухайн асуудал дээр цөөнхийн саналыг ...

Д.Лүндээжанлан: Цөөнхийг гурав хураана гэхээр дараагийнх нь цөөнх болчихоод ингэж, ингэж явсаар байгаад 15, 16 болчихож,... тухайн асуудал дээр л З удаа.

ЗТ дүгээр тойргийн депутат Баяраа: Редакци уншьяя.

I дүгээр зүйлийн I.дээр. Ардын Их Хурлын хуралдааны үйл ажиллагаа нь депутатууд, ард түмний нийтлэг эрх ашиг, үндэсний эв нэгдэл, төрийнхөө хуулийг дээдлэн, дотоод журам, дэгийг чанд сахин, асуудлыг чөлөөтэй ажил хэрэгчээр хэлэлцэн, ардын Их Хурлын хуралдаанд оролцсон нийт депутатын олонхийн саналаар шийдвэрлэнэ.

Хэрэв цөөнх хүсвэл З хүртэл хүн тайлбар хийж, дахин санал хураалгаж болно. Нэг асуудлаар З хүртэл удаа санал хураана. Ингээд санал хураалгаад, тэгээд зөвлөх өрхтэй оролцох нь хэвээрээ.

Ж.Уртнасан: Саяны депутатын санал дээр сөрөг саналтай хүн байна уу?

427 дугаар тойргийн депутат Ц.Элбэгдорж: Энэ дээр сая Гомбожав гуай их сайхан санал гаргасан л даа. Дэгд өөрөөр заагаагүй бол гэсэн... энэ угийг оруулах юм бол тэр ердийн олонхийн гэдгээр явчихаж болно. Дэгд өөрөөр заагаагүй бол гэдгээр. Тэр З хүртэл удаа санал хураана гэсэн энэ асуудлыг энд тусгахгүй байх нь зөв байхаа. Ер нь саналыг заримдаа хураасаар байгаад арван хэд ч хураадаг ийм тохиолдол бий. Нэг зүйл дээр санал хураагаад байх биш, нэг зүйл их олон талаар яригдлаг. Тэр бүр дээр санал хураах асуудал гарч ирдэг. Ингэхээр энэ З хүртэл гэсэн ийм хязгаарлалт тавьж өгөхийн шаардлагагүй. Депутатууд аяндаа өөрсдөө ойлгож байгаа. Хэдийд, яаж санал хураах вэ? гэдэг асуудал хэлэлцүүлгийн явцад их тодорхой болно гэж бодож байна. Гомбожав гуайн саналыг дэмжиж байна. Тэр угийг энд оруулж өгөөч ээ гэж хүсч байна.

Ж.Уртнасан: Түүнийг редакцийн группт оруулж байгаа.

261 дүгээр тойргийн депутат Д.Пүрэв: Тэгхээрээнэ санал хураалтанц үнэхээр их нарийн асуудал юм. Бага Хурлын туршилааас ингээд үзэхэд нэг асуудлаар 2 хүртэл удаа санал хураагаад бид энэ асуудлыг шийдэж чадахгүй ээ. Энэ 5 хүртэл хураах ёстой. Эхлээд олонхи нь цөөнхийг сонсоод, цөөнх олонхи болоод, эргээд түрүүчийн олонхи болсон нь, эргээд цөөнх болоод, ингэсээр явсаар байгаад 5 дахь удаагийн хураалтан дээр найдвартай шийднэ, онц маргаантай асуудлыг. Ийм учраас нэг асуудлаар ерөөсөө анх удаа санал хураагаад олонхи боллоо, дахиад цөөнх үгээ хэлээд, хоёр дахь удаагаа олонхи болох юм бол цааш хураахын шаардлага байхгүй. Ингэж сөөлжөөд яваа юм бол үнэхээр бид хоёр хүртэл удаа санал хураалтаар уг асуудлыг шийдэж чадахгүй шүү. Ийм учраас би 5 хүртэл хурааж болно гэж үзэж байна. I-5 удаа нэг асуудлаар, ийм тодорхой санал байна.

Ж.Уртнасан: Тэгхээр ийм томъёолол гарч ирж байх шиг байна. Депутатуудын саналыг З хүртэл санал хураая гэсэн нэг хэсэг байна. 5 хүртэл санал хураая гэсэн ийм хувилбар байна. Ерөөсөө санал хураалтын тоог заахаа больё гэсэн ийм хувилбар байх шиг байна. Энэ гурав дээр саналаа хураах уу?

З хүртэл удаа санал хураана гэдэг дээр санал нэгтэй байгаа депутатууд гараа өргөнө үү?

Соронзон хальстай тулгаж

Нийлсэн

Д.ЧУЛУУНЦЭРГ

79  
I991.XI.II.  
Кассет № I9  
I2.45-I3.00

Ж.Уртнасан - З хуртэл гэдгээс татгалзаж байгаа депутатууд гараа өргөнө үү! Бид ингэж тохирсон шүү дээ. Нэг асуудлыг зөвшөөрсөн, татгалзсан, тудгэлзсэн гэдгээр саналаа хураачихаад, дараагийн зүйлдээ орж байя гэсэн.

Б.Лханаасүрэн /I9I-р тойрог/:

-Би үүн дээр саналаа хэлчихье. Энэ саналаа З хуртэл гээд шийдчих шиг боллоо. Тэхээр энэ саналаа Ардын Их Хурлын хуралдааны нийтлэг журам гэдгийн 2-ын "З"-д яг ийм асуудал бий. Бид дэгтэйгээ сайн танилцах хэрэгтэй. Үүн дээр 2-ын "з"-г ургэлжлүүлээд, нэг асуудлыг шийдвэрлэхэд З хуртлэх удаа санал хурааж болно гэж бичвэл бидний саяны нэмж оруулах гээд байгаа зүйл үүн дээр болчихно.

Хуралдааны үндсэн журам дээр цөөнхийг хүндэтгэнэ гэсэн ерөнхий зарчим байх нь зүйтэй. Үүн дээр нарийн оруулмааргуй байна. Энэ шийдсэн асуудал дээр I0-р зүйлийн 2-ын "з"-д нэмээд оруулчихмаар байна.

Бас нэг асуудал байна. Бид Ардын Их Хурлын дарга, орлогч дарга нараа сонгоод санал хураасан, баталсан тогтоолоо хэвээ батлахыг асуумаар байна. Дараа нь та нар бүрэн эрхээ эдлэх ёстой. Дэгд ингэж заасан байгаа юм. Ардын Их Хурлын тогтоол заавал гарна шүү дээ.

Ж.Уртнасан - Бид үнэхээр тогтоолгүй хурал удирдаад эхлэчих шиг боллоо. Гомбожав даргаа, тогтоолоо гаргачихъя.

Танхимаас: -Даргаа, бид гараа өргеед сонгочихсон шүү дээ.

Ж.Уртнасан - Тогтоолоо батлах нь хууль зүйн хувьд зөв байх л даа. Батласныг бид ойлгож, баярлаж байгаа юм. Тогтоолыг албан ёсоор батлах хэрэгтэй юм байна шүү.

2.

Ж.Гомбожав -Давхар батлаж болох юм. Түрүүнд батласан шүү дээ. Би тогтоол дээр гарын үсэг зурахад бэлэн байна. Та, бид батлачихсан, тиймээс би Ардын Их Хурлын дарга, орлогч дарга нар хүчинтэй байгаа гэж ойлгож байна шүү дээ.

Ж.Уртнасан -Гомбожав даргаа, тогтоолыг албан ёсоор депутатуудад уншиж сонсгоод, гар өргөж батласны дараа бид санаа амармаар байна.

Ж.Гомбожав -Тэгье, би одоо гарын үсэг зураад баталчихъя.

З хүртэл санал хураая гэдэг дээр зөвшөөрсөн 226 депутат, олонх нь байна. Татгалзсан 32, түдгэлзсэн 23 хүн байна. Манай тоологчтой холбоостой юм уу, энэ тоо баланс барихгүй байна.

5 хүртэл санал хураая гэдгийг зөвшөөрч байгаа депутатууд гараа өргөе. Үүн дээр хэрэг байна уу. Эсвэл З гэдгээр олонх гээд тогтчих уу. За баярлалаа, тэгвэл бид редакццаа гүнийг З хүртэл унча санал хураах нь зүйтэй гэсэн редакц хийе.

Тийм учраас ийм редакц орох нь байна шүү дээ. Цөөнхийн саналыг сонссон дараа дахин санал хураалт явуулна. Гэхдээ энэ асуудлаар З-аас илүүгүй удаа санал хураанча гэсэн мэдэх бий.

Р.Гончигдорж -Ийм санал байна. Уучлаарай, эрхэм депутатууд аа! Дэгээр бид нэлээд сайн дэг гаргаад авах нь зүйтэй. Түүнээс гадна бид сонгосон Их Хурлын даргад тодорхой эрх мэдлийг дэгээр өгчихвэл суулдээ даргын эрхийг жэтгүүлээд байна гэсэн шүүмжлэл гарахгүй амар байна байх. Тийм учраас зайлшгүй шаардлагатай гэж үзвэл З хүртэл санал хураах бөгөөд зайлшгүй шаардлагатай гэж Ардын Их Хурлын дарга үзвэл дахин санал хураах асуудлыг шийдвэрлэн санал хурааж болно. Тэхээр зарим үед яг З гэчихсэн учраас энэ үед, энэ нь бидний хувьд хууль болчихож байгаа юм. Гэтэл Үндсэн хуулийн зарим асуудал дээр, Бага Хурал дээр I6 хүртэл хураасан нь шүүмжлэгддэг. Тэр нь юу юм бэ? Ардын Их Хурлын даргад ерөнхий мэдрэмж байна шүү дээ. Түүнийхээ дагуу Их Хурлын даргад эрхийг нь өгсөн нээлттэй нэмэлтэйгээр тогтовол ясан юм бэ гэсэн санал байна.

3.

Ц.Элбэгдорж /Ардын ИХ Хурлын 427-р тойргийн депутат/

-Цөөнхийн санал хэлье. Санал хураалтанд хязгаар тогтоогүй байя гэдгийн учир нь З хуртэл хураая гээд олонхоор шийдлээ шүү дээ.

Сая З хуртлэх гээд олонхоор тогтлоо, тэхээр З-аас илүү хураах шаардлага гарвал хурал орхиж гарах нь байна шүү дээ. Тийм учраас санал хураалтан дээр хязгаар тогтоохгүйгээр хурлын даргад Бага Хурлын даргын хэлдгээр ийм эрх хэмжээг өгөөд явчихвал бидний үйл ажиллагаа боломжтой болно. Хэрэв З хурчихээд, цаашаагаа энэ нь уг нь Үндсэн хууль шүү дээ, бид ямар нэгэн асуудлыг зүгээр хэлэлцэж байгаа биш. Магадгүй хэдэн удаа бид хэлэлцэж, хоорондоо ярьж байгаад, санал хураагаад шийдэх асуудал олон гарна шүү дээ. Уг өгүүлбэр, үсэг, үгнээс гардаг шүү дээ. Тийм учраас би энэ саналыг дахин тавьж байна. Санал хураалтан дээр хязгаар тогтоох шаардлаггүй, энэ асуудлыг Хурлын удирдлагын мэдрэмжээр энэ асуудлаа өгчихье. Хэрэв дахин санал хураах шаардлагатай гэвэл түүн дээр асуудал гаргана.

Т.Гантөмөр /Ардын Их Хурлын I40-р тойргийн депутат/:

-Санал хураалтан дээр Бага Хурлын гишүүдийн алддаг зүйл юу бэ гэхээр миний бодлоор саналаа олон хураадаг. Энэ нь танхимын сэтгэл зүйд их автдаг. Бид олон түмнийг төлөөлж ирсэн тийм уур амьсгалтай, гэтэл олон дахин хураах нь танхимины сэтгэл зүйд их автаж, цаашдаа олон түмний хүсэл бодлыг илэрхийлэх байдлаас хөндийрэх учраас цөөхөн З-аар хураах нь зүйтэй гэж бодож байна.

Ж.Уртнасан -Эрхэм депутатууд аа! энэ нь их өгзэгтэй асуудал юм. Хуралдааны явцад санал зөрөлддөг, ялангуяа Үндсэн хууль дээр бид шийдэж чадахгүйгээр санал зөрөлдөх зүйл анги олон гарах байх гэж бодож байна. Тийм учраас нээлттэй орхиё гэж санал оруулж байгаа Элбэгдорж, Бага Хурлын дарга Гончиг-

## 4.

дорж нарын санал нийлж байх шиг байна. Үүн дээр би санал хураалгаж шийдье гэж бодож байна. З гээд тогтоочих уу, эсвэл үүнийг зайлшгүй шаардлагатай үед дахин санал хураах эрхийг хурлын даргад үлдээе гэсэн нээлттэй, онгорхой үлдээх уу гэдэг дээр санал хураамаар байна.

Тиймээс З хүртэл хураагаад, боллоо гэдэг дээр хатуу зогсох депутатууд гарцаа өргөнө үү. Түрүүнд өргөсөн түүгээр болох уу. Хэрэв Бага Хурлын дарга Гончигдорж, Элбэгдорж нарын саналын дагуу зайлшгүй шаардлагатай гэж үзвэл дахин санал хураахыг Их Хурлын даргад олгоё гэсэн нээлттэй хэсгийг зөвшөөрөөд, нэмэлт болгоё гэж оруулж байгаа хэрэг шүү дээ. Депутатууд аа, ийм юм гарах байх шүү.

З болчилоод, маргаад, зарим хүмүүс хурал хаяад гарах гээд байвал мэдрэмжээр гурав дахь, дөрөвдэх удаа хураалгаж болно шүү дээ. Тэр эрх л оддох уу гэж оруулж байгаа хэрэг шүү дээ. Депутатууд аа, ийм юм гарах байх шүү.

Хурлын удирдлага энэ танхимд нөлөөлөхгүй байхын тулд бид нэлээд хожим гарцаа өргөж байна. Үүнийг та бүхэн олонхийг дагаад байна гэж битгий ойлгоорой гэдгийг хүсмээр байна. Бид та бүхэнд нөлөөлөхгүйн тулд нэлээд хожим та бүхний саналын дараа өөрсдийнхээ саналыг илэрхийлж байх тийм боломж олгоно уу.

Үүн дээр Бага Хурлын дарга Гончигдоржийн саналын дагуу санал хураалт явууллаа. Бага Хурлын дарга Гончигдоржийн санаалаар зайлшгүй шаардлагатай гэж үзвэл дахин санал хураах эрхийг Ардын Их Хурлын даргад үлдээх гэсэн дээр олонх нь буюу 229 хүн санал өгсөн байна. Үүнийг редакцийн группт егье.

I-р бүлэгийн I-р зүйлийн талаар манай редакцийн групп ажиллаж, та бүхний саналыг оруулж байна.

## 5.

Д.Энхбаатар /Ардын Их Хурлын 178 -р тойргийн депутат/

-Хэлэхийн хувьд би ямар санал оруулья гэдгийгээ хэлсэн шүү дээ. Зарчим гэдэг дээр оруулья гэсэн журам байгаа юм. Байгууллага, хөдөлмөрчид болон Ардын Их Хурлын депутатуудын зүгээс Ардын Их Хурлын сонорт хүргүүлэхээр ирүүлсэн захидал, цахилгаан, санал хүсэлтийг тухайн үед нь танилцуулж байна гэж. Энэ нь хойно нь байхгүй ээ. 8 дээр аппаратууд байгууллага, хөдөлмөрчдөөс ирсэн захидал, бичгүүдийг бүлэглэж, бүртгэж, төрөлжүүлнэ гэсэн заалт байгаа юм. Дараа нь Их Хурлын даргад танилцуулна гэж байгаа юм. Түүнээс Их Хурлын сонорт биш юм.

10-ын 2-ын "л" дээр ийм зүйл байхгүй. Түүн дээр өргөдөл, гомдол, асуулт лавлах зүйл байгаа юм. Би өөр зүйт яриад байна шүү дээ. Их Хурлын сонорт хүргэх асуудлыг ярыж байна. Энэ нь 1-д орох ёстой юм.

Ж.Уртнасан -Зарчмын ач холбогдолтой санал юм шиг байна. Та бидний танишаж, хэлэлцэж байгаа дэгийн 10-р зүйлийн 2-р заалтын "л" гэсэн хэсэг дээр энэ нь байгаа юм. Гэхдээ депутат Энхбаатарын хэлж байгаа санал нь шууд манай Их Хуралд хандаж хөдөлмөрчдөөс ирсэн захидал, бичиг, илгээмжийн бүхийг эндээс сонсож байяа гасан асуудлыг зүйлчтэй оруулья гэсэн санал бийх шиг байна. Учн дээр санал хуреаж.

С.Чулдуунбаатар -Ардын Их Хурлын 132-р тойргийн депутат :

-Эрхэм гишүүн Энхбаатарын санал нь зарчмын хувьд зөв санал юм. Тэхээр "л" заалтын талаар тэр үед нь саналаа хэльвэ гэж бодож хүлээж байсан юм. Үүнийг тодруулж болох юм.

Их Хуралд ирүүлсэн захидал, мэдээллийг ил тод мэдээлэхийн хамт, хөдөлмөрчдийн өргөдөл, асуултыг хуралдаан даргалагч зохицуулж, хариу өгч, дунг . Их Хуралд илтгэж байна гэсэн хэлбэрээр энд тодруулах нь зүйтэй юм.

Соронзон хальстай  
тулгаж нийлсэн

Бичээч

*Д.Баярбаатар*

/Ц.БАЯРМАА/

/ С.Түүл/

84

Кассет № 20  
1991-XI-II  
15.00-15.15

-Тэгвэл бид энэ заалтыг хэлэлцэхдээ тодруулж редакц хийж болох юм байна. Ингээд үүнийг нээлттэй үлдээе.

Ардын Их Хурлын I дүгээр тойргийн депутат С.Баяр:

-Их Хурлын дарга аа! горимын хувьд нэг зуйлийг тохирчих-моор байна тэгэх үү. Тэгэхлээр сая нэгдүгээр зуйлийн нэгдүгээр хэсгийг ерөнхийд нь оруулах саналуудаа оруулаад санал хураагаад тогтчихлоо. Редакцийн хэсэг маань энэн дээр томъёоллуудаа бичээд эцэст нь дэгээ бүр баталсныхаа дараа шинэ редакцийг л толилуулна гэсэн ийм л ойлголттой байгаа тийм ээ. Нэгэнт одоо нэгдүгээр зуйлийн нэгдүгээр хэсэг бол батлагдчихлаа. Гол гол оруулж байгаа зарчмын юмнууд нь тусчихлаа. Тэгээд редакцийг суулд нь бид дэгээ удирдлага болгоод ажиллах үүднээс суулд нь депутатууддаа тараах ийм л юм хэлж байгаа шүү дээ тийм ээ. Таны хэлсний дагуу.

Ж.Уртнасан:- Энэ дээр санал хоёрдож байх шиг байна. Манай редакцийн группийн дарга Баярын санал бол бид ингээд зарчмын хувьд батлаад явъя. Бүр дэгээ бүгдийг нь дуусгасны дараа редакц хийсэн хувилбараа сонсоод баталчихъя гэсэн ийм санаа байх шиг байна. Түрүүчийн зарим депутатуудын санал бол бид ингэж мартаад бүр ингэж хэлэлчихээд суулд нь гарчихаад эргэж ярих тусгуй юм. Тийм учраас ерөөсөө редакц хийсэн зуийлийг дараагийн зуийлийг танилцаж ярьж байх хоорондоо уншаад баталчихаад явъя гэсэн ийм хоёр санаа байгаа юм. Тэгэхээр энэний алиныг нь бид сонгож авах вэ? гэдэг ийм санал бидэнд байна.

Ардын Их Хурлын тойргийн депутат С.Баяр:

-Тэгээд энэ ажлын хэсгийн хүмүүс чинь бас өөрсдөө депутатууд байгаа. Бас санал онол хэлэх учиртай. Санал хураалтанц ядаж гар өргөж оролцох ёстой. Ингээд явах юм бол энэ чинь байнга л нааш цааш хөдөлгөөн болоод тань уруу баахан бичиг

зөөсөн, хоёрдугаар хэсгийг ярж байхад нэгдүгээр хэсгийн редакцийг таньд оруулж ирж байдаг ийм л замбараагуй, жаахан дэг муутай юм болох юм болов уу. Нэгэнт зарчмаа тогтоод ингээд явж байгаа, та эндээс зарлаж байна. Редакцийг нь сүүлд нь танилцуулаад эцэст нь баталчихвал ясан юм бэ?

Ж.Уртнасан: - За депутат Баярын саналыг зөв зүйтэй гэж зөвшөөрч байгаа депутатууд гараа өргөнө уу. Ер нь олонхи байна даа. Тийм учраас бараг тоололтгүй юм байна.

За одоо нэгдүгээр зүйлээ бил нэгэнт хэлэлцлээ. Нэгдүгээр зүйлийн нэгдүгээр заалтыг бил зарчмын хувьд яриад тохирчихлоо гэж бодож байна. Ингээд нэгдүгээр зүйлийн нэгдүгээр заалтыг бүгдээрээ зарчмын хувьд баталчих уу, үндсэнд нь. Зүйл зүйлээрээ явах уу?

Ардын Их Хурлын I дүгээр тойргийн депутат С.Баяр: - Тийм ээ. Одоо нэгдүгээр зүйлийнхээ хоёрдугаар хэсгийн тухай яриад тэгээд л цаашаа явъя.

Ардын Их Хурлын дарга Ж.Уртнасан:

- За эрхэм депутатуудаа манай түрүүчийн хөтөлбөр дээр нэг цаг 30 минут гэж байсан. Энэ дэгэн дээр нэг цаг хүртэл гэж байгаа. Тэгэхээр манай зөвлөхүүд нэг цаг гэдгээр тогтсон байна. Ингээд ерөнхий дэгийнхээ дагуу үдийн завсарлага нэг цагаас 15 цаг хүртэл хооллож, үдийнхээ хоолыг тавтай зооглохыг хүсч байна.

Завсарлага 13.00-15.00

Ж.Уртнасан: - Эрхэм депутатуудын өдрийн амгаланг айлтгая. Та биднийг завсарлаад ирэх хугацаанд бас техникийн дэвшил явсан байна. Электрон техникийн "Санал" систем ашиглалтандаа орж, энэ та бидний ажлыг ихээхэн хөнгөвчилнэ гэж найдаж байна. Ингээд хуралдааныхаа ажиллагааг ургэлжлүүлье. Дэгээ ургэлжлүүлэн хэлэлцье. Дэгийн нэгийн нэгдүгээр зүйлийн хоёрдугаар заалт. Энэ хоёрдугаар заалт Ардын Их Хурлын хуралдааныг нээлттэй хийж түүнд төр, нам, олон нийтийн байгууллага, хөдөлмөрчдийн

4.

хэлээд байгаа юм уу? Өөр дотоод журам байвал ямар янзын юм байна. Тэрийг тайлбарлаж хэлж өгч болох уу? Тэр Их Хурлын хоёрдугаар хуралдааны дотоод журам гэдэг дээр бол ер нь илтгэлүүдийн минутыг л бичсэн байгаа. Өөр дотоод журам гэж бидний гар дээр юм байхгүй. Тэгэхлээр нэг бол дэг бол дэгийг баримтална гэж хэлмээр байна. Эсвэл дотоод журам гэж тусдаа юм байвал тэрийг сонсмоор байна.

Ардын Их Хурлын дарга Ж.Уртнасан:

-Тэгэхээр энэ дээр эрхэм депутатуудын анхаарлыг нэг төвлөрүүлмээр байна. Нэгдүгээр зүйлийн нэгдүгээр заалт бол депутатуудад хамаарч байгаа. Ардын Их Хурлын үйл ажиллагаа нь депутатууд, ард түмний нийтлэг эрх ашгийг илэрхийлсэн.

Энэ нэгдүгээр зүйлийн хоёрдугаар заалт бол урилгаар оролцож байгаа хүмүүс, олон нийтийн байгууллага, хөдөлмөрчийн төлөөлөгчид, хэвлэл, радио, телевизийн ажилнуудад хамаарч байгаа учраас энэ өгүүлбэр байсан ч илүүдэхгүй юм болов уу гэсэн ийм бодолтой байна. Депутат нөхдийн саналыг сонсоё.

Ж.Уртнасан:- За олонхийн саналаар бид техникээ ч нэг шалгая. Санал хураая. Нэгдүгээр зүйлийн хоёрдугаар заалтыг хэвээр үлдээе гэсэн төлөөлөгчид санал хураах хайрцгийнхаа зөвшөөрсөн гэдэг товчийг дарна гэдгийг ойлгож байгаа байх. Өчигдөр та бид наарт дадлагажуулснаар I-5 хуртэл тоолох буюу 5 секундын хугацаанд аль дарах товчоо дарах ёстой гэж ойлгож байгаа, за ингээд санал хураалтыг эхэль.

Хонх цохиод энэ кнопоо дарья. Энэ бол нэгэн жигд эхлэх дохио юм шиг байна. За санал авч эхэллээ.

За бид 39I-үүлээ. 9I хувийн ирцтэй байна. Одоо санал хураалтандаа орьё. Дэгийн нэгдүгээр зүйлийн хоёрдугаар заалтыг хэвээр үлдээе гэсэн санал хураалт явуулах гэж байна. Одоо саналаа эхэль. Санал хураалт эхэллээ.

Зөвшөөрсөн

## 5.

Эрхэм депутатуудаа "Санал" системийн манай энэ техник будлиагүй гэж ойлгож байна. Яагаад гэвэл энэ бид нарын саяны энэ хугацаанд долоо, найман хүн нэмэгдчихлээ. Энэ хумус маань суудал дээрээ суугаад санал хураалтанд оролцож байна гэж би ойлгож байна. Тэгэхээр энэ санал хураалтын систем маань будлихгүй байна гэж би ойлгож байна. Ингээд олонхийн саналаар дэгийн нэгдүгээр зүйлийн хоёрдугаар заалтыг үлдээж байна.

Дэгийн гуравдугаар заалт уруу орьё. Ардын Их Хурлын хуралдааны ажиллагаа, үр дүнг тогтоосон журмын дагуу радио, телевизиэр нэвтрүүлнэ. Хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр мэдээлнэ. Энэ зорилгоор Ардын Их Хурлын хуралдааныг сурвалжлах хэсгийг Их Хурлын даргын шийдвэрээр томилон ажиллуулна гэсэн гуравдугаар заалтыг хэлэлцье. Депутат нөхдийн олонхийн саналаар санал хураалтанд орьё. Энэ заалтыг хэвээр үлдээе гэсэн...учлаарай

Их Хурлын даргын шийдвэрээр сурвалжлах хэсгийг томилон ажиллуулна гэдгийг асуух байна уу? Тэгэхээр энэ хэвлэл, мэдээллийн өөрсдийн аппарат бий шүү дээ. Тэгэхлээр бид Их Хурлын өөрийн хэвлэл мэдээллийн аппаратыг томилон ажиллуулах тухай ярьж байна гэдэг л ойлголт нацад байна. Энэ бол орон даяар нэвтрүүлэх радио телевизийнхээс гадна хурлын өөрийн аппаратын дотоод ажлын хэсгийн сурвалжлах хэсэг гэж ойлгож байна.

Ардын Их Хурлын 277 дугаар тойргийн депутат Л.Болд: Тодруулмаар юм байна. Тэгэхлээр тогтоосон журмын дагуу нэвтрүүлнэ гэж ямар журмаа хэлээд байна вэ? Тогтоосон журам гэж. Ахиад журам батлах юм уу, одоо тийм мөрдөгдөж байгаа журам байгаа юм уу?

Ж.Уртнасан:-Одоогийн мөрдөж байгаа журмыг л хэлж байгаа гэж бодож байна. Манай хэвлэл, мэдээллийн хууль гараагүй байгаа шүү.

Л.Болд:-Тэгэхлээр одоо журмаар нэвтрүүлэгдэж байна уу?

## 3.

төлөөлөгчид, хэвлэл, радио, телевизийн ажилтан, түүнчлэн гадаадын дипломат төлөөлөгчдийг урилгаар байлшуулж болно. Хуралдаанд урилгаар оролцогчид дотоод журмыг чанд сахих үүрэгтэй. Хэлэлцэх асуудлын шинж байдлыг харгалзан Ардын Их Хурлын нийт депутатууд өрдийн олонхийн саналаар хуралдааныг хаалттай явуулж болно гэсэн ийм заалт байгаа. Үүн дээр депутат нөхдийн саналыг сонсоё. Хэвээр үлдээх үү. За тэгвэл бид одоо "Санал" системээ өөрсдөө шалгаж үэье. "Санал" системийн аппаратаар...

Ардын Их Хурлын 141 дүгээр тойргийн депутат Ж.Авхия:  
 -Би хоёрдугаар зүйл дээр санал хэлмээр байна. Хуралдаанд урилгаар оролцсон улсууд хуралдааны дотоод журмыг сахих үүрэгтэй гэсэн байх юм аа. Тэгэхээр энэ бол зөвхөн урилгаар оролцсон хумуусуудад биш, зөвлөх эрхтэй оролцсон байлаа ч гэсэн, таслах эрхтэй оролцсон байлаа ч гэсэн бүгдээрээ хурлынхаа дотоод журмыг сахих үүрэгтэй байвал ясан юм бэ? Ийм учраас урилгаар гэсэн үгийг хасах саналтай байна. Хуралдаанд оролцсон бүх хумуусууд хурлын дэг журмыг сахих үүрэгтэй байхаар заахын тулд урилгаар гэж онцолсныг хасах саналтай байна.

Ж.Уртнасан:-Урилгаар гэдэг тодотголыг авья гэж байна уу?

Ж.Авхия:-Тийм. Авья гэж байна.

Ж.Уртнасан:-Депутат Авхия гуай. Уг нь нэгдүгээр зүйлийн нэгдүгээр заалт дээр терийнхээ хуулийг дээдлэн дотоод журмыг чанд сахина гэдэг уг байгаа. Гэхдээ депутат нөхдийн саналыг бид авья. Тэгэхлээр урилгаар гэдэг уг илүү тодотгол ч байж болох л юм.

Ардын Их Хурлын 98 дугаар тойргийн депутат Д.Марав:-  
 Энэ саяны хоёрт байгаа тэр хуралдаанд урилгаар оролцогсод хуралдааны дотоод журмыг чанд сахих үүрэгтэй гэдгийг ерөөсөө бугдийг нь хасчихмаар байна. Тэртээ тэргүй дээрээ байгаа. Энэ бол энд оролцож байгаа улсыг л хэлээд байна шуу дээ. Бугдийг нь хасчихвал ясан юм бэ гэсэн саналтай байна.

Ардын Их Хурлын 264 дүгээр тойргийн депутат Б.Банли:  
 Нэг асуултын чанартай юм байна. Энэ дотоод журам гэж дэгийг

6.

Журам бусаар нэвтрүүлэгдэж байна уу гэдгийг яаж мэдэх вэ?

Ж.Уртнасан:-За энэ тогтоосон журам гэдэг бол одоогийн энэ дэгээр тогтоосон журмаа л бид дотооддоо баримталж, дэгээ л тогтоосон журам.

Л.Болд:-Би нэвтрүүлэх журам яриад байна шүү дээ.

Ж.Уртнасан:-Нэвтрүүлэх журам бол манай мөрдөж байгаа журам л байгаа шүү дээ.

Л.Болд:-Тийм журам байхгүй байгаа шүү дээ. Яаж нэвтрүүлэх вэ гэдэг журам маань байхгүй байна шүү дээ.

Ж.Уртнасан:-Хэвлэл, радио, телевизиэр үү?

Л.Болд:-Аль эсвэл бүр аваад хаячихдаг юм уу?

Шууд саналаа хэлье үргэлжлүүлээд. Тэгэхээр хуралдааны ажиллагаа, явц, дунг гэж, үр дун биш, явц дунг радио, телевизиэр нэвтрүүлж хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр мэдээлнэ гэвэл яасан юм ба?

Ж.Уртнасан:-Тэгэхлээр эрхэм депутат Болдын асуултаанд хариуљя. Энд Бага Хурлын даргын захирамжаар батлагдсан дотоод журам мөрдөгдэж байгаа юм байна. Түүн дээр нэмээд Их Хурлын депутатууд, бид өөрсдөө Их Хурлын даргынхаа хэмжээнд энэ захирамжийг өөрчилж болно гэсэн ийм боломжтой юм байна. Тэгэхлээр бид энд бол өөрсдийн дотоод дэгээрээ өөрсдийн журмыг бий болгож болох юм. Өөрөөр хэлбэл энэ хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нээлттэй дамжуулья, хаалттай хуралдаан хийе гэдгийг бол бид өөрсдөө тухайн үедээ ярьж зохицож болох юм аа.

За депутат Болдын хэлсний дагуу явж гэдэг үгийг нэмж оруулах уу? Уг нь үйл ажиллагаа гэдэг маань явц шүү дээ. Хуралдааны ажиллагаа гэдэг маань явц л юм байгаа юм. Тийм.

Ардын Их Хурлын 23 дугаар тойргийн депутат Ц.Энхбат:- Энэ зүйлд орсон энэ зорилгоор Ардын Их Хурлынхуралдааны сурвалжлах

хэсгийг Их Хурлын даргын шийдвэрээр томилон ажиллуулна. Энд хаахан тодорхой хэлж өгмээр байна. Ямар сурвалжлагч, ямар хэсэг, хэн хэн орж байгаа юм. Миний ойлгож байгаагаар "Ардын эрх" со-ниноос хүмүүс орж байгаа байх. Тэгээд ер нь нэг хэсэг бол тийм яриа гарсан шүү дээ. Энэ чинь төрийн сонин мөн юм уу биш юм уу гэдэг ч яриа гарч байсан. Тэгэхээр бид нар бол яг нэвтрүүлж байгаа хүмүүсийн талаар мэдээлэл авмаар байна үнэхээр. Тэгээд тэр хүмүүстээ асуудал тавих, эсвэл өөрсдөө энэ Их Хурлаасаа хүн томилцог ч юм уу ийм асуудал дээр. Тэгэхгүй бол нэг талын тийм мэдээлэл маш их өнгөрсөн чуулганаар явсан. Сүүлд нь энэ бас нэг маргаантай асуудал гараад байдаг. Тийм учраас энэ асуудлыг тодруулж өгнө үү гэж хүсч байна.

Ардын Их Хурлын 85 дугаар тойргийн депутат К.Сайраан:- Би саяны асуусан депутатын асуултыг дэмжиж байна. Тэрнээс гадна энэ ирэх долоо хоногийн телевизийн нэвтрүүлгийн программыг харахад орой болгон 20 минутын тойм байгаа. Өнөөдөр яах вэ нээлтийн ажиллагаа үзээс өмнө шууд нэвтрүүлсэн гэж ойлгосон. Тийм учраас энэ одоо орой болгоны 20 минутын тойм Ардын Их Хурлын хуралдааны талаар хангалттай юу? Нийт ард түмэнд хуралдааны үйл ажиллагааны талаар.

Хоёрдугаарт, энэ 16 дугаар зүйлийн хоёрт, би тэр давхардаж байгаа зүйлийг хэлэх гэсэн юм. Их цааз, Ардын Их Хурлын бусад баримт бичгийг "Ардын эрх" сонинд албан ёсоор нийтлэхээс гадна хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд дамжуулна гэсэн байна. Энэ саяны энэ гуравдугаар заалт дээр мөн ашилхан ийм заалт байгаа шүү дээ. Хэвлэл, мэдээлэлд нэвтрүүлж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ гэсэн. Энэ хоёр заалтыг нэгтгэх арга байдаг уу?

СОРОНЗОН ХАЛЬСТАЙ ТУЛГАЖ  
НИЙЛСЭН

БИЧЭЭЧ Л.ХОРЛОО

П.ТӨМӨРБААТАР

1991-XI-II.  
Кассета № 21  
15.15-15.30

Уртнасан: -Энэ дээр тодотгол хийх хэрэгтэй юм шиг байна. Депутатууд Ардын эрх сонини тухай асууж байна. Ардын эрх сониньг енөөдөр манай Бага Хурлын төрийн хэвлэл гэм нийтэлсэн тэр нийтлэл тэр олгосон эрх хэвээрээ байгаа. Ийм учраас бид Ардын эрх сонинг төрийн хэвлэл гэдэг энэ хэвлэл мэдээллийн төв хэрэгсэл гэдгээр нь ойлгоё гэсэн санаатай байна. Сурвалжлах группийг бид тухайн үедээ бид өөрсдөө томилно шуу дээ, тийм учраас энэ та бидэнд нийтэд ил тод байх юм.

-I дүгээр микрайонд санал байна. I09-р тойргийн депутат С.Лхагвасүрэн: - Тэгэхээр энэ хуралдааны ажиллагаа дунг телевиз хэвлэл мэдээллээр дамжуулах тогтсон журам гэдэг нь баймаар юм шиг байна. Яагаад гэвэл бүх үйл ажиллагааг I00 хувь нэвтрүүлж амжихгүй нь мэдээж. Тийм учраас ард түмний онцлон анхаарч байгаа зарчмын гэм узсэн гол асуудлуудыг харин заавал телевиз радиогоор шууд дамжуулах нь зүйтэй байх аа. Үүнийгээ тэр журмандаа оруулж өгвөл зөв юм биш уу гэсэн ийм санал байна.

Уртнасан: -За саналуудыг хүлээж авлаа. Тэгэхээр манай зарим депутатууд журманд тодотгол хийе гэсэн санал оруулж байна. Үүнийг юу гэм узэж байна вэ депутатууд, энэ заалтыг хэвээр үлдээх уу, эсвэл редакцийн группит энийг нэмэлт болгож оруулж гэдэг санал өгөх уу. За санал хураалт явуулж байж шийдье. Тэгэхээр I дүгээр зуилийн З дугаар заалтыг хэвээр үлдээе гэсэн саналтай депутатууд ер нь хэвээр үлдээе гэснийг зөвшөөрснийг татгалзсан, тудгэлzsэн энэ З юм гаралц ирнэ шуу дээ. Ийм учраас I дүгээр зуилийн З дугаар заалт дээр санал хурааж байна. Депутатуудыг санал хураалтаад бэлтгэхийг хүсч байна.

За энэ саналыг бүх депутатуудын 88 % нь хэвээр үлдээе гэсэн саналтай байна. Ер нь бид Бага Хурлын нөхдүүдтэйгээ зөвлж ярилаа. Тэгэхээр тухайн үедээ ард түмэндээ энийг чөлөөтэй нэвтрүүлж, энийг заавал ард түмэндээ хүргэе гэсэн ийм зүйлүүд дээр бид урьдчилан тогтоон хэвлэл мэдээллийн хэрэгслээр нээлттэйгээр

2.

ашиглах ийм боломжийг бид өөрсдөө үлдээж байна. За ингээд 3 дугаар зүйлийг олонхийн саналаар 356 депутатын саналаар буюу 88 %-ийн саналаар үлдээлээ. За 2 дугаар зүйлийг хэлэлцье. Нэгэнт та бүхэнд 2,3,4 дүгээр зүйлийг шууд баталчихъя, энэ өнгөрчихсөн юм.

Депутат Элбэгдоржийн саналыг авч үзэх үү, ер нь энэ бол үнэхээр хийгдсэн бид мөрдөөд явж байгаа ийм ажил юм. Тийм учраас 2 дугаар зүйл, 3 дугаар зүйл, 4 дүгээр зүйлийг хамтат нь 4 орлогч гээд тэгээд болоо.

Бид өөрсдийнхөө өөрчилснийг энэ дээр нэгэн дээрээ засаад оруулчихъя. 2 биш 4 болгоё. За ингээд 5 дугаар зүйл хуртэл.

-2 дугаар зүйл дээр санал байна.

-Их Хурлын дарга аа, түүүн бид нэг тогтоол батлуулж чадаагүй байгаа шүү дээ. Одоо харин тэрэн дээрээ тэр тогтоолыг батлуулчихмаар байна.

72 дугаар тойргийн депутат А.Болат: - Тэр 2 дугаар зүйл дээр депутатуудын нэросийн 75 %-ийн хэмжээгээр хуралдаан явуулхаар заасан заалт дээр өөр саналтай байна. Бид ингэж тоо тогтоосон гол үндэс л болбол мэдээжийн үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулийг баримталсан байгаа. За энэ маань нэлээн алсыг харсан, магадгүй зарим тохиолдолд өэлжит бус чуулган хийх тохиолдол ч гарсан гэсэн энэ утгаар хийсэн байгаа бид өнөөдөр. Бүх депутатуудын 98 % нь ирж байгаа өнөөдрийн энэ түвшин дээр I дүгээрт 2 дугаарт бид Их цаазаа хэлэлцэж байгаа ийм тохиолдолд, 3 дугаарт цөөнхийн саналыг хүндэтгэнэ гэчихээд ийм бодлого тавьж байгаа З хүчин зүйлээс харгалзан үзэж депутатуудын 90-иэс дээшхи хувийн ирцтэйгээр бид энэ хуралдаанаа явуулж байх саналыг хэлэлцуулж өгөөч өэ гэж бодож байна. Ойлгогдсон уу угүй юу минийх.

I дүгээр микрофонос хуралдааны дарга аа, 2 дугаар зүйл дээр санал байна. 38I дүгээр тойргийн депутат Н.Цэрэнхүү: - Тэгэхээр энэ 2 дугаар зүйл дээр хуралдааны хүчин төгөлдөр болох гэдгийг бид нар ганцхан тоон үзүүлэлт талаас нь бодмооргүй байна

3.

гэж санал оруулж байна. Яагаад вэ гэхлээр өглөөнөөс хойш зарим депутатын хэлсэн саналаас цухалзаж байгаа, хуралдааныг орхиж магадгүй байгаа. Хуралдааныг цөөнхийн саналыг авч узэхгүй байна гээд орхисон тохиолдолд цаана улдсэн хүмүүс нь 75 хувьас дээш байгаа ч гэсэн хуралдааныг хүчин төгөлдөр гэж узэх юм уу. Ер нь хуралдааны I, 2 дугаар зүйл дотор гарсан дотоод журам гэж тэр дотоод журмыг бид нар өрөөсөө тэгээд бүгдээрээ л гар өргөчих-лөө. Хуралдаан жинхэнэ ач холбогдоор нь аваад узэх юм бол дэгтэй журамтай, сахилга эхийн байгуулалттайгаар байх талаас бид нар бас анхаармаар байгаа юм. Тийм учраас хуралдааныг орхих тухай асуудлыг хуралдааныг хүчин төгөлдөр болох энэ зүйлтэй яаж холбож узэх вэ?

9 дүгээр тойргийн депутат С.Зориг: - Тэгэхээр депутатуудад хандаж нэг хүсэх юм байна. Эрхэм депутатууд эхлээд Үндсэн хуулиа уншичлаад дараа нь дэгээ яривал яласан юм бэ? Дэгээ Үндсэн хуулийн дээр гаргах гээд байна шүү дээ. Тэрэнд бол ямар асуудлыг ямар саналтайгаар батлахыг заачихсан байгаа. Тэр дэгийг Үндсэн хуулийн хэмжээнд аваачиж тавьж яах гэсэн юм бэ? Нэмэлтийн хууль байна уу тэр чинь Үндсэн хуулинд хамааралтай шүү дээ. Үндсэн, хууль, Үндсэн хуулийн нэмэлтийн хууль хоёрыг дахин нэг уншичвал яласан юм бэ? Угүй бол байхгүй бол Их Хурлын дарга, орлогч тарааж өгдөг юм уу яадаг юм дахиад.

Уртнасан: Эрхэм депутат С.Зоригийн саналыг хүлээж авлаа. Болатын саналын хувьд бол Зоригийн санал их нелөөлөх ач холбогдолтой юм. Хэрэв энэ 75 хувь гэдгийг бид өөрчлөхөд хурвэл 90 хувь гэж засахад хурвэл бид бас хуулиа өөрчлөх хэрэгтэй болох талтай байна. Ийм учраас эрхэм депутатууд энэ асуудлыг бас анхааралдаа болгоноо уу. За санал хураалтад орох уу? Баярлалаа.

За санал хураахад бэлтгээрэй. Дэгийн 2,3,4 дүгээр зүйлийг бид дэгийн талаар санал хураах гэж байна. Хэвээр улдээх гэсэн депутатууд саналаа өгөхийг хүсч байна. За санал хураалтад бэлтгээрэй.

За дэгийн 2,3, 4 дүгээр зүйлийг депутатуудын дийлэнх олонхи буюу 97 %, 395 депутат зөвшөөрч байна. Татгалзсан 7 хүн буюу 2 %,

тудгэлзсэн 5 хүн буюу I хувь байна. За ингээд та бутгийн олонхийн саналаар дэгийн 2,3,4 дугаар зүйлийг баталлаа. За 5 дугаар зүйл дээр саналаа ярилцъя. Хэлэлцэх асуудал депутатын булэг дотроо 4 заалттай, энэ 4 заалтыг нэг бурчлэн авч хэлэлцэх үү, зүйлийг өрөнхийд нь авч хэлэлцэх үү гэдэг асуудал байгаа, зүйлээрээ ярилцвал дээр үү, за зүйлээрээ яръя.

4-р микрофон, 231 дугаар тойргийн депутат Г.Амарбаян: -5 дугаар зүйлийн I дугаар зүйл дээр АИХ-ын хуралдааны хэлэлцэх асуудал, түүний дарааллыг депутатуудын намын булгийн ахлагч нарын зөвлөлгөөнөөр урьдчилан хэлэлцэж депутатуудын саналыг нэгтгэн нэгтгэсэн байвал зохино гэдгийн энд найруулгад өөрчлөлт оруулмаар байна. Энд депутатуудын намын булгийн ахлагч нарын зөвлөлгөөнөөр урьдчилан хэлэлцэж, депутатуудын саналыг нэгтгэсэн байвал зохино гэдэг ёнэ өгүүлбэрийг бутнээр нь хасаж түүний оронд тэр хэлэлцэх асуудал түүний дарааллыг нийт депутатуудын З-ны 2-ын саналаар баталж хэрэгжүүлнэ гэж оруулах нь зүйтэй байна. Ер нь Их Хурлын депутатууд өөрийнхөө Их Хурлын хэлэлцэх асуудлаар түүнийхээ дарааллыг өөр нэг хүчний зөвшөөрөл оролцоо зөвлөлгөөгөөр батлах асуудал Зарчмын хувьд тохиорхгүй гэж үзэж байна.

I дугаар микрофон, 288 дугаар тойргийн депутат: С.Баярцогт: -5 дугаар зүйлийг бүхэлд нь өөрчлөх саналтай байна. Зүйлийн нэрийг хэлэлцэх асуудал, депутатын булэг гэснийг депутатуудын булэг, түүний эрх үүрэг гэж засах саналтай байна I-рт, 2-рт бүлгийг бүхэлд нь АИХ-ын хуралдааны юу хэлэлцэх асуудлаа орхиод шууд депутатууд тодорхой асуудлаар булэг байгуулж болно. Булэг нь энэ намын булгийн дараах асуудлаар одоо энд байгаа намын булэг нь гэснийг шууд депутатуудын булэг нь АИХ-ын хуралдаанд хэлэлцэх тодорхой асуудлуудаар бүлгийнхаа депутатуудтай санал солицлох нэгтгэх, тэдний зөвшөөрлөөр хуралдаанд санал илэрхийлэх асуудлыг дангаараа буюу хамтран зохицуулна гэсэн энэ ганцхан үүргээр бүх депутатуудын бүлгийг нэг үндсэн ижил тэгш үүрэгтэй болгоё гэсэн ийм I-р санал байгаа. Депутатын булэг нутаг дэвсгэрийнх байж болно, намуудынхаар байж болно, депутатууд тодорхой асуудлаар нэгдэж булэг болж болно гэсэн энэ саналыг I-рт оруулж өгөх хэрэгтэй.

2-рт энд байгаа намуудын намуудаас сонгогдсон депутатуудын тоо харилцан адилгүй байгаа учраас одоо жишээ нь нэг депутаттай нам бий. 5 депутаттай нам бий, 300 гаруй депутаттай нам ч бий. Түүнээс гадна нам бус депутатуудыг нэг бүлэг бол гэж шахсан энэ заалт бол депутатуудын өмнө тэгш биш байдлыг бий болгож байгаа юм аа. Тодорхой намын гишүүн байснаараа тэр хүн бол 5-уулаа нэгдэж бүлэг болж болно. Намын гишүүн бус депутатууд бол заавал нэгдэж байж нэг бүлэг болно гэсэн энэ болбол одоогийн байгаа улс төрийн тогтолцоо энэ бүх юмтайгаа зөрчилдэж байгаа. Жишээ нь би ийм юм хэлмээр байна. Одоо гишүүн бус депутатууд маань дотроо болбол наад зах нь Бүгд найрамдах нам байгуулахыг зорьж байгаа депутат байна гишүүн бус депутат байна, түүнээс гадна улс төрийн тодорхой хөдөлгөөн Монголын арднысан намын Арднысан холбооны депутатууд байна. Залуучуудын холбооны идэвхтэн депутатууд байна. Мөн 281 -ийн холбоо гэх мэтчилэн улс төрийн зорилготой мэргэжлийн чиглэлтэй ийм бүлгүүд байгаа. Энэ бүлгүүдийг тооцож узээд еренхий зарчмыг нь батлаад депутатуудын бүлэг байгуулагдаж болно. Энэ дээр болбол урьд нь ийм асуудал гарч байсан, I дүгээр хуралдаан дээр. За мэргэжлээрээ бүлгүүд байгуулбал ясан юм бэ гэсэн асуудал гарч ирж байсан. Энэ бол тухайн намын бодлоготой холбоотой. Тухайн нам, тухайн намын гишүүн депутатууд болбол бодлогоороо нэгдэж чадаж байх ёстой, ингэж чадахгүй байгаа бол тухайн намын зохион байгуулалтгүй асуудал гэж узэх ёстой. Тэрнээс биш энийг дахиад гишүүн бус депутатуудаас бүлэг гарынажлээр зэрэг мэргэжлийн гээд л янз бурийн гэж тэрнэйг хаах зорилгоор ийм асуудал тавьдаг. Зүгээр энэ дээр анхаарах нь зүйтэй гэж тайлбарлаж байна.

Уртиасан: Эрхэм депутат Баярцогтын санал бол бүлэг байгуулж болно, депутатын бүлэг байгуулж болно, тэгэхдээ тэр бүлгүүд маань намын, эвслийн, мэргэжлийн гэсэн аль ч хэлбэрээр байж болох юм гэж нээлттэй узэх ийм санал гэж ойлгож болох уу.

Эрхэм депутатууд энэ саналыг юу гэж узэж байна вэ? Энд бол нэг л намын бүлэг л гэж байгаа шүү дээ. За нам бусчууд бүлэг байгуулж болно гэж, тэгэхлээр эрхэм депутат Баярцогтын саналаар бол уүнийг нэлээн өргөн цар хүрээтэй нээлттэй орхие, намын, эвс-

лийн, мэргэжлийн булгууд байгуулж болно гэсэн лавлагаагий нь дэгд оруулъя гэж байна. Энэ талаар ямар саналтай байна вэ?

41 дүгээр тойргийн депутат Н.Пүрэвдорж: - Тэгэхээр АИХ-ын хуралдааны хэлэлцэх асуудал, түүний дарааллыг депутатын намын булгийн ахлагч нарын зөвлөлтгөөнөөр урьдчилан хэлэлцэж депутатын саналыг нэгтгэсэн байвал зохино гэсэн энэ заалтыг л хасчихъя. Тэгээд аяндаа нутаг дэвсгэрийн булэг, бусад булгууддээ нэгдээд л асуудлаа зохицуулж байна биз. Яагаад гэвэл депутатуудын чинь байнгын комиссууд байж байна. одоо бүрэн эрхтэй. Өшөө өөр булгууд байж байна, мэргэжлийн, тэгэхлээр энэ заалтыг л хасчихъя.

Соронзон хальстай тулгаж  
нийлсэн

Бичээч

М. БУРМАА

Л. БАТЦЭЦЭГ

1991.XI.II.

Кассет № 22

15.30-15.45

405 дугаар тойргийн депутат Б.Лигдэн:

-5 дугаар зүйлийг хоёр зүйл болгож хуваамаар байгаа юм. Хэлэлцэх асуудал, энэ бол зарчмын чанартай юм. Депутатын бүлэг гэдгээ өөр нэг зүйл болгоод З, 4 дүгээр зүйлийг иш нэгтгэх нь зүйтэй юм гэж бодож байна.

дээр

I дүгээр асуудал+Баярцогтын саналтай өрөнхийдөө ойр байна. Их Хурлын хуралдаанаар л шийдвэрлэж тогтооно гэдгийг, хэлэлцэх асуудлыг ийм маягаар оруулах нь зүйтэй байх. I-ийн 2-т хэлэлцэх асуудал гэж зүйл гаргаж, хоёр гэдэгтээ энэ 2 дугаар зүйлийг хамааруулж хэлэх гэж байгаа юм. З дугаар хуудасны хоёр дахь мөрөнд "хэрвээ шинээр" гэж байгаа. Хэрвээхуралдааны явцад шинээр асуудал гарч ирэх юм бол гээд цааш нь ургэлжлүүлээд явчихбал зүгээр юм гэж бодож байгаа.

Депутатын бүлэг гэсэн тэр асуудал бол З, 4 дүгээр зүйлийг хамааруулаад энэ дээр Баярцогтын саналыг энд хамааруулж оруулах нь зүйтэй байх. Гэхдээ энэ дээр нэг мөсөн би хэлчихье. З дугаар заалтын хамгийн сүүлд "нам бус депутатын бүлэг байж болно" гэж байгаа шүү дээ. Тэрий дараа 4 мөр алгасаад "намын гишүүн бус депутат нэгдсэн нэг бүлэг байтуулж, ахлагчaa сонгож ажиллаж болно" гэсэн байгаа. Ийм хоёр санааг нэгтгээд давхардуулж болох байх, хамтраад нэг өгүүлбэр болгоод хийчихнэ зүгээр биш уу гэж хэлэх гэсэн юм.

Ж.Уртнасан: -5 дугаар зүйлийг хоёр эхийл болгож задалъя гэсэн санал гарч ирж байна, хэлэлцэх асуудал, депутатын бүлэг гэсэн. 5 дугаар зүйлийг хэлэлцэх асуудал, депутатын бүлэг гэсэн энэ хоёрыгоо нэг зүйл байлгах уу, хоёр зүйл болгох уу гэдэг ийм санал хураалт явуулах хэрэгтэй болох нь шиг байна. Бүлгийн хувьд дахиад намын бүлэг, ажлын бүлэг, мэргэжлийн бүлэг, нутаг дэвсгэрийн гэсэн ийм олон бүлэглэлүүд гарч болох ийм хувилбар байна. Үүнийг нээлт-

тэй орхиж болох юм, редакцийн комисст даалгаад.

Энэ зүйлийг хоёр зүйл болгох уу, нэг зүйл болгох уу гэдэг дээр санал хураалт явуулах уу? Манай дэгийн энд бол нэг зүйл байгаа шүү дээ. Дотроо хоёр заалттай. Депутат Лигдэн гуайн саналаар бол үүнийг хоёр зүйл болгоё гэж байна.

Хуралдааны дэг ёс байдаг, үндсэн санал, хажуугийн буюу нэмэлт санал гэж. Тэгэхээр бид үндсэн зүйл дээрээ санал хураалт явуулъя. 5 дугаар зүйлийн хэлэлцэх асуудал "депутатын бүлэг" гэсэн чигзэр нь үлдээгээд зохих редакци хийе. Урьдчилан хэлэлцэж депутатуудын саналыг нэгтгэсэн байвал зохино гэдгийг хасъя гэсэн санал гарч ирж байна. Энэ хэсгийг бас хөёрын гуравын саналаар үлдээе гэсэн санал байгаа юм.

50 дугаар тойргийн депутат А.Далхжав: -Бид нар Үндсэн хууль хэлэлцэнэ гэдэг юмаа урьдчилаад мэдэж байгаа шүү дээ. Одоо хэлэлцэх уу, угүй юу гэдэг дээр ингэж байх хэрэггүй юм. Ерөнхий асуудлаа бол урьдчилсан ямар нэг аппаратаар Их Хурлынхаа аппаратдаа ярьж шийдэж, зар мэдээгээ хүргэчихээд бусад асуудал, дарааллаа бол ийм байдаар өнөөдрийн ийм хэмжээнд ярьж шийдэж байвал яасан юм бэ?

18 дугаар тойргийн депутат Г.Ганболд: -Саяын бүлэгтэй холбогдуулаад товчхон санал хэлье. Нэгдүгээрт, энд сууж байгаа Ардын Их Хурал бол Улсын Бага Хурал биш, өөрөөр хэлбэл, энд байгаа депутатууд бүгдээрээ ард түмнээс сонгогдсон депутат гэдгийг бид нар ойлгох ёстой юм.

Хоёрдугаарт, хэрвээ энд бүх асуудлыг намын булгуудийн бэлтгэлтэйгээр оруулж ирээд байх юм бол анхны чуулган дээр байсан юм давтагдана. Намуудын бодлого Ардын Их Хурлын депутатуудад нөлөөлөхгүй гэсэн баталгаа байхгүй.

## 3.

Гуравдугаарт, бүх бүлгүүдэд адил тэгш эрх өгөх нь зүйтэй гэсэн Баярцогтын саналыг дэмжиж байна.

Дөрөвдүгээрт, үнэхээр парламентад байгаа манай улс төрийн намууд бодлого, юмаа ярыж хэлэлцэж тогтъё гэх юм бол энэ бололцоо энэ өрөнхий зүйл ангиар олгогдоно гэдгийг манай бүх депутатууд ойлгох хэрэгтэй л дээ. Ингээд энэ бүлгийг хоёр хэсэг болгоод хоёрдугаарт, депутатын бүлгийн тухай гаргасан Баярцогтын саналыг дэмжиж байна.

Ж.Уртнасан: -Зүйлийг хоёр зүйл болгоё гэж үү?

Г.Ганболд: -Энэ зүйлийг хэлэлцэх асуудал, депутатын бүлэг гэдэг хоёр зүйл болгочихоод хоёрдугаар зүйлээ депутат Баярцогтын гаргасан саналын дагуу шийдвэрлээ гэсэн ийм саналтай байгаа юм.

328 дугаар тойргийн депутат Б.Дашзэвэг: -Энэ Их Хурлын хэлэлцэх асуудал, депутатуудын бүлэг гэдэг дээр "намын" гэдэг угүүдийг цөмийг хасмаар байна. Их Хурлын депутат бол ерөесөө гадаадхи хүчээр энэ үйл ажиллагаа, дэс дараа явагдах гээд байна. Ийм учраас энэ бүх зүйлээс "намын" гэдгийг хасаад депутатын бүлгийг хэлэлцэх асуудалтай нь батлах саналтай байна.

Ж.Уртнасан: -Саналаа тасалья гэж манай эрхэм депутатууд үзэж байна. Тэгэхээр бид ийм хоёр санал хураалт явуулах нь шиг байна. 5 дугаар зүйлийг хэлэлцэх асуудал, депутатын бүлэг гэсэн хоёр бүлэг, хоёр зүйл болгоё гэсэн санал орж ирж байна. Энэ дээр санал хураалт явуулъя.

5 дугаар зүйлийг хэлэлцэх асуудал, депутатын бүлэг гэсэн хуучин хэвээр үлдээе гэсэн дээр санал хураалт явуулъя. Санал хураалтад бэлтгэхийг хүсч байна. Санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн 196 49%

Татгалзсан 165 42%

Түдгэлзсэн 36 9%. Энэ санал хураалтыг явуулахад

4.

5 дугаар зүйлийг хэвээр үлдээс гэдэг дийлэнх, ердийн олонхийн саналыг авч чадсангүй. Татгалзсан улсууд олон байна. Тийм учраас энэ 5 дугаар зүйлийг 2 зүйл болгоё гэсэн санал хураалт явуулъя.

5 дугаар зүйлийг хэлэлцэх асуудал, депутатын бүлэг гэсэн хоёр зүйл болгоё гэсэн санал байгаа.

Депутатууд техникт сайн итгэл өгөхгүй байх шиг байна. Тийм учраас дахиад "ирц" гэдэг санал хураах буюу хамгийн доод талынхаа товчийг дарж техникеэ шалгаж үзье. Ирцийг буртгэхэд бэлтгээрэй.

Бидний ирц 4II депутат буюу 96 хувь нь иржээ гэсэн ийм хариу өгч байна. Уүнийг одоо бид санал хураалтын явцад шалгаж амжих учраас санал хураалтаа ургэлжлүүлье.

Одоо 5 дугаар зүйлийг хэлэлцэх асуудал, депутатын бүлэг гэсэн хоёр зүйл болгоё гэдэг дээр санал хураая.

ЗИ5-р тойргийн депутат Ч.Бат-Эрдэнэ: -Их Хурлын дарга аа, 5 дугаар микрофонд зөвшөөрөл олгоно уу. Нэг санал байна. 2 зүйл болгомооргүй байна. 5 дугаар зүйлээ нэг зүйлтэй, дотроо 2 заалттай болгочихмоор байна. Зүйл нь хэвээр, 5 дугаар зүйл, тэгээд I дүгээрх нь хэлэлцэх асуудал, 2 дугаарх нь депутатын бүлэг гээд хоёрхон өгүүлбэртэй ийм болгож хиймээр байна.

Х.Уртнасан: -Уг нь хуучин бид тэгэж үзсэн шүү дээ. Хэлэлцэх асуудал энэ хуучин хэвээрээ байя. Хэлэлцэх асуудал, депутатын бүлэг гэсэн дийлэнх олонхийн саналыг авч чадсангүй. Тийм учраас бид нар хоёр дахь хувилбарын санал хураалтад бэлтгэж байна.

Хэлэлцэх асуудал, депутатын бүлэг гэсэн 2 зүйл байлгая гэдэг дээр санал хураалт явуулъя, бэлтгээрэй. Санал хураалт явж байна.

## 5.

Цийлэнх олонхийн саналаар буюу 250 депутат, 62 хувь нь энэ зүйлийг хоёр зүйл болгоё гэж санал оруулж ирлээ. 5 дугаар зүйл хэлэлцэх асуудал байг. Энд манай редакцийн групп редакц хийгээд оруулаг. 6 дугаар зүйл болж депутатын бүлэг гэсэн ийм зүйл нэмэгдэх нь. Тэгэхээр депутатын бүлэг гэдгийг энэ 2, 3 заалттайгаар биш та бүгдийн саналыг үндэслээд Ардын Их Хурлын хэлэлцэх асуудлаар саналаа нэгтгэх зарчмыг дор дурдсан депутатын бүлэг байхаар зохион байгуулж гэсэн санал байх шиг байна.

Нэгдүгээрт, намын харьяллаар  
Хоёрдугаарт, нутаг дэвсгэрийн  
Гуравдугаарт, мэргэжлийн онцлогоор  
Дөрөвдүгээрт, бусад гэсэн санал орж ирж байна.

Эвслүүд бүлэг болно гэдэг юм энэ дээр нэмэгдэх уу, угүй юу. Намын харьяллаар, нутаг дэвсгэрийн харьяллаар, мэргэжлийн онцлогоор, бусад гэдэг.

Манай депутатын ихэнх нь ингэж их төрөлжүүлж задлаад хэрэггүй, ерөөсөө депутатын бүлэг байгуулж болно гэдгийг нэг томоохон онгорхой үлдээе гэж байна. Энэ дээр санал хураая гэж бодож байна.

Депутатын бүлэг байгуулж болно гэдгээр нэг зүйл үлдээ.

69 дүгээр тойргиын депутат Ж.Яламсүрэн: -Депутатуудын бүлэг байгуулж болно гэж ерөнхий орхихоор нутаг дэвсгэрийнх байж болох юм, намынх байж болох юм, мэргэжлийнх байж болох юм гэж ойлгох нээ. Ер нь Их Хурлын хуралдааны хэлэлцэх асуудлын онцлогоос шалтгаалаад энэ булгууд явц дунд дэгд орохгүйгээр завсарлага авах тийм тохиолдолд гарах болов уу, угүй болов уу. Тийм учраас энийг нэг нарийн харгалзаж үзэж, жишээлбэл, намын бүлэг ерөөсөө байж болохгүй гэж зарим депутат тэгэж байна. Тэгэхээр энэ чинь нэгдсэн журмаар нэг асуудлаа оролцуулж шийдвэрлүүлэх ийм юм зайлшгүй гарах болов уу гэж бодож байна. Тийм учраас энэ булгийг тус

бүрд нь зааж өгчихөөд тэгээд харин асуудал шийдэх дээр намынхаа юмуу, нутаг дэвсгэрийн саналыг нэгтгэж, ямар нэгэн хуралдааны явцад дэгд заахгүйгээр завсарлага авч болох энэ талын юмыг энд оруулж өгмөөр санагдаад байгаа юм. Тийм тийм булгууд завсарлага авч болно, тэчнээн хугацааны юмуу. Энэ асуудлыг тусгаж өгмөөр санагдаад байх юм.

Э.Уртнасан: — Энэ хувилбар юм. Тэгэхээр Ядамсүрэн депутатын тавьж байгаа хүсэлтэд бид бол намын бүлэг байж болохгүй гэсэн ийм юм байхгүй байгаа шүү дээ. Тийм учраас намын бүлэг байж болно. Харин таны саналыг тусгавал ер нь аливаа бүлэг ямар нэгэн асуудлаар санал солилцох зорилгоор завсарлага авч болно гэсэн ийм өгүүлбэрийг манай редакцийн комисс нэмж болох юм.

Аливаа бүлэг асуудлыг хэлэлцэж, санал солилцохын тулд завсарлага авч болно гэсэн нэг заалтыг энэ 6 дугаар зүйлд оруулах талаар санал хураах уу? Магадгүй зарим зерчилтэй асуудлууд дээр санал солилцохсor завсарлага авах тийм тохиолдол гарах байх гэж бодож байна.

10 дугаар тойргийн депутат О.Дашбалбар: — Ардын Их Хурлын хуралдааны хэлэлцэх асуудал, түүний дарааллыг депутатуудын намын булгийн ахлагч нарын зөвлөлгөөнөөр урьдчилан хэлэлцэж, депутатуудын саналыг нэгтгэсэн байвал зохино гэж байна. Би уржигдар хэлсэн. Дахин дахин жужиг найруулж Их Хурлын депутатуудыг ингэж тоглоом болгохоо больё гэж. Өнөөдөр бид Их Хурлын 7 орлогчийг сонгоход ч гэсэн мөн мэдэн будилуулж байгаад 7 хүн дээр дерөв дерөв хүний санал, нэг хүн дервэн удаа гар өргөх уу, эсвэл 7 удаа гар өргөөд олонхийн саналаар шийдэх уу гэдгийг аль ч учрыг олохгүйгээр энд будлиантуулж байгаад наадам хийсэн шүү та нар.

Ер нь хуралдаан туйлын замбараагүй болж байна гэдгийг би хэлье гэж бодож байна.

Хоёрдугаарт, намуудын бүлгийн ахлагч нарын зөвлөлгөө-  
нөөр урьдчилан хэлэлцэж ингэж байх юм бол энд хуралдах  
бид нарт хэрэг байхгүй. Яагаад гэвэй, энэ бол төрийн дээд  
эрх барих байгууллагын хурал болохоос биш намуудын хурал  
биш. Тийм учраас энийгээ би нэлээн хатуу анхаараасай гэж  
ингэж санаж байна.

Ямар ч байлаа гэсэн Ардын Их Хурал төрийн, монгол  
улсын гэдгийнхээ өмнөөс онцгойлж ярих хэрэгтэй байна. Түүнээс  
биш намууд өөр өөрийнхөө эрх ашгийг хамгаалах тийм хурал  
биш гэдгээ энд анхаармаар байна гэж санагдаж байна. Ийм  
учраас хэлэлцэх асуудлыг зөвхөн депутатууд хэлэлцэж шийднэ.  
Энэ бол намуудын бүлгүүдэд ямар ч хамаагүй байх ёстой гэсэн  
ийм санал тавьж байна.

Соронзон хальстай  
тулгаж нийлсэн

Ж.НАРАНТУУЛА

Бичээч    Ө.ОЮУНЧИМЭГ

үндсэндээ нэг булэг гэж үзэж асуудлыг энэ дэгийнхээ заасан дагуу хэлэлцэх нь зүйтэй гэж үзэж байна. Тийм учраас энэ намын булэг, бусад булгуудийг энэнээс хасах саналтай байна.

45 дугаар тойргийн депутат Лхагвасүрэн -Түрүүчийн ярьж байгаа нилээн депутатуудын саналтай миний хувьд санал нэг байна. Уүнийг ерөөсөө өнгөцхөн хараад ингэж харагдаж байгаа шуу дээ. АИХ-ын хуралдааныг хэлэлцэх асуудал, түүний дарааллыг намын булгууд урьдчилан авч хэлэлцэж тохиролцсоны дараа Их Хурлын депутат нарын саналыг авбал авах л юм даа гэсэн утгатай өгүүлбэр байж байгаа. Тэгэхээр уүнийг бүрмесөн хасах саналтай байна. Яагаад гэвэл намын булгууд тэртэй тэргүй байгаа шуу дээ. Өөр ямар булгийн тухай цухалзах гээд байгааг би ойлгохгүй байна. Тэгэхээр энэ байлгах шаардлагагүй юм.

14 дүгээр тойргийн депутат Лхагвасүрэн -Тэгэхлээр энэ байна л даа. Намын булгууд тэртэй тэргүй зайлшгүй байгаа. Дээрээс нь яаж байна вэ гэхлээр нутаг дэвсгэрийн булэг гарч ирнэ мэдээжийн хэрэг. Нам бусчуудын, мэргэжлийн булэг гээд. Ингэхлээр үүнтэй холбогдуулаад хэлэхэд зарим нь булгэрхэх нь энээ тэрээ гээд асуудлууд яриад байна л даа. Жишээлбэл, бие даасан депутат хүн ямар нэгэн асуудал дэвшүүлээд одоо энэ хэлэлцэх асуудал гээд байна, болдогтуй юмуу. Уүнийг нийт депутатууд авч хэлэлцэе гэвэл батлаад авч хэлэлцдэг юм байгаа биз, хэлэлцэхгүй гэвэл авч хэлэлцэхгүй л юм байгаа биз. Заавал тэр 40 гэсэн тоог үндсэндээ би хүлээн зөвшөөрөхгүй байгаа. Жишээлбэл 40 гэсэн тоог хатуу заагаад өгөх юм бол АИХ-ын байнгын комисс байж байна шуу дээ. 21 хүн энэ тэр гэсэн. Иймэрхүү юмнууд байна. Уүнийг тодруулах л хэрэгтэй юм шиг байна.

314 дүгээр тойргийн депутат Гантэмэр -Депутатын булэг байж болно. Тэр нь буртгэгдсэн байна гэж л заая. Тоо бол хэрэггүй. Яагаад СДН, өөр нам гэхээрээ 5,6 хүнтэй булэг байж болдог, нам бус нь яахаараа 40,50 хүрч байдаг албатай юм бэ. Намын гишүүн байснаараа депутатын эрх хязгаарлагдах ёсгүй. Хоёрт, хуралд хэлэлцэх асуудлыг хурлын даргаас оруулаад л депутат нар шууд хэлэлцэж болно шуу дээ. Бүлэгт хамаараагүй гээд депутат нар хэзээ ч хязгаарлагдах ёсгүй. Ямар нэгэн нам юмуу бүлэгт ороогүй депутат байж байтал тэр чинь энэ асуудлыг хэлэлцэх эрхгүй болохгүй шуу дээ. Энэ бол намын юмуу булгийн гэдэг. Энэ нь депутатын булэг



Дашбалбар -Их хурлын **депутат** нөхөд өө, би зүгээр та нарын анхаарлыг нэг юманд хандуулахыг хүсч байна. Яагаад гэвэл Их хурлын дэгэнд биеэ биеэ доромжлохгүй гэсэн уг байгаа. Хоёрт гэвэл өчигдериийн цуглаан хийгээд энэ бух холбоодууд бол ганц холбоо, ганц хүн биш хэдэн арван мянган хүн байгаа. Цаана нь арваад холбоо байгаа. Монголын бух багш нар, монголын бух тээвэрчид, худалдааны ажилчид, НААУ-ний ажилтан, ажилчид бүгд байгаа. Эднийг бүгдийг харгис гэж хэлж байгаа бол энэ угзээ хэлж байгаа хүн би өөрөө угзээ буцааж авч уулчлалт гүйх ёстой гэж бодож байна. Уучлалт гүйхгүй бол энэ харгис гэдэг ийм угийг оруулж Ардын Их Хурлын депутатыг доромжилж байгаагийн хувьд би нехөр Хоржаубайг шүүхэд шилжүүлнэ.

197 дугаар тойргийн депутат Шура-Тэгэхээр энэ дээр зарчимтай ач холбогдолтой, юмаа бодож ярьцгаамаар байна. Хий хоорондоо маргаад байхын хэрэг алга. Энэ дээр бүлэг дээр бид урьд нь анхдугаар хуралдаан дээр янз янзын бүлэг байгуулаад яриад байсан. Мэргэжлээр гээд янз янзаар. Энэ дээр заавал нутаг дэвсгэрийн, намын гэж зааж байхын хэрэг алга. Ерөөсөө бүлэг байгуулж болно. Хичнээн ч хүн. Хамгийн гол нь узэл бодол, тэр бодлогоороо нэгдсэн байх ёстой. Түрүүн хүн хэлж байна шуу дээ. Нэг намын, ганц намын гишүүн хүн ч энэ дотор байж байгаа. Тэгэхээр ганцаараа ямар бүлэглэл болох биш. Зохих хэмжээний юугаар хоорондоо холбогдож байж, узэл бодлоороо нийлж байж л бүлэглэл болох ёстой байх гэж бодож байна. Хоёрдахь асуудал бол нэгдүгээр хэсгээс хасмаар санал байна. Энэ их хурлын хуралдааны **хэлэлцэх** асуудал, дотоод журмыг депутатуудын нутаг дэвсгэрийн намын бүлгийн ахлагчдын зевлэлгөөнөөр урьдчилан **хэлэлцэнэ** гэнэ. Энэ бол жинхэнэ манайхны хоцрогдол энэ. Ер нь бусад их хурал, аль ч хурлууд дээр монголд давтагдаж ирсэн юм бол ерөөсөө **урьдчилан** төлөөлөгчдийн ахлагчдын зевлэлгөөнөөр хэлэлцсэн юмаа гээд л гар өргөж байдаг, үүнээс татгалзмаар санагдаж байна. Ийм санал байна.

Уртнасан -Хэлэлцэх асуудлыг урьдчилан хэлэлцэхгүйгээр шууд л хэлэлцэж байя гэсэн санаа юм уу?

Шура -Тийм, шууд хэлэлцэж байя гэсэн санаа.

Уртнасан -Бүлгийн хувьд бол нэр заахгүй ээ.

Шура - Яахав хумуус бол тэртэй тэргүй, зохион байгуулсан байгуулаагүй **булэглэлхүд** зохион байгуулаад юмаа ярьчихаад ирнэ шуу дээ. Үүнийг заавал эндээс яаж байхын хэрэг алга.

3.

Уртнасан -Таны саналыг хулээж авлаа.Гуравдугаар микрофон.

27 дугаар тойргийн депутат Пүрэвдорж -Тэгэхээр би Шурагийн саналтай санал нэг байна.Хэлчихлээ.Тэгэхээр Хатанбаатарын ярьсан дээр 40 гэх дээр зэрэг арай л болохгүй болов уу.Зарим нам 40 депутат байгаа шүү дээ.Намын гээд цөөхөн нэр байж болохгүй, бусад нь олноороо байж болохгүй,тэгш байх болно.Ерөөсөө депутатын хэсгүүд,булэг байгуулж болно.Харин булэг бол албан ёсоор байгуулаад заавал буртгэгдэж байх ёстой байх.Тийм л журмаар,намын гэхгүй булэг байгуулж болно,ийм л байдлаар оруулж болно.Тоо тогтоогод хэрэггүй болов уу.Тоо тогтоовол зарим нь юугүй болчихно. Хоёр хүн ч бий шүү дээ.Ганц хүн ганцаараа л байх байх.

Лундээжанлан -Ганцхан санал давхардуулахгүйгээр цаг хэмнэх үүднээс хэлье.5 дугаар зүйлийн эхний хэсгийг нэгийг хасч олон хүн давхардуулаад байх юм.Ер нь өмнө нь урьдчилан зөвлөлдөө гээд байгаа.Үүнийг хороодоор юмуу булгуудээр ярилж болно л доо.Тийм учраас заавал удирдагчид нь,ахлагч нар нь зөвлөлгөөн хийсэн байвал зохион гэж тэр албан ёсны **байдгийг** больё,энэ саналыг олон хүн давхардуулж хэлж байгаа учраас санал нэг байна. Нэг л саналаараа явбал яссан юм бэ.Олон хүн давхардуулаад гаргаж байна.Хоёрдугаарт,хэрвээ депутатын булэг байгуулагдах юм бол тоо заавал байх ёстой.Тухайлбал нийт депутатын 5 хувиас доошгүй гэдэг юмуу 10 хувиас доошгүй гэдэг юмуу ямар нэг байдлаар тоо байх ёстой гэж бодож байна.

280 дугаар тойргийн депутат Цэнлбаяр - Тэгэхээр энд депутат Хатанбаатар,Баярцогт нар зөв зүйтэй санал гаргасан.Энд булгууд тэж байх нь зөв байх.Гэхдээ булгууд байгуулагдах доод талын тоо байх нь зүйтэй болов уу гэдэг саналтай байна.Булгууд ихээхэн зохион байгуулалттай байхгүй бол эмх цэгц дараалал алдаж магадгүй.Энд 4 гол булэг л байх юм шиг байна.Намын нутаг дэвсгэрийн, мэргэжлийн,тодорхой асуудлаар гэсэн ийм 4 булгийг зөвшөөрч дэгэнд тусгавал яана вэ.

226 дугаар тойргийн депутат Гарамжав- Тэгэхлээр миний санал бол одоо бид чухал асуудал хэлэлцэж байгаа энэ үед намархаж,булгэрхэхийг зогсоомоор байна.Энэ асуудлаас болж өмнө нь нилээн тодорхой асуудлууд дээр зөрчилдэж байсан.Ийм учраас улс орны эрх ашигт нийцэх энэ асуудал хэлэлцэж байгаа үед депутатууд

гэдэг чинь хаанахын ямар юм гарч ирчихээд байгаа юм бэ. Бид нар АИХ-ын депутатууд асуудлаа хэлэлцэх гэж байна. Заавал булгээр дамжуулах нь алба юмуу. Тэгэх юм бол бүлэг гэдэг юмыг бур хасъя. Энэ дээр маргаж цаг бараад хэрэггүй. Ер нь АИХ-ын депутатууд бүлэгтэй, бүлэггүй асуудлаа л хэлэлцэнэ. Хурлын байгууллага байна, асуудлаа бид хэлэлцэе, заавал булгээр дамжуулах ямар шаардлага байна вэ. Хэний бодлого, хэний үээл санааг энд шингээх гээд байгаа юм бэ. Шууд л ярилцъя. Эсвэл бүлэг байна, бүлэг нь буртгэгдсэн байна гээд л товчлоод энэ асуудал дээр маргаанаа зогсооё. Ийм санал байна.

105 дугаар тойргийн депутат Чойжилсурэн -Энэ хичнээн ч хамаагүй бүлэг байгуулах асуудал бол чуулганы чийл ажиллагааг улам хүндруулж, хэлэлцэх гэж байгаа асуудлын талаар нэгтгэж болмооргүй олон янзын саналыг гаргахад хүргэнэ. Ийм учраас ийм задгай байдлаар булгуудийг тавьж, дэгэнд оруулна гэдэг бол тусгүй зүйл юмаа. Ийм болохоор угүй юм бол саяын саналаар депутатынхаа хувьд л ярилцъя, угүй бол нам, нутаг дэвсгэрийн хэлбэрээр гэдэг энэ хоёрыгоо хадгалж үлдээ, аль ч намын бүлэгт хамарагдахгүй байгаа депутатууд бол нутаг дэвсгэрийн бүлэг дотор заавал хамрагдах учраас энэ хумуусуудийн эрх хэмжээнд ямар нэгэн хязгаарлалт тогтоосон зүйл эндээс гарч ирэхгүй. Ийм болохоор зэрэг энэ мэргэжлийн бүлэг ч гэдэг юмуу ийм янз янзын бүлэг байгуулаад ингэх юм бол ерөөсөө бид нарын хэлэлцэх асуудал чинь ямар нэгэн мэргэжлийн хүний асуудлыг тодорхойлох гэж байгаа асуудал биш шүү дээ. Цаашдаа хэлэлцэх гээд байгаа асуудал. Ийм болохоор үүнийхээ шинж чанарын үүднээс улсын эрх ашиг, иргэний угрэг эрх ашгийнхаа талаас л асуудал руу юмаа чиглүүлж хандахгүй бол суулдээ замбараагүй, шийдэж болохгүй юм руу орох гээд байна шүү.

177 дугаар тойргийн депутат Буянмөнх -Саяын 5 дугаар микрофоноос ярьж байгаа депутаттай санал нэг байна. Түүн дээр нэг санал байна. Бүлэг гэдэг маань юу вэ? Жирийн депутатас ямар давуу эрхтэй юм бэ, ямар уграгтэй юм бэ гэдгийг тодруулахгүйгээр ганцхан бүлэг гэдэг угийг тойроод яриад байх шиг байна аа. Энэ давуу, эрх угрийг нь тодруулж өгвөл түүний дараагаар бүлэг ямар бүлэг байгуулах юм бэ, ямар чиглэлээр байгуулах юм бэ гэдэг нь тодорхой болох ёстой байх аа.

-Уртнасан -Санал хураах ер нь дөхөж байна.

6.

9 дүгээр тойргийн дэпутат С.Зориг -Асуудлын гол нь юунд  
 байгаа шүү дээ. Булэг байгуулах уу, угүй юу гэдэг чинь хүссэн хүсээгүй байгуулагдана. Зочид буудалд хэдэн хүн очоод цуглараад яривал тэр булэг болно шүү дээ. Тэрийг хааж боох гээд нэмэр байхгүй.  
 Нэг аймгийнх юмуу, хэсэг үзэл бодолтой хүн нийлээд яривал ярина.  
 Хамгийн гол асуудал юунд байна вэ гэхлээр завсарлага авах асуудал  
 байгаа шүү дээ. Зөвлөлгөөн хийе гэвэл хэдэн намын дарга нэг өрөөнд  
 суугаад зөвлөлгөөн хийхэд хорих ямар ч нехцел байхгүй шүү дээ.  
 Булэг байгуулахыг зөвшөөреөд, харин ямар хэмжээний булэг нь аливаа  
 асуудал хэлэлцэж байхад завсарлуулах өрхтэй вэ гэдэг тэрийг хэм-  
 жээгий нь заагаад өгчих хэрэгтэй. Тэрнээс бусад юман дээр өөр өрх  
 байхгүй юм чинь яах юм бэ.

СОРОНЗОН ХАЛЬСТАЙ ТУЛГАЖ  
НИЙЛСЭН

Х.Санжар

/БАЯНДҮҮРЭН/

БИЧЭЭЧ

/Д.ЭНЭБИШ/

1991.XI.XI  
Кассет № 24  
16.00-16.15

165 дугаар тойргийн депутат Ч.Гомбосүрэн: Дэгийнхээ асуудлыг эрхэм депутатууд бид цөмөөрөө хариуцлагатай хандаж, зөв оновчтой санал дээрээ саналаа төвлөрүүлэх шаардлагатай байна.

Тэгэхлээр энэ дээр I зүйл хэлэхэд ерөөсөө энэ асуудалд булгийг ор үгүйсгэж болмооргуй санагдаж байна. Ерөөсөө л хоёрхон чиглэлээр намын булэг, нутаг дэвсгэрийн булэг байж болно. Энэ булэг тодорхой асуудлаар депутатуудад тэр булгийнхээ нэрийн өмнөөс асуудал депутатуудаар хэлэлцүүлж болох ийм л заалт оруулаад, бусдыг нь бүгдийг хасах саналтай байна. Ингээд нэгтгэчихвэл боломжтой болохоор байна. Энд харин нэг зүйлийг тодруулж асуух асуултын зүйл байна.

Энэ Ардын Их Хурлын хуралдаан хуулийн зөвлөхтэй байна гэсэн. Тэгэхдээр энэ хуралдаанд орж байгаа хуулийн зөвлөхийг депутатууд мэдэхгүй байгаа. Ямар хэн хэн гэдэг хүмүүс хуулийн зөвлөхөөр ажиллаж байгаа юм бэ. Энийг депутатуудад сонсгох хэрэгтэй байна. Шаардлагатай гэж үзвэл хуулийн мэргэжлийн болоод энэ хуулийн зөвлөх бүрэлдэхүүнд депутатуудаас оруулах шаардлагатай гэж үзвэл оруулах хэрэгтэй байна. Энийг эхэн дээрээ депутатуудад сонсгоод батлуулчихвал зүйтэй гэж бодогдоод байгаа юм. Өчигдөр, уржигдар битүү утгаар Ардын Их Хурлын хуралдаан хуулийн зөвлөхтэй хуралдана гэж хэлсэн. Тэрийг бас нэр усыг нь мэдэх шаардлагатай байгаа нэг ийм зүйл байна.

За тэр хурал завсарлуулах асуудал бол 10 дугаар зүйл дээр байж байгаа. Тэгэхдээр тэр 10 дугаар зүйлийн тэнд асуудал яригдана. Завсарлуулах тухай.

Уртнасан:

Тэгэхдээр депутатуудын санал үндсэндээ нэгдлээ гэж бодож байна. Манай эрхэм депутатууд хоёр зүйл дээр санал хураачихвал асуудлыг шийдчих юм.

Нэгдүгээрх нь булэг зайлшгүй байна гэдэг ийм санал байна. Булэг байх, эсэх тухай. Хэрэв булэг байх юм бол хүний тоо байх уу, үгүй шу. Зарим хүмүүс 40 гэж санал гаргаж байна. Зарим

## 2.

Хүн депутатуудын тодорхой хувиар гэж санал гаргаж байна. Хэрэв бүлэг байх тохиолдолд энэ хувь, тоо хоёрыг дахин санал гаргаж тогтох болох юм.

Одоо та бүгдээс ийм санал хураалтанд оролцохыг хүсч байна.

Депутатын тодорхой бүлэг байна, эсвэл байхгүй гэдгээр. Ер нь байна, байхгүй гэдгээр санал хураалт явуулчихад тодорхой болох болов уу. Тэгэхээр депутатын бүлэг, бүлгийг бид турхун тохирсон шүү дээ, нэр заахаа больё, ер нь депутатын бүлэг байж болно гэж. Тэр мэргэжлээр, намынхаар, орон нутгийнхаар, эвслийнхээр гээд. За бүлэг байх эсэх талаар санал хураалт явуулъя.

Санал хураахад бэлтгэнэ уу.

Тэгэхээр зарим депутатууд бүлэг байлгах асуудлыг өсөргүүцэж байгаа шүү дээ.

Үүгээр санал хураалт явуулах нь зүйтэй юу.

Ер нь депутатын бүлэг байна гэдэг асуудлаар, байх, эсэх асуудлаар санал хураалт явуулъя.

Санал хураахад бэлтгээрэй.

За депутатын бүлэг байх тухай асуудлыг манай депутатуудын 357 нь буюу 88 хувь нь зөвшөөрч байна. Ийм учраас депутатын бүлэг ажиллаж болох нь ээ. Харин депутатын бүлэг тодорхой асуудлаар санал солилцохын тулд завсарлага авах тухай асуудал 10 дугаар зүйлд байгаа учраас энд нэмэлт оруулж, энэ зүйл дээр нэмэлт хийх хэрэгтүй гэж бодож байна.

За одоо депутатын бүлэг байвал депутатын хувиар уу, тоогоор уу гэдэг нэг депутатуудын санал байгаа юм. Лундаажанцан депутат хувиар гэсэн Хатанбаатар депутат 40-өөс доошгүй гэдэг тоо хэлсэн.

Тооны хувьд хязгаарлах хэрэг байна уу.

За санал хураалт явуулъя. Тооны хувьд хязгаарлахгүй.  
Төмөрбаатар 95 лугаар тоирог

Нэг ийм санал байна.

Депутатын бүлэг, орон нутгийн депутатын бүлэг хуссэн ч, хуссэгүй ч байна. Энэ бол зөвхөн санал гаргах бүлэг биш шүү дээ.

Депутатуудыг зохион байгуулах, харилцах, ярилцах, ирж очих, материалыг хүртэл тараах, янз бүрийн үүрэгтэй байгаа шүү дээ.

Орон нутгийн депутатуудад хүссэн ~~үсэх~~ ч байна. Хажууд нь намын болоод бусад бүлгүүд байх тухай асуудал яригдаж байна уу гэхээс биш нэг л булэг байна, орон нутгийн булэг, тэргүнд бол зөвхөн орон нутгаас тухайн аймаг, тухайн хотоос хэдэн депутат байна тэрнийгээ ахалсан нэг л ахлагч байна тэр хүн л бусад депутатуудтайгаа харилцаж санал бодлоо авч бусад байгууллагуудтай харилцаж байна гэж би ойлгож байгаа. Гэтэл Гэрэлболц хуучин хуулиуд, хуучин бидний баримталж ирсэн юманд намын булэг гэдэг асуудал заавал орж ирж байсан. Ингээд намын, орон нутгийн гэсэн 2 булэг байгаад байсан. Одоо намынхыгаа больчихъё. Ерөөсөө орон нутгийн депутат нэг л булэгтэй байя.

Тэр нь Ардын Их Хурлын дарга, Ардын Их Хуралд туслах ийм булэг байх.

Уртнасан: За саналаа хураая.

За баярлалаа. Тэгэхээр бид бүлгийнхээ хувьд ер нь санал нэгдлээ шүү дээ. Намын, орон нутгийн, мэргэжлийн бусад бүлгүүд, эвсэл холбоодын булэг байж болох юм гэж. Харин тэр бүлгүүд депутатын хувьцар албан ёсны болгох уу, тоогоор албан ёсны болгох уу гэдэг дээр санал хураалт явуулаад, ер нь тоо ч хэрэггүй, хувь ч хэрэггүй гэвэл бид энэ асуудлыг таслахад бэлэн байна.

За депутатын булэгт тоо буюу хувь заахгүй гэдгээр санал хураалт явуулъя.

80 дугаар тойргийн депутат Л.Зарыккан: Ер нь депутат гэдэг маань нэгдүгээрт аль нэг намын дэмжлэгээр өөр намуудын туслашцаатайгаар депутат болсон хүмүүс. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт нутаг дэвсгэрээр тэр дотор байж байгаа багш, эмч, жолооч бүгдээрээ нийлж байж сонгосон улсууд. Тийм учраас бид намын ба орон нутгийн бүлгийн тухай ярина уу гэхээс биш, цаашаа мэргэжлийн бусад гэсэн ийм олон юм гаргаж ирэх юм бол энэ депутатууд ерөөсөө ажиллаж чадахгүй. Ийм учраас бид, миний санал гэвэл ерөөсөө эхний хоёр булэг байх нь зүйтэй, бусад бүлэг байгуулах юм бол тодорхой тоо зааж өөрсдөө байгуулна биз дээ. Тэргүнд бид нар оролцоод хэрэг байна уу гэсэн ийм саналтай байна.

Уртиасан:

Уламжлал ёсоор намын бүлэг ажиллана, орчин нутгийн бүлэг ажиллах нь байна. Манай зарим депутатуудын хэлж байгаагаар магадгүй мэргэжлийн эвсэл холбоодын бүлэг ажиллаж болох юм. Тийм тохиолдолд тоо хязгаартай байна гэдэг дээр санал хураалт явуулах уу. Тоон хязгаарыг бидэнд одоогийн байгаагаар 40 гэсэн тоо байгаа. Үүнээс өөр хувилбар гаргаж ирэх дэпутат байна уу.

ЗГ7 дугаар тойргийн депутат Д.Мандах: Нэгдүгээрт энэ зохион байгуулалтын талаар хэрвээ тухайн асуудлаар саналаа дууссан юм бол саналаа албан ёсоор тасалчихаад дараа нь санал хураалтанд ормоор байна. Тэгэхгүй бол санал хураалт чинь ингэж явж байгаад дундуур нь ахиж тухайн асуудлаар санал хэлээд эвлээд байна шуу дээ.

Хоёрдугаарт гэвэл нэгэнт боссон учраас түрүүний энэ дэпутатын бүлгийн талаар саналаа, санал уг нь давхардаад байна энэ нь сайн ангилагдахгүй байгаа учраас ахиж давтаж хэлэхээс өөр зам алга.

Нэгэнтээ дэпутатын бүлгийг янз бурийн чиглэлээр байгуулж болно гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа юм болбол тоо зааж болохгүй. Тoo заана гэдэг чинь эргээд дэпутатын бүлэг байж болох эсэхийг хязгаарлаж байгаа учраас хүлээж авах аргагүй. Тoo заахгүй байж байж л дэпутатын бух төрлийн бүлгүүд байгуулагдана. Тэрэн шиг жишээ нь 40 дэпутат нийлж байж нэг дэпутатын бүлэг болно гэвэл нэг хэсэг намын чинь дэпутатын бүлэг байхгүй болно шуу дээ. Тийм учраас хоорондоо зөрчилтэй саналыг би Хатанбаатар дэпутатыг гаргалаа гэж ойлгоод энийг эсэргүүцэж байгаа. Нэгэнтээ дэпутатуудын бух төрлийн бүлэг байна гэдгийг бид нар хорьж чадахгүй. Нэгэнт хорьж чадахгүй юм бол байхыг нь зөвшөөрөхөөс өөр зам байхгүй. Байхыг нь зөвшөөрч байгаа юм бол тоо хязгаар гэж болохгүй гэсэн ийм саналтай байна.

II дүгээр тойргийн депутат Ж.Бямбаа: Саяны дэпутат миний хэлэх гэсэн саналыг хэлчихсэн учраас би санал хэлэхгүй. Тoo хязгаарлаж болохгүй. Энэ бол олон, цөөн янз бурийн тоотой намууд байгаа учраас тоо тогтоож ерөөсөө болохгүй. Тэгвэл олонхи нь

цөөнхийгөө дарангуйлсан тийм асуудал гарчихна.

Уртнасан: За депутатуудын санал жигдэрчихшиг боллоо. Булгүүд ажиллатан. Тэгэхдээ булгүүдэд тоон хязгаарлалт байх уу, байхгүй юу гэдэг дээр санал хураалт явуулъя.

Депутатуудын булгүүдэд тоон хязгаарлалт байх уу, угүй юу.

23I дугээр тойргийн депутат Г.Амарбаян: Булгийнхээ төрлийг тогтоомоор байна шүү дээ.

Сая Зарынкан дарга ярилаа. Ерөөсөө намын булэг, нутаг дэвсгэрийн булэг гэсэн энэ хоёрыг албан ёсоор бид нар энэ дээр яая гэсэн энэ саналаа хураамаар байна. Өөр мэргэжлийн бусад эвсэл, холбоодын энэ булгүүдийг заавал энэ дээр оруулаад яахав. Тэгэхдээ ийм санал гаргаад байна л даа.

Уртнасан: Депутатуудын саналыг бас харгалзаж үзэх хэрэгтэй л дээ.

Санал үндсэндээ жигдэрлээ гэж бодож байна.

Лүнлээжанлан: Намын булэг, нутаг дэвсгэрийн булэг дээр тоо хязгаарлахгүй. Бусад төрлийн булэг гарч ирвэл тоо тавья гэсэн ийм л юм.

Уртнасан: Саналаа хураая. Булгүүд дээр тоон хязгаарлалт байх уу, угүй юу гэдгээр.

Булгүүд ажиллана. Булгүүд дээр тоон хязгаарлалт байхгүй гэдэг дээр санал хураалт явуулъя.

Саналын дун гарлаа. Депутатуудын ихэнх нь 84 хувь нь буюу 346 депутат намын булгүүдэд тоон хязгаарлалт байхгүй байя гэсэн ийм санал ирүүлжээ. Ерөөсөө булгүүдэд.

6 дугаар зүйл нийтдээ 2-хон заалттай. Нийт булгийн гишүүдийн тоо, нэрийг Ардын Их Хурлын даргад албан ёсоор өг бүртгүүлсэн байна гэдэг өгүүлбэрийн редакцийг тэнд хийлгэв.

II дугээр тойргийн депутат Ж.Бямбаа: Уртнасан даргаа хугацаа байх ёстой. Дэг батлагдсаны дараа дараагийн асуудал эхлэхээс өмнө булгүүд бол бүртгэгдсэн, мэдээлэгдсэн байх ёстой гэдэг дээр санал хураалгах хэрэгтэй.

Уртнасан: Эрхэм депутатуудаа зургадугаар зүйл дээр саналаа солицшоё. Депутатын бүрэн эрхийг зөвшөөрөх тухай.

5 дугаар зүйлийг бид хоёр зүйл болгохоор санал нэгтэй баталчихсан. I дүгээрх хэлэлцэх асуудал, 2 дугаарх нь депутатын булгийн асуудал.

Энийг зарчмын хувьд редакци хийе гэдгээ бид сая тохирчиллоо.

5, 6 дугаар зүйлийг бид зарчмын хувьд баталчих уу.

С. Чулуунбаатар:

Уучлаарай Их Хурлын даргаа нэг асууж, тодруулах зүйл байна. Тэгэхлээр ингэж ойлголоо. 5 дугаар зүйл бол хоёр зүйл боллоо гэдгийг ойлголоо. Нэгдүгээрх нь хэлэлцэх асуудалтай холбоотой, хоёрдугаарх нь булгийн тухай байх нээ гэж та хэлэлцүүллээ. Энэ зөв ойлголоо. Энэ дээр депутатууд ийм санал гаргаад байгаа шүү дээ. Тэрнийг та санал хураалгасангуй. Одоогийн байгаа төслийн 5 дугаар зүйлийн нэгийг хасъя. Хоёр зүйл болгосон ч, гурван зүйл болгосон ч, нэг зүйл байсан ч гэлээ гэсэн одоогийн тавдугаар зүйлийн нэгийг хасъя гэдэг ийм саналыг түрүүн хэд хэдэн депутат гаргана лээ дээ. Тэрнийг хасах уу, үлдээх уу гэдэг тухай асуудлаар санал хураагаагүй болох учраас редакцийн комисс нэгдүгээрт хүндрэнэ, хоёрдугаарт дараа ороод ирэхэд дахиад хэлэлцээд унана шүү дээ.

Соронаон хальстай  
тулгаж нийлсэн

*Б. Мула*

ЭНХТУЯА

Бичээч

*В. Оюун*

1991-XI-II  
Касет № 25  
16.15-16.30

Ж.Уртнасан -Нэхдуудийн олонхийн саналаар бид тавдугаар зүйлийн нэгдүгээр заалтыг хасъя гэсэн ийм л ойлголттой байгаа шуу дээ. Намын булгүүд дээр урьдчилан тохирно гэдгийг хасъя гэж хассан. Тэгээд редакци хийгээд орж ирэх байх. Энэн дээр бид санал нэг байгаа гэж ойлгож байна зөв шуу? Тэгвэл тавдугаар зүйлийн нэгдүгээр заалт хасагдсан гэдгээр санал хураалт явуулъя. Үүнийг зөвшөөрч байгаа гишиг саналаа өгнө шуу.

Э.Бат-Үүл /52 дугаар тойргийн депутат/ -Уртнасан даргаа, би одоо, наана чинь нэг анхаарах юм байгаа юм. Юу вэ гэхээр, би зүгээр депутатуудад ийм зүйл анхааруулах гэсэн юм л даа. Намын булэг дээр их анхааралтай хандарай. Яагаад гэхээр бид нар сонгууль хийхдээ намын нэрсээр сонгууль хийсэн явдал бий шуу. Намын нэрсээр. Тэгэхээр одоо жишээ нь, энэ чинь бас хэлэлцэх асуудалтайгаа уялдаад байна шуу дээ. За Үндсэн хууль хэлэлцэхэд нэг өөр болчихно, булгийн зохион байгуулалт чинь. Гэтэл Засгийн газрын асуудал Бага Хурлын асуудал хэлэлцэхээр чинь намын булэг гэдэг чинь гарцаагүй ажиллах хэрэгтэй болно шуу дээ. Тийм биз дээ. Тийм болохоор зүгээр намын тэр засаг захиргааны булэг бий шуу дээ. Тэр бол ойлгомжтой. Негеө, тэгэхээр та сая ингэлээ шуу дээ. Хэлэлцэх асуудлыг намын булгүүд зөвшүүлж орууллаа гэдгийг ерөнхийд нь хасчихаар зэрэг, за жишээ нь Засгийн газрын асуудал хэлэлцсэн чинь намууд одоо ингээд асуудал тавих болжээ. Улсын Бага Хурал дээр тавих болчихож л дээ. Тэгэх юм бол негеө бухэлдээ хасагдсан учраас тэр чинь...

Ж.Уртнасан -Үгүй л дээ, Бат-Үүл депутаттаа. Бид булгүүд байхыг зөвшөөрч байгаа учраас саналаа нэгтгээд оруулж ирэх нээлттэй үлдэж байгаа шуу дээ.

Э.Бат-Үүл -Энэ чинь ийм л дээ. Би зүгээр зориуд хэлэлцэх асуудалтай нь уялдуулаад байхгүй ю. Хэлэлцэх асуудалтай нь уялдуулаад байгаа юм. Өөрөөр хэлбэл одоо бухэлд нь намын бул-

2.

гүүд хэлэлцэж байж жишээ, за зүгээр бур муутаар бодъё л доо. Хэдүүлээ хэлэлцэж байгаад Ерөнхий сайдын асуудал гээд оруулах болбол яах вэ? Тэгэхээр бид нар чинь намын булгийн энэ эрхийг хасчихсан, сонгуулийн энэ эрхийг хасчихсан байж байгаа шүү дээ.

Ж.Уртнасан -Бид нэгэнт булгүүд байхыг зөвшөөрч хуульчлан зааж байгаа учраас санал тодорхой асуудлаар санал хураагаад оруулж ирэхийг нээлттэй үлдэж байгаа гэж бид бодож байна шүү дээ. Энэ бол нээлттэй үлдэнэ.

За бид тав, зургадугаар зүйлийг үндсэнд нь зарчмын хувьд зөвшөөрлөө гэж бодож байна. Одоо бидний энэн дээр бичсэнээр зургадугаар зүйл. Бидний тавдугаар зүйл маань шинэчлэгдэн бичигдэхэд тав, зургадугаар зүйл болох нь. Энд бичсэнээр бид 6 дугаар зүйл рүүгээ орьё гэж бодож байна. Зургадугаар зүйлийн өмнө шинэ 6 дугаар бүлэгт Ардын Их Хурлын депутатуудын нутаг дэвсгэрийн булгийн зохион байгуулалт, үйл ажиллагааг Ардын Их Хурлын зохион байгуулалтын дүрэм, БНМАУ-ын хууль тогтоомжийн бусад актаар зохицуулна гэдэг энэ өгүүлбэрийг бид хэвээр үлдээнэ гэсэн ойлголттой байгаа шүү.

За одоо 6 дугаар зүйлээ ярилцъя. Санал солилцмоор байна.

Ю.Жаргал /46 дугаар тойргийн депутат/- Энэ 6 дугаар зүйл дээр депутатын бүрэн эрхийг зөвшөөрөх гэдэг дээр энэ өөвхөн нехэн сонгогдсон депутатын асуудлыг биччихээд байна. Одоо дахин сонгууль бол хоёр тойрог дээр явж болзошгүй байна. Нехэн сонгууль хоёр тойрог дээр явж болзошгүй байна. Өнөөдрийн юун дээр бид дахин сонгуулийн 6, нехэн сонгуулийн 9 тойргийн депутатуудын бүрэн эрх батлуулсан учраас энэн дээр нехэн ба дахин сонгуулиар сонгогдсон гэдэг ийм юугаар оруулчих юм бол болох юм. Бусад нь энэ чигээрээ байж болох юм гэсэн ийм саналтай байна.

Ж.Уртнасан -Саналыг хулээж авлаа, өөр ямар санал байна вэ? Депутат Жаргалын саналыг редакцид оруулахыг редакцийн группд даалгая. За ингээд зарчмын хувьд 6 дугаар зүйл дээр санал хураалт

## 3.

явуулах уу? За 6 дугаар зүйлийн талаар санал хураалт явуулъя. Эрхэм депутатууд санал хураахад бэлтгээрэй эрхэм депутатууд.

Зөвшөөрсөн 399 депутат буюу 97 хувь нь байна. За баярлалаа.

За 7 дугаар зүйл рүү орьё. Ардын Их Хурлын дарга, орлогч дарга нарын үүрэг. Энэ зүйл хоёр заалттай юм. Энэн дээр депутатуудын саналыг сонсъё.

Ц.Элбэгдорж /427 дугаар тойргийн депутат/ -7 дугаар зүйл дээр ийм санал байна. Энэ 7 дугаар зүйлийн хоёрын "дарга нь хуралдааныг удирдах үүргээ орлогч даргад даалгаж болно" гэдгийг хасах саналтай байна. Тэгээд орлогч дарга нар, "хуралдааныг БНМАУ-ын Ардын Их Хурлын дарга, орлогч дарга нар өэлжлэн удирдана" гэж, "орлогч дарга нар өэлжлэн" гэдэг угийг дээд талын өгүүлбэр дээр нь нэмэх саналтай байна. Тухайн үед нь хэн удирдах вэ гэдгээ энэ таван хүн нь маань хоорондоо яриад шийдэх байх гэж бодож байна. Ер нь намууд нэр дэвшиүүлсэн, эндээс депутатууд дэвшиүүлсэн, манай дөрвөн орлогч даргын аль нь ч гэсэн хурал удирдах чадвартай ийм улсууд гэж бодож байна. Энийг энд заавал оруулж өгөх ёстой. Хурал нэлээн удах байх гэж бодож байна. Дараачийн нэг зүйл бол шинээр хоёрдугаар зүйлийн дараа, тэр хуралдааныг, хоёрдугаар зүйлийн өгүүлбэрт бас нэг өгүүлбэр нэмж оруулмаар байна л даа. БНМАУ-ын Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч нар Ардын Их Хурлын даргын зөвшөөрснеөр тодорхой асуудлыг хэлэлцүүлэхэд хуралдааныг удирдаж болно гэж оруулмаар байна. Яагаад энэ саналыг тавьж байна вэ гэхээр би үндэслэлээ хэлье. Их цаазыг хэлэлцүүлэх үед Уртнасан гуай ч юм уу, энд сууж байгаа дөрвөн депутат тэр бүр бүгдэд нь тэр зүйл дээр ямар учиртай юм гэдгийг нь тайлбарлаад ингэх шаардлага гарна. Хурал удирдаж байгаа хүн бол. Тэгэхээр энийг Их цаазыг зохион байгуулах комиссын дарга байсан манай Ерөнхийлөгч, энийг хоёр удаа Бага Хурлаар хэлэлцүүлэхэд хэлэлцүүлсэн Дэд ерөнхийлөгч хоёр бол энэн дээр тодорхой хэмжээний, бүрэн ойлголттой ийм хариултуудыг депутатуудад өгч чадна гэж ингэж найдаж байна.

4.

Хурлын дарга бол гар өргүүлэх, хурал удирдах ажлаа, хурлын даргын зөвшөөрснөөр Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч хоёр энэ хэлэлцүүлгийг явуулж болох юмаа Их цааз дээр. Би Их цааз дээр л энэ асуудлыг тавьж байгаа юм.

Н.Пүрэвдорж /41 дүгээр тойргийн депутат/ -Элбэгдоржийн саналыг зарчмын үүднээс зөвшөөрч болохгүй. Тэгвэл ерөөсөө хуулийн анхны мэдэгдэхүүн байхгүй асуудал болчихно. Энийг зөвшөөрөхгүй байна.

Н.Пүрэвдорж -Тэгэхээр  
Ардын Их Хурлын дарга, орлогч дарга нарын үүрэг гэж байна. Хуралдааны үед ойлгомжтой. Хуралдаан тарангут тэгээд нэг хоосон мануухай шиг юм болчихно тиймээ. Тийм учраас энд одоо Ардын Их Хурлын байнгын комиссуудаас боловсруулаад хэлэлцүүлж байгаа Ардын Их Хурлын дурмийн асуудлыг энэ дэгийн дараа бас батлаад авах хэрэгтэй юм шиг байгаа юм. Ийм саналтай байна.

С.Лхагвасурэн /47 дугаар тойргийн депутат/ -Энэ саяын Пүрэвдорж депутатын хэлсэнтэй санал нэг байна. Энийг тодотгой гэж бодож байна. БНМАУ-ын Ардын Их Хурлын хуралдааныг дарга удирдана, хуралдааныг дарга удирдана гэдэг нь зайлшгүй. Зөвхөн дарга, ээлжилж удирдана гэдгийг санал нийлэхгүй байна, энийг буруу гэж үзэж байна. Негеө талаас зарим шаардлагатай асуудлууд дээр Ерөнхийлөгч болон Дэд ерөнхийлөгч удирдана гэдгийг зөвшөөрөхгүй байна. Ийм саналтай байна.

И.Бадарч /293 дугаар тойргийн депутат/ -Энэ 7 дугаар булгийг бид нар хэлэлцэж байна. Миний ойлгосноор би 8 дугаар булгэг гэж ойлгож байна зөв үү?

Ж.Уртнасан -Тэгнэ. Шинээр 8 дугаар зүйл болно.

И.Бадарч -5 дугаар булгийн нэгдүгээр зүйлийг бид нар байхаар баталсан шүү дээ. Тэр Бат-Үлийн хэлдэг чинь зөв шүү дээ.

## 5.

Намуудын бүлгийг энд зөвшөөрөхгүй байж болохгүй шүү дээ. Тэр 5 дугаар бүлэгтээ орчихсон гэж ойлгож байна зөв үү? Хэрэв ороогүй бол дахин санал хураалгаж өгөөч. Тэр намууд тэртээ тэргүй Дээд шүүхээр батлагдсан бүлэгтээ тэр албан ёсны газрууд.

Ж.Уртнасан - Бид аливаа бүлэг байхыг зөвшөөрөөд, тодорхой асуудлаар санал солилцохын тулд завсарлага авч болно гэдгийг оруулчихсан шүү дээ.

И.Бадарч - Тэгсэн л дээ. Тэгэхдээ одоо наад оруулснаар чинь ийм болчилоод байна. Бид нэг асуудал дээр саналын зөрөө гараад цөөнх боллоо, тэгээд тэр цөөнхүүд бид нар нэг нэгийгээ харж байгаад нэг бүлэг болоод хурлын дундуур ч хамаагүй, төгсгэлд ч хамаагүй ийм салахгүй их олон бүлэг болоод, хурлын ажиллагаа их удаашрах юм биш үү?

Ж.Уртнасан - Булгуудийг албан ёсоор хүмүүсийн нэрийг, тоогий нь авч энд Их Хурлын дарга бүртгэсэн байна гэж байгаа шүү дээ. Тийм тохиолдолд бид булгуудэд завсарлага авах зөвшөөрөл олгоно.

И.Бадарч - Тэгвэл энэ долдугаар бүлэг буюу наймдугаар бүлэг дээр, зүйл дээр тэр ээлжилж удирдана гэдэг зөв юм шүү. Энэн дээр ерөнхийд нь Их Хурлын дарга хариуцах боловч энэ олон орлогч дарга нарыг бид хурал удирдах чадвартай гэж сонгочиhoод, ээлжилж удирдах болохоор нь зэрэг зөвшөөрдөггүй байдаг энэ буруу шүү. Тэр Элбэгдоржийн саналыг би дэмжиж байна. Харин тэр хоёр дахь саналыг хүлээж авч болохгүй.

Д.Балдан-Очир /155 дугаар тойргийн депутат/ - Тэгэхээр энэ 7 дугаар зүйлийн нэрийг өөрчилмөөр байна л даа. Их Хурлын дарга, орлогч дарга нарын эрх, үүргийн тухай яригдаж байгаа учраас, эрх, үүрэг гэхгүй бол энд үүрэг гэчихээд, доор нь эрх үүргийг бичсэн байна л даа. Энэ нэг ийм санал байна.

Хоёр дахь санал бол, уучлаарай, энэ бол зүгээр зайлшгүй байж болох юм. Их Хурлын даргыг эзэнгүй ч гэдэг юм уу, байхгүй нөхцөлд одоо бол орлогч дарга нар хурал удирдана гэж зайлшгүй байх ёстой. Ийм утгаараа бид бол дөрвийн дөрвөн орлогч тавьсан шүү дээ. Энэ бол ямар нэгэн нөхцөлд байж байх ийм заалт гэж би узаж байна. Тэгээд байхгүй нөхцөлд бол орлогч дарга нарт даалгах биш, энэ дарга нар бол даргын үүргийг гүйцэтгэх ёстой гэсэн ийм агуулгаар суулгаж өгмөөр байна.

Б.Сумьяа /340 дүгээр тойргийн депутат/ -Тэгэхээр миний ойлгох байгаагаар бол ер нь Ардын Их Хурлын даргын орлогч, дэд дарга гэдэг бол хоёр өөр ухагдахуун гэж би бодож байна. Хоёр өөр, орлогч, дэд дарга гэдэг бол. Тэгэхээр бид нэгэнт Их Хурлын даргын орлогч дарга гэж ярьж байгаа болбол тэр байхгүй уед л орлоно гэсэн уг. Дэд дарга гэвэл яахав ээлжлээд удирдаж болох юм. Тэгэхээр энэн дээр би энэнийхээ ялгааг гаргаж шийдвэх хэрэгтэй юм байна гэж бодож байна, нэгдүгээрт. Магадгүй ээлжлээд удирдана гэж бодвол орлогч биш, дэд дарга байх ёстой. Хэрэв орлогч гэдгээр нь тогтох юм бол ямар нэгэн шалтгаанаар Их Хурлын дарга өөрөө ажиллах бололцоогүй болсон тохиолдолд тэрийг орлож ажиллах ёстой юм шиг надад санагдаж байна л даа, нэгдүгээр асуудал.

Хоёрдугаар асуудал, хэрэв орлогч байна гэж бодвол ямар нэгэн шалтгаанаар Их Хурлын дарга эзгүй байхад хувэл дөрвөн орлогчийнхoo хэнээр удирдуулах вэ гэдгийг тэр Их Хурлын дарга өөрөө шийдвэж, депутатуудад мэдэгдэх ёстой гэж бодож байна. Тэгээгүй бол дөрвөн орлогч хэдүүлээ ярьж байгаад, би удирдъя, би удирдъя гэх үү? яахав. Тэгэхээр тэрийг Их Хурлын дарга шийдвэх юм уу, эсвэл хэнээр нь удирдуулах вэ гэдгийг энэ депутатууд өөрсдөө шийдвэх юм уу гэдгийг энд ярьж байгаад аль оновчтойгоор нь тогтоовол ямар вэ? гэсэн ийм хоёр санал байн

Д.Рэнцэннацаг /429 дүгээр тойргийн депутат/ -Ардын Их Хурлын дарга, орлогч дарга нар Их Хурлыг бэлтгэж

7.

явуулна гэж дэгд заасан байна. Энэ Их Хурлыг бэлтгэж явуулна гэдэг бол аль аль талаасаа нэлээн том, өргөн хүрээтэй, том асуудал байх л даа. Тийм учраас ерөөсөө нэг дарга ч юм уу, хоёр орлогч ч бай, шинэ дэгээр бол хоёрхон орлогчтой, энэ гуравхан хүн бэлтгэж явуулна гэдэг бол амаргүй асуудал байх л даа. Ийм учраас энэ хурлыг бэлтгэж явуулах ажил дээр хяналт тавина гэсэн ийм санаа оруулаад Ардын Их Хурлын аппарат бүхэлдээ энийг бэлтгэвэл ясан юм бэ гэсэн ийм бодол байгаа юм.

Хоёрдугаарт нь, энэ Их Хурлын хуралдааныг Ардын Их Хурлын дарга, орлогч нар удирдана гэж оруулмаар байгаа юм. Дарга орлогч нар удирдана гэсэн. Тэгэхээр энэ чинь бүгдээрээ дарга ч удирдана, орлогч нь ч удирдана. Сая Сумъяа депутат ярьж байх шиг байна. Депутат нар заавал тэруүгээр нь удирдуулна гэсэн тийм санал бол байж таarahгүй байх. Тийм учраас ерөөсөө дарга, орлогч нар удирдана гэж оруулах нь зүйтэй. Ийм санал байна.

Соронзон хальстай тулгаж  
нийлсэн

*Алтанцэц*

Д.АЛТАНЦЭЦЭГ

Бичээч Т.Уранчимэг

Кассет-26  
1991.II.II. 16<sup>30</sup>-16<sup>45</sup>

55 дугаар тойргийн депутат Н.Альясурэн:

Ардын Их Хурлын Хуралдааныг дарга удирдана. Ардын Их Хурлын даргын эзгүйд нь орлогч дарга нар хуралдааныг ээлжлэн удирдах байх. Үүнийг Ардын Их Хурлын дарга өөрөө тогтоож өгөх байна. Харин энэ зөвхөн Их цаазыг өөрөөр хэлбэл Үндсэн хуулийг хэлэлцэх үед Ардын Их Хурлын даргын зөвшөөрөлтэйгээр Ерөнхийлөгч, Улсын Бага Хурлын дарга нар Үндсэн хуулийг хэлэлцүүлж болно гэсэн зүйлийг энэ дээр нэмж оруулмаар байна. Яагаад гэхээр Ерөнхийлөгч бол Үндсэн хууль боловсруулах комиссын дарга байсан, Дэд ерөнхийлөгч бол үүнийг хоёр удаа Улсын Бага Хурлаар хэлэлцүүлсэн юм.

Ийм учраас үүнийг би хурлыг удирдана гэж яриагий байна шуу, Ардын Их Хурлын даргын зөвшөөрөлтэйгээр хэлэлцүүлж болно гэсэн ийм л зүйл оруулж гэж байна.

Энэ дээр санал хурааж өгнө үү гэсэн ийм хүсэлттэй байна.

285 дугаар тойргийн депутат С.Батсүх:

Ардын Их Хурлын хуралдааныг дарга удирдаж явуулах нь зүйтэй юм. Даргыг эзгүйд орлогч наарт даалгаж болно, үүнийг зөвшөөрч байна. Үндсэн хуулийг хэлэлцүүлэхэд дарга удирдана, дарга хэлэлцүүлнэ. Үндсэн хуулийн комисс, Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч түүнийг оруулж хэлэлцүүлнэ. Ер нь яг одоо Үндсэн хуулийнхаа асуудлыг хэлэлцүүлэхдээ яг гартаа барьж байх хүн бол Их Хурлын дарга байх ёстой.

Ж.Уртнасан: Санал үндсэндээ жигдэрлээ гэж бодож байна. Хоёр зүйл дээр санал хураалт явуулах болох нь. Нэгдүгээрт, энэ эрх, үүрэг гэдэг дээр "эрх" гэдэг үгийг нэмье гэдгийг редакцийн хэмжээнд шийдэж болох асуудал байх.

Зарчмын юм бол "Хурлыг дарга удирдана" хоёрдахь хувилбар бол "ээлжлэн удирдана" гэдэг ийм хоёр санал гарч байна. Эхнийхээр санал хураалт явуулж.

Их Хурлыг Их Хурлын дарга удирдана гэдгээр санал хураалт явуулъя. Санал хураахад бэлтгээрэй.

Нийт депутатын 378 + депутат буюу 92 хувь нь Их Хурлыг Их Хурлын дарга удирдана гэдэг дээр санал өгч байна. Энэ асуудал шийдэгдлээ.

Хоёрдугаар санал байна. Ардын Их Хурлын хуралдаанаар Үндсэн хуулийг хэлэлцэж байхад Үндсэн хуулийг Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч хэлэлцүүлж болно гэж. Ардын Их Хурлын даргын зөвшөөрлөөр. Энэ бол ер нь зарчмын хувьд байж байгаа санал гэж бодож байна. Энэ бол хэлэлцүүлж байгаа улсууд, та бидэнд бас асуултанд хариулах, энэ хэлэлцүүлэгт оролцох ийм нээлттэй үлдэх ёстой байхаа. Үүгээр санал хураалт явуулах шаардлага байна уу? За баярлалаа, шаардлага явуулах шаардлагагүй гэж үзэж байна.

**427 дугаар тойргийн** -Даргаа яагаад санал хураадаггүй, юм бэ? **депутат П.ЭЛБЭГДОРЖ:** Тодорхой санал тавьсан шүү дээ. Санал тавьсан бол тодорхой санал дээр санал хураах ёстой шүү дээ. Тэтгээд дараагийн нэг санал бол хажуугийн саналыг эхэлж хураалгах ёстой. Энэ дэгэн дээр байгаа саналыг эхэлж хураалгаж байна. Хажуугийн саналыг эхэлж хураалгадгийн гол учир нь тэр тухайн хүн санал гаргаж байгаагийн утга нь эндээ байгаа шүү дээ.

Хажуугийн санал олонхийн санал авахгүй бол дэг дээр байгаа санал тэр чигээрээ үлддэг. Эхлээд хажуугийн саналыг л хураах ёстой. Би тодорхой санал тавьсан.

**Ж.Уртиасан:** Ээлжлэн удирдана гэдэг асуудлаар уу?

**П.Элбэгдорж:** Ээлжлэн удирдах, Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч Үндсэн хуулийн хэлэлцүүлгийг хэлэлцүүлэхийг сая санал хураалгүй явчихлаа шүү дээ. Санал хурааж өгөөч гэсэн. Энэ Үндсэн хуулийг хариуцаж гарах ёстой хүн байх ёстой л доо. Боловсруулах төслийг, энэ ажлыг зохион байгуулсан, энэ ажлыг удирдаж байсан Ерөнхийлөгч, хариуцах эзэн байх ёстой. Энэ 430 депутат баталчихаа яваад өгнө. Үүнийг хариуцаж, нэг хүн хэлэлцүүлж батлуулах ёстой.

3.

Энэ үүднээс би асуудлыг тавьж байгаа юм.

315 дугаар тойргийн депутат Ч.Бат-Эрдэнэ:

Тэгэхээр бид нарын энэ хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөнд Үндсэн хуулийг Их Хуралд ямархүн оруулж хэлэлцүүлэх вэ? Бага Хурлын тайланг хэн оруулах вэ? Засгийн газрын тайланг хэн оруулах вэ гэдэг нь нэрээрээ тодорхой байгаа.

Тэгэхээр Элбэгдоржийн энд хэлж байгаа саналыг өрөөсөө хүлээж авах ямар ч үндэс байхгүй. Их Хурлын дээр энэ 3 хүнээ гаргаж тавих гээд байна шуу дээ. Ерөнхийлөгчийг Их Хурлын дээр гаргаж тавих гээд байна. Бага Хурлын даргыг Их Хурлын дээр гаргаж тавих гээд байна. Тийм учраас өрөөсөө тэр хэлэлцүүлнэ гэдэг үгийг оруулах ч хэрэг байхгүй. Тэртэй, тэргүй энэ улсууд бол Их Хуралд энэ боловсруулсан асуудлаа оруулж хэлэлцүүлнэ, бид хэлэлцэнэ, батална. Тийм учраас энэ 7 дугаар зүйлээ батлах, батлахгүй дээрээ санал хураамаар байна.

Ж.Уртнасан: Зарчмын хувьд эрхэм депутат Элбэгдоржийн тавьж байгаа санал зөв л дөө. Бид депутатуудын саналыг зайлшигүй авч үзэж санал хураалт явуулж байх учиртай гэж би ойлгож байна. Гэхдээ нийт депутатууд хэрэв зөвшөөрвөл энэ 7 дугаар зүйлээр санал хураалт явуулах хэмжээнд хүргэсэн юм болов уу гэж би ойлгож байнаа.

Яагаад вэ гэхээр бидний бичээд баталсан энэ журман дээр үнэхээр хэлэлцүүлэх хүний нэр, хаяг байж байгаа. Ийм учраас бид заавал дэг дотор оруулж, дахин батлах шаардлагагүй болов уу? гэж бодож байна.

Ц.Адьяасүрэн: -Уучлаарай, Уртнасан даргаа. Ийм ойлголтоор бид санал гаргасан л даа. Нэг депутат санал гаргахдаа хурлыг ээлжилж даргална гэдэг тухай гаргасан шуу дээ. Ерөнхийлөгч, Бага Хурлын дарга. Тэгэхээр миний хувьд бол нэгдсэн санал бол даргалах тухай бол зөвшөөрмөөргүй байна гэдгээ ярьсан.

Хуралд асуудал оруулах тухай бол заавал энд тусгах тухай ярих шаардлагагүй гэж бодож байна.

Ж.Уртнасан: Учлаарай, бид түүгээр санал хураалт явуулаад Их Хурлыг Ардын Их Хурлын дарга удирдана гэдгээр санал хураалт явуулаад олонхийн саналаар шийдсэн гэж би ойлгож байгаа.

Хоёрдахь санал хураалтын юм бол бид харин Дэд ерөнхийлөгч, Ерөнхийлөгч энэ асуудлыг оруулна, хэлэлцүүлнэ гэдгээр энэ дээр оруулах уу? Үгүй юу гээд санал хураалт явуулаад энэ санал хураалт явуулах шаардлагагүй гээд шийдчихлээ шуу дээ.

Хоёрдугаарт булэгт бол.

Т04 дүгээр тойргийн депутат Л.Жагварал:

Энэ Ардын Их Хурлын дарга, орлогч дарга нарыг баталсан тухай тогтоолоо албан ёсоор батлуулж өгөөч ээ гэж би дахин дахин гүймаар байна. Ингэж явсаар байгаад суулдээ асуудал болох вий?

Ж.Уртнасан: Эрхэм депутат Жагваралын саналын талаар санал хураалт явуулах уу?

Та бүгдийн анхаарлыг БНМАУ-ын Ардын Их Хурлын тогтоолд төвлөрүүлье.

БНМАУ-ын Ардын Их Хурлын тогтоол  
1991. II. II № 06

Улаанбаатар хот

БНМАУ-ын Ардын Их Хурлын даргыг сонгох тухай

БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулийн дөрөвдүгээр зүйлийг үндэслэн БНМАУ-ын Ардын Их Хурлаас ТОГТООНЬ:

БНМАУ-ын Ардын Их Хурлын даргаар З18 дугаар тойргийн депутат Жамбалдоржийн Уртнасанг сонгосугай.

Дарга Гомбожав гэсэн ийм тогтоол байна.

5.

Хоёрдугаар тогтоол

БНМАУ-ын Ардын Их Хурлын тогтоол

1991.II.II

№ 07

БНМАУ-ын Ардын Их Хурлын орлогч  
дарга нарыг сонгох тухай

БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулийн дөрөв-  
дүгээр зүйлийг Үндэслэн БНМАУ-ын Ардын Их Хурлаас ТОГТООХ нь:

БНМАУ-ын Ардын Их Хурлын орлогч даргаар 43 дугаар тойргийн  
депутат Нямжавын Батбаяр, 194 дүгээр тойргийн депутат Төмөрийн  
Жагай, 144 дүгээр тойргийн депутат Цог-Очирын Доохууз, 278  
дугаар тойргийн депутат Доржийн Моондой нарыг тус тус сонго-  
сугай.

Хурлын дарга Гомбожав гэсэн ийм тогтоолууд байна.

Та бүгдийг санал хураалтанд бэлтгэхийг урж байна.  
Ардын Их Хурлын 6 дугаар тогтоолын санал хураалт явуулъя, үүнийг  
батлах талаар. Санал хураалтанд бэлтгэнэ үү?

Ардын Их Хурлын 6 дугаар тогтоолыг 399 депутат буюу 98 хувь  
нь зөвшөөрч байна.

Хоёрдугаар тогтоол буюу 7 дугаар тогтоолоор санал хураалт  
явуулахад бэлтгээ. Бүх депутатын 94 хувь нь буюу 380 депутат  
7 дугаар тогтоолыг зөвшөөрлөө.

Одоо дэгээ хэлэлцэх асуудлыг ургэлжлүүлье. Дэгийн 7 дугаар  
зүйлийг саяны нэмэлт засвар хийгээд зарчмын хувьд баталъя  
гэсэн депутатууд санал хураалтанд бэлтгэнэ үү.

Дэгийн 7 дугаар зүйлийг депутатуудын 96 хувь нь буюу 395  
депутат зөвшөөрлөө. Татгалзсан 7 хүн буюу 02 хувь, түдгэлзсэн  
8 хүн буюу 02 хувь байна.

8 дугаар зүйлийг хэлэлцье. Ардын Их Хурлын хуралдааны ажлын ...

427 дугаар тойргийн депутат П.Элбэгдорж: Их Хурлын даргаа 7 дээр цөөнх болж уг хэлье.

Сая хурал удирдана гэж Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчийг хурал удирдана гэж санал тавьсан гэж зарим хүмүүс ойлгох шиг боллоо л доо. Тэр хүмүүс уучилна биз. Их цаазыг хэлэлцүүлэг явууллахад энэ тайлбар өгөх, яг Их цаазаа бариад хэлэлцүүлнэ гэсэн утгаар хэлсэн юм. Түүнээс дарга хурлаа даргална, удирдана гэдэг энэ утга нь байж байгаа юм шүү гэдгийг дахин хэлэх гэсэн юм.

Тэгээд та хажуугийн саналыг хураалгана гэж зөвшөөрсөн мөртөө нэг л хураалгасангуй тэгээд бутнээр нь батлуулаад цааш нь шуугиулчихлаа л даа.

Хажууд нь гарч байгаа саналуудыг санал хураалгаж л үзэх гээд байгаа юм л даа. Санал хураалгая гэж тодорхой санал тавьж байна л даа. Уүнийг хураалгаж өгөөд явж байвал ямар вэ?

45 дугаар тойргийн депутат М.Энхсайхан:

Их Хурлын даргаа, өнөөдөр бид нар ажлаа эхлээд явж байна. Таанд ажиллахад хүнд байгаа гэдгийг ойлгож байна. Бид танд туслах ёстой. Бид ч гэсэн энэ ажил хэрэгч уур амьстгалыг бурдуулэх ёстой гэж бодож байна. Тийм учраас бас нэг зарим санал хэлэхгүй бол болохгүй юм болов уу гэж бодож байна.

Асуудлыг ингээд 8 дугаар зүйлийг хэлэлцүүлэхдээ та эхлээд санал ямар санал байна вэ гээд дараа нь саналаа тасалдаг байхгүй бол ярианы явц дундаас чинь санал орж ирээд ажил эвд-рээд байнаа гэдэг асуудал байна, уүнийг анхаarahгүй юу?

Хоёрдугаарт, бидний зүгээс асуудлыг дэвшүүлж тавихлаа заавал Их Хурлын даргаасаа зөвшөөрөл авч байж ярж байхгүй бол

хэн микрофон дээр түрүүлж очсон нь дуугараад байх юм бол ажил замбараагүй болно, үүнийг анхааралдаа авахгүй юу гэж бодож байна.


Өөр нэг асуудал юу вэ гэхээр депутатуудын тавьж байгаа санал болгоныг өөр дээрээ бүртгэж авч байхгүй бол болохгүй байна. Таныг харахад тэмдэглэл хөтлөхгүй байна. Тэгээд депутатуудын хажуугийн саналыг эхэлж санал хураалгаж байх явдлыг өмнөө болгож авахгүй юу гэсэн асуудлыг тавьж байна.

Өөр нэг асуудал юу вэ гэхээр энэ гэрэлтээд ассан саналыг уншаад байх хэрэггүй баймаар байна, танд. Цаг алдаад байна. Тийм учраас иймэрхүү асуудал дээр анхаараад, жаахан гартаа аваад чангахан явмаар байна гэсэн юм хэлмээр байна.

Ж.Уртнасан: Баярлалаа, зарчмын саналыг хулээж авлаа. Та бүгдийг бас энэ саналыг хулээж авч байгаа гэж ойлгож байна.

Депутат, Бага Хурлын гишүүн Энхсайханыг саналыг бид баяртайгаар хулээж авч байна. Үнэхээр саналыг тасалж байя, явц дундуур, санал хураалтын дундуур санал гараад байна. Энэ билгийн ажлыг удаашруулна, цаг алдана. Энэ зөв зүйтэй юм. Бид энд тэмдэглэл хөтөлж байна, баярлалаа.

Соронзон бичлэгтэй тулгаж  
НИЙЛСЭН



Д.ЧУЛУУНЦЭГ

БИРЭЭЧ Д.ЦЭНДСҮРЭН

1991.XI.II.  
Кассет № 27.  
I6.45-I6.55

Д.Батбаяр/ Ардын Их Хурлын 309-р тойргийн депутат:

-Аппаратыг Ерөнхий нарийн бичгийн дарга удирдана гэж байна. Үүн дээр нэг ийм үүрэг нэмэх хэрэгтэй гэж үзэж байна. Санал авах ажил өглөө тооллогоор явагдсан. Одоо аппарат, хэрэгс-лэлээр явагдаж байна. Тийм учраас аппаратын Ерөнхий нарийн бичгийн дарга санал авах техник хэрэгсэл болон тооллогын ба-талгааг хариуцна гэж үүрэг болгож оруулах хэрэгтэй байна.

С.Билэгсайхан/Ардын Их Хурлын 184-р тойргийн депутат:

-Ерөнхий нарийн бичгийн дарга гэдэг дээр миний санал байна. Аль нэг орлогч дарга нь Ерөнхий нарийн бичгийн дарга нь байг. Хэрэв тэгэхгүй бол депутат бус хүн энэ үүргийг гүйцэтгэх нь гэсэн ойлголт надад төрөөд байна.

Ч.Хурц/Ардын Их Хурлын 287-р тойргийн депутат/:

-Би өглөөний дэгийн редакцийн комисс томилсон, 8-р зүйл хоёр харшилдаж байгаа байдлыг би ажиглаж байна. Тийм учраас Дэгийн редакцийн зөвлөлийг Баяр даргатай томилсон нь бид Хурал явуулах процедурын алдаа хийсэн байна гэж үзэж байна. Яагаад гэвэл энэ хурлын бүхий л зүйл ажиллагаа, бичиг хэрэг хэргийг хөтлөх Ерөнхий нарийн бичгийн даргаа өндөөр томи-лоод, 8-р зүйлийн дагуу, нөхөр Баяр тэргүүтэй редакцийн зөвлөлийг депутатын бүрэн эрхийн дагуу ажлаа хийгээд, хуралдаа суух боломжийг олгох нь зүйтэй болов уу. Тийм учраас одоо нарийн бичгийн даргаа хурлын дарга сонгочихвол бусад зүйл нь болж байна.

Ж.Гомбожав:

-Ерөнхий нарийн бичгийн дарга гэдэг нь түрүүчийн Ардын Их Хурлын дарга, орлогчдыг ажиллаж байх үед томилогдоод, ажилдаа орчихсон. Би уржигдар эрхэм депутатуудад танилцуулсан.

## 2.

Засгийн газрын хэрэг өрхлэх газрын дарга н. Моломжамц удирдах байгаа. Энэ хүн нь миний уржигдар уншсан бух аппаратын зүйлүүдийг зохицуулах учраас Их Хурлын орлогч дарга удирдахад бэршээлтэй. Бичгийн машин, бичиг хэрэг, аж ахуйн бух асуудлуудыг зохицуулах үүрэгтэй юм. Үүнээс гадна хөдөлмөрчдөөс ирж байгаа захидал, мэдээлэлийг боловсруулах энэ бух ажлыг хариуцсан хүн юм. Тийм учраас орлогч дарга дээр байх нь зохиж муутай гэдгийг болгоно уу.

Депутатуудын гаргасан саналын дагуу ийм засвар хийх ёстой юм шиг байна. Аппаратыг аппаратын гэдгий нь хоёрдахь аппаратын гэдгийг дараад аппаратыг түр томилогдсон ерөнхий нарийн бичгийн дарга удирдана гэсэн түр томилогдсон гэсэн угийг оруулах нь зүйтэй болов уу гэж бид засвар хийж байсан юм.

Аппаратыг түр томилогдсон Ерөнхий нарийн бичгийн дарга удирдана гэж.

Ж.Уртнасан -Баярлалаа, тэхээр депутат нөхдийн сонорт нэг зүйлийг тайлбарлаж ойлгуулья гэж бодож байна. Бидний өнөөдөр томилсон Баяр ахлагч тай депутатын групп нь манай дэгийг ариутган шүүж, редакц хийж та бидэнд бүрэн бүтэн болгож өгөх үүрэг зорилготой комисс ажиллаж байгаа юм.

Харин Аппаратын Ерөнхий нарийн бичгийн дарга гэдэг нь БНМАУ-ын Бага Хурлын даргын 1991 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн захирамжаар батлагдсан аппарат ажиллаж байгаа юм байна. Гомбожав дарга сая бүрэн тодорхойлж хэллээ. Энэ нь зөвхөн энэ хуралдааны биш, бусад бух асуудлыг зохицуулах дотоод ажил, унаа, тээвэр, хоол хүнс энэ бух асуудлыг хариуцаж байгаа юм байна. Комиссын нарийн бичгийн дарга нь Моломжамц гуай юм байна.

Дэг дээр Аппаратыг Ерөнхий нарийн бичгийн дарга удирдана. Түүнийг Ардын Их Хурлын дарга томилоно гэсэн зүйл

## 3.

байна. Хэрэв та бүхэн зөвшөөрөл би Бага Хурлын даргын захирамжийг бүрнээр сайшаан хүлээн авч, Моломжамсыг Ерөнхий нарийн бичгийн даргаар тохоон томилон, үүрэгт ажлаа цааш нь ургэлжлүүлэн гүйцэтгэх эрх олгож байна.

Б.Гунджалам /Ардын Их Хурлын 183-р тойргийн депутат/:

-Би танд үдээс өмнө бичиг явуулсан. Энд ажиллах нөхцөл хүнд байна. Хоёр метр газраас хүчтэй гэрэл, энэ нь ажлын аппараттай холбогдох асуудал л даа. Маш хүчтэй про-жектор шарж байна. Үдээс өмнө миний толгой өвдсөн учраас үдээс хойш би хаалттай ирээд сууж байгаа учраас нэг гараа-раа юм бичээд ажиллаж болохгүй байна. Зориуд үүнийг унтраах-гүй байна. Ажлын аппарат ажиллах нөхцөлийг олгох хэрэгтэй байна. 21 хоногт хүчтэй гэрэлд шаруулаад байвал хүний эрүүл мэнд юу болох вэ, үүнийг анхаарч үзнэ биз ээ.

Ж.Уртнасан -Депутат Гунджаламын хүсэлтийг ёсоор нь биелүүлэх шиг боллоо. Тэр их шарж байгаа чийдэнг ун-раалаа.

Цааш нь ажлаа ургэлжлүүлье. 8-р эйлээ санал хураагаад батлая. Үүн дээр зарчмын өөр нэмэлт санал байна уу депутатууд аа!

Алга бол саналаа тасаллаа гэж ойлгож байна. 8-р зүйл дээр өөр санал алга байна. Батлая гэсэн саналтай байна. Санал хураалт явуулахад депутатууд бэлтгэнэ уу.

8-р зүйлийг депутатуудын 97 хувь буюу 399 депутат зөвшөөрч байна. Хоёр хувь буюу 8 хүн татгалзлаа. 1 хувь буюу 3 хүн түдгэлзэж байна.

Эрхэм депутатуудын сонорт нэг зүйлийг хэлэхэд экран дээр гарч байгаа татгалзсан, түдгэлзсэн, зөвшөөрснийг уншиж

## 4.

байхгүй бол энэ бичлэгт орохгүй байгаа юм. Тийм учраас намайг битгий нуршлаа гэж бодоорой. Үүнийг би бүрэн эхээр нь та бүхэнд уншиж байх үүрэгтэй боллоо.

9-р зүйлээ хэлэлцье. Үүн дээр санал байна уу? Санал байхгүй бол саналаа таслая. Энэ зүйлийн талаар санал хураалт явуулах бэлтгэнэ уу.

Нийт депутатын 96 хувь буюу 393 хүн зөвшөөрч байна. З хувь буюу 12 хүн татгалзлаа. 1 хувь буюу 3 хүн түдгэлзэж байна. Ингээд 8-р зүйлээ баталлаа.

Хурлын дотоод журмын дагуу завсарлага 20 минут.

Соронзон хальстай  
тулгаж ийлсэн

*Л.Баярмаа*

/Л.БАЯРМАА/

Бичээч

С.туул

Кассет 28  
1991-XI-II  
17.20-17.35

Х.Уртнасан:-Хуралдаанаа үргэлжлүүлье. Бид хуралдаанаа эхлэхээс өмнө компьютерт ирцээ шалгаж баймаар юм шиг байна. Манай зарим депутатуудын суудал их онгорхой харагдаж байна. Тэгэхээр хуралдаан эхлэхэд бид ирцээ нэг шалгая. За ирц авах гэж байна. Бэлтгээрэй. Ирвэл зохих 427 депутатас 358 депутат байна. Ирц 84 хувь байна. Хуралдаанаа үргэлжлүүлье. За одоо бид дэгийнхээ 10 дугаар зүйлийг хэлэлцье. Ардын Их Хурлын хуралдааны нийтлэг журам. 10 дугаар зүйлтэй холбогдуулж депутатуудын саналыг сонсоё.

Ардын Их Хурлын 368 дугаар тойргийн депутат Н.Баасанжав: Энэ 10 дугаар зүйлц ийм саналууд байна. Арын хоёрдугаар заалтын "а" хэсэг байгаа. Энд бол депутатын тойргийн дугаар, овог, нэрээ хэлж хуралдаанд даргалагчаас уг хэлэх зөвшөөрөл авна гэж байна. Энэ овог гэдгийг нь хасчихвал ясан юм бэ? Энэ бол ерөөсөө биелэгдэхгүй, цаг ч их идэх юм, түрүүчийн хэлсэн бүх хүмүүс бол овог хэлэхгүй болоод байгаа, аяндаа редакцаас овгийг нь оруулчих нь биз. Хоёрдугаарх нь энэ "б" заалт байгаа, депутатууд хэлэлцэх, шийдвэрлэх асуудал бүрээр өхний удаа долоо, хоёр дахь удаа тав, гуравдахь удаа гурав гэсэн ингээд гурван удаа уг хэлнэ гэж байгаа. Энд одоо ийм санал байна. Зарим нэг асуудлаар нэг депутат хоёр гурван удаа босч байна. Энэ бол цаг их үрж байна. Хоёрдугаарт нь зарим улсад саад бэрхшээл их гаргаж байгаа тал байна. Тийм учраас энд ямар санал оруулах гэж байна гэхлээр нэг асуудал дээр нэг депутат нэг удаа л уг хэлэх юм уу, санал гаргах гэсэн зүйл оруулбал ясан юм бэ? Энэ бол эрхийг хязгаарлаж байгаа зүйл биш, энэ бол ямар нэгэн байдлаар, хуралдаан аль нэгэн байдлаар тодорхой болгож, түүнийг бол арай цаг хэмнэх үндсэн дээр ийм санал оруулбал ясан юм гэсэн зүйл байна. Энэ "е"-д байгаа депутатуудын ердийн олонхийн саналаар хэлэлцэх асуудлын шинж байдлыг харгалзан саналуудыг депутатуудын нэросийн хавсралтаар авч болно гэж. Шинж байдал гэдгийн оронд онцгой байдлыг харгалзан саналыг гэдэг зүйлийг оруулбал ясан

## 2.

юм бэ гэсэн санал байна. Энэ дугаарын энэ хэсэгт байгаа Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч хэдийд ч уг хэлж болно гэсэн. Тэртээ тэргүй Дэд Ерөнхийлөгч бол хэдийд ч уг хэлж болно. Өөрөө цепутат. Ийм учраас энэ заалтыг хасчихвал ясан юм бэ? Ийм зүйл оруултия гэж бодож байна. Өөр нэг зүйл бол бидний урьдчилан тараасан программ, хөтөлбөрт бүтэн сайн өдөр, I7-ныг тэнд бол ажиллахгүйгээр ийм орсон байгаа, тэгвэл энэ дэгдээ оруулж өгч байж I7-нд баталгаатай амрах уу яах вэ гэдгийг тогтоож өгөхгүй бол тэр зүйл будэг байгаа ийм саналыг оруулж байна.

Ардын Их Хурлын I69 дүгээр тойргийн депутат Б.Шагдар: -Тэгэхлээр энэ I0 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт түруучийн бидний бас нэг хөндөөд орхисон хурлаас завсарлагаа авах тухай асуудал байна. Энэ завсарлагааавах эсэхийг доорхи байдлаар найруулбал ясан юм бэ гэсэн ийм санал байна. Тодорхой асуудал хэлэлцэх явцад шаардлагатай бол депутатын бүлгийн хүсэлтээр хуралдаанд оролцож байгаа депутатуудын ердийн олонхийн саналаар хуралдааныг нэг цаг хүртэл хугацаагаар түр завсарлаж болно гэж хязгаар тогтоож өгвөл ясан юм бэ? Тэгэхгүй бол ямар нэг депутатын бүлэг, ямар нэгэн асуудал дээр завсарлагаа авах шаардлагатай байна гээд завсарлагаа аваад бид хэлэлцэж болоогүй байна, дуусаагүй байна гэсэн шалтгаанаар удаан хугацаа барьж, хуралдааныг сунжуулж болох юм уу гэсэн ийм тал харагдаж байх шиг байх юм.

Ж.Уртнасан: -Нэг цаг хүртэл хугацаагаар гэж үү?

Б.Шагдар: -Тийм. Би тийм санал оруулж байна. Энэ мийн хувийн санал.

Ардын Их Хурлын 55 дугаар тойргийн депутат Ц.Альясурэн: -Бид нар уржигдар та бүгдийн саналыг харгалзаад энэ дээр зарим нэгэн засвар хийсэн юм л даа. Тэрийгээ энэ дээр хэлчихье гэж бодож байна. Тэр нэгдүгээр хэсгийн хоёрдугаар өгүүлбэрийн дараа 20 минутын завсарлагатай явуулна гэж байна шуу дээ.

## 3.

Энэний дараа шаардлагатай үед оройн хуралдааны хугацааг сунган хийж болно. Ням гаригт амарна гэсэн ийм юу оруулъя гэсэн санал байгаа юм. Сая тэр хоёрын "г"-д тэр депутатууд хэлэлцэх асуудал бүрээр эхний удаа долоо, хоёр дахь удаа тав, гурав дахь удаа гурван минут гэдгийг байхгүй бол болохгүй. Тэр чинь депутат хүн, ялангуяа Үндсэн хууль хэлэлцэх гэж байгаатай холбогдуулж хоёр гурван удаа босч хэлэх шаардлага гарна шүү дээ. Тийм учраас ганц удаа босохоор хязгаарлаачихвал энэ чинь юу ч болохгүй шүү дээ. Түрүүн бид нар хэлсэн байгаа. Тэр цөөнх нь саналаа хэлнэ гэж байгаа. Гэтэл тэр чинь түрүүн уг хэлсэн хүн дараа нь цөөнх болчихоод юмаа тайлбарлах болбол хоёр дахь удаагаа хэлэх эрхгүй болчихсон юм чинь түрүүнийхээ дэгийн түрүүн орсон зүйлийг зөрчих болчихоод байна шүү дээ. Ийм учраас энэ "г"-г нь хэвээр нь үлдээе гэсэн саналтай байна.

Харин "м" дээр Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч гэдгийн Дэд Ерөнхийлөгч гэдгийг больё гэсэн ийм саналтай байгаа юм. Тэр гуравдугаар зүйлийн дараа бол депутат нь хуралдааны даргын зөвшөөрөлгүйгээр гаражыг хориглоно гэсэн ийм юм нэмж оруулъя гэсэн саналтай байгаа юм.

Ардын Их Хурлын 23I дүгээр тойргийн депутат Г.Амарбаян: Энэ түрүүчийн депутатуудын хэлсэнтэй санал нэг байна. 10 дугаар зүйлийн нэг дээр хурлын хугацааг сунгах тухай асуудал байна. Сая Адъяасурэн депутат хурлын хугацааг зүгээр сунгая гэсэн ийм юу байгаа, энэнд бас тодорхой цаг хэрэгтэй байна. Хурлын хугацааг оройн хуралдаан нэг цагаас илүүгүй хугацаагаар сунгая гэсэн ийм заалт оруулъя гэсэн ийм санал оруулж байна. Завсарлагаа гэж байна. Хуралдааныг тур завсарлаж болох ийм эрхийг 30 минутаас илүү хэтрүүлэхгүй байя гэсэн ийм санал оруулъя гэж бодож байна. Мөн энэ өгүүлбэрийн дараагаар бид нар дэгэндээ ням гаригт амраана гэсэн заалтыг энд оруулъя гэсэн ийм саналтай байна. Тэр бусад депутатуудын саналтай нэг байна. Тэр Ерөнхийлөгчийг бол хэдийд ч уг хэлэх болно гэсэн энэ асуудлыг зөвшөөрч, Дэд Ерөнхийлөгч нэгэнт их хурлын

## 4.

депутат байгаа учраас энэ бусад депутатуудынхаа нэгэн адил эрхээр уг хэлж байх нь зүйтэй байна аа гэсэн ийм зүйлийг энд оруулъя гэж бодож байна.

Ардын Их Хурлын 427 дугаар тойргийн депутат Ц.Элбэгдорж: 10 дугаар зүйлийн "д". Депутат нь уг хэлэхдээ бусыг доромжлох буюу гүтгэх, өөрийн саналыг тулгахаар хүч хэрэглэхийг, бусад уриалахыг хориглоно гэж. Энэ хүч хэрэглэх гэдгийг ойлгохгүй юм. Яана гэсэн уг вэ? Тэгэхээр энэнийг, энэ "д"-гээ хасчихвал ясан юм бэ гэсэн ийм санал оруулж байна. Дараач нь "е" дээр депутатуудын ердийн олонхийн саналаар гээд эхэлж байгаа, депутатуудын ердийн олонхийн саналаар гэсэн энэ дөрвөн угийг хасъя. Хэлэлцэх асуудлын шинж байдлыг харгалзаж саналыг депутатуудын нэрийн жагсаалтаар авч болно гээд ингээд бичье. Хэрвээ заавал ямар нэгэн хязгаар тогтооё гэх юм бол 30 хүртэл хүний санал авсан тийм асуудлаар ч гэдэг юм уу хийхгүй бол энэ нэрийн жагсаалтаар авахад ердийн олонхиор авах ийм боломж их бага гарч ирэх байх аа гэж ингэж бодож байна. "ж" дүгээр зүйлийг бүрэн хасъя гэж бодож байна. Яагаад гэхлээр ердийн олонхиор санал тасална гэж байгаа. Тэртээ тэргүй ямар нэгэн байдлаар санал хурааж л энэ санал таслагдана. Түүнээс биш зүгээр л явж байгаад санал хураахгүйгээр ямар нэгэн асуудал шийдвэгдэхгүй, ийм учраас энэ өөрөө хийгдээд явчих асуудал учраас энэ "ж"-г хасч болж байгаа юм.

"ж" дээр депутатууд хуралдаанд хэлэлцэх асуудлын хурээнд тусгайлан санал гаргаж, түүн дээрээ санал хураалгах буюу хэлэлцүүлэг хийлгэж болно гээд, болох гэдгийг болно гэж оруулаад, бөгөөд гэдгээс хойшхийг хасъя гэсэн саналтай байна. Тайлбар шаардлагагүй байх аа гэж бодож байна. Хурлын даргаас хүсэхэд түрүүн хажуугийн саналыг хураалгаагүй. Одоо ингээд хураалгаачээ гэсэн саналыг тавьж байна. Энэ хажуугийн гарч байгаа бүх саналуудыг.

Ардын Их Хурлын 405 дугаар тойргийн депутат Б.Лигдэн: -Тэгэхлээр энэ 10-ын нэгдүгээр заалтанд өдрийн хуралдааны цагийн

## 5.

талаар нэг санал байна. Ялангуяа Үндсэн хуульжэлэлцэх үед. Өдрийнхөө алдсан алдаа ч юм уу, гарсан санал дүгнэлтийг маргаашийн хуралдаанд бэлтгэх зорилгоор бас нухацтай бодох чөлөөт цаг хэрэгтэй гэж ойлгож байна. Тийм учраас ялангуяа Үндсэн хууль хэлэлцэх үед юм уу, ер нь ингэвэл ясан юм бэ? Нэг, гурав, тав дахь өдөр 19 цаг хуртэл хуралдъя. Хоёр, дөрөв, зургаа дахь өдөр бэлтгэг рүүдэд нь 17 цаг хуртэл хуралдъя. Ням гаригт тэртээ тэргүй унших байлгүй. Ийм саналыг оруулж, энэ хуралд бэлтгэх асуудалд нэлээн анхаарал тавимаар байна гэж бодож байна. Нам, орон нутгийн бүлэг, мэргэжлийн бүлэг, депутатуудын бүлэг санал бодлюу солицдох шаардлага гарах байх, заавал завсарлагаа авахын тулд биш, бас оройн цагаар ийм бололцоо олгох нь зүйтэй болов уу гэж ингэж бодож байна.

Хоёрдугаар заалтын хувьд тэр "д" заалт байна. Ер нь жаахан юутай юм даа. Зөвлүүлвэл зөвлүүлчихэж болох юм. Өөрийн саналыг бусад тулгахыг хориглоно гэсэн ийм замаар, тэр хүч хэрэглэх энэ тэрийг нь хасаад тийм байж болох юм.

Хоёрдугаар заалтын "л"-хэсэгт. Ардын Их Хуралд ирүүлсэн өргөдөл, лавласан зүйл, асуулт, мэдээлэл, бусад асуудлыг гэсэн маягаар ингэж хоёр зүйл нэмвэл ясан юм бэ? Мэдээлэл, бусад асуудлыг зарлан сонсгоно гэсэн. "Н" зүйл дээр Ерөнхийлөгч өөрийн хүсэлтээр буюу депутатуудын шаардлагаар хэзээ ч уг хэлж болно гэж тэмдэглээд, Дэд Ерөнхийлөгчийг хасах ийм бодол байна.

Ардын Их Хурлын II дүгээр тойргийн депутат Ж.Бямбаа:-  
Хоёрдугаар зүйлийн "б" -д энэ хурлын дарга ирүүлсэн нэрийн дарааллыг баримтлан асуудал бүр дээр уг хэлэх зөвшөөрөл олгоно гэж байна тийм ээ. Гэтэл бид бол өрөөсөө нэр тийш нь өгөхгүй, микрофон дээр очиж зогсоод тэр дарааллаараа яриад байгаа шүү дээ. Тэтгэхээр тэр чинь практик дээр байгаа бидний уг хэлж байгаа юу чинь, анхны хуралдаан ч гэсэн, энэ ч гэсэн эхлээл л микрофоны дарааллаар уг хэлнэ гэдэг юм уу юу ч гэдэг юм, энэ-

## 6.

нийг яаж найруулбал зүгээр юм, яг үйл ажиллагаа, дэг хоёр маань зөрөөд байна л даа. Дараа нь тэр "е" байна. Депутатуудын одоо ингэж байгаа шүү дээ, шинж байдлыг харгалзан саналыг депутатуудын нэрийн жагсаалтаар авч болно гэж. Тэгэхээр ингээд захаас нь хөөгөөд чи бос, тэр бос, чи ингэх уу угүй юу гээд, энэ чинь өрөөсөө сунжирсан хачин юм болох нь. Тэгэхлээр энэ бол нэгэнт бид аппарат, хэрэгсэлтэй байж байгаа учраас энэ зүйлийг хасчихвал ясан юм гэсэн ийм санал байна.

СОРОНЗОН ХАЛЬСТАЙ ТУЛГАЖ  
НИЙЛСЭН

П.ТӨМӨРБААТАР

БИЧЭЭЧ Л.ХОРЛОО

1991-XI-II.  
Кассета № 29  
17.35-17.50

Ж.Бямбаа:-За энэ Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч хэдийд ч уг хэлж болно гэж, за тэгэхээр нэгэнт Их Хурлаас сонгогдсон Ерөнхий лөгч, дэд Ерөнхийлөгч 2 бол улсын Ерөнхийлөгчийн хувьд бол хүндэтгэлтэйгээр уг хэлэх ёстой. Тэр мэдээж хэрэг. Гэвч Их Хурал хуралдаж байгаа нөхцөлд Их Хурлынхаа депутатуудын эрхтэй Ерөнхийлөгч, дэд Ерөнхийлөгч байна гэдэг чинь яг энэ юуныхаа зарчимд таарч байна уу, угуй нуу, энийг бас бодоод тэгээд нэг хүн угуй л дээ янз бурийн санал гарна, босоод тайлбарлаад л ухуулга, сэнхруулгэ, ийм янз бурийн асуудлыг нааш нь цааш нь болгон, ийм юм хийвэл яах юм ухаандаа. Энийг бид бас бодолцох ёстой шүү дээ. Тийм ээ, Тэгэхээр энийг яж оруулах нь зөв уу, эсвэл шаардлагатай үед гэдэг юм уу, эсвэл асуудал бур дээр одоо хэдэн уг хэлнэ ч гэдэг юм уу, нэг тийм юм байвал ясан юм гэдэг ийм З санал л байна.

3-р микрофон, 214 дүгээр тойргийн депутат: -Б.Доржсамбуу: Энэ 2-ын г-д З удаа нэг депутат хэлэлцэж шийдвэрлэх асуудлаар уг хэлэхээр ингэж оржээ. Бид зарим депутатууд нь хөдөө орон нутгаас ард түмнийхээ итгэл найдварыг хүлээж ирчихээд, энд бас ард түмнийхээ сэтгэл санааг энд хэлж яримаар зүйл их байх юм. Олон боссонгууд нь амжаад юм хэлчих юм. Зарим нь чадахгүй юм. Энэ депутат хүн гэдэг бол өөрийн бодолтой бас хэлэх угээ олон хуваалгүйгээр хэлчих ийм чадвартай ирсэн байх гэж итгэж байна. Ингээд I удаа хэлүүлье гэдэг ийм санал өгч байна. Нөгөө нэг асуудал Ерөнхийлөгч, дэд Ерөнхийлөгч, Ерөнхий сайд З бол бас бидэнд хэдий хэр депутат мөн ч бай, биш ч бай өр нь бас санал бодлоо бидэнтэй солижож байх нь зүйтэй байх, энэ улсыг чөлөөтэй уг хэлүүлэх ийм санал байна.

4-р микрофон: 355-р тойргийн депутат Баянмөнх - 10 дугаар зуiliйн 2-ын а-д бол ингэж заасан байна л даа. Депутат нь тойргийн дугаар, нэрээ хэлж байж зөвшөөрөл авах ёстой. Тэгэхээр бид практик дээр өнөөдөр бий зөвшөөрөл авчихаад дараа нь тойргийн

дугаараа хэлж байгаа. Тэгээд бол тойргийн дугаар, нэрээ хэлж байж, хэн болохы нь харж байж зөвшөөрөл өгнө гэсэн утга энд байгаа учраас энэ бол зөвшөөрөл авсны дараа тойргийн дугаараа, нэрээ хэлж байж гэж засмаар байна. За 2-т бол энэ завсарлагыг бол би Ер нь 20 минутаас хэрэггүй гэж үзэж байна. Бид бол цаг хугацаа их хэрэгтэй байна, олон чухал асуудал хэлэлцэнэ. Ийм учраас цаг юм уу, 30 минут аваад суучихдаг, тэгээд нэг хэсэг нь энд байгаад байдаг, хурал бол иймгүй, Ер нь 20 минутад багтааж нэгэнт одоо нам, өвслүүд ер нь санаа сэтгэл нэгтэй хүмүүс л байдаг. Ийм учраас 20 минутад л тохироод ороод ирэхэд л болех байх гэж, энэнээс илүү хугацаа бол сунжирсан юм болох байх гэж. Тэнд бол маргалдах боломжийг өгнө байх, энэ 10 дугаар зүйлийн 2-ын г-д заасны нь депутаттууд уг хэлэх юу байна л даа З удаа уг хэлнэ гээд. Тэгэжээр бид I дүгээр зүйлийн I-д бол ажил хэрэгчээр чөлөөтэй хэлэлцэнэ гээд батлахисан. Асуудлыг ажил хэрэгчээр чөлөөтэй хэлэлцэнэ гээд. За гэтэл бол г-д бол одоо тодорхой цаг заачихсан, энэ 2 бол зөрчилдэж байна. Ер нь ялангуяа Үндсэн хуулийг баталсны дараа бол ард түмэнд одоо үндсэн хуультай хамт ямар уг, зураг хонрох вэ гэвэл ер нь ард түмний бүрэн эрхт төлөөлэгч нар Их Хуралд очоод хэлэх ёстой угээ билний дамжуулах ёстой юмыг хэлж чадаагүй шүү дээ энэ Үндсэн хуулийг бол ер нь тулгаж хүлээлгээд цаг магаар хавчаад батлуулсан шүү дээ. гэсэн ийм мую уг, зургийг бол бид хамт үлдээж болохгүй. Ийм учраас энэ цаг хугацаа тогтоох асуудал дээр бол бид енэе депутаттууд бол хэдэн ч удаа босож хэлэх эрхий нь өгье. Нэг удаа уг хэлэхдээ төчнөөн минутаас хэтэрч болохгүй гэсэн ийм заагийг гаргавал зүйтэй гэж бодож байна. Ийм учраас орон даяар нэвтрүүлэгдэнэ, ард түмэн харна, манай депутат босохогэхэднэ чи 4-дахиа босож байна уу, гээд суулгачихна шүү дээ. Нэг юм хэлээд дуусаагүй байж байтал цаг боллоо гээд суулгачихна шүү дээ. ийм уг яриа шинэ Үндсэн хуультай хамт хонторч магадгүй юм. Ийм зураг харагдаж байгаа юм. Нөгөөтэйгүүр бол үндсэндээ 15 минут уг хэлэх нэг асуудал дээр бол үүнийг чамлахгүй байна, бид энэ хэлбэр зохион байгуулалтаяа ингэж хийвэл зүгээр гэж бодож байна.

-З дугаар микрафон: - 215-р тойргийн депутат Ж.Чунагсүрэн: -10-р зүйлийн I-ийн хамгийн тэгсгэлийн нэг өгүүлбэр байгаа, салбар хороод байгуулах тухай, эндээс үзэхэд билний бүгд хуралдаан маань хороодынхуралдаан болж салж хуралдах юм байна аа гэсэн

оилгоц өгч байгаа. Тэгээд тэр салбар хуралдаанаас гаргасан шийдвэр маань, зөвлөх эрхтэй эцсийн шийдвэр биш байгаа. За тэгэхээр ийм хороод олон гарах нь ээ тэр 9 дүгээр хуудсанд бас нэг ийм хороо байгуулах тухай өгүүлсэн байна. Тэгхээр энүүнийг энд дэгэнд ийм хороо байгуулах юм бол нэг газар нь зарчмын хувьд томъёолодд оруулаад олон давхардуулахгүйгээр оруулбал ясан юм бэ гэсэн саналтай байна. 2-рт тэр депутатууд материалтайгаа ажиллах асуудал боловсруулах цаг олгох үүднээс тэр депутат Лигдэнгийн гаргасан саналыг би дэмжиж байна. Энийг бүр хэлэлцүүлж дэгэндээ тусгах нь зүйтэй байна. Гэснийм саналтай байна.

8 дугаар тойргийн депутат Ёндонцоо: -2-ын г- дээр депутат хэлэлцэн, шийдвэрлэх гэдэг угийг хасаад депутат бол хэлэлцэж байгаа асуудал бүрээр гэж оруулбал арай дээр болов уу гэсэн саналыг, шийдвэрлэх асуудал бол цөөхөн, зүгээр хэлэлцэж байгаа асуудал бүр. Д-дээр нь депутат хэлсэн угийнхээ төлөө хариуцлага хүлээхгүй гэж оруулья.

2-р микрафон: I63-р тойргийн депутат Мижид: -Тэгэхээр энэ I0-р зүйлийн I-р хэсэгт энэ хугацааны асуудал завсарлаганааны завсарлах уу угүй юу ямар хугацаагаар завсарлах вэ гэдгийг тухайн үед нь хэлэлцэж шийдвэрлэхээр байхгүй болбол уг асуудлынхаа мэн чанараас хугацаа, тэр шийдвэр завсарлах зөвшөөрөл өгөх асуудал шийдэгдэнэ байх. Тийм учраас энүүнийг дэгэнд оруулах нь зүйтэй байх. Одоо 2 минут, 30 минут, I цаг гэж шийдэх боломж алга, уг асуудал ямар асуудал байх вэ гэдэг нь өнөөдөр мэдэгдэхгүй байна. Завсарлага авах гэж буй агуулга, ач холбогдол нь ямар байх юм. Тэрний төгсгөлийн өгүүлбэр байна. Ерөөсөө энэ депутатуудыг их олон хороо, бүлэг, ажлын хэсэг салбар болгож байгаа чинь хэр зэрэг зүйтэй юм гэдгийг бодмоор байна. Энэ өр нь ямар үүрэгтэй хороо болох гээд байгаа юм бэ, энийг бол миний тухайд хасах санал байна. Ерөөсөө хасчихмаар санал байна. 2-р зүйлийн 2-р заалтны гэдэг юмуу, I0-р зүйлийн 2-р заалтны гэдэг юм уу, I0-р зүйлийн 2-р заалтны Б хэсэг чинь хуучны 7-гийн 2 дугаар зүйлийн Б-тэй мөн л ялгаагүй 2 дахиад л орчихож байгаа шүү дээ. Даргын эрхтэй, депутатад уг хэлэх зөвшөөрлийг дарга өгнө гэж байдаг нэг талаасаа энд бол депутат уг хэлэх зөвшөөрлийг даргаас авна гэсэн ухааны

2 км давхардах ороод байгаа шүү дээ. Тэгэхээр энд зүгээр энэ нь байх юм уу, угүй юм уу нэгдэх юм уу ямар ач холбогдолтой юм гэж. Энд нэг юм байгаа юм. Тэр Л гэдэг заалт байгаа юм, Л гэдэг заалтад иргэдээс ирсэн өргөдөл, мэдээллийг хулээж аваад нийтэд зарлан сонсгоно гэж байгаа юм, нийт гэдэг чинь Монголын ард тум-нийг нэрлэж байгаа юм уу, энд байж байгаа депутатуудыг нэрлэж байгаа юм уу, энэ бас тийм л хоёрдмол уг байна лээ. Н гэдэг заалт бол ер нь нэлээн бодож яримаар, энэ заалт байх уу угүй юу гэдэг дээр бол бодмоор асуудал байна. Миний тухайд бол хасах саналтай байна.:

188 дугаар тойргийн депутат Б.Буянцэлгэр: -Дэд Ерөнхийлөгчийг хэдийд ч уг хэлэхийг нь хасъя гэж байна. Тэгэхээр бид ногин жил Ерөнхийлөгч, дэд Ерөнхийлөгчийг эрхэлж байгаа албан тушаалтай нь холбогдуулаад нэлээд өндөр эрх мэдэлтэйгээр сонгож баталсан. Тэгэхээр энэ бол өрөөсөө л олгогдсон эрх нь л гэж би үзэж байна. Энэ хүмүүс бол өөрсдийн эрхэлж байгаа албан тушаалтай уялдаад улс орны өнөөгийн нөхцөл байдал, өнөөдөр бидний хэлэлцэж байгаа асуудалтай биднээс илүү танилцсан, биднээс илүү мэдэж байгаа улс гэдэг нь маргаангуй юм. Энэ талаа с нь авч үзэх хэрэгтэй юмаа. Ингээд Ерөнхийлөгч, дэд Ерөнхийлөгч бол хэдийд ч уг хэлсэн болохоор энд хэвээр нь үлдээх саналтай байна. Энийг ойлгоходоо хэдийд ч гэдгийг санал хураалт явагдсаны дараа ч юм уу, саналын дун гарсний дараа ч хэлж болохоор ингэж ойлгох хэрэгтэй гэж бодож байна. Магадгүй бид олонхоороо сэтгэлийн хөдөлгөөн одоо тийм зарим шалтгаанаар асуудлыг олонхитой дулцуудаад буруу шийдэх ч асуудал гарч мэднэ. Ингээд дээрх нөхцөл байдлын үүднээс энэ хүмүүс бол хэдийд ч бидний гаргасан санал, бусад зүйлийн талаар угээ чөлөөтэй хэлэх, тайлбар хийх эрхтэй байх болов уу гэсэн ийм бодолтой байна.

2 дугаар микрофон: 165-р тойргийн депутат Гомбосурэн:

-Энд нэг 2,3 зүйлийг хасах саналтай байна. Энэ И хэсэг дээр байгаа хуралдаан даргалагч, хуралдаанд үндсэн болон хавсралт илтгэл тавих хугацааг илтгэл тавигчтай зөвшүүлсөний үндсэн дээр урьдчилан тогтоон гэсэн, энийг хасмаар байна. Илтгэгч санал шүүмжлэл тавьсаны дараа хуралдаан даргалагчийн зөвшөөрснөөр уг хэлж болно гэсэн энийг хасах саналтай байна. Ерөнхийлөгч, дэд Ерөн-

144

хийлгч хэдийд ч уг хэлж болно гэж энэ болбол шаардлагатай үедээ л депутатуудад мэдэгдээд зөвшөөрлеөр хэдэнч удаа энэ саяын нэр дурдсан хумуус бол уг хэлж болно. Энийг бол дэгд заавал оруулах шаардлагагүй гэж бодож байна. За дараагаар нь депутат уг хэлэхдээ бусдыг доромжлох буюу гутгэх, өөрийн саналыг тулгахаар хүч хэрэглэхийг бусдад уриалахыг хориглоно гэсэн ийм зүйл байгаа, тэгэхээр энэ депутат хүч хэрэглэхийг хориглож байгаа биш, хүч хэрэглэхийг аль нэгэн хүчинд юм уу, аль нэг нийтэд уриалахыг хориглоно гэсэн санаа байгаа юм. Тэгэхээр энэ бол байгаагаараа байж байх нь зүйтэй гэсэн ийм саналтай байна. За тэр олон хороо, салбар хороо байгуулна, салбар хороодын шийдвэр нь Их Хурлын хуралдаанд зөвлөх шинжтэй байна гэсэн энэ асуудлыг саяын депутат нэхөр Мижид хасах санал оруулсан, үүнийг дэмжиж байна. Энэ одоо шаардлагагүй зүйл. За дараагаар нь бол энэ З хэсэгт байж байгаа. Энэ З -г одоо уг нь болбол урьд 8-ын Г-тэй цуг нийлуулж оруулах ёстой байсан. Энэ урд талд нэг дурдагдаад, ард нэг дурдагдаад нэг ийм 2 км холилдож хутгалдаад байж байгаа. Энийг эсвэл урьдахаас нь авчирч энд нэмэх, эсвэл урьд 8-ын Г-тэй найруулах тийм шаардлагатай байгаа юм. За ийм зүйлийн санал байна.

Здугаар микрофон: 296-р тойргийн депутат Батжаргал: -Тэгэхээр үдээс хойши хуралдааныг ажиллахад 10 депутат ирсэнгүй. Ер нь байдлыг харахад орон гаран байдал чөлөөтэй байх шиг байна. Тэгэхээр нэгэнт дэг хэлэлцэж байгаа учраас бид хуралд суухгүй байгаа депутатууды багтгэлийг гаргаж мэдээлж байх, нөгөө талаас хуралд суухгүй депутат чөлөө авч, тайлбараа гаргаж энд хурлынхаа утга агуултыг барьж ажиллах талаас нь асуудал оруулмаар байгаа юм.

4 дүгээр микрофон: -III-р тойргийн депутат Г.Бадарч: -Энэ Д хэсэг дээр бол би Лигдэн гуай, Гомбосүрэнгийн хэлсэн саналтай нэг байна. Элбэгдоржийн саналыг зөвшөөрөхгүй байна. Нөгөөтэйгүүр энэ дээр ер нь бид нар ардын их хурлын дэпутатууд хуралдаандаа ирж энэ хурлынхаа нэр төрийг одоо улсынхаа чухал асуудлыг хэлэлцэж байгаа учраас ерөөсөө АИХ-ын депутатууд хуралдаан орхиж явахыг одоо хориглоно гэсэн заалтыг зориудаар оруулмаар байна. Нөгөөтэйгүүр би саяын Батжаргалын саналтай нэг байна. Хуралдаан бурийн эхэнд нь ирцийг авч АИХ-ын даргаас хуралдаанд оролцсон депутатуудад

6.

шалтгааныг мэдэгдэж байна гэж оруулъя. Тэгэхгүй бол ер нь одоогийн байдлаар энэ хэдэн хүн бол хаалга хаалга сахиад суучихдаг дуртай нэг нь сууж, дургүй нэг нь гарч байдаг. Ийм зарчим байж болохгүй байхаа. Тийм учраас энэ тулгамдсан гол асуудал дээр гол анхааръя. Нөгөөтэйгүүр тэр Н заалт байна. Тэрэн дээр бол Ерөнхийлөгч гэсэн Ерөнхийлөгч гэдгий нь үлдээтээд дэд Ерөнхий-лөгч гэдгий нь хасах саналтай байна. Ийм л зүйл байна.

6-р дугаар микрофон: 430 дугаар тойргийн депутат Д.Тогооч:  
 -Бид нар бас хурлын дэгээ сахиад, дараалал жоохон хараад зогсоод байлаа, дараалал алдагдаад байгааг цаашид анхаарна уу гэж хэлэх байна. Энэ хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад ярихад хуралдааны үргэлжлэх хугацааг өөрчлөх зохицуулах асуудлыг хурлын дарга санал оруулаад нийт депутатуудын зөвлөлийн олонхиор шийдвэрлэж байх нь зүйтэй болов уу. Бид нь зарим үед хугацаанаасаа өмнө завсарлах юм ч байгаа байх, зарим үед сунгаж хуралдах ч юм нэлээд бий, гэж ингэж ойлгож байна. 2 дугаарт энэ салбар хороод гэдэгтэйгээр санал нийлэхгүй байна. Ерөесөө ажиглавал одоо энэ хэдэн депутатуудыг хэдэн депутатын ажлын хэсэг, булэг, салбар хороодод тараагаад, ингээд ерөесөө гол санаа маань алдагдах нь ийм учраас ер нь анх эхлээд депутатын групп байгуулсанаас зарим депутатууд бол бас санал өгөөгүй байгаа. Ер нь цаашид анхаарахгүй бол бид нь болохгүй нь ээ. Ийм учраас салбар хуралдаан, салбар хороод байгуулах асуудлыг авч үзэх хэргүй юм. Хуралдааныхаа ажлыг үр дүнг идэвхтэй болгохын тулд бас хэлбэрий нь өөрчлөхийн тулд зөвхөн хуралдаан биш зарим үед ярилцлага зарим материалтай танилцах, материалын боловсруулалтан дээр суух зэргээр бид нар өглөө, үдээс өмнө, үдээс хойшийн хуралдааныг зохицуулж байвал зүйтэй болов уу, энэ талаар заримдаа хөдөлмөрчдийн ирүүлсэн саналтай танилцах юм уу, зарим байгууллага дээр очиж хөдөлмөрчдийн төлөөлөгчидтэй уулзах ч юм уу ийм хэлбэрийн ажил зохиовол дээр болов уу гэж бодож байнаа.

Соронзон хальстай  
тулгаж нийлсэн  
Бичээч

*М.Бурмаа*

Ш.БУРМАА

Батцэцэг

1991.XI.II.

Кассет № 30

17.50-18.05

Үг хэлэх хугацааны хувьд тодорхой юм заагаад хэрэггүй байх. Энэ заасан хугацаа, мөн Үндсэн хуулийн тесел хэлэлцэхэд мөн энэ чигээрээ орсон байгаа. Хэн хэдэнминут яаж хэлэх вэ, депутатууд өөрсдөө зохицуулах байх гэж бодож байна.

19I дүгээр тойрог Б.Лханаасурэн: -Тэгэхээр энд ийм нэг санал гарч байна. Энийг депутатууд харгалзаж узэх нь, их бодож узэх нь зүйтэй юм. Лигдэн гуай I, 3, 5 дахь өдөр 19 цаг хүртэл, бусад өдөр 17 цаг хүртэл ажиллая гэж байна. Тэгэхээр бид хэрэв 17 цаг хүртэл ажиллавал өдөрт 6 цаг ажиллах нь байна, ингээд тооцоод узэхээр 8 цаг ажиллах ёстой, бид. Тийм учраас Хөдөлмөрийн хуультай зөрчилдэх гээд байна. Тийм учраас цаг хэмнэж, үр бүтээлтэй байхын тулд цагийг хорогдуулахгүй баймаар байна. Орой 19 цаг хүртэл ажиллая, шаардлагатай бол сунгая. Ер нь бүтэн сайн өдөр бол ажиллахад болохгүй байх гэх газаргүй. Шаардлагатай бол бүтэн сайн өдөр ажиллана гэж оруулмаар байна. Амарна гэж оруулахаасаа гадна.

Тийм учраас цагаа хорогдуулаад ингээд хуралдаад эхлэх юм бол энэ чинь хөдөлмөрчид, ард түмэн юу гэж узэх вэ? Биднийг чинь 8 цагийн оронд 6 цаг ажиллах болохгүй нээ.

Хоёрдугаарт, энэ саналыг харгалзаж узнэ үү гэсэн санал байна, санал хураах үед. Хоёрдугаарт, 10 дугаар зуилийн I дүгээр зүйл дээр депутатуудын гаргаж байгаа саналыг бүрэн дэмжих байна. Шаардлагатай бол оройн хуралдааныг сунгаж болно, нэг цагаар. Завсарлагаа бол 30 минут хүртэл байж болно гэсэн зүйл байна. Салбарын хороодын шийдвэр гэдэг дээр I-ийн хоёр догол мөрөн дээр "шийдвэр нь Ардын Их Хурлын хуралдаанд зөвлөх шинжтэй байна" гэж байна. Салбарын хороодын шийдвэр гэж байж таарахгүй, салбар хороодын санал юмуу, зөвлөмж байж болно. Тэр бол Их Хуралд зөвлөх шинжтэй байж болох юм.

"б"-д нэрийн дарааллыг гэхээр энэ чинь биелэгдэхгүй байна шуу дээ. Тэгэхээр микрофоны дарааллыг гээд шууд оруулбал

яасан юм бэ? Гурван удаа уг хэлэх энэ зүйлийг хэвээр нь байлгах нь зүйтэй. Ерөөсөө ганцхан удаа уг хэлээд, санаалаа хэлээд болно гэж хэрхэвч байж таарахгүй. Яагаад гэвэл, олон депутат санал хэлсний дараа хүмүүсуудийн бодол санал бол янз бүрээр эргэж дахин дахин өөрийнхөө нотолгоог зөвтгэх ийм аргумент, фактуудыг хэлэх шаардлага гарч болзошгүй. Тийм учраас гурван удаа уг хэлэх энэ асуудал бол зөв юм.

Элбэгдорж санал хэлж байна. "е"-д депутатын ердийн олонхийн санаалаар гэдгийг хасъя гэж. Тэгэхээр ердийн олонхийн санаалаар саналыг нэрээр авах асуудлыг шийднэ гэж байгаа шүү дээ. Тэрнээс ерөөсөө асуудлуудыг ердийн олонхийн санаалаар шийднэ гээд байгаа юм биш. Нэрээр санал хураах уу, угүй юу гэдгээ нийт депутатын дунд санал хураагаад ердийн олонхийн санал нь тэгье гэвэл нэрээр санал хураана гэсэн уг. Би ингэж ойлгож байгаа.

"ж"-г хасъя гэж байна. Энийг хасч болохгүй. Санаалаа таслах асуудлыг чинь одоо бид зөвлөгөө, санал гаргаж байна. Одоо ингээд санаалаа таслах уу, угүй юу гэдгийг чинь одоо санал хураана шүү дээ. Тэгэхээр энийг чинь ердийн олонхийн санаалаар санаалаа хурааж таслахгүй бол болохгүй. Энэ заалт заавал байх шаардлагатай.

Эцэст нь дэд ерөнхийлөгч, энэ тэрийг байлгах асуудал ариад байна, уг хэлэх асуудал дээр. Энэ дээр Ерөнхийлөгч бол бид ямар ч байсан энэ хүнд бол нэг хүссэн үед нь өөрийнхөө санааг хэлчих ийм боломж олгох хэрэгтэй. Туруун би уг хэльэ гэж бодож байсан. Ийм бололцоо олдоогүй. Ялангуяа Их цаазын төслийг хэлэлцэх үед Ерөнхийлөгч энэ хэлэлцуулгийг явуулж болох юм гэж үзэж байгаа. Бид гадаад орнуудын парламентаас их туршлага авах дуртай, их ярьдаг юм билээ, улсууд.

ЗХУ-ын АДХ-ыг чинь Горбачев даргалаад явуулсан шүү дээ, сая тэрийн эргэлтийн дараа. Тийм учраас энэ депутат биш, Ерөнхийлөгчид эрх олгоод хурлыг эхнээс нь аваад дуустал хуралдаан явуулах эрх олгож байхад бид одоо туршлага гээд ингэж ярьдаг юм бол ганцхан асуудлыг хэлэл-

3.

ЦҮҮЛЭХЭД, хурал явуулчихад болохгүй гэхийн газар өрөөсөө байхгүй.

Дэд ерөнхийлөгчийн хувьд энэ хүн депутат хүн учраас хэзээ ч өөрийнхөө эрхийг эдлээд энд уг хэлж болно. Тийм учраас энийг бол хасъя гэсэн саналтай байна.

221 дугаар тойргийн депутат Н.Цогт-Очир: -Энэ дээр ийм санал байна."а", "б" энэ хоёрыг нийлүүлээд ингэж найруулж болохгүй юу гэдэг санал байна. Депутат Ардын Их Хурлыг даргалагчаас зөвшөөрөл авсны дараа овгийн эхний устгийг хэлж нэрийг хэлээд сонгогчдынхoo болон өөрийн саналаа хэлж болно гэж найруулж болмоор юм шиг байна. Ийм санал байна.

Хоёрдугаарт, "хүч хэрэглэхийг" гэдгийг хасмаар саналтай байна.

Гуравдугаарт, "дэд ерөнхийлөгч" гэдгийг тэртээ тэргүй манай дэд ерөнхийлөгч депутатынхаа хувьд эрхээ эдэлж байгаа гэж үзэж байна.

288 дугаар тойргийн депутат С.Баянцогт: -1 дугаар зүйлийн эхний өгүүлбэрийн хамгийн суулийн хэсэг нь "тодорхой асуудал хэлэлцэх явцад шаардлагатай бол депутатын ердийн олонхийн буюу намын булгийн" гэдэг тэр редакцаар "намын" гэдэг нь хасагдаж байгаа гэж ойлгож байгаа шүү дээ. Тэгэж ойлговол зөв биз дээ.

Түүнээс гадна доошоо яваад "е" заалт дээр ингэж хэлэх гээд байгаа юм. Хаалтан дотор хийсэн ч болно, нэрээр хураана гэдэг санал байна шүү дээ, нэрийн жагсаалтаар авч болно гэдгийг.

Үндсэн хуулийн эцсийн хэлэлцүүлгийн зүйл бурийг нэрээр санал хураана гэсэн ийм санал оруулах саналтай байгаа. Техникийн боломж бусад юмаа харгалзаад. Уг нь зүйл бурийг нэрээр хураавал их сайн байгаа, зөвхөн Их цааз дээр. Ийм саналыг хураалгаж

өгөөч гэсэн саналтай байгаа.

Тодорхой салбар хороодыг байгуулахыг бол хасъя гэсэн саналтай байгаа. Энэ дээр бол давхардаж байна. Дэд ерөнхийлөгч депутат учраас энд ёс зүйн хэм хэмжээ байх ёстой байх. Ер нь Дэд ерөнхийлөгч ч гэсэн яагаад бид нар депутатынх нь эрхийг хасаагүй билээ гэдгээ жаахан бодолцох ёстой. Тэр утгаараа угийг хязгаарлах ёстой байх. Ерөнхийлөгчид эрх олгох ёстой, яагаад гэвэл депутат биш учраас гэсэн саналтай байна.

413 дугаар тойргийн депутат Н.Насан-Очир: -Уртнасан дарга аа, одоо саналууд их давхцаад байх шиг байна. Ингэж цаг урэхийн хэрэг байна уу? Хурлын дарга нэлээн чангадуухан шиг гартай, дэглэмтэй хандахгүй бол олонд үлгэр дууриалтай хурал аа. Сахилга, дэг журам ярьж байж энэ хурал чинь үлгэр болохгүй бол монголд энээс өөр үлгэр болох хурал байхгүй шуу. Ийм учраас энэ депутатуудыг ордог, гардаг, урилгаар орж байгаа улсууд орох, гарах нь дурны асуудал байна. Энэ тал дээр манай орлогч дарга нар ч гэсэн анхаарч, хяналт тавьж ажлаа хуваарилбал ямар юм бэ гэсэн санал байна. Ингээд саналаа энийнхээ дагуу шууд хураагаад явбал яасан юм бэ? Одоо олон санал аваад бужигнаад байх тусам улам л ... Нэг санал давхцаад байна, цаг урэхийн нэмэр юм биш уу гэсэн саналыг хэлэх гэсэн юм.

266 дугаар тойргийн депутат Д.Цэвэгдорж: -Энэ 10-ын I-д намын булгийн оронд "бүлгүүдийн" гэж оруулмаар байна. Ийм саналтай байна.

Хоёрдугаарт, 2-ын "б"-г хасмаар байна. 7-гийн 2-ын "б"-д энэ хоёр асуудал давхардаж ороод байгаа учраас энэ 2-ын "б"-г шууд хасчихмаар ийм саналтай байна. 7-гийн 2-ын "б"-г үзээрэй, энэнтэй давхар зүйл байгаа.

Ерөнхийлөгч, Ерөнхий сайд гэж оруулж өгмөөр байна. Дэд ерөнхийлөгч бол тэртээ тэргүй депутат учраас тэр хэдийд ч уг хэлж болно. Энэ дээр Ерөнхий сайдыг оруулж өгмөөр байна. Ийм гурван санал байна.

## 5.

98 дугаар тойргийн депутат Д.Марав: -Салбар хороод гэдгийг хасмаар байна, бүгдийг Яагаад гэвэл, энэний турүүн "булэг" гээд урд талд бид нар маргаж байгаад баталчихаад ард нь салбар хороогоо яримааргүй байна.

"г" дээр "тулгахаар хүч хэрэглэх" гэдгийг бүгдийг аваад "уриалахыг хориглоно" гээд энэ хэвээр нь байлгамаар байна. Яагаад давхардаад байгаа вэ гэхээр харгалзаж үзнэ гэсэн утгаас яриад байгаа шуу дээ. Даргалагч, илтгэгч гэсэн энэ угнуудийг арай өөр маягаар бид жишээлбэл, Уртнасан гуайл даргалагч гэж тавиагүй шуу дээ. "Дарга" гэж тавьсан. Энэ угнуудийн найруулгыг жаахан бодмоор байна.

"л" дээр саналаа хэлье. Хуралдааны үед иргэдээс Ардын Их Хуралд ирүүлсэн өргөдөл, санал, гомдол, хүсэлт, асуулт болон бусад зүйлийг гэж найруулмаар байна. Тэгээд энэ дээр микрофоноо бидэнд дунд суусан улсуудад шилжүүлдэг юмуу, дандаа энд очерлоод байх юм уу гэдгийг одоо энд шийдэж өгмөөр байна.

Гуравдугаар зүйл байгаа. З дугаар зүйл дээр манай зарим депутатууд намайг төлөөлж яриараарай гэсэн. Тэр ямар зөрчил гаргасныг тодруулж гаргаж өгөхгүй бол тэр чинь зарим нь хурлаасаа гараад явчихна, энэ давхардаад байна шуу дээ. Зөрчлийнхөө байдлыг яг батламжтай болгож өгмөөр байна.

389-р тойргийн депутат Н.Баточир:

2-ын "л" дээр ийм санал байна. Хуралдааны үед байгууллага, хамт олон, иргэдээс гэж оруулмаар байна. Байгууллага, хамт олноос Ардын Их Хуралд ирүүлсэн өргөдөл, лавласан зүйл, асуултыг хуралдаан даргалагч зохицуулна. Нийтэд зарлан сонсгоно. Зарим асуудалд хуралдааны явцад хариу өгнө гэж оруулмаар байна.

Уртнасан даргад хэлэхэд, турүүн та Их Хурлын тогтоолыг радио, телевизээр явна. Босож дараагийн Их Хурлын тогтоолыг

уншихдаа суудлаасаа босож уншихыг анхааруулж байна.

Энэ батлагдсан зүйл ангиуд маань цаанаа редакцидаа яг энэ үсэг, үгээрээ, өгүүлбэр утгаараа бууж байгаа эсэхийг та хурлын дарга, орлогч нар анхаараарай. Дараа нь дэг батлагдаад дуусдаг. Бид нарын гар дээр хувилагдаад хүрээд ирдэг, зарим юман дээр буруу зөрүү гараад маргаан гарах вий гэсэн санал байна.

399 дүгээр тойргийн депутат Л.Чилхаажав: -Санал давхардахгүйгээр ганцхан санал хэлье. 10 дугаар зүйлийн "и" гэсэн заалт Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч хэдийд ч уг хэлж болно гэдгийг хасъя гэсэн санал налзэн гарах шиг боллоо. Тэгэхээр би энийг хасч болохгүй гэж бодож байна. Бүр бодлоггүй юм бол, Их цаазын төслийг хэлэлцэх үед Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч хэдийд ч уг хэлж болно гэж оруулмаар байна. Яагаад ингэж байгаа юм гэвэл, Дэд ерөнхийлөгч Улсын Бага Хурлаас Их цаазын төслийг боловсруулах комиссыг баталсан. Ерөнхийлөгч бол энэ комиссын дарга. Энэ хоёр хүн бол Их цаазын төслийг хэлэлцэж байх явцад хэдийд ч уг хэлж болно гэсэн онцгой эрхийг олгох нь зүйтэй болов уу гэсэн саналтай байна.

Ж.Уртнасан: -Одоо ингээд саналын гол гарлаа гэж бодож байна. Ийм учраас саналаа таслах уу?

Танхимаас: -Тэгье.

Ж.Уртнасан: -Санал хураахад бэлтгээрэй, санал таслахаар санал хураах гэж байна.

Манай санал өгсөн депутатуудын 97 хувь нь буюу 346 хүн саналаа тасалъя гэсэн санал ирүүллээ. 2 хувь буюу 7 хүн татгалзаж байна. 1 хувь буюу 5 хүн түдгэлзэж байна. Ингээд олонхийн саналаар санал авалтыг тасаллаа. Одоо саналынхаа дүнг бид шүүн хэлэлцэж редакцид өгөх эсэхээ яръя.

Олон санал гарлаа. Нийтдээ 37 санал түүвэрлэж, тэмдэглэж авлаа. Үнээс давхардсан саналууд олон байна. Эхнээс нь

7.

эхлээд явъя. 10 дугаар зүйлийн I дүгээр заалт дээр хуралдааны хугацааг манай зарим гишүүд нэг цаг хүртэл, шаардлагатай үед нэг цаг хүртэл сунгаж болно гэсэн ийм заалт хэлж байна. Ням гаригт амарья гэсэн заалт оруулъя гэж зарим депутатууд санал гаргаж байна. Завсарлагын хугацааг 30 минут, нэг цаг гэсэн хоёр санал оруулж байна.

Мөн I дүгээр заалтын 2 дугаар өгүүлбэр буюу, 2 дугаар өгүүлбэрийг Чунагсүрэн, Мижид, Баярцогт, Норов нарын депутатууд шууд хасъя /5 хүн/ гэсэн санал ирүүллээ. Ингээд I дүгээр заалт дээр цаг хугацаан дээр бид хөдлөх шаардлагатай ю? 9-13, 15-19 цаг. Энэ дээр нэг редакц хийвэл "шаардлагатай бол" ...

Соронзон хальстай  
тулгаж нийлсэн:

Ж.НАРАНТУУН

Бичээч Ө.ОЮУНЧИМЭГ

1991.II.II

Кассет № 31

18.05-18.20

шаардлагатай үед нэг цаг хүртэлх хугацаагаар сунгаж болно гэдэг ийм өгүүлбэр байгаа юм. Унийг редакцид шилжүүлэх үү.

Уртнасан -Санал хураах уу, шаардлагатай бол хуралдааны цагийг нэг хүртэлх хугацаагаар сунгаж болно гэсэн ийм нэг хувилбар байгаа юм. Ийм хувилбар манай орлогч дарга санал болгож байна. Цагаа заахын өмнө шаардлагатай үед хугацаа сунгаж болно гэдэг өгүүлбэр хийе гэж. Энэ дээр санал хураалт явуулъя. Шаардлагатай үед хуралдааны хугацааг сунгаж болно гэж. Санал өгсөн депутатуудын 74 хувь нь буюу 303 хүн зөвшөөрч байна. 23 хувь нь буюу 94 хүн татгалзлаа. 3 хувь буюу 12 хүн түдгэлзэж байна аа. Ингээд ердийн олонхийн саналаар шаардлагатай үед бид хуралдааны хугацааг сунгаж болох нээ. Ийм редакцийн засвар хийгдлээ.

Хоёрдугаар өгүүлбэр дээр тодорхой асуудлыг хэлэлцэх үед ердийн олонхийн буюу намын бүлгийн саналаар хуралдааныг түр завсарлаж болно гэдэг өгүүлбэр дээр зарим хумуус нэг цаг хүртэл гэж байна, зарим хумуус 30 минут хүртэл хугацаагаар гэж байна. Бид хугацаа заах уу? Намын гэдгийг хасъя гээд байна, ер нь бүлгийн.

Энэ редакцид шууд хэлчихье. Намын гэдэг угийг хасах саналтай байх шиг байна. Намын гэдгийг хасах санал оруулж байна. Энэ дээр санал хураалт явуулъя. Ер нь намын гэдэг угийг хасаад бүлгийн олонхийн саналаар завсарлага авч байя гэж, намын гэдэг тодотголыг хасъя гэж байна. Санал өгсөн гишүүдийн 70 хувь нь буюу 279 нь зөвшөөрч байна, 28 хувь буюу 114 хүн татгалзлаа, 2 хувь буюу 8 хүн түдгэлзэж байна. Цөөнхөд зөвшөөрөл олгоё. За Энхсайхан депутат.

Ж.Энхсайхан -Их хурлын дарга аа. Энэ дээр цөөнх санал хэлж болно биз дээ. Тэгэхээр ийм юмаа. З хүн нийлээд бүлэг гэж бүртгүүлж болно. З хүн бол, гурав гурваараа бүгдээрээ бүлэг болчихоод дараа нь цагийн завсарлага авч болохгүй ээ. Тийм учраас энэ завсарлага авах әрх бол зөвхөн намын бүлгүүд дээр нээлттэй байх нь зөв, бусад нь угүй юмаа гэж. Тийм учраас намын гэдэг угийг хасч болохгүй байгаа юм.

Уртнасан -За цөөнхийн саналыг бид хүндэтгэн узэж байна.

Цөөнх нь намын гэдгийг онцгой эрх олгоё, бусад булгууд З хүн нийлчихээд цагийн завсарлага аваад байвал сүйд болно гэсэн санал орж ирж байна. Бид сая намын гэдэг угийг хасья гэдэг санал хураалт явуулсан юм. Тэгэхлээр цөөнхийн саналыг хүндэтгэн узэж дахин санал хураалт явуулъя. Намын гэдгийг хасах уу, үлдээх уу гэдэг дээр санал хураалт явуулъя. Өөрөөр хэлбэл намын гэдгийг үлдээе гэсэн нь зөвшөөрнө гэдгээ дарна. Намын гэдгийг үлдээнэ гэдэг нь зөвшөөрнө гэдгээ дарчихъя, намын гэдгийг хасья гэдэг нь татгалзая. Намын гэдэг булэг дээр ярж байгаа шуу дээ. Бусдыг хайхрахаа болилоо шуу дээ бид нар. Онцгой эрх. Олонхийн санал авч байна. 58 хувь буюу 236 хүн зөвшөөрч байна, энэ саналыг. Манай редакцийн групп үүнийг сайн бичиж авч байгаарай. Энэ хоёрдахь цөөнх болж гарч ирж байна. Татгалзсан 167, түдгэлзсэн 6.

27 дугаар тойргийн депутат Пүрэвдорж -Хэрвээ намын булгууд намын асуудлаар шийдэх юм бол үндсэн хуулийг намуудын их хурлаар батлах ёстой байсан. Тийм учраас хэрвээ булэг байгуулахыг зөвшөөрч байгаа бол бух булэг ижил, тэгш эрхтэй байх нь зүйтэй. Ер нь булэг бол их хурлын туршид ч зарим булэг нь байх байх, зарим асуудал дээр ганцхан асуудал дээр санал нийлсэн, узэл санаа нийлсэн депутатууд нэг булэг болоод тэр асуудлаа шийдчихсэний дараа тэр булэг албан ёсоор тараад их хурлынхаа даргад бүртгүүлээд явах байх, өрөөсөө парламентын журам бол ийм л дээ. Тэгэхээр хэрэв булэг байгуулахыг нэгэнт бид дээр зөвшөөрсөн бол тэр булгууд ижил эрхтэй байх нь зүйтэй, яагаад гэвэл тэр булгууд чинь депутатуудаас бурдсан булэг учраас аль нэг намын гишүүн депутат нь илүү эрхтэй, өөр булэг нь депутат нь дутуу эрхтэй байж болохгүй л дээ. Тийм учраас нэгэнт депутатуудын булэг учраас ижил эрхтэй байх нь эзйтэй. Яагаад гэвэл ут булгуудийг бурдгуулсан депутат нь ижил эрхтэй учраас. Иймд бүтгээрээ л завсарлага авдаг бол авдаг, авдаггүй бол авдаггүй байх нь зүйтэй. Энэ чинь ардчилын соёл биз дээ наад захын.

288 дугаар тойргийн депутат Баярцогт -Саяны саналаар бол угтаа булэг байхын ач холбогдол алга болж хуучин намын булгууд гэсэн байдалд орж байгаа юм. Ер нь зүгээр энэ дээр булгуудийг узэл бодлын нэгдлээр байгуулна. Энэ дээр намуудын булэг бол ер нь намын гишүүнчлэлээрээ байгуулагдчих байх гэж найдаж байна. Энэ

булэг, бусад булэг байгуулагдах асуудал бол хүмүүс нутаг дэвс-гэрийн гэдгээр яриад байх шиг байна. Энэ бол зүгээр аж ахуйн чанартай булэг байдаг. Зөвхөн тэр байр сууц, гол булгийг намын парламент дахь фракц буюу намын булэг гэдэг ойлголт нь дандаа үзэл бодлын булэг байдаг. Үзэл бодлын булэг гэдэг ойлголтоор ойлгодог. Энэ тохиолдолд нам бусчуудын хувьд энэ асуудал хүчтэй тавигдаж байгаа юм. Тийм болохоор намын булэг гэдгээр явцуураад асуудлыг авч шийдвэрлэх юм бол дандаа ярьдаг, нэг намын ноёрхол байлаа гэж ярьдаг байсан бол одоо парламентын суудалтай 4 намын ноёрхол гэдэг асуудал эргэж тавигдана. Тэр утгаараа бол нам бусчуудыг харч үзэх ёстой. Энэ санал дээрээ дахиж санал хурааж энэ дээр депутат бүхэн ижил тэгш эрхтэй байх ёстой. Намынхаа гишүүнчлэлээс хамаarahгүйгээр.

Уртнасан - Энэ дээр санал задарч байна.

I48 дугаар тойргийн депутат Баттулга - Би хамгийн цөөнх нь, түдгэлзсэн. Энэ дээр бид нар найруулга гэж хэлэх юмуу зарчим гэм хэлэх юмуу энэ уг өгүүлбэрээрээ бодох хэрэгтэй. Туруун Баярцогт, зарим хүмүүс хэлж байна. Энэ дээр би шууд саналаа хэлчихье. Энэ дээр бид нар депутатуудын булэг гэдгээр явж байгаа. Тийм учраас депутатуудын булгээс санал оруулж, депутатуудыг ердийн олонхи дэмжсэнээр түр завсарлаж болно гэж ингэж л оруулах ёстой. Тэриаас биш ямар нэг булэг нь гарангутаа шууд л завсарлага авч болохгүй. Тэр чинь депутатууд өөрсдөө шийднэ шүү дээ. Энэ хурлыг завсарлах уу угүй юу гэдэг нь депутатуудын ердийн олонхи нь шийдэх ёстой. Харин саналаа хэн дэвшүүлэх вэ, субъект нь хэн байх вэ гэдэг дээр ярьж байгаа гэж би ойлгож байгаа. Тийм учраас депутатуудын булгээс тодорхой санал оруулах ёстой. Түүнийг депутатуудын ердийн олонхи дэмжсэн тохиолдолд хугацаатай, хугацаагүй нь түр завсарлагаагаа авч болох иймэрхүү янзаар найруулаад орж болох байх аа гэж бодож байна. Тэгэхдээ депутатууд санал өгөхдөө З-хан гишүүнтэй булэг оруулж ирэхэд депутатууд өөреөр хандана шүү дээ. Энэ дээр депутатуудын бүрэн эрх байгаа.

Уртнасан - Эрхэм депутат Баттулга аа. Ердийн олонхи гэж байгаа шүү дээ. Тэгэхлээр намын гэдгийг.

Баттулга - Энэ дээр ийм байхгүй юу. Ердийн олонхи буюу намын булгийн саналаар гэж орчихоод байгаа дээр хүмүүс эмзэглээд

байгаа байхгүй ю.Өөр намын булгийн санал оруулангуут л хуралдаан маань тэр чигээрээ завсарлаачих юм шиг харагдаад байгаа юм.Үүнийг уншихад.Өөрөөр хэлбэл депутатуудын булэг нь саналаа дэвшигүүлэх эрх нь депутатуудын булэгт байна.Завсарлуулах эрх нь депутатуудын ердийн олонхийн санал байна.Ингэж л оруулах хэрэгтэй.

Уртнасан -Эрхэм депутатуудын сонорт жижигхэн редакц танилцуулах хэрэгтэй болох нь.Намын булэг санал оруулж,депутатуудын ердийн олонхи зөвшөөрвөл гэдэг ийм редакц хийчихвэл болж байна уу? Булгийг хасчихъя гэж уу.

71 дүгээр тойргийн Ядамсүрэн -Үүнийг ийм байдлаар, нэгдүгээрт булгийг үндсэн хуулийг хэлэлцэх ийм нехцэлд бол узэл бодлын булгүүд байж болохоор.Бага хурал + сонгох уед нэгэнт намуудын суудал өгөхөөр түрүүчийн нэмэлт хуулинд байгаа учраас намын булэг байхаар ийм хоёр заалт гарч ирэх хэрэгтэй байна.Хэлэлцэж байгаа тодорхой асуудлаас болоод үндсэн хуулийн хэлэлцэх энэ нехцэлд бол депутатын узэл бодлын хэсгээр булэглэн, хийсэн булэг байж болно.Ингэж тодруулаад нэгөө асуудлаа хуучин хуульд байж байгаагаа удирдлага болгоод тэрэн дээр намуудын булгүүд байна гэсэн ийм заагаар гаргавал ямар вэ гэсэн санал байна.

Уртнасан -Дахин санал явуулах уу депутатууд аа? Хэлэлцэж байгаа асуудлын онцлогоос болоод хувилбартай хандая гэж депутат Ядамсүрэн санал гаргаж байна.Эрхэм депутат Баттулга ер нь намын гэдгийг хасъя гэсэн,депутатуудын булэг гэж.

Баттулга -Энэ дээр би ямар нэгэн юм хасъя гэж хэлээгүй. Би зүгээр шууд томъёолон уншихъя л даа.Тодорхой асуудал хэлэлцэх явцад шаардлагатай бол депутатуудын булгээс санал оруулж хуралд оролцож байгаа депутатуудын ердийн олонхийн дэмжлэгээр хуралдааныг түр завсарлаж болно.Депутатуудын булэг гэдэг дотор намын булэг байгаа.

Уртнасан -Баттулгын хийсэн редакцийг редакцийн группт шилжүүлэх уу.Санал хураая.Депутат Баттулгын саналаа. Саналыг дэмжиж байгаа депутатууд.Депутат Баттулга өөрийнхөө хувилбарыг манай редакцийн комисст өгнө уу.

Депутат Баттулгын хувилбарыг манай депутатуудын 83 хувь нь буюу 329 хүн дэмжлээ. 13 хувь буюу 52 хүн татгалзаж, 4 хувь буюу 15 хүн түдгэлзэж байна. Депутат Баттулгыг өөрийнхөө хувилбарыг бичиж депутат Баярт өгөхийг хүсч байна. За дараагийн зүйл Ням гаригийн амралтын тухай байгаа юм. Нам гаригт амарна гэж зарим депутат санал гаргаж байна. Зарим хумуус бид их шахуу цагт ажиллах учраас ер нь өдрийн цагаа ч сунгая, бутэн сайн өдөр ч ажиллахаар тогтоё гэдэг ийм хувилбар байгаа юм. Тэгэхээр ням гаригт амарна гэдэг дээр санал хураалт явуулъя. Санал өгсөн депутатуудын 82 хувь нь буюу 341 хүн ням гаригт амарч байя гэж байна. 14 хувь нь буюу 59 хүн татгалзаж байна, 3 хувь буюу 14 хүн түдгэлзлээ. Тэгээд олонхийн саналаар бид дэгэндээ ням гаригт амарна гэдэг заалт өгүүлбэр оруулах нээ.

СОРОНЗОН ХАЛЬСТАЙ ТУЛГАЖ  
НИЙЛСЭН

Эвдэлж

/БАЯНДҮҮРЭН/

БИЧЭЭЧ

/Д.ЭНЭБИШ/

1991.XI.XI

Кассет № 32

18.20-18.15

Энэ заалтын 2 дугаар өгүүлбэрийг депутат Чунагсурэн, Мижид, Баярцогт, Шарав нарын олон хүмүүс энэ бол ач холбогдол багатай заалт юм хасъя гэсэн ийм санал ирлээ. Энэ дээр санал хураалт явуулъя.

414 дүгээр тойргийн депутат Гантэмэр: Хурлын даргын микрофоныг хаахан чангалаад өгчихмөөр байна. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт та тэр самбар дээр байгаа мэдээллийг хэлэх-дээ нийт депутатуудын тэд нь санал өглөө гэж хэл. Энэ чинь баримт бичигтээ орж байгаа юм бол. Заримдаа 401 өгөөд заримдаа 402 өгөөд байх юм. Нийт депутатын тоог хэлж байвал, цаанаа бичигдэж байх нь зөв байх гэж ойлгож байна.

Уртнасан:

Сүүлчийн I дүгээр заалтын 2 дугаар өгүүлбэрийг депутатууд хасах санал ирүүлж байна. Уүнийг энэ талаар санал хураалт явуулах уу?

Яагаад ийм өгүүлбэр оруулсан юм бэ, тайлбар сонсоё гэж байна шүү дээ. Депутатууд.

За бид хоёрдугаар өгүүлбэрээр дэгийн эхийг зохиосон комиссийнхонтой ярилцаж та бухэнд тайлбар сонсгоё. Энэ хугацаанд цаг хоод бидэнд бас нэг саналаа цааш нь үргэлжлүүлэх хэрэгтэй байна.

Энэ тодорхой асуудлаар санал солилцохын тулд завсарлага авна гэсэн ийм өгүүлбэр дээр манай зарим хүмүүс 30 минут, зарим нь I цаг гэж байгаа, зарим депутатууд цаг хязгаарлахгүй байх сонирхолтой байх шиг байна. Энэ дээр бид цаг тогтоох уу?

Мижид:

Уучлаарай. Миний өгсэн санал бол тухайн үед нь тохирч байя гэж байсан.

Гурван санал байна шүү дээ.

30 минутаас хэтрэхгүй байя гэсэн нэг санал бий. Нэг цаг байя гэсэн санал бий. Депутат Мижидийн саналаар тухайн үед нь

## 2.

зохицуулж байна. Юу ч гэсэн энэ цагийг тогтоох уу, үгүй юу гэдэг дээр санал хураагаад дараа нь хоёр хувилбараар санал хураагаад авчихъя гэж бодож байна. Тэгэхээр энэ дээр бид цаг тогтоох уу, санал хураалт явуулъя.

Санал өгсөн депутатуудын 77 хувь нь буюу 318 хүн цаг тогтооё гэсэн санал ирүүлж байна. 21 хувь нь буюу 87 хүн нь татгалзаж байна. I хувь нь буюу 6 хүн түдгэлзэж байна.

Олонхийн санаалаар бид цаг тогтоох боллоо. Одоо тэгэхээр бидэнд хоёр хувилбар байгаа. 30 минут хуртэл, I цаг хуртэл гэж. Одоо энэ хоёр дээр санал хураалт явуулъя.

Мижид:

Уртнасан даргаа. Сая ойлгомжгүй болчихлоо л доо. Ер нь цаг тогтоох юмуу, тухайн үед нь цаг тогтоох юмуу гэж асуух ёстой байсан байхгүй юу. Гэтэл энэ хумус өрөөсөө л цаг тогтоох ёстой гэдэг дээр өгчихлөө. Өнөөдөр тогтоох уу, тухайн үед нь тогтоох уу гэдгийг ойлгосонгүй.

Уртнасан: Тухайн үед нь гэдэг хувилбарыг бид гуравдахь хувилбар болгож авч үзье. Одоо бид 30 минут, I цаг гэдэг дээр санал хураая гэж бодож байна. Үгүй юу.

Депутатуудаа тэгэхээр бид зарчмын саналыг дахиж авч үзэх хэрэгтэй юм шиг байна. Цаг тогтоохыг эхлээд бид 30 минут, I цаг гэдгээр биш, өрөөсөө тухайн үед нь цаг тогтооё гэдэг дээр санал хураачихвал ямар байна вэ?

Тухайн үед нь цаг тогтооно гэдгийг зөвшөөрч байгаа депутатууд, ер нь тухайн үед нь цаг тогтооно гэдгээр санал хураалт явуулчихъя.

За санал өгсөн депутатуудын 82 хувь нь буюу 338 хүн тухайн үед нь цаг тогтооё гэж санал өглөө. I 7 хувь буюу 69 хүн татгалзаж байна. I хувь буюу 5 хүн түдгэлзэж байна. Тэгэхээр бид хэлэлцэж байгаа асуудалтайгаа уялдуулаад тухайн үед нь завсарлах цагаа зарлаж тогтох байхаар шийдлээ. Ингэж редакцийн группт санал өгье.

3.

14 дүгээр тойргийн депутат С.Лхагвасүрэн: Би юм тодруул-маар байх юм. Энэ хороод гэдэг угийг улсууд ойлгохгүй байх шиг байгаа юм. Би хувьдаа ингэж ойлгож байгаа юм. Жишээлбэл хэлэлцэж байгаа асуудлаар, жишээлбэл тодруулах шаардлагатай депутатуудын ажлын хэсэг, тусгай комисс гарч магадгүй. Энийг хороод гэж ойлгоод байгаа юм болов уу. Жишээлбэл Засгийн газрын асуудал авч хэлэлцэх, энэ асуудал дээр янз бурийн асуудал гарч магадгүй гэж би дотроо бодоод байна. Тэгэхлээр энийг хороод гэдэг утгаар энд оруулчихсан юм болов уу. Үнэхээр тийм байгаа бол энийг хасахгүй байх нь зүйтэй гэсэн тийм саналтай байна.

326 дугаар тойргийн депутат И.Гомбожав: Энэ салбар хороодыг байгуулах талаар бид дэгийн төсөлд оруулахдаа Үндсэн хуулийн төслийг хэлэлцэхэд их ач холбогдолтой юм. Цаг хэмнэхэд хэрэгтэй юм гэж узсэн юм. Тухайлбал Үндсэн хуулийн 5 бүлэг дээр бүлэг тус бүр дээр хороо байгуулаад салж хуралдаад тэр бүлгүүд дээрээ саналаа яриад суулд нь эндээ нэгтгэвэл олон хүн саналаа илэрхийлэх бололцоотой, нэгтгэн дүгнэх хэрэгтэй гэдэг үндсэн дээр оруулсан. Бусад асуудал дээр салбар хороод байх шаардлагагүй юм. Үндсэн хуулийн төсөл хэлэлцэхэд энэ их хэрэгтэй юм гэж узэж оруулсан юм байгаа юм. Тэрнээс биш энэ бол Бага хурлын байнгын хороотой холбогдолгүй, депутатын булэгтэй холбоогүйгээр хийсэн байгаа.

#### Уртнасан:

За дэгийн төслийг боловсруулсан Ганбаатар бидэнд сая хариу ирүүлж байна. Энэ хоёрдугаар өгүүлбэр дээр салбар хороод гэдэг ямар учиртай уг вэ гэхээр энэ үндсэн хуулийн төслийг боловсруу - лахад нийтдээ бүлэг тус бүрээр салбар хороод болж ажилласан юм байна. Энийг л хэлж байгаа юм байна. Түүнээс биш өөр ямар нэгэн тусгай салбар хороод байхгүй. Энэ үндсэн хуулийн төслийг боловсруулахад энэ бүлэг тус бүр дээр салбар хороод болж ажилласан. Энийг хэлж байгаа юм гэсэн ийм тайлбар ирлээ. Энэ өгүүлбэрийг энд үлдээх үү гэдэг санал байна.

#### Чунагсүрэн:

Салбар хороод, ажлын хэсэг байгуулна гэсэн юм бол тэр хойно үндсэн хуулийг хэлэлцэх үедээ II дүгээр зүйлд байна уу даа, тэрний эцэст байж байгаа. Олон газар хороод байгуулах тухай дэгэнд

оруулах хэрэг алга. Тийм учраас энэ урд талыг хасчихъя гэж ингэж санал гаргасан юм.

Тэгвэл бид санал хураалтаа явуулчихъя. Одоо тодорхой боллоо.

Даргаа, бид нар нэг зөв юм ойлгомоор байх юм. Миний ойлгож байгаа зөв уу, угүй юу.

168 дугаар тойргийн депутат Г.Ванландаагва: Ялангуяа үндсэн хуулийг хэлэлцэх үед бүлэг тус бүрээр нь, одоо ойлгож байгаагаар энийг бэлтгэсэн комисс дээр депутатууд хуваагдаж очиж, тэнд очсон тухайн бүлэг дээр очсон нь тодорхой сайн ойлголттой явж ирээд энд их товчилж хурдавчилсан байдлаар батлах гээд, байна гэж би ингэж ойлгоод энэ хороо хэрэгтгүй гэж би хэлэх гээд байна л даа. Салж хуралдаад буцаад нийлэхээрээ үлдэж байгаа, одоо жишээ нь 80-аад хувь гэдэг юмуу 70-аад хувь нь төдийлэн тийм ул суурьтай энэ асуудалтай танилцах нөхцөл тухайн тэр хэлэлцэж байгаа бүлгийн доторхи аливаа нэгэн жижиг асуудал ч байсан гэсэн. Ингэхээр ийм байдлыг хийх хэрэгтгүй болов уу гэсэн ийм санал байна.

#### Уртнасан:

Баярлалаа. Депутатуудаа.

Тэгэхээр нэгдүгээр зүйлийн 2 дугаар өгүүлбэрийг бидний бодож байгаагаар хасчихаж болмоор юм шиг байна. Депутатууд Чунагсүрэн гуай, Мижид, Баярцогт <sup>Ванландаагва нар</sup> санал гаргалаа. Энэ үнэхээр 9 дүгээр хуудасны хамгийн суулд З-дээр яг энэ заалт байна. Ийм учраас энэ заалтын 2 дугаар өгүүлбэрийг хасъя гэсэн санал оруулж байна. Санал хураалт явуулах уу?

За бэлтгээрэй. Санал хураалт явуулж байна. Энэ 2 дугаар өгүүлбэрийг хасахаар.

Санал өгсөн депутатуудын 91 хувь нь буюу 374 хүн зөвшөөрлөө, 8 хувь буюу 32 хүн татгалзаж, 1 хувь буюу 3 хүн түдгэлзэж байна. Тэгээд энэ өгүүлбэрийг хасъя.

За хоёрдугаар заалт байна. Хоёрдугаар заалт дотроо

## 5.

Дашням:

Тэр 9 дүгээр хуудасных бол ерөөсөө хэлэлцээд бүхэлд нь зөвшөөрсний дараагаар, би бол тэгж ойлгож байгаа юм л даа. Редакцийн маягийн тийм хороо байгуулаад негеөхөө яах юм бэ. Саяных бол арай өөр юм шиг надад ойлгогдох юм. Яг энэ бүлгүүдээр хэлэлцэж байгаа учраас санаа бодлоо нэгтгэх, бас нэг олон юмнууд, тэгэхэд ийм олон хороонууд байгуулж ажиллуулах болтой юм. Тэгэхээр би бол ийм саналтай байна. Энийг санал болгоод саяныхаа хоёрдахь хэсгийг хасахгүй эргүүлээд та нар нэг бodoоч. Нэг олон юм яахгүйгээр тодорхой асуудлаар санал бодлоо нэгтгэх асуудлаар депутатуудын салбар хороо байгуулан ажиллах санал гарган хэлэлцүүлж болно.

**Хороо байгуулна уу, угүй юу.** Тэр юмаар хороо байгуулна гэж байгаа санал нь үнэтэй юмуу, угүй юмуу тэрнийг тухайн үед нь шийдээд өгнө биз.

Ургасан:

Депутат Дашнямд бас тайлбар өгмөөр санагдах байна. Энэ "з" заалт бол Ардын Их Хурал, Их цаазын төслийг бүхэлд нь зөвшөөрсөн нэхцэлд зохих саналын дагуу мэдээж бид хэлэлцэж санал гаргана. Түүнийг зарчмын хувьд өөрчлөх, найруулан засах бүхий хороо гэж байгаа юм. Энэ бол утга агуулга нь багтаж байна гэж ойлгогдож байгаа. Ийм учраас дахин санал хураалт явуулахгүйгээр олонхийн саналаар энийг шийдвэрлэе.

Хоёрдугаар заалтыг үсгийн дугаартай байгаа. Тэгэхээр хоёрдугаар заалтын "а" хэсэг дээр ярья. Энэ тойргийн, энэ бол техникийн асуудал юм. Зөвшөөрөл аваад микрофоны ард очиж тойргийн дугаар, нэрээ хэлж угээ хэлж байгаа үүнтэй урвуу байна гэсэн. Уүнийг редакци залруулчихаж болохоор томъёолол шиг байгаа юм. Энийг ийм засвар хийгээд хэвээр үлдээх уу гэсэн санал байна.

Соронзон хальстай  
тулгаж нийлсэн

Бичээч

ЭНХТУЯА

В.ОЮН

1991-XI-II  
Кассет № 33  
18.35-18.50

### Х.Уртнасан

-Баянменх

депутат хэлсэн, одоогийн манай техникийн зохион байгуулалттай урвуу байна гэж. Бид эхлээд микрофоны дугаар хэлүүлчихээд, дараа нь тойргийн дугаар, нэрээ хэлж байгаа. Энийг редакци, овог

гэдгийг хасчихъя. Ингээд энэ заалтыг үлдээх үү? За санал хураалт явуулъя. Хоёрдугаар заалтын "а" хэсэг. За санал өгсөн депутатуудын 98 хувь буюу 397 хүн зөвшөөрч байна, I хувь буюу 5 хүн татгалзлаа, мөн I хувь буюу 5 хүн түдгэлзэж байна. "А" хэсэг хэвээр үлдлээ. За ихэнх депутатууд хоёрдугаар заалтын "Б" хэсгийг хасъя гэсэн санал ируулж байгаа юм. Энэ үнэхээр "А" заалт байж байгаа нехцэлд илүү юм шиг санагдаж байна. Нэрийн дарааллыг бид авахгүй байгаа, микрофоныг шууд дуудаад ярьж байгаа учраас "Б" заалтыг хасъя гэсэн санал оруулж байна. Санал хураалт явуулъя.

Санал өгсөн депутатуудын 98 хувь нь буюу 397 нь зөвшөөрлөө. Учлаарай энэ санал гараагүй байх шиг байна. За нийт санал өгсөн депутатуудын 95 хувь нь буюу 382 нь зөвшөөрлөө, З хувь буюу 14 хүн татгалзаж байна, I хувь буюу 6 хүн түдгэлзлээ. Тийм учраас энэ заалтыг олонхийн саналаар хасъя. Одоо хоёрдугаар заалтын "в" хэсэг дээр депутатууд санал гаргаагүй. Ийм учраас энэ заалтыг хэвээр үлдээе гэсэн саналыг оруулж байна. Санал хураалт явуулъя.

За хоёрдугаар зүйлийн "в" хэсгийг 97 хувь нь буюу 399 депутат үлдээе гэж байна, 2 хувь буюу 9 хүн татгалзаж, I хувь буюу 4 хүн түдгэлзлээ. Энэ заалт үлдэж байна.

Хоёрдугаар зүйлийн "г" хэсэг. За энэ хэлэлцэж шийдвэрлэх асуудал тус бүр дээр гурван удаа гурван хугацаа заасан. Үүнийг зарим депутатууд нэг удаа болгоё гэсэн санал ирууллээ. Зарим хумуус бид чөлөөтэй ярилцах учраас хугацаа заахгүй ярилцъя гэсэн ийм санал ируулсэн. Ажил хэрэгч чөлөөтэй ярилцъя гэж. Зарим нь энэ хэвээр нь үлдээе гэсэн ийм гурван хувилбар байгаа юм.

Олонхи депутатууд хэвээр үлдээе гэсэн санал ирүүлж байх шиг байна. Ийм учраас хэвээр үлдээе гэснээр санал хураагаад үзэх уу? Хажуугийн санал олонхийн дэмжлэг авч чадахааргүй байна гэж би ойлгосон юм. Гэхдээ депутатууд та бухэн мэдэх биз. Хажуугийн саналыг гэвэл эхлээд бид нэг удаа босч уг хэлнэ гэдэг дээр санал хураалт явуулчихъя. Дараа нь хугацаа заахгүй гэдгээр санал хураалт явуулчихъя гэж бодож байна. Цаг алдахын нэмэр болов уу гэж бодож байна шуу дээ.

Уучлаарай цаг жаахан хожих зорилгоор хэвээр үлдээе гэдэг дээр санал хураалт явуулъя. Санал өгсөн депутатуудын 94 хувь буюу 387 хүн хэвээр үлдээх санал ирүүллээ. 5 хувь буюу 19 хүн татгалзаж байна, 1 хувь буюу 4 хүн түдгэлзлээ. Ийм учраас энэ хоёрдугаар заалтын "Г" хэсэг хэвээр үлдлээ. Редакцид. "Г" хэсэг дээр хүч хэрэглэх гэдэг угэн дээр депутатууд налээн эмзэглэж байгаа. Нэг депутат тайлбарлахдаа үүнийг шууд гар хөл зөрүүлэх хэрэг биш, бусад эвсэл холбоод ямар нэгэн хүч хэрэглэх гэсэн ийм утгаар ойлгох нь зүйтэй гэсэн нэмалт тайлбар өгсөн, тэгэхээр хүч хэрэглэх гэдэг энэ үгийг редакцид хасах буюу редакцийн найруулгад үлдээх гэсэн ийм санал байх шиг байна. Зарим депутатууд ерөөсөө энэ хэсгийг тэр чигээр нь хасчихъя гэсэн ийм санал ирүүлсэн. Тэгэхээр эхлээд энэ заалт байх уу, байхыг зөвшөөрөх уу үгүй юу гэдэг дээр санал хураалт явуулъя. Энэ заалт байх хэрэгтэй юу гэдэг дээр санал хураалт авъя.

Ж.Барамсай /426 дугаар тойргийн депутат / -Би бол ингэж ойлгосон энийг. Тэгэхээр энэн дээр би ингэж ойлгож байна. Хүч хэрэглэхийг бусдад хүч хэрэглэнэ гэсэн маягаар ойлгоод одоо бараг, ер нь завсарлагаанаар зодоо хийх юм уу гэж бодоод байгаа юм. Энэ бол хүч хэрэглэхийг ямар нэгэн хүчинд уриална гэсэн санаа байгаа учраас энэ бол байхад болно гэсэн санаа.

Ж.Уртнасан -Бусдад уриалах гэсэн уг байгаа шуу дээ тиймээ. Энэ заалтыг хэвээр үлдээе гэдэг дээр санал хураалт явуулъя. Санал өгсөн депутатуудын 89 хувь нь буюу 363 хүн энэ заалтыг хэвээр үлдээе гэсэн санал ирүүллээ. 9 хувь буюу 35 хүн тат-

## 3.

галзаж байна. 2 хувь буюу 9 хүн тудгэлзлээ. Энэ заалтыг хэвээр үлдээлээ. За хоёрдугаар заалтын "е" хэсэг дээр депутат Элбэгдорж депутатуудын ердийн олонхийн саналаар гэдэг угийг хасья, харин ингээд хэлэлцэх асуудлын шинж гэдэг дээр <sup>Зарим депутатууд онцлог,</sup> байдлыг харгалзан гэсэн ийм нэмэлт тодотгол оруулж байгаа. Ингээд эхний дөрвөн угийг хасаад, энэ заалтыг хэвээр үлдээх үү? Санал хураалт явуулъя.

Санал өгсөн депутатуудын 78 хувь нь буюу 312 хүн энэ заалтыг хэвээр үлдээх санал орууллаа. 18 хувь нь буюу 73 хүн татгалзаж байна. 4 хувь буюу 17 хүн тудгэлзлээ. Энэ заалтыг олонхийн саналаар хэвээр үлдээж байна. "Ж" заалт дээр хоёр санал байгаа юм.

С.Баярцогт /288 дугаар тойргийн депутат/ -Энэн дээр би нэг санал яг залгуулаад хэлсэн байгаа. Энэ заалттай холбогдуулаад. Их цаазын эцсийн хэлэлцүүлгийн зүйл бурийг, хэрэв техникийн боломжгүй бол булэг бурийг нэрээр хураана гэдгийг яг албан ёсоор энд тохиролцвол зүйтэй юм. Дараа нь хариуцлагын асуудал гэсэн. Их цааз дээр санал хураах талаар юм бол байхгүй байгаа юм л даа. Зарчмынх нь юмнууд.

С.Баяр /I дүгээр тойргийн депутат/ -Даргаа сая "е" заалт огт өөрчлөлтгүй үлдчихлээ тиймээ.

Ж.Уртнасан -"е" заалтад бид нар депутатуудын ердийн олонхийн саналаар гэдэг угийг нь хасахаар...

С.Баяр /I дүгээр тойргийн депутат/ -Ерөөсөө хэвээр үлдлээ л гэж ойлголоо шүү дээ.

Ж.Уртнасан -Тэгвэл редакцид хэвээр үлдээх гэдгээр нь ойлгогдох. Депутат Баярцогтын асуултад хариулахад энэ нэрийн хагсаалтаар авч болно гэсэн тодотгол байгаа шүү дээ. Энээс өөр ямар тодотгол нэммээр байгаа юм бол доо?

4.

Ингээд болох юм биш уу?

С.Баярцогт -Их цаазын эцсийн хэлэлцүүлэг бол гол нь тохирсон, орж ирээд л дандаа санал хураалтаар явах учраас, ихэвчлэн санал хураалтаар явна, зарчмын асуудал дээр хүн бол уг хэлнэ, маш цөөхөн хүн уг хэлэх байх гэж санаж байгаа. Тэгээд тэрийг зарчмын хувьд батлах учраас дандаа нэрээр явчихвал ясан юм бэ гэсэн саналтай байгаа юм. Техникийн боломж байхгүй бол угүй ядаж булгээр. Дандаа нэрээр нь санал хураах.

Ж.Уртнасан -Эрхэм депутат Баярцогтоо би нэг тайлбар хэлэхийг хүсч байна. Энэ манай цахим техник хэдийгээр ил санал хураалтын далд хэлбэр боловч, шаардлагатай гэж узэх юм бол нэр, суудлыг гаргаж ирэх боломжтой. Тийм учраас бид энэн дээр нэг их санаа зовохгүй байж болох болов уу гэж бодож байна.  
Цөөнх угээ хэлэх гэж байна уу?

Ц.Элбэгдорж /427 дугаар тойргийн депутат/ -Депутатуудын ердийн олонхийн саналаар гэдэг энэ дөрвөн угийг хасахын учрыг дахин хэлье. Баярлалаа та бүхэнд, тэгвэл би ойлгосонгүй.

Ж.Уртнасан -Баярлалаа. За цаашаа явъя. Уучлаарай эрхэм депутат Элбэгдоржоо. Та сая энэ дөрвөн угийг хассан гэж ойлгов уу? Хасаагүй хэвээр үлдээсэн гэж ойлгов уу?

Ц.Элбэгдорж -Би хасчихсан гэж ойлгоод баярлаад суулаа л даа.

Ж.Уртнасан -Угүй ээ, энэ олонхи депутатууд хэвээр үлдээнэ гэдгээр нь бид үлдээсэн шүү.

Ц.Элбэгдорж -Хассан гэдгээр санал аваад олонхи нь тэрэн дээр гараад хассан гэж энд байгаа бүх депутатууд тэгж байна л даа. Хасахыг дэмжиж байгаа гэдгээр санал аваад зөвшөөрсөн нь олонхи гараад тэгээд хассан гэж энэ дөрвөн угийг. Би тэгж ойлгосон юм.

5.

Ж.Уртнасан -Тэгвэл одоо энэ хэвээр үлдээс гэсэн нь цөөнх болж байна. Эрхэм депутат Баар тайлбар тавих уу?

С.Баар /I дүгээр тойргийн депутат/ -Би цөөнх биш л дээ. Редакци дээрээ юу гэж оруулахыгаа л учрыг сайн ойлгохгүй байгаа юм. Зүгээр санал хэлэх юм бол энэ депутат Элбэгдоржийн хэлээд байгаа дээр бас юм бий л дээ. Яагаад гэвэл нэрээр хураах тийм тохиолдолд бол мэдээж олонхи нь дэмжихгүй бол нэрээр хураахгүй л тэгээд өнгөрөөд явчихна. Тэгэхдээ энийг дөрвүүлэngий нь энэ дөрвөн уг байна шуу дээ, депутатын ердийн олонхийн саналаар гэдгийг бүр хасаад хаячих юм бол дуртай депутат нь ганц хүн, ерөөсөө би нэрээр хураахыг шаардаж байна гээд ингээд эцэс тэгсгэлгүй юм болох байх. Тийм учраас нэг 30 депутат гэж хэлж байсан шиг санагдаж байх юм. Тиймээ. Энэ дөрвөн угийг хаслаа гэхэд 30-аас доошгүй депутатын шаардлагаар нэрийн жагсаалтаар хурааж болно гэдэг ийм томъёолол байвал болмоор юм шиг санагдаж байгаа юм.

И.Элбэгдорж -Баярын саналыг дэмжиж байна даргаа. 30-аас доошгүй ч гэдэг юм уу, 30 хүртэл гэж байх юм бол болно. Ямар нэгэн тийм хэмжүүр байхгүй бол бас дуртай нь босож ирээд нэрээр санал хураа гээд байх байх.

Ж.Уртнасан -За депутатууд ойлголттой болох шиг боллоо. Ямар нэгэн хэмжүүр байх хэрэгтэй юм шиг байна. Тэгэхээр редакцийн групийн ахлагч Баярын саналаар 30-аас доошгүй гэсэн ийм редакци хийж оруулах уу?

С.Лхагвасүрэн/47-р тойргийн депутат/ -Санал байна. Тэр 30 гэдэг чинь ямар учиртай тоо юм бэ? Тийм учраас энийг тухайн үед нь нэрээр хураах уу угүй юу гэдгийг депутатууд олонхийн саналаар гар өргөж байгаад л шийдчих хэрэгтэй шуу дээ.

Ж.Уртнасан -Ердийн олонхийн гэдгээр уу?

С.Лхагвасүрэн -Ердийн олонхийн гэдэг нь хуучнаараа л байж байг.

6.

С.Баяр /Г дүгээр тойргийн депутат/ -Тэгвэл байгаагаар нь хураалаа гээд бүр протоколд үлдээмээр байна л даа.Дахиад л санал хураалгачихгүй юу даа.

Г.Зуунай / 143-р тойргийн депутат/ -Би энэн дээр ийм санал хэлмээр байна л даа.Яхав олонхи депутатын саналаар нэрээр ил санал хураахдаа хураана биз.Гэхдээ нэрээ ил өгөхийг хүсэж байгаа хүн байвал нэрээ хэлээд бичуулчихдэг, тэрийг нь хавчихгүйгээр, 2 ч хүн бай, 20 ч бай.Тэгвэл ардчилал болох байх.Түүнээс биш хүн хүсэхгүй байхад заавал ил чи саналаа өг гэж нүүрийг нь улайлгаж байж, гарсаа өгч бичуулэх бол бас нөгөө талаасаа ардчиллыг хавчиж байгаа ийм хэлбэр болно.Тийм учраас хүссэн хүн нэрээ ил өгөх эрхтэй, тэгээд олонхийн саналаар өгдөг.Ийм л хувилбар дээр тогтмоор байна.

Соронзон хальстай тулгаж  
нийлсэн

*А.Ч.Манж*

Д.АЛТАНЦЭЦЭГ

Бичээч Уранчимэг

Кассет 34.1991.II.II  
18<sup>50</sup>-19<sup>05</sup>.

Ж.Уртнасан: Хуучин хувилбарыг хэвээр үлдээе гэдэг дээр санал хураалт явуулъя.

Санал өгсөн депутатуудын 83 хувь нь буюу 31 хүн хэвээр үлдээе гэсэн санал ирүүллээ. 14 хувь буюу 56 хүн татгалзаж байна, 3 хувь буюу 13 хүн түдгэлзэж байна.

Энэ хоёрын "е" заалт хэвээр үлдэж байна.

"ж" хэсэг.

427 дугаар тойргийн депутат Ц.Элбэгдорж: Даргаа З дахиа цөөнх болж хэлэхгүй бол болохгүй нь ээ. Сая Зуунайгийн хэлдэг гар өргүүлнэ гэдэг дээр хүмүүс будилчих шиг боллоо.

Энэ коноп дараад юм бүхэн дээр, бидний суудал дээр байгаа бид нарын нэрийг энэ конопонд хийчихсэн байгаа. Тэнд нэр гарангутцаад талд нь принтөр дээр бүх нээрс бичигдээд гарчихна.

Ямар нэгэн байдлаар тэр гар өргө, барь гэсэн юм байхгүй шүү дээ. Техникийг ингэж хийсэн гэж би ойлгож байгаа.

Тэнд ингээд 339 гээд гарахад ар талд нь зөвшөөрсөн дээр 339 депутатуудын нэр, суудал, суудлын гарч бий хийчихсэн байгаа учраас гарна. Тэнд ямар нэгэн гар өргөөд байх юм гарахгүй.

Дараагийн нэг зүйл бол энэ бидний сонгогчид биднийг харж байгаа л даа. Ямар асуудал дээр манай депутат ямар байдлаар хандсан бэ? гэдгийг бид үүнийг шаардлагатай үед нь хэлэх ёстой. Нэрээр, ердийн олонхиор санал хураана гэхээр хүмүүс нээрээр санал хураалгахгүй гэж олонхи нь байгаа тохиолдолд яг санал хурааж байгаа шиг болдог шүү дээ. Бага Хурал дээр ч гэсэн олонхийг авч чаддаггүй. Нэрээр санал хураана гэсэн тухай бүрдээ олонхийг авч чаддаггүй шүү дээ. Тэгэхээр 30-аас доошгүй гэж оруулаад, ямар нэгэн хэмжүүр тавиад, 30-аас доошгүй хүн нь нэрээр санал хураах хүсэлт гаргасан тохиолдолд гээд оруулчих юм бол болно. Техникийн хувьд бүрэн боломжтой, бид нар дахин дахин гарваа өргөөд байх шаардлагагүй. Ийм л юм байгаа. Хэн юны төлөө байсан гэдэг нь Их цааз, энэ бүх хариуцлагатай асуудал дээр байх ёстой л доо.

Ж.Уртнасан: Эрхэм депутат Элбэгдорж оо, тэгэхээр бид нэгэнт энэ принтерт нэр байгаа учраас шаардлагатай гэж үзвэл шаардаад бид нэрээ, саналаа өгсөн тэр нэрээ тодотгуулаад тодотгол хийлгэж болох биш уу. Тийм боломж байна шүү дээ.

Ц.Элбэгдорж: Тийм боломж байхгүй л дээ. Заримдаа нэрээр санал хурааж байхыг зөвшөөрч байгаа, зарим хэсэг нь нэрээр гаргахыг хүснэ, зарим хэсэг нь нэрээр гаргахыг хүсэхгүй. Тэгэхээр энэ техник чинь өөрөө ялгахгүй шүү дээ. Тэгвэл заавал гар өргөхөд л хүрнэ. Нэрээр санал хураана гэдэг дээр ирц гэдэг дээр дараад бид нар хураадаг шүү дээ.

Ж.Уртнасан: Энэ хэсгийг дараагийн редакцийн дараагийн танилцуулга хүртэл нээлттэй үлдээе. Бодох боломж бидэнд байх шиг байна.

"ж" хэсэг дээр эсрэг, тэсрэг хоёр санал байгаа юм. Нэг хэсэг нь хэвээр үлдээе гэж байгаа, нэг нь хасъя гэсэн санал ирүүлж байгаа. Тэгэхээр хажуугийн саналыг түрүүлж авч хэлэлцье. Энд бид хэвээр үлдээнэ. Одоо энэ "ж" хэсгийг хасъя гэдэг дээр санал хураалт явуулъя.

Санал хураалтанд бэлтгээрэй. Энд бид хажуугийн саналыг чухалчилж авч үзсэн. Гэтэл хажуугийн саналыг зөвшөөрсөн 171 депутат буюу 44 хувь, татгалзсан нь 202 депутат буюу 51 хувь, ийм учраас тэр санал хэвээр үлдэж байна. Түдгэлzsэн 6 хувь буюу 23 хүн байна.

"ж" заалт дээр татгалзана гэдэг маань хэвээр үлдэнэ гэсэн уг шүү дээ.

Цаашаа явъя. "з" заалт. "з" заалтан дээр санал тараагуй, тийм учраас хэвээр үлдээх.

Ц.Элбэгдорж: /427 дугаар тойрог/ Санал гарсан. Даргаа миний санал байгаа. Хийлгэж болно гэдгээр орхиё. Бүх депутатууд

хэлэлцэж байгаа асуудлаар тодорхой санал гаргах эрхтэй. Уүнийг ямар нэгэн байдлаар хоръж болохгүй.

Ж.Уртнасан: Учлаарай, Элбэгдорж оо яалаа гэнээ?

Ц.Элбэгдорж: Санал гаргаж түүн дээрээ санал хураалгах буюу хэлэлцүүлэг хийлгэж болно гэж. Депутатууд чөлөөтэй санал гаргаад түүн дээрээ хэлэлцүүлэг хийлгэж болно. Түүнийг ердийн олонхийн санал заавал авч байж, дараагаар нь санал гаргана гэсэн ийм юм байхгүй.

Депутатууд өөрсдөө санал гаргах эрхтэй, тэр эрх нь чөлөөтэй байх ёстой гэсэн юм байгаа. Ар талд нь хаачихсан байгаа шуу дээ. Ердийн олонхи зөвшөөрсөн тохиолдолд гээд.

Ж.Уртнасан: Энэ редакцийн чанартай засвар юм. Өөрийнхөө хувилбарыг манай редакцийн группт өгөхийг Элбэгдорж депутатаас хүсье.

Ингээд энэ редакцид найруулан зассан хувилбараар энэ заалтыг үлдээх санал хураалт явуулъя.

Элбэгдоржийн хийх редакцийг хүлээн авч энд засвар орууља. Тэгээд үлдээе.

79 хувь буюу 316 депутатын саналыг зөвшөөрч байна, 17 хувь буюу 69 депутат нь татгалзлаа, 4 хувь буюу 14 хүн түдгэлзэж байна. Элбэгдоржийн редакцийг авч нэмээд, заалт хэвээрээ үлдэнэ гэсэн уг.

Т.дүгээр тойргийн депутат С.Баяр: Элбэгдоржийн редакци ямар ч байсан гэсэн тусгах ийм үүрэг редакцийн комисс хүлээж байна гэж ойлгож болох уу?

Ж.Уртнасан: Баяраа, Гурван үгийн засвар л байна шуу дээ.

С.Баяр: Даргаа, жаахан тодорхой байхгүй бол редакцийн комисс хэцүү л болно л доо.

9 дүгээр тойргийн депутат С.Зориг:

Би ойлгосноор бол Элбэгдоржийн засварыг оруулбал би жишээ нь дэгийг дахиад эхнээс нь хэлэлцье гээд санал гаргавал хэлэлцэх нь байна шуу дээ. Яагаад гэвэл олонхи нь зөвшөөрөөгүй байхад дуртай саналыг хэлэлцье гэж байгаа шуу дээ. Тэгвэл би санал гаргана шуу дээ, дэгийг дахиад эхнээс нь явъя.

Ж.Уртнасан: Хэлэлчүүлэг хийлгэж болно гэж зассан шуу дээ.

С.Зориг: Санал авахгүй болно гэвэл тэр чинь би одоо шаардаад зогсчихно шуу дээ. Миний саналыг хэлэлц, дэгийг эхнээс нь хэлэлцье гээд.

1 дүгээр тойргийн депутат С.Баяр:

Байгаагаар нь санал хураагаад үзээч.

133 дугаар тойргийн депутат Ц.Нанзаддорж:

Хэрвээ энэ "д" заалтыг тэгж хэвээр нь, хуучин вариантаас нь өөрчлөх юм бол хурал дахиад эхлэх нь байна. Ингэж ойлгоод байна. Ийм учраас үүнийг цөөнх нь байгаа, би тэр цөөнх. Тийм учраас дахин санал хураах хэрэгтэй байна.

369 дүгээр тойргийн депутат Л.Пүрэвдорж:

Тэгэхээр та Элбэгдоржийн гаргасан санаа, олонхи депутатуудын санаа хоёрын зааг ялгааг ойлгомжгүй хэлж санал явуулсан учраас хүмүүс будилаад байна. Энэ зааг ялгааг депутат нөхөр Зориг тодорхой гаргалаа гэж бодож байна.

1 дүгээр тойргийн депутат С.Баяр:

Хэвээр нь үлдээе гэдэг дээр санал хураачихаач дээ.

Ж.Уртнасан: Тэгвэл бид ийм хувилбар дээр санал хураая.

18 дугаар тойргийн депутат Г.Ганболд: Энэ буруу ойлголцол явчих вуу гэж би ойлгож байна шүү дээ. Элбэгдорж хэлэхдээ, тэртэй, тэргүй бид нар дэгийн I дүгээр булэгт, аливаа асуудлыг хуралдаанд оролцсон нийт депутатын ердийн олонхийн саналаар шийдвэрлэнэ гэдэг ерөнхий заалт тавьчихсан учраас, депутатынх нь эрх байна, энэ асуудлыг оруулж хэлэлцүүлнэ, ердийн олонхи нэгэнт шийдчих юм бол одоо хэлэлцүүлэх эрхтэй болох юмаа гэж хэллээ гэж ойлгосон. Түүнээс биш хэлсэн л бол хэлэлцүүлнэ гэж ойлгоогүй шүү дээ.

Яагаад гэвэл энэ I дүгээр зүйл дээр, аливаа асуудлыг ердийн олонхиор шийднэ гэсэн ерөнхий заалт байгаа шүү. I дүгээр хуралдааны зарчим гэдэг дээр..

427 дугаар тойргийн депутат Н.Элбэгдорж: Харин тэр Ганболдын саналаар л нэгдүгээр зүйл дээр ердийн олонхи гэж байгаа учраас ингээд байгаа юм л даа. Тэгвэл яах вэ үүнийгээ дахиад давтаад хэлээрэй гэж болох л юм.

18 дугаар тойргийн депутат Г.Ганболд: Хүн санал хэлээд л тэр саналын дагуу яваад байдаг юм байж болохгүй шүү дээ. Тэртэй, тэргүй тэр саналыг Их Хурлын танхимд сууж байгаа депутатууд хэлэлцэж, шийдваж таарна. Хэлэлцүүлэх үү, үгүй юу? гэдэг. Би тэгж ойлгосон.

328 дугаар тойргийн депутат Б.Дашзвэг: Энэ Ганболдын хэлж байгаа I дүгээр бүлэг дээр "ердийн" гэдгийг хасчихсан шүү дээ. Тэгээд одоо ахиад тэнд байж байна гэж худлаа ярж болохгүй шүү дээ. Хасаад үүнийг баталчихсан шүү дээ.

I дүгээр тойргийн депутат С.Баяр: Тэгэхээр сая депутат Элбэгдорж ирж редакция узүүллээ л дээ. Тэгэхээр энэ зарчмын асуудал юм л даа. Бид нар бас дутуу ойлгоод байх шиг байна. Зөвхөн хийлгэж болноо гээд үлдээчих юм бол энэ асуудлын нэг тал нь үлдчихээд байгаа юм. Депутат санал гаргах. Гарсан саналыг

хархэх вэ гэдэг шийддэг механизмыг нь хасчихаад байна л даа. Тийм учраас энэ санал гаргах эрх нь үлдэж байгаа юм. Гэхдээ чухам аль тэр асуудлыг хэлэлцэх үү? Үгүй юу гэдгийг ердийн олонхи зөвшөөрсөн тохиолдолд гэдгийг заавал үлдээх нь зарчмын ач холбогдолтой. Тэгэхгүй бол дуртай юмаараа хүн асуудлыг депутат Зоригийн хэлсэн шиг, дэгээ эхнээс нь хэлэлцье гэх юм бол тэгээд яваад өгөх нь байна шуу дээ.

Тийм учраас энэ заалтыг хэвээр нь үлдээх дээр санал хурааж өгөөч ээ гэсэн тийм хүсэлт байна.

Ж.Уртнасан: Баярлалаа. Бид цөөнхийн тайлбарыг сонслоо. Болно гэж засчихаад бусдыг нь хасах нэг санал байгаа юм. Болно гэчихээд болно биш болох бөгөөд гээд цаашаа явж байгаа нэг санал байгаа юм. Тэгэхээр редакцийн комиссын гишууд, олонхи гишууд ер нь үүнийг хуучнаар нь үлдээх нь зүйтэй юмаа гэсэн ийм санал оруулж байх шиг байна. Энэ дээр санал хураалт явуулъя. Энэ заалтыг яг хуучнаар нь үлдээе гэдэг дээр санал хураалт явуулъя.

Санал өгсөн депутатуудын 95 хувь нь буюу 387 хүн энэ саналыг зөвшөөрч байна, 3 хувь буюу 13 хүн татгалзлаа, 2 хувь буюу 7 хүн түдгэлзэж байна. Энэ заалтыг хэвээр үлдээхээр боллоо.

Дараагийн "и" заалт.

I дүгээр тойргийн депутат С.Баяр: I дүгээр бүлгээ дуусгачихаад завсарлай.

Ж.Уртнасан: Депутатууд аа, дахин нэг санал хураалт явуулъя. Бидэнд энэ бүлгийг дуусгахад цөөхөн минутын хугацаа үлдсэн болов уу гэж бодож байна. Хэрэв та бүгдийг зөвшөөрвэл 2 дугаар бүлэг хүртэл хэлэлцихээд явбал ямар вэ? Энэ дээр санал хураалт явуулъя.

32 дугаар тойргийн депутат Л.Мандах: Хурлын даргаа энэ дээр зөвшөөрөл хүсч байна. Саяны санал хураасан заалтан дээр. Би энд найруулгын чанартай юм хэлэхгүй бол болохгүй байна л даа. Хэлэх уу?

Ж.Уртнасан: Энд санал хураалт явуулчихлаа шүү дээ, Мандах аа!

Л.Мандах: /32 дугаар тойрог/

Энд чинь ийм болчилоод байна шүү дээ. Нэгэнтээ тэр депутат чинь санал гаргаад, саналаа хураалгах юм уу? хэлэлцүүлгээ хийлгэж болно гэж өхлээд хэлчихээд байна шүү дээ. Өөрөөр хэлбэл өрдийн олонхийн санал авсны дараа хэлэлцүүлэг хийлгэх биш, хэлэлцүүлэг хийлгэж болно гэж байгаа. Харин депутатуудын олонхи нь зөвшөөрснөөр л дарга удирдах нь байна шүү дээ. Тийм утгатай болчилоод байна шүү дээ, наадах чинь. Утга нь тийм байгаа биз дээ. Зөвхөн хэлэлцүүлэг хийхдээ олонхийн санал авах бишээ, өхлээд хэлэлцүүлгээ хийлгэчихнэ биз, санал гаргасан хүн чинь. Тэгээд дараа нь зөвхөн олонхийн саналаар дарга удирдах утгатай өгүүлбэр баталчихлаа шүү дээ, яг хэвээрээ бол. Би тийм найруулгын чанартай юм хэлэх гээд байна.

1 дүгээр тойргийн депутат С.Баяр: Саяны депутат өөрийнхөө саналыг редакцийн комисст өгчихэж болно шүү дээ. Энд редакцийн хармаар юмнууд байна.

Ж.Уртнасан: Депутат Мандах өөрийнхөө хувилбарыг депутат Баярт өгөөрэй гэж хүсч байна.


Та бүгдээс нэг санал хураалт явуулъя. Хэрвээ бид дэгээ хатуу баръя гэвэл одоо ингээд завсарлахад бэлэн байна. Ялихгүй юм үлдэж дээ, нэг булгийг дуусгая гэвэл бид хэлэлчихмээр байна. Энэ булгийг дуусгая гэдэг санал хураалт явуулъя. Санал хураалтанд бэлтгэе. Үргэлжлүүлээд дуусгачихъя. Бага хугацаа үлдэх байх.

За баярлалаа, их ажил хэрэгч байгаа юм байна. 78 хувь нь энэ хоёрдугаар булэг хуртэл явъя гэж санал ирүүллээ.

8.

ЗІ6 депутат. 21 хувь буюу 83 хүн татгалзлаа, 1 хувь 4 хүн  
түдгэлзэж байна. Тэгэхээр энэ 1 дүгээр бүлгээ дуусгачиаад  
завсарлай.

Соронзон бичлэгтэй  
тулгаж нийлсэн



Д.ЧУЛУУНЦЭГ

Бичээч Д.Цэндсүрэн

1991.XI.II.

Кассет № 35

19.05-19.20.

Ж.Уртнасан -Ийм заалт дээр нэг их санал гарсангүй. Ганцхан хүний хасая гэсэн санал байна. Тэхээр хажуугийн саналыг мөрдлөгө болгож байгаа учраас энэ заалтыг хасая гэдэг санал дээр санал хураалт явуулъя.

62 буюу 241 хүн зөвшөөрч хасая гэсэн санал ирүүлжээ. 37 хувь буюу 148 хүн татгалзаж байна. З хувь буюу 13 хүн түдгэлзэж байна. Бид сая хасая гэсэн санал хураалт явуулсан шүү дээ. Цөөнх үгээ хэлж болно.

Ц.Өөлд /235-р тойргийн депутат/: -Хэрэв энэ заалтыг хасвал тэр илтгэгч хүн нь хоёр цаг ч илтгэж болох тийм чөлөөтэй болох юм. Тийм учраас энэ заалтыг хэвээр үлдээх талаар санал хурааж өгнө үү гэж эрхэм даргаас хүсэж байна.

Ж.Гомбожав /326-р тойргийн депутат/: -Үүнийг манай депутатууд бодохдоо одоо тараасан илтгэлүүдийг бодох шиг боллоо. Үнээс гадна илтгэлүүд орж ирэх ёстой шүү дээ. Жишээ нь Дээд шүүх, Прокурорын "алт, диллерийн" асуудал байна. Энэ нь урьдчилан цагт хязгаарлах хэрэгтэй байх. Хэрэв тэгэхгүй бол хичнээн цагаар ярьж болно шүү дээ. Тиймээс энэ заалтыг хэвээр байлгах саналтай байна.

Ж.Уртнасан -Эрхэм депутатууд аа! үүн дээр гоомой хандсан байж болох юм. Энэ нь үнэхээр бидний хөтөлбөр, дэгэнд бичигдээгүй, заагдаагүй хавсралт илтгэл орж ирэхээр болвол түүний хугацаа, илтгэлийн нэрийг бид урьдчилан тогтох шаардлага байх шиг байна. Тийм учраас үүнийг нээлттэй, энэ чигээр нь үлдээх нь илүү хувилбар болох юм биш байгаа гэсэн сэтгэгдэл төрж байна. Тийм учраас дахин цөөнхийн саналыг сонссны үндсэн дээр дахин саналхураалт явуулъя.

"и" заалтыг хэвээр үлдээе гэсэн дээр санал хураалт явуулж байна.

Баярлалаа, депутатууд зөв ойлгосон юм шиг байна.

80 хувь буюу 326 хүн хэвээр үлдээх санал ирүүллээ. 18 хувь буюу 75 хүн татгалзаж байна. Хоёр хувь буюу 8 хүн зөвшөөрлөө. Ингээд энэ заалгаа хэвээр үлдээе.

"к" заалт нь мөн үүнтэй адил юм. Хэрэв ямар нэгэн тайлбар тавихгүй бол бидэнд ирсэн саналаар, нэг сөрөг санал бол үүнийг хасчихъя гэсэн санал ирсэн. Үүн дээр нэмэгзваалт байгаа. Бид хажуугийн саналыг харгалзан уздэг учраас "к" заалтыг хасая гэдэг дээр санал хураалт явуулж байна.

Энэ заалтыг 35 хувь буюу 140 хүн зөвшөөрч байна. 248 хүн буюу 62 хувь нь татгалзаж байгаа учраас энэ заалт хэвээр үлдлээ.

"л" заалтын" нийтэд "гэсэн угийг редакц хийж хасая гэсэн зарим депутатуудын санал ирсэн байна. "Ардын Их Хурлын хуралдаанд оролцож байгаа депутатуудад" гэсэн уг нэмье гэсэн редакцийн чанартай засвар ирсэн байна. Мөн "Байгууллага, хамт олон" гэсэн угийг нэмье гэсэн редакцийн чанартай засварууд байна. Энэ засваруудыг нь хийгээд хэвээр үлдээхээр санал хураах уу?

Редакцийн чанартай засварыг Баярт даатгаад, энэ заалтыг хэвээр үлдээх санал хурааж байна.

96 хувь нь зөвшөөрч, 389 саналаа өглөө. З хувь буюу 14 хүн татгалзаж, 1 хувь буюу 3 хүн тудгэлzsэн байна.

С.Баяр/1-р тойргийн депутат/ -Их Хурлын даргаа, "м" заалт руу орохоос өмнө, энэ нь сая батлагдчихлаа. Гэхдээ редакцийн гэсэн зүйлийг хаана, хаанаа бид зөв ойлголтой баймаар байна. Та күг редакц гэж үзэж байна вэ? Энд өргөдөл, мэдээлэл, бусад асуудлыг хуралдаан даргалагч зохицуулж,

3.

нийтэд зарлаж сонсгоно гэсэн редакц хийхийг хэлж байна уу, эсвэл өөр юм хэлж байна уу?

Ж.Уртнасан "Нийтэд" гэдэг уг нь учир дутагдалтай байна гэсэн учраас үүнийг хасая гэж байгаа шүү дээ. Дараа нь Их Хурлын хуралдаанд орж байгаа депутатуудад гэсэн редакц хийх юм. Байгууллага, хамт олон гэсэн үгийг оруулаад, нийтэд гэсэн үгийг хасая.

"м" заалт дээр ямар ч санал гараагүй учраас би депутатуудыг зөвшөөрч байна гэж ойлгож байна. Үүн дээр хэвээр үлдээе гэсэн дээр санал хураалт явуулъя.

99 хувь буюу 403 депутат зөвшөөрлөө. I хувь буюу З депутат татгалзаж, 0 хувь буюу I хүн түдгэлзсэн байна.

Ц.Нанзаддорж /133-р тойргийн депутат/ Их Хурлын даргаа, цөөн хэлье. Өргөдөл гэдгийг Их Хурал авч хэлэлцээд байх юм уу. Янз бурийн өргөдөл Их хуралд орж ирээд бид үүнийг хэлэлцээд сууж ~~байх~~ юм уу. Өргөдөл гэсэн үгэн дээр их анхаармаар байна. Хэлцэнэ гэж байгаа шүү дээ.

Ж.Уртнасан -Депутатууд аа! анхаарлаа төвлөрүүлье. Дараагийн заалт "н" дээр гурван санал байгаа юм. Эдд бичсэнээр Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч хоёр хэзээ ч уг хэлж болно гэсэн. Гэтэл гурван хувилбар ~~байна~~. Зөвхөн Ерөнхийлөгчийг уг хэлэхийг зөвшөөрч байгаа юм. Мөн Хоёрдахь хувилбар нь Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгчийг зөвшөөрөө гэсэн хоёрдахь хувилбар байгаа юм. Дээр нь гурав дахь хувилбар нь Ерөнхий сайдыг нэмэж байгаа юм. Ийм гурван хувилбарын санал байна.

Депутатууд аа! санал хураалтандаа бэлтгээ. Тэхээр хуучин бичсэн хувилбар дээр нэмэгдэх санал бол Ерөнхий сайд гэсэн уг нэмэгдсэн учраас хажуугийн саналыг Ерөнхий сайд, Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч хэзээ ч уг хэлж болно гэсэн хувилбараар орууљя гэж бодож байна.

С.Баар -Эхлээд Ерөнхийлөгч, дараа нь Дэд Ерөнхийлөгчийг нэмээд, дээр нь Ерөнхий сайдыг нэмээд ингээд гурван хувилбараар орууља.

Ш.Уртнасан -Цаг хожихын тулд энэ гурвыг салгаад санал хураавал амархан болох юм шиг байна.

Ерөнхийлөгч хэзээ ч уг хэлж болно гэдгээр санал хураалт явууља.

Санал өгсөн депутатуудын 90 хувь буюу 367 хүн зөвшөөрч байна. 9 хувь буюу 37 хүн татгалзаж, 1 хувь буюу 6 хүн тудгэлзлээ.

Хоёрдахь санал хураалтандaa бэлтгэнэ уу. Дэд ерөнхийлөгч хэзээ ч уг хэлж болно гэдэг дээр санал хураалт явууља.

Үн дээр 28 хувь буюу II3 хүн зөвшөөрч, мөн 69 хувь буюу 280 хүн татгалзаж байна. З хувь буюу II депутат тудгэлзжээ.

Л.Пүрэвдорж/27-р тойргийн депутат/ -Үн дээр Дэд ерөнхийлөгч гэж орчихоод байгаа юм аа.

Ш.Уртнасан -Уучлаарай, Пүрэвдорж гуай, та тойргийн дугаар, нэрээ, тэхдээ хоёрдахь санал хураалт дээр цөөнх болж байгаас саналаа хэлж байна гэж ойлгох уу?

Л.Пүрэвдорж -Тийм ээ, үн дээр Дэд ерөнхийлөгч гээд орчихсон байгаа юм. Тэхээр Их цаазын төсөл хэлэлцэж байхад өргөн барьсан Бага Хурлын даргыг өрдөө гурван удаа уг хэлүүлээд, дуугуй суулгаад бид хэлэлцээд байх нь л дээ. Зүйл бур дээр уг хэлж тайлбар хийх асуудал гарч мэднэ шүү дээ. Би нэгд тийм л юм бодож байна.

5.

Ж.Уртнасан -Хэрэв бид буруу ойлгож байгаа бол саналаа солицдоё. Нэгэнт Их цаазын төслийг хэлэлцүүлж байгаа нехцэлд хэлэлцүүлэхээр оруулж байгаа хүн нь Дэд ерөнхийлөгч учраас тэр хүн чөлөөтэй хэлж, хариулж болох байх. Хэлэлцүүлэх асуудал өөр юм.

С.Зориг /9-р тойргийн депутат/ -Би эрхэм депутатуудад нэг зүйлийг сануулмаар байна. Та нар өөрсдөө дэг журам, сахилга алга байна гэж яриад байдаг. Гэтэл өөрсдөө сонгогдсон Бага Хурлын даргын уг хэлэх эрхийг нь хасах гээд байна шүү дээ. Ижилсүүлж авч үзэх ямар ч нехцэл байхгүй. Хэрэв та нар журамтай байя гэвэл сонгосон Ерөнхийлөгчөө, чөлөөт цагт нь ордог Дэд ерөнхийлөгчээ хэзээ ч уг хэлэх зөвшөөрлийг нь олгох ёстой. Ингэж байж журам тогтохоос биш, өөрсдөө замбараагуйтээд байвал журам хэзээч тогтохгүй.

Ж.Уртнасан -Бид цөөнхийн саналыг сонслоо. Тийм учраас бид цөөнхөө хундэтгэж, дахин санал хураалт явуулья. Дэд Ерөнхийлөгчийг хэзээч уг хэлж болно гэдэг дээр санал хураалт явуулж байна.

Санал хөдлөгөөнгүй байна. 26 хувь буюу 106 хүн зөвшөөрлөө. 283 хувь буюу 70 хүн татгалзаж байна. З хувь буюу 14 хүн түдгэлзлээ.

Гурав дахь санал хураалтанд бэлтгэлэнүү. Үүн дээр хажуугийн санал Ерөнхий сайдыг нэмсэн байна. Ерөнхий сайд хэзээ ч уг хэлж болно гэсэн дээр санал хураалт явуулья.

Ерөнхий сайдыг 33 хувь буюу 129 хүн зөвшөөрч, 66 хувь буюу 266 хүн татгалзаж, 2 хувь буюу 8 хүн түдгэлзлээ. Тийм учраас Ерөнхийлөгч хэзээ ч уг хэлж болно гэсэн хувилбараар үлдэх нээ.

Цөөнхийн саналыг дахин сонсьё. Үндсэн хууль хэлэлцэх үед энэ нь хамаarahгүй асуудал гэж бид ойлгож байгаа шүү дээ.

6.

- Э.Бат-Үүл /52-р тойргийн депутат/-Зоригийн санал дээр депутатууд анхаарлаа хандуулаач ээ. Депутатууд өнөөдөр Дэд өрөнхийлөгчөө өөрсөдтгэйгээ, нэг хувь депутат-тай адилтгаж үзнэ гэдэг нь дэндэж байна шүү дээ. Түрүүнд бид үүгээр сонгууль хийсэн шүү дээ. Үндсэн хууль дээр энэ нь байж байгаа шүү дээ. Бид тэхээр Монголын төрийн бодлогыг илэрхийлж, улс төрийн бодлогод гол үүрэг гүйцэтгээд байгаа хүнээ бид ...

Өнөөдөр бид олон түмэнд юу харуулж байгаа юм бэ? Түрүүний чуулган дээр бид сонгочихсон шүү дээ.

Соронзон хальстай  
тулгаж нийлсэн

*Ж.Баяржавын*

Л.БАЯРМАА

Бичээч

С.ТУУЛ

Кассет 36  
I991-XI-II  
I9.20-I9.35

Ардын Их Хурлын 52 дугаар тойргийн депутат Э.Бат-уул:  
 -Үндсэн хуулиа хараачээ.Үндсэн хуулийнхээ нэмэлтийг хараачээ.Энэ чинь дэндүү будуулэг зүйл болно шуу дээ.  
 Наадахь чинь хоёр танхимтай гэж одоо их ярьдаг, тэгвэл хоёр танхимтай, нэг танхимт чинь спикер палат байж байна шуу дээ. Тэрийгээ бид нар чинь ямар ч уг хэлэх эрхгүй болгож байна гэдэг чинь арай дэндэж байна шуу дээ.Угүй угүй, чөлөөтэй, энэ чинь Дэд ерөнхийлөгчийнхээ хувьд эрхээрээ чөлөөтэй уг хэлэх ёстой шуу дээ.Яагаад гэвэл бидний хэлэлцэж байгаа асуудал чинь улс төрийн, төрийн бодлогын асуудал явж байгаа гэдгийг депутатууд ойлгомоор байна.

Ардын Их Хурлын 280 дугаар тойргийн депутат Ш.Цэндбаяр:  
 Тэгэхлээр би цөөнх санаалаа хэлье.Саяны тэр томъёололд Ерөнхий сайдыг оруулах ёстой байсан.Гэхдээ ар талд нь хаалтан дотор Засгийн газрын тайланг хэлэлцэх үед гэж ингэж оруулбал ямар вэ?

Ардын Их Хурлын 178 дугаар тойргийн депутат Д.Энхбаатар :  
 Тэгэхлээр энэ Дэд Ерөнхийлөгч бол бас дуртай цагтаа уг хэлэх эрхтэй хүн байгаа юм. Яагаад гэвэл бид нар ингэж ойлгоод байна л даа.Адилхан депутат хүн учраас бидэнтэй адилхан уг хэлэх ёстой гэж.Тэгэхээр энэ хүн бол адилхан депутат биш, 430 бидний адилхан депутат дундаас бид нар өөрснөө сонгоод гаргачихсан хүн.Ерөнхийлөгчийг бид адилхан тэгж гаргасан шуу дээ.Тийм учраас энэ хүн жирийн депутаттай адилхан ёстой хүн биш.Бид нар өөрсдөө сонгоод энэ хүнийг чинь гаргачихсан.Тийм учраас дуртай цагтаа уг хэлэх эрхтэй гэж бодож байна.

Ардын Их Хурлын 41 дүгээр тойргийн депутат Н.Пүрэвдорж:  
 Нэг асуудал байна аа.Бид ахиад замбараагүй байдалд орж эхэллээ.Юүн дээр гэхлээр.Их Хуралдаа Бага Хурал тавих гэж байгаа юм уу? Эсвэл депутатууд чинь Дэд Ерөнхийлөгчдөө

## 2.

тайлан тавих гээд байгаа юм уу гэж ойлгогдож байна. Тэгэхлээр өнөөдөр Их Хурлаар Ерөнхийлөгчийн тайлан, Дэд Ерөнхийлөгчийн тайлан, Их Хурлын энэ хурлын дэгийн асуудал чинь өөр асуудал шүү. Тийм ээ. Бага Хурлын үйл ажиллагаа чинь томилогдсон үүднээс сээ бас нэг өөр асуудал. Их Хуралд орж ирчихээд, энэ дээр онцгой эрх өдэлнэ гээд байвал энэ чинь хууль зүйн үүднээс ямар байна аа?

-Энэ олонхийн санал уу, цөөнхийн санал уу?

Н.Пүрэвдорж:- Ер нь зүгээр энэнийг анхаарах. Тийм учраас ю гэж байна гэхлээр өрөөсөө тэртээ тэргүй тэр уг хэлэх эрхийг чинь бид чадахгүй шүү дээ. Тийм ээ. Ороод хэлдэг журмаараа хэлнэ, тайлбараа өгнө. Тэрэн дээр заавал хардаж сэргээд негеэ Дэд Ерөнхийлөгч, Ерөнхийлөгчийг уг хэлүүлэхгүй гээд хартай байлаар депутатууд хандаад байж болохгүй. Их Хурал гэдэг чинь өнөөдөр бүрэн эрхтэй байгууллага шүү.

Ардын Их Хурлын 45 дугаар тойргийн депутат М.Энхсайхан:- Энэ дээр нэг ийм асуудал байгаа юм аа. Бид нар депутаттай зэрэгцүүлэх үү Дэд Ерөнхийлөгчийг энэ тэр гэж ярихын хэрэггүй байх. Манай Дэд Ерөнхийлөгч ийм эрхийн төлөө хөөцөлдөхгүй, гэхдээ зүгээр энд асуудал ийм байна. Гэхдээ зүгээр Үндсэн хуулийн асуудал ярихад Бага Хурал өөрөө боловсруулж өргөн барьж байгаа учраас Дэд Ерөнхийлөгч уг хэлэхээс өөр арга байхгүй, Бага Хурлын тайлан ярихад Дэд Ерөнхийлөгч өөрөө Бага Хурлын даргын хувьд байн босч юм ярих хэрэгтэй болно. Засгийн газрын асуудал ярихын хувьд бол Бага Хурал Засгийн газрыг эмхлэн байгуулсны хувьд Засгийн газрын асуудал яригдаж байхад мөн Бага Хурлын дарга босч элдэвийн асуудал ярих хэрэгтэй болно. Энэ утгаараа гэх юм бол өрөөсөө өнөөдөр Их Хурлаар хэлэлцэх бух асуудлууд дотор Бага Хурлын даргын босч ярих юм зөндөө бий. Тийм учраас энэ дээр бид нар хэн нь дээрээ, доороо энэ бол бараг хүүхдийн шахуу асуудал яригдаад байна үнэндээ. Тийм учраас зүгээр ямар асуудал хэлэлцэх гэж байгаа бил ээ. Хэн хэнийгээ байгуулсан билээ гэдэг талаасаа хандах юм бол

## 3.

Бага Хурлын даргынхаа хувьд, Дэд Ерөнхийлөгчийнхөө хувьд хэээечч босч уг хэлэх өрхтэй байх нь зүйтэй юм аа гэж бодож байна.

Ардын Их Хурлын З дугаар тойргийн депутат Р.Барсболл:  
 -Би их товчхон ярья. Арай жаахан өөр талаас нь яримаар байх юм аа. Дэглэлт гэдэг бол хязгаарлалт, хязгаарлалт бол энэ үүднээс авч үзэх юм бол бид манай төрийн дээд ~~хувшигд~~ байгаа цөөхөн хэдэн хунийг нэг их сурхий хязгаарлах гэж оролдоод хэрэггүй болов уу гэж бодож байна. Хундэтгэлийн үүднээс авч үзэх юм бол Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч, Ерөнхий сайд Ч.гэсэн ийм хуралдааны үед уг хэлэх зүй ёсны хэрэг байх гэж бодож байна. Хязгаарлалтгүйгээр. Ийм ч учраас би бол ингэмээр байна. Ерөөсөө хасъя. Тэр "м" гэсэн зүйлийнхээ "м"-ийг бурмсөн хасъя. Холбогдох асуудлаар тухайн үед нь энэ гурван хүн гүйцэд угээ хэлэг ээ.

Ардын Их Хурлын 428 дугаар тойргийн депутат Д.Ганболл:  
 -Тэгэхээр энд би ганцхан л үндэслэл хэлье л дээ. Өнөөдөр Дэд Ерөнхийлөгч бол Ерөнхийлөгчийг өнөөдөр эзгүй байхад орлох ийм бүрэн өрхтэй хүн. Бид нар бодоод үзэхэд шууд ойлгомжтой байгаа шүдээ. Хэрэв Дэд Ерөнхийлөгч маань өнөөдөр Ерөнхийлөгчийг эзгүй байхад Ардын Их Хурлын хуралдаан дээр сууж байх юм бол энэ бол Ерөнхийлөгчийн эрх, ургийг авна. Тэгэхээр энэ хүн дуртай цагтаа тэр үед уг хэлэх эрх нь бас байхгүй байх нь л дээ. Ийм парадэкс болох гээд байхгүй ю. Тийм учраас Дэд Ерөнхийлөгч хэдийд ч уг хэлэх эрх нь байж байх ёстой. Энэ хүн бол Ерөнхийлөгчийг орлох өрхтэй, эзгүй үед нь.

Ардын Их Хурлын 22 дугаар тойргийн депутат Л.Дашням :  
 -Би зүгээр цээнхийн санал болгоод шинэ найруулга санал болгоё. Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч, Ерөнхий сайдаар хэдийд ч уг хэлүүлэхээр урьж болно гэж энэ найруултыг санал аваачээ гэж бодож байна.

Ардын Их Хурлын 10 дугаар тойргийн дэпутат О.Дашбалбар:  
 Нэг юмыг л би сайн ойлгохгүй байна. Саналыг хэд хэдэн удаа

## 4.

авчихаад дахиад ингэнэ гэдэг бол олонхийг юу гэж үзээд байгаа юм бүү мэд. Хоёрт гэвэл Ардын Их Хурал хуралдааж байхад түүнээс өөр төрийн дээд эрх барих байгууллага байхгүй. Өөр парламент өндөр хөгжсөн орнуудад бол Ардын Их Хурлын хуралдааны үед засгийн эрх, Ерөнхийлөгчийн эрх бүгд Ардын Их Хуралдаа шилждэг, тэр ч байтугай тамгаа шилжүүлж өгдөг ёстой. Өнөөдөр би хараад үзэхэд Ардын Их Хурал Дэд Ерөнхийлөгчөөсөө доор байгаа юм шиг ийм ойлголт төрүүлэх гээд байх юм. Би энэнийг чинь ойлгохгүй байна. Дэд Ерөнхийлөгчийн уг хэлэх өрхийг бид угүйсгээгээгүй, дуртай цагтаа уг хэлцэг л юм байгаа биз. Гэхдээ депутатынхаа хувьд депутат учраас тэр хүн уг хэлэх өрхтэй. Депутат биш байсан бол бид энэ хүнийг Ерөнхийлөгчтэй адил зөвшөөрч болно.

Депутат учраас тэртээ тэргүй энэ хүн угээ хэлнэ. Тэгээд олонхийн саналыг харгалзахыг хүсч байна. Нэгэнт ардчилал гэж байгаа юм бол олонхи чинь дахин дахин татгалзаад байхац ингээд байна гэдэг бол утгагүй юм.

Ардын Их Хурлын 429 дүгээр тойргийн депутат Е.Рэнцэн-нашаг:- Энэ ерөөсөө л одоо бас л сахилга суларч байгаатай холбоотой асуудал юм л даа. Одоо манайд бол ерөөсөө дарга нарыгаа адилхан л байлгах гээд байгаа юм. Дээр, дооргүй. Тийм учраас тэр улсад чинь тэргүүн байна, өрх гэрт ч тэргүүн байгаа. Ийм учраас ерөөсөө энэ дээр Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч, Ерөнхий сайд бол энэ улс гүрний тэргүүнүүд, энэ баганууд угээ чөлөөтэй хэлж байх нь зүйтэй байх аа. Тийм учраас ерөөсөө чи ч чи, би ч би гэсэн байцаар байж таarahгүй гэж бодож байна.

Ардын Их Хурлын 85 дугаар тойргийн депутат К.Сайраан:- Депутат Барсболдын хэлсэн саналаар, хувилбараар санал хураая.

Ардын Их Хурлын 41 дүгээр тойргийн депутат Н.Пүрэвдорж:- Тэгэхлээр ярихгүй юмаар, хэлэхгүй юмаар, хэрэггүй юмаар

## 5.

хөөцөлдөж, хүүхийн тоглоом шиг ийм юм ярьж байхаа больё. Муухай юм. Ийм том депутатууд. Ийм том танхимд, ийм их нэр хүндтэй хуралд ирчихээд тэгээд иймэрхүү юмнууд яриад байдаг чинь, энэ чинь юунд зориулж байгаа цаг юм бэ? Ер нь Хурлын даргад хэлэхэд хумуусуудийн тавьж байгаа саналцбас заримдаа хайхрамжгүй хандаж байна. Би түрүүн уг хэлэхдээ энэ заалтыг бүхэлд нь хасъя гэсэн санал тавьсан. Тэгээд тэр гурван Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч, Засгийн газрын Ерөнхий сайд шаардлагатай үедээ чөлөөтэй угээ хэлж байгээ, энэнийг бид тэгнэ, ингэнэ гэж ийм юм дэглэхээ больё. Энэ заалтыг хасъя гэсэн ийм л юм байх ёстой, тэгсэн чинь заавал тэرنийг эрх өгнө, энэнийг эрх өгөхгүй гэж ийм юм яриад байх ямар шаардлага байна. Ерөөсөө энэ гурван хүн бол шаардлагатай үедээ депутатуудтайгаа саналаа солилцох тийм эрх хэмжээ байх ёстой. Ийм учраас энэнийг хасах хэрэгтэй гэсэн санал байна. Үндсэн хуульд бол Бага Хурлын дарга ингэнэ, тэгнэ, хязгаарлана, хязгаарлахгүй гэсэн юм байхгүй.

Ж.Уртнасан:- Энэ саналыг цэмжиж байна. Энэ саналаар бол бид хүүхэд шиг байдлаасаа гарах юм байна л даа.

Ардын Их Хурлын 288 дугаар тойргийн депутат С.Баярцогт:- Энэ бол хүүхийн тоглоом биш. Ёс ёмбогор, тэр түмбэгэр гэж байх ёстой. Энэ хүнийг Дэд Ерөнхийлөгчийнх нь хувьд, Бага Хурлын даргынх нь хувьд үнэхээр уг хэлүүлэх эрхтэй. Би Бага Хуралд гишүүнийх нь хувьд энэ хүн бол өөрөө тийм эрхийн төлөө явахгүй, тэгэхдээ энэ хүн бол депутат. Монголд хэрвээ одоо парламент хоёр танхимтай байгаа бол тэр хүн хоёулангийнх нь гишүүн, дээд талын танхим хуралдаж байхад дээд талын дарга нь даргалж байх ёстой, хэрвээ энэ хүн, сая Ганболд хэлж байна. Ерөнхийлөгч байхгүй үед Ерөнхийлөгчийг төлөөлнө. Ингэхэд парадокс уусч байгаа гэж хэлж байна. Яагаад гэвэл эрх байхгүй гэж. Ерөнхийлөгч хүн бол харин депутат биш байх ёстой. Тэгэхэд харин депутат хэрнээ Ерөнхийлөгчийн юмыг үйлчлээд байгаа, энд бол өөрөө парадокс уусч байгаа.

Бид зөвшөөрлийг нь өгч болно, тэгэхдээ энд бол асуудлыг нь хэлэлцээд, депутатас нь татгалзуулчих хэрэгтэй. Яг үнэхээр хундрэлтэй байгаа. Депутат байгаагийн хувьд бол Улсын Дэд Ерөнхийлөгч Бага Хурлын дарга хэрнээ яг бид нар шиг депутатын үүрэг гүйцэтгээд 10 мянган сонгогчдын асуудал гэж ургэлж тийм юман дээр байх бол үнэхээр хундрэлтэй. Энэ бол тоглоом биш, хэрвээ бид нар энэнийг тухайн үеийнхээ асуудлаар дандаа юмаа шийдээд байх юм бол төр ёс гэдэг чинь тогтохгүй, төр бол түмбэгэр байх ёстой, ёс бол ёмбогор байх ёстой.

Ардын Их Хурлын 191 дүгээр тойргийн депутат Б.Лханаасүрэн: Тэгэхлээр Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгчийг хэдийд ч уг хэлүүлж болно гээд, хэлж гэдгийг нь хэлүүлж болгошихъё. Өөрөөр хэлбэл гурван удаа хэлэх эрхээ өдөлдэг, шаардлагатай бол бид дараа нь хэзээ ч хэлүүлж болно. Энэ бол маш зөв вариант байх. Тэгэхлээр яагаад ингээд байна гэхлээр, хязгаарлах гээд байгаа юм бэ гэхлээр энэ чинь цаанаа учиртай л даа. Тэр чухал хуулиудыг хэлэлцэхэд Дэд Ерөнхийлөгч бүх асуудлаар уг хэлж, олон дахин хэлж депутатуудад нэлөөлж болзошгүй гэдэг үүднээс л энэ улсууд чинь ингээд байгаа шүү дээ. Тэгэхлээр энэнийг бас эрхбиш харгалзахгүй бол болохгүй. Хэлүүлж болно гэвэл болмоор юм шиг байна.

Ардын Их Хурлын 45 дугаар тойргийн депутат М.Энхсайхан:- Учлаарай ахиад босчихъё. Угий өэ би асуудал хэлэлцэхэд асуудал тулган хүлээлгэх талаасаа биш, жишээлбэл Их Хурлын дарга бид нарыг асуудал хэлэлцэж байхад процедур талаасаа аягүй их хүнд гацаатай юмнууд их гарна. Бага Хурал дээр тийм хүнд юм зэндөө гарч байсан, эндээс гарч байсан туршилага байгаа. Тийм учраас бас тус болоод хэлчих юм ч гарна. Элдэвийн асуудал гарна.

Ардын Их Хурлын 25 дугаар тойргийн депутат Л.Энэбиш-Ийм юм ойлгогдоод, ажиглагдаад байх юм. Энэ маргаан бол Их цаазын төслийг хэлэлцэх үед үнэхээр их нарийн юм байна л даа. Энд

маргаад байгаа чинь тэнд гарах нь л дээ. Ер нь бид бол олон шатанд хүсэлтээ тавых байгаа шуу дээ. Янз бурийн санал, тэгэхээр босоод нэг тайлбарлачихаад хуучнаар нэг зутгуулээд явдаг ийм арганд орох нь л дээ. Ерөнхийлөгч, Ерөнхийх сайд хоёр босоод л дураараа, ингээд л урдаас нь тийм тийм гэж тайлбар хэлчихээд тэгээд л санал асуугаад явах юм бол өнэ Их цаазын төсөлд янз бурийн санал, онол гарна шуу. Ер нь Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч, Улсын Бага Хурлын дарга өрхээ өдэлж байгаа гэвэл би өдлүүлж байгаа гэж бодож байна. Энэ хумуусууд бол өнэнийг боловсруулах комиссын дарга нь байсан. Бага Хурлаа удирдаж хийлгэсэн. Санал онол нь орж ирсэн. Одоо яг Их Хурлын депутатууд саналаа хэлэлцэхэд өнд бол чөлөөтэй уг хэлүүлийн гэдэг бол бидний саналын эсрэг дандаа тайлбар хэлж байх бүрэн өрхийг олгох гэж байна. Ийм учраас би өнэ дээр өнэ заалтыг бүрэн хасах хэрэгтэй.

Ардын Их Хурлын дугаар тойргийн депутат Ш.Шагдарсурэн:  
Би горимын санал хэлмээр байна. Одоо цөөнхийг хоёр удаасосон соод санал хураалгамаар байна. Тэгэхдээ би саянын депутат нехөр Энэбийшийн угэн дээр нэг юм хэлмээр байна. Энэ Их цаазыг санаачлагч нь Улсын Бага Хурал, Их цаазын ажлын хэсгийн дарга нь Ерөнхийлөгч, өнэнийг хэлэлцэх явцад нь асуултандаа тайлбар өгөх эсэхийг нь харин хязгаарлачих юм бол харин тэр тусгуй болно шуу.

Ардын Их Хурлын 283 дугаар тойргийн депутат Ш.Шагдарсурэн:  
Тэгэхлээр бид бол бүгдээрээ хэлэлцвэл буруугүй гэдэг угийг санах ёстой, нэг хүн ярих нэг өөр, хоёр хүн нийлээд ярих бас нэг өөр байдгийг бод л доо. Тэгэхээр бид бол өнөөдөр улс орны үнэхээр чухал асуудлуудыг хэлэлцэнэ. Ээдрээтэй ийм үед байгаа. Энэ бүгдийгээ бодолцмоор байна. Тэгэхээр Энэбиш бол жишээлбэл бүгдээрээ эсрэг тайлбар өгөөд явчих юм биш ийм юм ярьж байна. Хумуус алга ташиж байна. Би энэнд гайхаж байна. Ийм байж болохгүй. Ер нь бол зөвхөн тухай тухайн асуудлыг хэлэлцүүлэхэд нь байжвал тэрэн дээр нь угээ хэлчигээ гэж байна. Энэ зөв байж болно. Гэхдээ тэр асуудлыг хэлэлцэхэд бух асуудлууд, улс орны асуудлуудыг ярих учраас бүгд халиад негеэ асуудлууд нь

8.

хоорондоо холбогдоод ингээд явчих нь гэж ингэж ойлгож байгаа юм аа. Би хувьдаа бол. Ийм учраас зөвхөн тэр асуудлууд дээр биш, бусад асуудлуудыг хэлэлцэж байх үед ч гэсэн уг хэлэх эрхийг нь олгох ёстой юм аа гэж ойлгож байна. Энэ талаас нь хандаж узэхгүй юу та нар.

СОРОНЗОН ХАЛЬСТАЙ ТУЛГАЖ  
НИЙЛСЭН

П. ТӨМӨРБААТАР

БИЧЭЭЧ Л.ХОРЛОО

1991-XI-II.  
Кассета № 37  
19.35-19.48

191

-Одоо заавал нэг эсрэг л юм болох гэж байгаа юм шиг л бүх тогтолцоо маань зарим одоо депутатууд туруунд хэлсэн, бугдээрээ /кассетын бичлэг тасарсан/

-Жигдэрчих шиг боллоо. Би одоо та бүхэнд санал хураалтад бэлтгэхийг уриалаад нэг ийм юм тайлбар тавья. Уучлаарай би саналаа тасалчихлаа <sup>ШУУ ДЭЭ.</sup> Тэгэхээр бид ийм юмыг депутатууд минь анхаарч уззэчээ. Бид ямар зүгээр хөрүүлийн алим биш энийг байлгана байлгахгүй гэж булаацаалдаад хэрэгтгүй байна. Ганцхан ойлгууштай юм бол хэрвээ манай парламент үнэхээр 2 танхимтай, байнгын ажиллагаатай парламент нь бага хурал юм бол парламентын бага хуралын дарга маань жирийн депутат биш бага хурлын дарга Улсын Дэд Ерөнхийлөгч, энэ утгаараа болбол бид бас харж узүүштэй чухал гэж ойлгож байна, энэ бүх асуудлыг оруулбал мэдээж хэрэг та бид нар уриалж дуудаад ч шууд тушаалынх нь дагуу босгож байгаад асуух ч ийм шаардлага гарах байх. Ийм учраас зарим депутатууд ер нь их боломжийн санал гаргалаа гэж бодож байна. Бид энийг ингэж маргалдаад хэрэгтгүй юм шиг байна. Депутат Барсболд, Гомбосурэн, Энэбиш нарын саналаар энэ заалтыг хасчихъя. Тэгэх юм бол энэ хүн хэдийд ч уг хэлэх нь нээлттэй хэвээр үлдэх юм. Ингээд энэ заалтыг өрөөсөө байлгана, нэмнэ, хасна гэж Ерөнхийлөгч, дэд Ерөнхийлөгч гэж ангилийн зааглахаа болжээ. Энэ заалтыг хасъя гэсэн санал хураалт явуулах гэж байна. Санал хураалтад бэлтгэнэ үү.

За баярлалаа. Энэ заалтыг олонхийн саналаар 60 % хувь нь буюу 240 депутат хасъя гэж байна. 36 % нь буюу 146 депутат татгалзаж байна. 4 депутат буюу 16 нь түдгэлзлээ. Ийм учраас энэ заалтыг хасчихъя. За одоо эцсийн заалт байна.

: -Тэгвэл Ерөнхийлөгч одоо ямар хууль зүйн үндэслэлээр одоо уг хэлэх эрх үлдэх вэ?

Уртнасан: -Ерөнхийлөгч уг хэлэх бүрэн эрхтэйгээ үлдсэн. Ямарч тохиолдолд. Дэгд журамласангуй шүү дээ. Тийм учраас тэр хүн маань босоод хэлж л байг. Бид энэ дэгээр дэглэсэнгүй шүү дээ.

-Энэ чинь АИХ-ын депутатуудын одоо уг хэлэх эрх нь үлдэж байгаа шүү дээ. Туруу бид нарыг чинь нэг нэгээр нь салгаад Ерөнхийлөгч уг хэлж болно гэдгий нь бол зөвшөөрсэн. Тэгээд энэ заалтаа бүгдий нь хасчих юм бол түрүүчийн хэлэлцэн маань хамтдаа хасагдчихаж байгаа шүү дээ. Тийм учраас өнөөдрийн АИХ дээр Ерөнхийлөгч уг хэлэх эрх бол байх ёстой.

-Хурлын дарга аа, зөвшөөрөл өгнө уу,

-За одоо бид санал хураалт явуулчихлаа.

-Цөөнх нь угээ хэлмээр байна шүү дээ.

406 дугаар тойргийн депутат Ч.Тэрбиш: - Нэг асуудал дээр З-аас доошгүй санал хураахгүй гэдгийг мэдэж л байна л даа. Гэхдээ энэ чинь бид Ерөнхийлөгч нэг гэж 2 хураагаад, Ерөнхий сайд гэж 1 хураагаад, тэгээд дэд Ерөнхийлөгчтэй нэг хураагаад дахиад яж байна шүү дээ. Энэ нь чинь З өөр юм хурааж байсан шүү дээ. Тэгэхээр энэ дээр би саяын депутаттай санал нэг байна. Ерөнхийлөгчид онцгой эрх өгөхэд яагаад болохгүй байна аа, бид Ерөнхийлөгчийг Ерөнхий сайд, дэд Ерөнхийлөгчтэй зэрэгчүүлж тавих гээд байх юм. Манай монгол улсын толгой нь ганц л толгой байгаа, нэг толгойдоо л санал өгье. Туруун зарим депутатууд энэ биднээс сонгож баталсан энэ тэр гээд нэг жаахан тийм төрийн эрх барих юм шиг яриад байна лээ, ноднингийн өдийд Их Хурлаар бол Их Хурлын чуулганаар бидний сонгосон хүн олон бий. Сонгосон болгон маань депутатуудаасаа илүү эрх эдлээд байх юм бол Бага Хурлын 50 гишүүн бас илүү эрх эдлэж болох л байх. Тийм учраас ганцхан Ерөнхийлөгч илүү эрх эдлүүлсэн түрүүчийн заалтан дээр дахиад санал хураалгах санал тавыж байна. Бид 2 л санал хураасан шүү дээ.

-Энэ дээр би нэг тайлбар хэлчих уу. Үндсэн хуулийн 13 дугаар зүйлд нэмэлтийн хууль Ерөнхийлөгч бол манай ардын төрийн тэргүүн гэж, тийм учраас Үндсэн хуулийн нэмэлтийн хууль одоо шинэ Үндсэн хууль үйлчилтэл үйлчилнэ. Тийм учраас төрийн тэргүүн хүн ямар ч хуралц уг хэлэх бүрэн эрхтэй. Тийм учраас энэ дэгэнд заасан заагаагүй уг хэлэх эрх бол би байгаа гэж ойлгож байгаа.

-За одоо ганцхан заалт үлдлээ. Эрхэм депутатуудаа, тэсвэртэй байна уу. Одоо энэ З дугаар заалтыг хэлэлчихээд тэгээд завсарлая. З дугаар заалт дээр бидэнд тодорхой санал ируулээгүй. Хэвээр үлдээхээр санал хураах уу. За санал хураалт явуулья. З дугаар заалтыг хэвээр үлдээе.

За баярлалаа, нийт санал өгсөн депутатуудын 97 хувь нь буюу З.. /кассетад яриа давхардсан/

? Ц.Элбэгдорж:

-Дарга аа, энэ дээр нэг асуудлыг эргэж хэлэлцье гээд орхисон шүү дээ, тэр Е-г . Маргааш хуртэл тайван байх хэрэгтэй байна л даа. Нэг асуудал онгорхой үлдчихээр их хэцүү байна. Тэр Е заалтыг. Хасъя гээд эхлээд олонхи авсан, дараа нь тайлбарлаж байгаад хураасан чинь дахиад олонхи болчихсон, ийм л 2 удаа санал хураасан. Депутатуудын ердын олонхийн саналаар гэдэг тэр 4 угэн дээр. Тэг хээр 30-аас дээш депутатын дэмжлэг авсан тохиолдолд 30- аас дээш депутат нь хүссэн тохиолдолд гээд л энийг хиймээр байна, энийг ингээд дахин санал тавьж байна. Хүндэт депутатууд энийг харж үзээч өэ. Маргааш хуртэл тайван байх хэрэгтэй шүү дээ. Энэ өнөөдөр үүнийгээ шийдэх хэрэгтэй нэг асуудлыг.

-Депутатууд аа тайван сууна уу, зарлалын чанартай 2,3 зүйл байна. Манай ажлын хэсгээс ируулж байна. Нийт депутатуудад сонордуулж өгнө уу гэсэн ийм зарлал байна.

-Улаанбаатар хотод ажиллаж, аж төрдөг АИХ-ын депутатуудыг орой бүр I9-20 цагт 4 чиглэлд гэрт нь дехуулж өгөхөөр унаа хийлчилнэ. Хаяг нь автобус бүр дээрээ байгаа. Ажлын хэсэг гэсэн ийм зарлал байна. Өнөөдөр бид Засгийн газартаа гардуулж өгөхгүй бол болохгүй гэсэн цаг хожигдох ийм нэг юм байна. Өндөр настнуудын 2 дугаар сүүлт I99I-II-I2-ноос өхлэн сүүлт хийх болсныг Их Хурлын чуулганы депутат нийрын сонорт дамжуулж өгөхийг хүсье. Засгийн газар амьжиргааг баталгаажуулах тухай замалтаяа биелүүлэхгүй байна гэсэн ийм сонордуулах бичиг ирж байна. Үүнийг бид Засгийн газартаа дамжуулья. Хуралдааны дараа депутатуудын нууц

таг дэвсгэрийн бүлгийн дарга нарыг өргөтгөлийн "З" танхимд цуглахыг хүсч байна. Монголын парламентын бүлгэмийн гүйцэтгэх хорооны дарга Зориг гэсэн зарлал байна. Энд 2 тогтоол байгаа юм. АИХ-ын тогтоол, 1991 оны II-р сарын II-дугаар БНМАУ-ын АИХ-ын даргыг чөлөөлөх тухай, БНМАУ-ын Ундсэн хуулийн нэмэлтийн тухай хуулийн 4 дутгээр зүйлийн 4 дэх хэсгийг хндэслэн БНМАУ-ын АИХ-аас тогтоох нь: БНМАУ-ын АИХ-ын даргаас 326 дугаар тойргийн депутат Жамбын Гомбожавыг чөлөөлсүгэй. Дарга Уртнасан, за энэ тогтооолыг хэлэлцэхийг энэ дээр санал шүүмжлэл байна уу, за тэгвэл тогтооолыг батлах санал хураалт явуудь.

За баярлалаа, 93 % нь буюу 148... /кассетад яриа давхардсан/

Уучлаарай манай депутатууд их яарч байх шиг байна. гар өргөө энэ тогтооолын төслийг батлах депутатууд гараа өргөнө уу.

За баярлалаа 100 хувь байх шиг байна.

Татгалзаж байгаа хин байна уу, 5, Түдгэлзэж байгаа 5 байна.

Депутатуудаа түр сууна уу, одоохон дууслаа.

Одоо бас нэг тогтоол байна, БНМАУ-ын АИХ-ын орлогч дарга нарыг чөлөөлөх тухай, БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дүгээр хэсгийг үндэслэн БНМАУ-ын АИХ-аас тогтоох нь БНМАУ-ын АИХ-ын орлогч даргаас 55 дугаар тойргийн депутат Цахиагийн Адъяасурэн, 22-р тойргийн депутат Лувсандамбын Дашиям, 216 дугаар тойргийн депутат Ойдовын Долгорсурэн, 83-р тойргийн депутат Хылышийн Хүзкей нарыг тус тус чөлөөлсүгэй. гэсэн ийм тогтоолын төсөл байна. За энэ тогтоолын төслийг батлая гэсэн депутатууд гарцаа өргөнө үү. Баярлалаа. Татгалзаж байгаа депутат байна уу, 4, баярлалаа. Түдгэлзэж байгаа алга. За баярлалаа. Одоо суулчийн ганцхан зарлал байна. Хурлын ажлын хэсгээс бидэнд энийг унших өгөөч гээд. АИХ-ын дарга дараах зарлалыг хургэнэ үү. Өмнөговь, Дундговь, Дорноговь, Говь-Алтай, Өвөрхангай, Увс, Баянхонгор, Ховд, Завхан, Сүхбаатар аймгийн дарга нар 19.15 минутад Байгаль орчнын хяналтын улсын хороонд очиж сайд Батжаргал, Батсуурь наортай уулзахыг урьж байна. Хуралдаан тараад шууд очиж уулзах юм. Нэг их удахгүй. 15-30 минут гэнээ.

-За баярлалаа. Та бүхэнд.

Соронэон хальстай  
тулгаж нийлсэн

Ш.Бурмаа Ш.БУРМАА